

See discussions, stats, and author profiles for this publication at: <https://www.researchgate.net/publication/294870356>

# ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

Book · January 2016

CITATIONS

0

READS

866

5 authors, including:



**Sarthi Acharya**

Institute of Development Studies

21 PUBLICATIONS 68 CITATIONS

SEE PROFILE



**Odmaa Narantungalag**

Massey University

1 PUBLICATION 0 CITATIONS

SEE PROFILE



**Ganzorig Gonchigsumlaa**

Mongolian University of Life Sciences

18 PUBLICATIONS 3 CITATIONS

SEE PROFILE

Some of the authors of this publication are also working on these related projects:



BIHAR RURAL LIVELIHOODS PROJECT- "JEEVIKA" [View project](#)



Support to Employment Creation in Mongolia (SECiM C2) piloting quality private sector work in selected livestock and vegetable value chains project [View project](#)

All content following this page was uploaded by [Ganzorig Gonchigsumlaa](#) on 03 October 2016.

The user has requested enhancement of the downloaded file.



САНГИЙН ЯАМ

# ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар  
2015



DDC 300 T-574

## ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

Боловсруулсан:

САНГИЙН ЯАМ  
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗАР

Сарти Ачаряа  
Н.Одмаа  
Д.Чимэддагва  
Г.Болормаа  
Г.Ганзориг



Энэхүү гарын авлагыг Сангийн яамнаас НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд боловсруулж, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан “Ядуурал, байгаль орчны доройтлыг бууруулах санаачлага” хөтөлбөрийн санхүүжилтээр хэвлүүлэв.

ISBN 978-99973-825-8-0



## АГУУЛГА

АГУУЛГА.....	iii
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	ix
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	x
ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ .....	xi
ӨМНӨХ ҮГ.....	2
Гарын авлагын хэрэгцээ, шаардлага.....	2
Гарын авлагын зорилго .....	2
Гарын авлагын агуулга .....	3
БҮЛЭГ НЭГ. ҮНДСЭН ОЙЛГОЛТ .....	4
1.1 Хөгжлийг тодорхойлох нь .....	4
1.2 Бодлогыг тодорхойлох нь .....	4
1.3 Бодлого боловсруулагч .....	5
1.4 Хөгжлийн төлөвлөлт .....	5
1.5 Тогтвортой хөгжил ба бодлого төлөвлөлт .....	8
БҮЛЭГ ХОЁР. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ.....	12
2.1 Нөхцөл байдлын шинжилгээ: суурь судалгаа, бодлогын хувилбарууд.....	12
2.2 Асуудлын шинжилгээ .....	13
2.3 Арга зүй .....	14
2.4 Макро түвшний төлөвлөлт .....	20
2.5 Мэдээллийг шинжлэх.....	21
2.6 Тогтмол ба урсгал хувьсагчид.....	22
2.7 Мэдээллийг хувиргах: Үзүүлэлт болон индексийг боловсруулах ...	23
2.8 Нөхцөл байдлын шинжилгээнд хэрэглэгддэг дискриптив статистикийн товч танилцуулга.....	23



2.9 Мэдээллийг бүлэглэх .....	24
2.9.1 Нэг хэв маягийн бүлэглэлт .....	24
2.9.2 Хоёр хэв маягийн бүлэглэлт .....	25
2.9.3 Дундаж, медиан, моод .....	25
2.9.4 Стандарт хазайлт болон Вариацийн коэффициент .....	27
2.9.5 Дисперс .....	27
2.9.6 Тархалтын налалтын коэффициент (skewness) болон куртосис (kurtosis) коэффициент .....	28
2.9.7 Баганан болон шугаман диаграмм .....	29
2.9.8 Хугацаан цуваа .....	32
2.9.9 Регрессийн шинжилгээ .....	34
2.10 Монгол Улсын статистик мэдээллийн тогтолцоо .....	37
2.10.1 Хүн ам, орон сууцны тооллого .....	38
2.10.2 Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа .....	38
2.10.3 Засаг захиргааны мэдээлэл .....	39
2.10.4 Байгалийн нөөц, цаг уурын өөрчлөлтийн мэдээллийн сан ....	40
2.11 Мэдээлэл, нотолгоо цуглуулах .....	41
2.12 Нөхцөл байдлын шинжилгээнд хэрэглэгдэх бусад сэдвүүд .....	42
2.12.1 Бага түүвэр судалгаа .....	42
2.12.2 Тэгш бус байдлыг хэмжих .....	44
2.12.3 Хүн амын болон боловсролтой холбоотой мэдээлэл .....	45
2-р бүлгийн Хавсралт 1: Хөгжлийн шинжилгээнд ашиглагддаг зарим нэг статистикийн үзүүлэлтүүд .....	47
Төлбөрийн болон худалдааны тэнцэл .....	47
Төсвийн алдагдал .....	47
Инфляци .....	47
Үнийн индекс .....	47



Нэмүү өртөг .....	48
Бүтээмж.....	48
Ашиг .....	48
<b>БҮЛЭГ ГУРАВ. БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ .....</b>	<b>49</b>
3.1 Төлөвлөлтийн зарчим ба үйл явц .....	49
3.2 Бодлого төлөвлөлтийн үр дүнгийн хүрээ .....	51
3.3 Төлөвлөлтийн төрөл.....	52
3.3.1 Урт хугацааны бодлого .....	53
3.3.2 Дунд хугацааны бодлого .....	54
3.3.3 Жилийн төлөвлөгөө .....	57
3.3.4 Салбарын бодлого .....	59
3.3.5 Бүс нутгийн болон орон нутгийн бодлого.....	59
3.4 Зорилго тодорхойлох .....	61
3.5 Дунд хугацааны бодлого болон нэг жилийн төлөвлөгөөний зорилт .....	63
3.5.1 Хөдөө аж ахуй .....	63
3.5.2 Аж үйлдвэр .....	63
3.5.3 Үйлчилгээний салбар .....	64
3.6 Бүс нутгийн хөгжлийн зорилтыг тодорхойлох нь .....	65
3.7 Хүний хөгжил болон байгаль орчны зорилтыг тодорхойлох .....	65
3.7.1 Хүний хөгжил .....	65
3.7.2 Ядуурал .....	66
3.7.3 Боловсрол, хүний нөөц, эрүүл мэнд .....	67
3.7.4 Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй.....	68
3.7.5 Жендэр.....	68
3.7.6 Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засаг .....	68
3.8 Бүс нутгийн хөгжлийн бодлогын анхаарах асуудал.....	69



3.9 Үр дүнгийн хүрээний хэрэгжилтийн үйл явц.....	70
3.9.1 Үр дүнгийн хүрээний төлөвлөлт ба төсөв .....	70
3.9.2 Үндэсний зорилт ба яамд .....	70
3.9.3 Хөтөлбөр .....	72
3.9.4 Дэд хөтөлбөр .....	73
3.9.5 Үйл ажиллагааны болон ажлын төлөвлөгөө .....	73
3.10 Салбар хоорондын асуудал .....	74
3.11 Төлөвлөгөөг төсөвлөх .....	77
3.11.1 Капитал болон гарцын өсөлтийн харьцаа .....	77
3.11.2 Санхүүгийн эх үүсвэр .....	78
3.12 Төлөвлөлтийн тусгай сэдэв .....	79
3.12.1 Эрсдэлийн шинжилгээ .....	79
3.12.2 Хөтөлбөрийн үнэлгээ .....	82
3-р бүлгийн Хавсралт 1: 2016-2021 оны Үндэсний хөгжлийн бодлогыг боловсруулах удирдамжийн загвар .....	85
3-р бүлгийн Хавсралт 2: Дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах загвар .....	103
3-р бүлгийн Хавсралт 3: Экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ .....	106
<b>БҮЛЭГ ДӨРӨВ. ТАЛУУДЫН ОРОЛЦОО БА ЗӨВШИЛЦӨЛ.....</b>	<b>108</b>
4.1 Талуудын оролцоо .....	108
4.2 Оролцогч талуудын шинжилгээ .....	110
4.3 Оролцогчдын зураглал болон шинжилгээ .....	111
4.4 Орон нутгийн хэлэлцүүлэг хийх .....	113
4.5 Салбар дундын асуудлаарх яамд хоорондын хэлэлцүүлэг .....	113
4.6 Оролцогч талуудын хоорондын хэлэлцүүлэг .....	114
4.7 Дээд шатны шийдвэр гаргагчдад мэдээлэл өгөх, танилцуулах ...	114
4.8 Хэлэлцүүлгийн мэдээллийг ашиглах .....	114



БҮЛЭГ ТАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ .....	115
5.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний ялгаа.....	115
5.1.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ гэж юу вэ? .....	115
5.1.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагч .....	118
5.1.3 Сургалт болон чадавхи .....	118
5.2 Үр дүнгийн хүрээ/Логик хүрээ.....	119
5.2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээнд үр дүнгийн хүрээг боловсруулах нь .....	119
5.2.2 Үр дүнгийн хүрээг тодорхойлох нь .....	122
5.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, үе шат .....	123
5.3.1 Шалгуур үзүүлэлт.....	123
5.3.2 Зорилтот түвшний үзүүлэлтийг тогтоох .....	124
5.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх үе шат .....	125
Үе шат 1: Төлөвлөлт .....	126
Үе шат 2: Бэлтгэл.....	127
Үе шат 3: Мэдээлэл цуглуулах.....	127
Үе шат 4: Шинжилгээ, дахин хянах.....	127
Үе шат 5: Үр дүнг тайлагнах .....	127
Үе шат 6: Үр дүнг ашиглах .....	128
5.5 Хяналт-шинжилгээний мэдээллийн хүснэгт .....	128
5.6 Үнэлгээний аргачлал ба мэдээлэл.....	139
5.6.1 Зарчмууд.....	139
5.6.2 Үнэлгээний арга .....	140
5.7 Хөтөлбөр, дэд хөтөлбөрийн үнэлгээний мэдээллийг бий болгох .	143
5.7.1 Макро түвшний үнэлгээ.....	145
5.7.2 Үр дүнгээ тайлагнаж, илтгэх.....	146
5.8 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зохион байгуулалт.....	146





5.8.1 Макро түвшний мэдээлэл .....	146
5.8.2 Мэдээлэл бий болгох явц .....	147
5.8.3 Мета мэдээллээс шалгуур үзүүлэлтүүдийг тооцох асуудлууд .....	149
5.9 Монгол Улсын Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо .....	150
5.10 Тусгай сэдэв: Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Өөрчлөлтийн онолыг хэрэглэх нь .....	151
5.10.1 Ойлголт .....	151
5.10.2 Өөрчлөлтийн онолын зарим онцлогууд.....	153
5-р Бүлгийн Хавсралт 1: Үр дагавар/ үр нөлөөний үзүүлэлтийн шат дараалал .....	156
5-р Бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц.....	158
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ.....	165



## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 1 Үр дүнд суурилсан удирдлага.....	8
Зураг 1. 2. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн нийтлэг зураглал .....	11
Зураг 2. 1 Нөхцөл байдлын шинжилгээний схем .....	12
Зураг 2. 2 Асуудлын модны загварын үндсэн ойлголт.....	15
Зураг 2. 3 Сургуульд хамрагдалт: Бага сургуулийн жишээ .....	16
Зураг 2. 4 Цогц асуудлын учир шалтгааныг илрүүлэх: Уур амьсгалын өөрчлөлт.....	18
Зураг 2.5 Цогц асуудлыг шийдэх: Уур амьсгалын өөрчлөлтийг багасгах, удаашруулах .	19
Зураг 2. 6 Баганан диаграмм .....	30
Зураг 2. 7 Шугаман диаграмм .....	30
Зураг 2. 8 Хоёр хэмжээст цэгэн диаграмм .....	31
Зураг 2. 9 Задгай болон тэгшитгэсэн хугацаан цувааны цэгэн диаграмм .....	34
Зураг 2. 10 Монгол Улсын статистикийн тогтолцоо.....	37
Зураг 2. 11 Лоренцын муруй .....	44
Зураг 3. 1 Үр дүнд суурилсан удирдлагын хүрээ .....	49
Зураг 3. 2 Төлөвлөгөөний үр дүнгийн хүрээ .....	52
Зураг 3. 3 Төлөвлөлтийн уялдаа .....	53
Зураг 3. 4 Компьютерийн танхим тохижуулахад ашиглаж болох ТХҮА-ийн зураг.....	58
Зураг 3. 5 Зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт тодорхойлох.....	61
Зураг 3. 6 Салбар хоорондын асуудал.....	76
Зураг 3. 7 Эрсдэлийн шинжилгээний аргачлал .....	80
Зураг 3. 8 Ирээдүйн хандлагыг тодорхойлох загвар.....	80
Зураг 3. 9 Үйлдвэрийн санхүүгийн тайлангийн жишээ, бүтээгдэхүүний үнэд эрсдэлийн хэлбэлзлийг харуулсан байдал.....	81
Зураг 4. 1 Оролцогчдын зураглал .....	111
Зураг 5. 1 Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо .....	117
Зураг 5. 2 Хяналт шинжилгээ-үнэлгээний ялгаа .....	118
Зураг 5. 3: Өөрчлөлтийн онол ба үр дүнгийн хүрээний зураглал .....	154
Зураг 5. 4: Жишээ.....	155



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2. 1 Дүүргүүдийг нэг хэв маягаар бүлэглэх (нэг хүнд ногдох орлого) ..	24
Хүснэгт 2. 2 Мэдээллийг хоёр хэв маягаар бүлэглэх .....	25
Хүснэгт 2. 3 Хураасан ургац, тариалсан талбай, бүс нутгаар .....	26
Хүснэгт 2. 4 Өрхийн нэг хүнд ногдох зарлага .....	26
Хүснэгт 2. 5 Ажилчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, 2014 он .....	29
Хүснэгт 2. 6 15-аас дээш насны ажиллагчдын тоо, улирлаар .....	33
Хүснэгт 2. 7 Хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын хувийг тодорхойлогчид (Камбожи улсын тосгодын нэгдсэн мэдээлэлд үндэслэсэн) .....	36
Хүснэгт 2. 8 Судалгааны материал цуглуулах аргууд .....	41
Хүснэгт 3. 1 Төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хүснэгт ....	71
Хүснэгт 3. 2 Хөтөлбөр, дэд хөтөлбөр, үйл ажиллагааны уялдаа .....	72
Хүснэгт 3. 3 Засаг захиргааны түвшин ба тайлагналт .....	74
Хүснэгт 3. 4 Үйлдвэрийн орлогын тайлангийн жишээ (эрсдэлийн хувьсагчуудыг заасан) .....	80
Хүснэгт 3. 5 Төслийг үнэлэх аргачлал .....	83
Хүснэгт 4. 1 Оролцогч талуудын ангилал .....	110
Хүснэгт 4. 2 Хэлэлцүүлгийн шалгах хуудас .....	112
Хүснэгт 5. 1 Үр дүнгийн хүрээ/Логик хүрээний дарааллын түгээмэл схем .....	119
Хүснэгт 5. 2 Нийгмийн хоёр төслийн матрицын жишээ .....	121
Хүснэгт 5. 3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн шинжүүд ..	123
Хүснэгт 5. 4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний загвар .....	126
Хүснэгт 5. 5 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шатууд .....	126
Хүснэгт 5. 6: Үнэлгээний төрөл .....	140
Хүснэгт 5. 7 Стандарт, бусад зорилтот түвшний арга .....	142



## ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1. 1 Бодлого боловсруулахад анхаарах зүйлс .....	5
Шигтгээ 1. 2 Хөгжлийн төлөвлөлт .....	6
Шигтгээ 1. 3 Бодлого төлөвлөлтийн албан хаагчийн чиг үүрэг .....	7
Шигтгээ 1. 4 Сайн бодлого төлөвлөлтийн 10 шинж чанар .....	9
Шигтгээ 2. 1 Асуудлыг түүний шинж тэмдгээс ялгах нь – Асуудлын модны жишээнүүд .....	13
Шигтгээ 2. 2 Макро түвшний төлөвлөлтийн Нөхцөл байдлын шинжилгээний зарим түгээмэл сэдэв .....	20
Шигтгээ 2. 3 Мэдлэг, хандлага, дадлын судалгаа (МХДС) .....	43
Шигтгээ 2. 4 Нөхцөл байдлын шинжилгээг тайлагнах .....	45
Шигтгээ 3. 1 Үр дүнгийн хүрээ (ҮДХ) буюу Логик хүрээ (ЛХ) .....	50
Шигтгээ 3. 2 Турк улсын 2023 оны Алсын Хараа: Мэргэшлийн тэргүүлэх чиглэл .....	54
Шигтгээ 3. 3 Дунд хугацааны бодлого .....	55
Шигтгээ 3. 4 Төслийн үнэлгээ, хяналтын арга хэрэгсэл .....	58
Шигтгээ 3. 5 Үндэсний болон орон нутгийн хариуцлага – Олон улсын туршлага	60
Шигтгээ 3. 6 Ядуурал ба байгаль орчин .....	66
Шигтгээ 3. 7 Сургуулийн өмнөх боловсролын ач холбогдол .....	67
Шигтгээ 3. 8 Салбар хоорондын уялдааг хангахад хамтарсан хөтөлбөр болосвруулах нь: Камбожи улсын кейс жишээ .....	75
Шигтгээ 3. 9 Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн бодлогод тусган төлөвлөх нь .....	82
Шигтгээ 5. 1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хоорондын ялгаа .....	117
Шигтгээ 5. 2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчийн чиг үүрэг .....	118
Шигтгээ 5. 3 Макро түвшний зорилтыг тодорхойлох .....	125
Шигтгээ 5.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл цуглуулах, удирдах хяналтын хуудас .....	138
Шигтгээ 5. 5: Хагас хуурай бүс нутаг дахь ус нөөцлөх төслийн үнэлгээ .....	143
Шигтгээ 5. 6 Судалгааны жагсаалт .....	149





## ӨМНӨХ ҮГ

### Гарын авлагын хэрэгцээ, шаардлага

Дэлхийн эдийн засаг даяарчлагдаж байгаа энэ үед улс орнууд хоорондоо илүү хамааралтай болж, шинжлэх ухаан, технологийн дэвшил, үйлдвэрлэлийн үр ашиг, улс төрийн хамтын ажиллагаа нь тэднийг улам бүр ойртуулан нягтруулж байна. Гэсэн хэдий ч эдийн засаг, санхүүгийн хямрал, ядуурал, байгаль орчны бохирдол болон дархлалын олдмол хомсдол (ДОХ) гэх мэт олон улсын түвшинд тулгамдсан асуудлууд нь бодлого төлөвлөлтийн явцад хүнд сорилтуудыг дагуулсаар байна. Иймд тулгамдаж буй асуудлыг оновчтой тодорхойлох, нөөц бололцоогоо үр ашигтай удирдах нь үр дүнтэй бодлого төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэхэд нэн чухал байна.

Монгол Улсын эдийн засагт уул уурхай, хөдөө аж ахуй, худалдааны салбар давамгайлж, экспортын 90 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаараа бүрдүүлж байна. Гэвч дотоод хуримтлал хязгаарлагдмал, ядуурлын түвшин өндөр байгаа зэрэг нь эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлж, орлогыг тэгш хуваарилахад чиглэсэн бодлого төлөвлөлтийн тогтолцоог зүй ёсоор шаардаж байна.

Монгол Улсад бодлого төлөвлөлтийн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, бодлогын баримт бичгүүдийн боловсруулалт хангалтгүй, хоорондын уялдаа сул, хүрэх үр дүн тодорхойгүй, хэрэгжилтийг хянахад хүндрэлтэй, санхүүгийн эх үүсвэр нь тусгагдаагүй зэрэг асуудлууд байсаар байна.

Иймд үндэсний, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулахад олон улсын стандарт, арга зүйд суурилсан нэгдсэн аргачлал бүхий гарын авлага зайлшгүй үгүйлэгдэж байна.

### Гарын авлагын зорилго

Энэхүү гарын авлагын зорилго нь Засгийн газрын болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын бодлого төлөвлөлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан албан хаагчдад Засгийн газрын бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалаар хангахад оршино. Гарын авлага нь бодлогын нэгдсэн мөчлөгийн дагуу Үр дүнд суурилсан удирдлагын хүрээнд төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг нэгтгэсэн болно. Түүнчлэн уг гарын авлагыг бодлогын төсөвлөлт, санхүүгийн асуудал хариуцсан албан хаагчид лавлагаа болгон ашиглах боломжтой.



### Гарын авлагын агуулга

Гарын авлага нь таван бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт - Бодлого, түүний төрлүүдийн талаарх үндсэн ойлголт болон бодлого төлөвлөлтийн үйл явцын талаар хэрэглэгчдэд мэдээлэл өгнө. Хоёрдугаар бүлэгт - Үр дүнд суурилсан бодлого боловсруулахад шаардлагатай нөхцөл байдлын шинжилгээг хэрхэн хийх, мэдээлэл, нотолгоо цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх, асуудалд шийдэл олох аргачлалын талаар тайлбарлана. Гуравдугаар бүлэгт - Урт, дунд болон богино хугацааны бодлогыг төлөвлөх үе шат, бодлогын хэрэгжилтийг орон нутаг, салбар хооронд уялдуулах талаар өгүүлнэ. Дөрөвдүгээр бүлэгт - Бодлого төлөвлөлтийн үйл явцад талуудын оролцоог хангахын ач холбогдол, санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулах талаар дурдана. Тавдугаар бүлэгт - Бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны үе шат, аргачлалыг дэлгэрэнгүй тайлбарлана. Энэхүү гарын авлагыг дасгал, жишээ болон хавсралт материалаар баяжуулсан болно.

# БҮЛЭГ - 1

---

**ҮНДСЭН ОЙЛГОЛТ**

The background features a large, faint circular graphic composed of several segments. Overlaid on this are several icons: a hand pointing at a screen, a lightbulb, a stack of coins, and a group of people. There are also two dashed circles of different sizes, one larger and one smaller, positioned to the right of the central text.





## БҮЛЭГ НЭГ. ҮНДСЭН ОЙЛГОЛТ

**Тойм:** Энэ бүлэгт хөгжлийн тодорхойлолт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчим болон тэдгээрийн үндэслэл, шаардлагын талаар тусгав.

### 1.1 Хөгжлийг тодорхойлох нь

Хөгжлийн үйл явц нь хүмүүсийн сонголтыг сайжруулахад чиглэгдсэн байдаг. Хүн аливаа сонголтыг хийхийн тулд боловсрол, мэдлэгтэй, эрүүл чийрэг байхаас гадна өөрийн гэсэн үнэт зүйл бүхий амьдралыг цогцлоох чадвартай байх ёстой. Ингэснээр хүн амьдралын тодорхой зорилготой болж, илүү олон боломжтой болох, мөн орлогоо нэмэгдүүлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх нөхцөл бүрдэнэ. XXI зуунд хөгжлийн зорилт нь тогтвортой хөгжлийг хангахад чиглэж байна. Энэ нь өнөөгийн хэрэгцээгээ хангахдаа хойч үеийнхээ хэрэгцээг хангах боломжийг хязгаарлахгүй хөгжих явдал юм<sup>1</sup>.

### 1.2 Бодлогыг тодорхойлох нь

Оксфордын толь бичигт бодлогыг "Хувь хүмүүс, бизнесийн байгууллага, улс төрийн намууд, Засгийн газраас санал болгож буй болон дэмжиж буй үйл ажиллагааны зарчим, чиглэл" хэмээн тодорхойлжээ.

**Бодлого** гэж Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан улс төрийн шийдэл, үйл ажиллагааны чиглэлийг хэлнэ. Бодлого нь аюулгүй байдал, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль, дүрэм зэрэг өөр өөр үйл ажиллагаанд зориулагдсан байж болно. Бодлого бол тухайн орны Үндсэн хууль, бусад хууль, эрх зүйн хүрээнд болон институцийн тогтолцоонд тохирсон нэг ба түүнээс дээш багц асуудлуудыг шийдвэрлэх уламжлал, соёлд нийцсэн авч хэрэгжүүлэх арга хэмжээний **замын зураглал** юм.

### **Хөгжлийн бодлого нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг сайжруулах зорилготой**

Монгол Улсад тулгамдаж буй асуудлууд болох ядуурал, тэгш бус байдал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, ажилгүйдэл, бүс нутгийн хөгжлийн ялгаатай байдал, байгаль орчны доройтол зэрэг асуудлыг бодлогын хүрээнд шийдвэрлэхэд анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд тухайн нөхцөлд тохирсон шийдлийг олох нь бодлогын хамгийн чухал хэсэг юм.

---

<sup>1</sup> 'Хүний хөгжлийн гарын авлага: Ойлголт, хэмжүүр ба бодлого', Сакико Фукуда Парранд, А.К.Шива, Оксфордын Их сургууль, Нью-Йорк, 1995. See for definitions, Handbook of Human Development: Concepts, Measures, and Policies, Sakiko Fukuda-Parr and A.K. Shiva Kumar (Eds.), Oxford University Press, New York 1995.

**Тайлбар:**

1. Бодлого нь аль нэг улс оронд зориулагдсан макро түвшинд байж болно.
2. Бодлого нь салбарын эсвэл зорилтот бүлэгт зориулагдсан байж болно.
3. Бодлого нь бүс нутаг, газар зүй, засаг захиргааны нэгжид зориулагдсан байж болно.
4. Бодлого нь микро түвшинд байж болно.

### 1.3 Бодлого боловсруулагч

Монгол Улсын Үндсэн хуульд бодлого боловсруулагч нарын эрх, үүргийг дараах байдлаар тодорхойлжээ:

*“Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд болон салбарын сайд нар, орон нутгийн засаг, захиргааны удирдлага нь төрийн бодлогыг санаачлах, боловсруулах, батлах, хэрэгжүүлэх эрх, үүргийг эдэлдэг.”*

Аливаа бодлогын баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн чадварлаг, боловсон хүчний оролцоо нэн чухал юм. Бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан албан хаагчид бодлого боловсруулж, түүнийг нь Засгийн газар, УИХ, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн баталдаг. Салбарын түвшинд бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүргийг яам нь хүлээдэг. Бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан албан хаагчид нь төрийн албан хаагчид учраас хөгжлийн бодлого төлөвлөлт болон хууль, эрх зүйн орчны талаар өндөр мэдлэг, туршлагатай байхыг шаарддаг.

Бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан албан хаагчид аливаа бодлогыг боловсруулахдаа Шигтгээ 1.1-д дурдсан асуудлуудыг заавал авч үзэх хэрэгтэй.

#### Шигтгээ 1. 1 Бодлого боловсруулахад анхаарах зүйлс

- Улс орны хууль, эрх зүйд нийцсэн байх,
- Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах,
- Байгалийн баялгийн хомсдлыг бууруулах,
- Жендэрийн тэгш байдлыг хангах,
- Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хангах,
- Ядуурлыг бууруулах, орлогыг тэгш хуваарилах,
- Бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах.

### 1.4 Хөгжлийн төлөвлөлт

Хөгжлийн төлөвлөлт гэдэг нь бодлогыг үндэсний, орон нутгийн болон салбарын бодлогыг урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө болгон хувиргах үйл явц юм. Хөгжлийн төлөвлөгөөний ерөнхий бүтцийг Шигтгээ 1.2-т үзүүлэв.



## Шигтгээ 1. 2 Хөгжлийн төлөвлөлт

Хөгжлийн төлөвлөгөө ямар төрөлтэй байдаг вэ?

### *Хугацаагаар:*

Улс орнууд нь хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшнээсээ хамааран хөгжлийн төлөвлөгөөгөө тодорхой хугацаанд өөрчлөн шинэчилж байдаг. Тухайлбал:

Богино хугацаа (1-2 жил)

Дунд хугацаа (3-9 жил)

Урт хугацаа (10 болон түүнээс дээш жил)

### *Засаг захиргааны түвшнээр:*

Ихэнх хөгжлийн төлөвлөгөөг янз бүрийн түвшинд боловсруулж хэрэгжүүлдэг. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө гэж тухайн улс орны хөгжлийн зорилт, бүхий л салбарыг хамарсан төлөвлөгөөг хэлнэ. Түүнд суурилан бүс, орон нутаг, салбарын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулдаг. Бүсийн хөгжлийн төлөвлөгөө нь засаг, захиргаа эсвэл засаглалын түвшинд ялгаатай хэд хэдэн газар нутгийг хамарсан байна. Аймаг, нийслэл, хот, дүүрэг эсвэл сум болон хот, тосгоны хөгжлийн төлөвлөгөө нь бүсийн хөгжлийн төлөвлөгөөний жишээ юм.

### *Хамрах хүрээ болон зорилгоор:*

*Үндэсний цогц төлөвлөгөө:* Тодорхой хугацаа, төсвийн хүрээнд Засгийн газраас макро түвшинд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн хөгжлийн бодлогын чиглэл, зорилт, арга зам болон стратегийг тусгасан байдаг.

*Салбарын төлөвлөгөө:* Тухайн салбарын бодлогын чиглэл, зорилт, стратеги, хөтөлбөр, төслийн хүрээг тодорхойлно. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө эсвэл урт хугацааны бодлогын зорилттой уялдсан байна.

*Тусгай төлөвлөгөө:* Ядуурлыг бууруулах стратегийн төлөвлөгөө, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний төлөвлөгөө гэх мэт.

Хөгжлийн төлөвлөгөөний бүтэц

Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах нэгдсэн стандарт байхгүй ч ихэнх хөгжлийн төлөвлөгөө нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байдаг. Үүнд:

### *Зорилго, зорилт болон хүрэх түвшин*

Зорилго, зорилт нь хүрэхийг хүсч буй нөхцөл, байдлыг ерөнхийд нь илэрхийлдэг. Нөгөө талаас хүрэх түвшин нь зорилготой уялдсан мэдэгдэхүйц амжилт, үр дүн юм.

### *Бодлого, стратеги, хөтөлбөр болон төсөл*

Бодлого нь зорилго, зорилт болон хүрэх түвшинг хэрэгжүүлэх чиглэлийг өргөн хүрээнд тодорхойлсон байдаг. Бодлогын зарим жишээ нь: Засгийн газрын төсвийн хуваарилалт, нээлттэй эдийн засгийн бодлогоор гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалалттай газар нутаг эсвэл барилга барихыг хориглосон газар нутгийг тодорхойлох гэх мэт болно. Стратеги нь бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх нарийвчилсан арга зам юм. Стратеги, хөтөлбөр, төслүүд нь салбарын болон салбар хоорондын тэргүүлэх чиглэлээрээ ялгаатай байдаг.

### *Хэрэгжилтийн бүтэц, зохион байгуулалт*

Хэрэгжилтийн бүтэц, зохион байгуулалт нь хөтөлбөр, төсөл эсвэл стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, арга замыг тодорхойлдог. Үүнд удирдлагын бүтэц, нийт оролцогчдын эрх үүрэг, хариуцлагыг зааж өгдөг.

### *Санхүүгийн эх үүсвэр*

Хөтөлбөр, төсөл эсвэл стратегийн төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тогтоосон байдаг.

### *Хэрэгжүүлэх хугацаа*

Дэвшүүлсэн зорилго, зорилтот түвшиндээ хүрэхийн тулд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн стратеги, хөтөлбөр болон төслийн хэрэгжих хугацааг тогтоосон байдаг.



**Тайлбар:** Олон улсын түвшинд Vision document буюу Хэтийн зорилтын баримт бичиг гэж нэрлэгддэг Үндэсний хөгжлийн төлөвлөгөө (ҮХТ) нь улс орон даяар хөгжил, дэвшил, хүн амын сайн сайхныг тасралтгүй сайжруулахын тулд тодорхой хугацаанд өргөн хүрээт зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Олон улсын гэрээ хэлэлцээр тухайлбал, Тогтвортой хөгжлийн зорилгуудад нэгдсэнээр тухайн орны ҮХТ-ний бодлого, зорилт, стратегийн үзүүлэлтэд өөрчлөлт орж болно. ҮХТ-ний дагуу салбарын бодлогыг төлөвлөдөг.

Монгол Улсад бодлого боловсруулагч нар нь шат бүртээ төлөвлөлтийн чухал үүрэг, хариуцлага хүлээдэг ба тэдний ажлын чиг үүргийн талаар Шигтгээ 1.3-т товчхон танилцуулж байна.

### Шигтгээ 1. 3 Бодлого төлөвлөлтийн албан хаагчийн чиг үүрэг

Бодлого төлөвлөлтийн албан хаагч нь	
<b>Хаана</b>	Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн захиргааны байгууллага
<b>Юу хийдэг</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийгэм-эдийн засгийн асуудал, бэрхшээлийг тодорхойлох</li> <li>• Бодлогын хувилбаруудыг боловсруулах</li> <li>• Бодлогын оновчтой хувилбарыг тогтоох</li> <li>• Бодлого төлөвлөх</li> </ul>
<b>Хэнтэй хамтарч</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Яамд, Засгийн газрын агентлаг</li> <li>• Орон нутгийн засаг захиргаа, агентлаг</li> <li>• Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага</li> <li>• Хоёр талт болон олон талт олон улсын хөгжлийн түншүүд</li> <li>• Хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгсэл</li> <li>• Иргэд, олон нийт</li> </ul>
<b>Юунд тулгуурлан</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Мэдлэг, дадлага</li> <li>• Техникийн хүчин чадал</li> <li>• Улс төрийн амлалт</li> <li>• Бүтэц, зохион байгуулалт</li> <li>• Хөтөлбөр, төсөв</li> <li>• Удирдлагын арга хэрэгсэл, тогтолцоо</li> </ul>
<b>Юуны төлөө</b>	Урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэхийн төлөө ажиллах



### 1.5 Тогтвортой хөгжил ба бодлого төлөвлөлт

Монгол Улсад аливаа бодлогыг төлөвлөхдөө тогтвортой хөгжлийн зарчимд суурилсан байх нь нэн чухал байна. Иймд хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийгэм, эдийн засаг, байгаль орчны нийтлэг зорилтуудыг тусгасан байх шаардлагатай.

Тогтвортой хөгжилд хүрэх нэгэн оновчтой арга зам бол ногоон эдийн засгийн загвар юм. Энэ нь байгаль орчны эрсдэл, доройтол, байгалийн нөөцийн хомсдлыг бууруулахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн хөгжлийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засаг юм.

Үр дүнд суурилсан удирдлагыг хэрэгжүүлснээр тогтвортой хөгжилд хүрэх боломжтой. Үр дүнд суурилсан удирдлага нь төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн “Бодлогын мөчлөг” гэсэн загварт нийтлэг суурилдаг. Зураг 1.1-д энэхүү бодлогын мөчлөгийг үзүүлэв.



Зураг 1. 1 Үр дүнд суурилсан удирдлага<sup>2</sup>

<sup>2</sup>Эх сурвалж: Умард Ирландад Бодлого боловсруулах гарын авлага, Тэргүүн сайд болон Тэргүүн дэд сайдын ажлын алба, Умард Ирланд, [www.ofmdfni.gov.uk](http://www.ofmdfni.gov.uk)



Бодлого төлөвлөлтийн үйл явц нь үр дүнд суурилсан байхаас гадна дэлхий нийтийн болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хурдацтай хөгжил, улс орны онцлогийг тусгасан байхын тулд ирээдүйд чиглэсэн, гадаад орчинтой уялдсан, нотолгоонд тулгуурласан, тэгш хүртээмжтэй, хамтарсан, сургамжаас суралцсан, олон нийтэд үр өгөөжтэйгөөр хүрсэн, хэрэгжилт нь цаг тухай бүрт нь хянагдан, үнэлэгдэж өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн байх шаардлагатай байдаг. Энэ шаардлагыг Шигтгээ 1.4-д харуулав.

## Шигтгээ 1. 4 Сайн бодлого төлөвлөлтийн 10 шинж чанар

### 1. ИРЭЭДҮЙД ЧИГЛЭСЭН

Тухайн бодлогын хүрэх үр дүнг ойлгомжтой тодорхойлсон байх шаардлагатай. Ингэхдээ нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын өнөөгийн хандлага, цаг уурын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, статистик мэдээлэлд суурилан наад зах нь ирэх 5 жилд гарах үр нөлөө, үр дагаврыг таамагласан зураглалыг гаргах хэрэгтэй. Энэ нь дараах шинжтэй:

- зорьж буй үр дагаврыг эхний үе шатанд боловсруулах,
- болзошгүй эрсдлийг урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулахдаа авч үзэх.

### 2. ГАДААД ОРЧИНТОЙ УЯЛДСАН БАЙХ

Бүс нутаг, улс орон, олон улсын нөхцөл байдал, нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзэн туршлагаас нь суралцах. Энэ нь дараах шинжтэй:

- олон улсын туршлагаас суралцах, бусад улс орнууд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг судлах;
- Монгол Улсын хувьд гарч болох онцлог байдал, зөрүүг хүлээн зөвшөөрөх.

### 3. ШИНИЙГ ЭРЭЛХИЙЛСЭН, УЯН ХАТАН БҮТЭЭЛЧ БАЙХ

Уян хатан, шинийг эрэлхийлсэн, нэгэнт тогтсон арга замын талаар асуулт тавьсан, шинэ бүтээлч санааг дэмжиж, шаардлагатай үед арга барилаа тогтмол сайжруулах. Үйл явц нь холбогдох оролцогч талууд, ялангуяа нийгмийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа бүлгийн дуу хоолойг сонсох боломжийг нээлттэй байлгах. Эрсдлийг тодорхойлон, сайн удирддаг байх. Энэ нь дараах шинжтэй:

- хуучин арга барилаас илүү шинэлэг арга барилд (үзэл бодлоо уралдуулах хурал хийх гэх мэт) суралцах,
- хүссэн үр дагавраар амжилтыг үнэлэх,
- эрсдэлийг үнэлэн, үр дүнтэй удирдах,
- шинэ санааг дэмжсэн удирдлагын бүтэц, багийн үр дүнтэй ажиллагаа явуулах алхмыг хийдэг байх,
- бодлого боловсруулах багт холбогдох талуудыг оролцуулдаг байх,
- байгалийн нөөцийг зохистой ашиглах.

### 4.НОТОЛГООНД ТУЛГУУРЛАХ

Бодлого боловсруулагчдын зөвлөмж, шийдвэр нь олон эх үүсвэрээс авсан хамгийн сайн нотолгоонд суурилсан байдаг. Нийт оролцогчид бодлого боловсруулалтын эхний үе шатнаас эхлэн боловсруулж дуусах хүртэл бүхий л шатанд оролцоно. Энэ нь дараах шинжтэй байна:

- өмнөх судалгаанд суурилах,
- шинээр судалгаа явуулах,
- холбогдох мэргэжилтэнтэй зөвлөлдөх, дотоод болон гадаад зөвлөхүүдтэй санал солилцох,
- өртөг, зардлыг зөв тооцож үнэлсэн хувилбаруудыг авч үзэх.

### 5. ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙХ

Бүх оролцогчдын эрэлт, хэрэгцээг хангах бодлогын шууд болон шууд бус нөлөөллийг авч үзэх. Энэ нь дараах шинжтэй:



- үйлчилгээ үзүүлэгч, хэрэгжүүлэгчидтэй зөвлөлдөх,
- эцсийн хүлээн авагч буюу бодлогын нөлөөг хүртэх хүмүүстэй зөвлөлдөх,
- нөлөөллийн үнэлгээг хийх,
- эцсийн хэрэглэгчид болон үйлчилгээ хүргэгч нараас бодлогын талаар санал авах, байр суурийг сонсох.

#### **6. ХАМТАРСАН БАЙХ**

Стратегийн зорилтыг байгууллагын чиг үүргээс илүү чухалчлан, бодлогын ёс зүй, ёс суртахуун, эрх зүйн суурийг бүрдүүлж бодлогын нэгдсэн, цогц байдлыг хангах. Салбар хоорондын зорилтыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын зохистой тогтолцоог гаргах. Энэ нь дараах шинжтэй:

- хамгийн түрүүнд салбар хоорондын зорилтыг нарийвчлан тодорхойлох,
- бусад газруудтай хамтран ажиллах зохион байгуулалтыг тодорхойлж, сайжруулах,
- үр дүнтэй хамтран ажиллахад учрах саад, бэрхшээл, түүнийг даван туулах арга замыг тусгах,
- хэрэгжилтийг бодлого боловсруулах үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болгосон байх.

#### **7. СУРГАМЖААС СУРАЛЦСАН БАЙХ**

Сургамжаас суралцах арга барил нь дараах шинжтэй:

- авсан сургамж, шилдэг туршлагын талаар мэдээллийг түгээн дэлгэрүүлэх,
- сургамжаас суралцсаны үр дүнд бодлого боловсруулагч ямар арга хэмжээ авсан тухай мэдээлэл солилцох,
- алдаатай бодлогын нөлөө болон хэрэгжилтэд гарсан алдаа хоёрыг нарийн ялган зааглах.

#### **8. ХАРИЛЦАА**

Олон нийтэд бодлогыг хэрхэн хүргэх асуудлыг авч үзэх. Энэ нь дараах шинжтэй:

- олон нийттэй харилцах болон хүргэх стратегийг боловсруулан хэрэгжүүлэх,
- эхний үе шатнаас эхлэн удирдлагыг мэдээллээр хангах.

#### **9. ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

Бодлогын үр дүнтэй байдалд системтэй үнэлгээ хийхийг бодлого боловсруулах үйл явцад суулгаж өгөх. Энэ нь дараах шинжтэй:

- үнэлгээний зорилтыг эхнээсээ нарийвчлан тодорхойлох,
- амжилтын шалгуурыг тодорхойлох,
- үнэлгээний аргачлалыг тогтоох,
- бодлогын эцсийн үр дагаврыг үнэлэх аргачлалыг турших.

#### **10. ХЯНАЛТ ТАВИХ**


Хэрэгжүүлж буй бодлого нь шийдвэрлэхээр зорьж буй асуудалд чиглэгдэж чадаж байгаа эсэхэд гарч болох өөрчлөлтийг авч үзсэнээр тогтмол хяналт тавих. Энэ нь дараах шинжтэй:

- хэрэгжилтийг зохистой хэмжих үзүүлэлт бүхий байнгын хяналтын хөтөлбөртэй байх,
- үйлчилгээ үзүүлэгч болон эцсийн хэрэглэгчдээс бодлого боловсруулагч нарт санал бодлоо хүргэх механизмтай байх,
- давхардсан эсвэл амжилтгүй бодлогыг зогсоох.

Бодлогын мөчлөгийн үр дүнд суурилсан бодлого төлөвлөлтөд Зураг 1.2-т үзүүлсэн үйл ажиллагаа харилцан хамааралтай. Шийдвэр гаргах үйл явцыг ерөнхийд нь харуулсан зураглалыг Зураг 1.2-оос харж болно.



**Зураг 1. 2. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн нийтлэг зураглал**







# БҮЛЭГ - 2

---



## НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

---



## БҮЛЭГ ХОЁР. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

**Тойм:** Энэ бүлэг нь нөхцөл байдал болон асуудлыг хэрхэн шинжлэх талаарх үндсэн логик, арга замуудыг заахын зэрэгцээ тулгамдаж буй асуудлыг баримт, нотолгоогоор хэрхэн баталгаажуулах, Монгол Улсад хэрэглэгдэж буй мэдээллийн системийг хэрхэн ашиглах талаарх мэдлэгийг олгох зорилготой. Мөн дискриптив статистикийн талаарх анхан шатны ойлголтыг агуулсан. Тусгай сэдвүүд хэсэгт түүвэр судалгааг хэрхэн хийх, тэгш бус байдлыг хэрхэн хэмжих талаар тайлбарласан. Эдийн засгийн шинжилгээнд ашиглагддаг гол үзүүлэлтүүдийг энэ бүлгийн хавсралтад оруулсан болно.

### 2.1 Нөхцөл байдлын шинжилгээ: суурь судалгаа, бодлогын хувилбарууд

Өмнөх бүлэгт бодлогыг бодит үйл ажиллагаа болгон хувиргахад төлөвлөгөө шаардлагатай байдгийг дурдсан. Гэвч аливаа төлөвлөгөөг боловсруулахаас өмнө нийгмийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг тал бүрээс нь нарийвчлан судалж, ул суурьтай үндэслэл дэвшүүлэх нь чухал юм.

Нөхцөл байдлын шинжилгээ нь тухайн улс орны үндэсний хэмжээний, салбарын, бүс нутгийн, тодорхой хүн амын бүлгийн хэмжээнд хийгдэж болох тул судалгаа, шинжилгээнд хэрэглэж буй арга, аргачлал нь уян хатан байх шаардлагатай байдаг.

Зураг 2. 1 Нөхцөл байдлын шинжилгээний схем



Тайлбар: алхам 4-ийг гуравдугаар бүлэгт тайлбарлах ба бусад алхмыг энэ бүлэгт авч үзнэ



## 2.2 Асуудлын шинжилгээ

Аливаа асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг дэвшүүлэхээс өмнө уг асуудал гарах болсон шалтгаан, түүнээс бий болсон үр дагаварыг сайтар судлах шаардлагатай. Иймд доорх алхмуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлж, асуудлыг гүнзгийрүүлэн судлах,
2. Оролцогч талууд болон эмзэг бүлгийн төлөөллийг тодорхойлж тэдэнтэй санал солилцож тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг шинжлэх,
3. Асуудлын шийдлийг гаргахын тулд судалгаа шинжилгээ хийх, түүнд шаардлагатай мэдээ, мэдээлэл, нотолгоог цуглуулах,
4. Асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах,
5. Эрсдэлийг үнэлэх,
6. Бодлогын хувилбаруудыг харьцуулах зэрэг болно.

Бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүд тулгарч буй хүндрэл бэрхшээлийн шалтгаан, үр дагавар, цар хүрээг итгэл төрүүлэхүйц үндэслэлтэй гаргаж ирснээр шийдвэр гаргагчдын түвшинд бодлогын хувилбаруудыг авч үзэх нөхцөл бүрдэх юм. Шаардлагатай бол олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар уг асуудлыг анхаарлын төвд оруулах боломжтой. Гэхдээ асуудлын мөн чанарыг сайтар ойлгоогүй бол түүнийг шийдвэрлэхээр дэвшүүлэн тавьсан бодлогын зорилго нь хүссэн үр дүнд хүрэхгүй болох аюултайг анхаарах хэрэгтэй.

Шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудлыг тодорхойлохдоо үндсэн асуудал болон түүнээс илэрч буй шинж тэмдэгийг ялгаж ойлгох хэрэгтэй. Шинж тэмдэг гэдэг нь асуудлаас бий болж байгаа үр дагавар юм. Доорх жишээ нь төлөвлөлтийн мэргэжилтэн асуудлыг түүнээс илрэн гарч буй шинж тэмдгээс хэрхэн ялгаж болохыг тайлбарлана.

### Шигтгээ 2. 1 Асуудлыг түүний шинж тэмдгээс ялгах нь–Асуудлын модны жишээнүүд

- **Жишээ 1.** Тойргийн иргэд сүүлийн үед хүүхдүүд гэдэсний өвчнөөр өвдөж байгаа тухай сонгогдсон төлөөлөгчиддөө гомдоллов. Энэ нь асуудлын шинж тэмдэг болохоос жинхэнэ асуудал нь биш юм. Гэдэсний өвчин нь бохирдсон ус, эрүүл ахуйн шаардалга хангаагүй хүнсний бүтээгдэхүүн, эсвэл орон нутагт гэдэсний халдварт бактери байгаагаас гарсан байж болох юм. Өвчний оношийг (өөрөө хэлбэл асуудлыг) зөв тодорхойлох нь тохирсон эмчилгээг сонгоход амин чухал билээ. Жишээлбэл, ус, хоолны чанарыг шалгах гэх мэт юм.

- **Жишээ 2.** Ажилтнуудын дунд явуулсан судалгаагаар тухайн ажлыг гүйцэтгэх журам ойлгомжгүй байгаа нь ажиглагдсан. Энэ шинж тэмдгээс харахад доор дурдсан асуудлын аль нэг нь байж болох юм. Үүнд: Удирдах ажилтан журмын тайлбарыг сайн хүргэж чадаагүй, журмууд хоорондоо зөрчилдөөнтэй, журмыг ойлгоход төвөгтэй, ажилчид сайн мэргэшээгүй. Эдгээрийн аль нь жинхэнэ асуудал болохыг тогтоосноор шийдлийг тодорхойлж болно.





- **Жишээ 3.** Сургуулийн сурагчдын дүн буурч байна. Энэ шинж тэмдэгт дараах асуудлууд нөлөөлж байж болно. Үүнд: Гэр бүлийн тогтворгүй байдал, суралцах орчин тав тухгүй, багш нарын ур чадвар сул, хичээлийн хөтөлбөр өөрчлөгдсөн зэрэг байж болно. Асуудал нь нийгэм, эдийн засгийн шинж чанартай бол боломжит хувилбар нь боловсролын салбараас нийгмийн үйлчилгээнд илүү анхаарах эсвэл тухайн нөхцөл байдлаас хамаарч боловсрол, нийгмийн салбарыг хамтад нь авч үзсэн бодлогын хувилбар байх боломжтой.
- **Жишээ 4.** Өвчтөн эмч дээр ирэн миний нүд бүлцийгээд, хамар битүүрээд байна гэжээ. Гэвч энэ нь илэрч буй шинж тэмдэг болохоос гол асуудал нь биш юм. Энэ шинж тэмдгийн цаана ханиад хүрэх, харшил хөдлөх, шороо тоосноос болох гээд олон шалтгаанууд байдаг.

Нөхцөл байдлын эсвэл асуудлын шинжилгээг хийхэд мэдээллийн олдоц, нотолгооноос хамаарч тоон болон чанарын мэдээлэл цуглуулах зорилгоор асуулга явуулах мөн шаардлагатай үед газар дээр нь очиж асуудалтай танилцах зэрэг аргуудыг хэрэглэх шаардлагатай болдог. Ихэнх тохиолдолд нэгээс олон аргыг хослуулан ашигладаг.

### 2.3 Арга зүй

#### Асуудлын мод<sup>3</sup>


Нөхцөл байдлын шинжилгээ хийх олон аргачлал байдаг ч нийгэм, эдийн засгийн болон байгаль орчны шинжилгээ хийхэд хамгийн түгээмэл ашиглагддаг нь Зураг 2.2-д үзүүлсэн Асуудлын мод юм. Асуудлын мод нь тодорхой асуудлын шалтгаан, үр дагаваруудыг бүхэлд нь харах боломж олгодог. Энэ нь тухайн асуудлын онцлог шинжийг гаргаж ирдэг тул хөгжлийн төлөвлөлтийн үйл явцад чухал юм. Асуудлын модны шинжилгээг хийхдээ өнөөгийн тулгарч буй асуудлын шалтгааныг тодорхойлсноор асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг олдог. Асуудлын мод нь гол асуудлыг бий болгож буй хэд хэдэн үндэс буюу шалтгаан, модны мөчир буюу үр дагаварын харилцан хамаарлыг гаргаж ирснээр нийгмийн өмнө тулгамдаж буй асуудлыг зөв тодорхойлох боломжийг бүрдүүлдэг. Мөн одоогоор хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд шийдвэрлэгдээгүй хүчин зүйлсийг ч гэсэн энэхүү модны тусламжтайгаар тодорхойлж болно. Жишээ нь: Одоо хэрэгжиж буй дүрэм журам нь асуудлыг үүсгэж буй гол хүчин зүйл байж болох ч төлөвлөсөн бодлогын хүрээнд шийдвэрлэгдэхээргүй байж болно. Энэ нь бодлогын зорилтод хүрэхэд саад болж болох юм. Өөрөөр хэлбэл, мөрдөгдөж буй дүрэм, журмыг өөрчлөх нь бодлогын цар хүрээнээс давсан асуудал бол асуудалд шинжилгээ хийж буй хүмүүс энэхүү хүчин зүйлийг бодлогын хувилбартаа харгалзаж үзэх хэрэгтэй.

<sup>3</sup> See, <http://www.toolkitsportdevelopment.org/html/resources/91/910EE48E-350A-47FB-953B-374221B375CE/03%20Problem%20tree%20analysis.pdf>



Ямар ч асуудлын модны шинжилгээнд оролцогч талуудыг хянуур, зөв тодорхойлох нь маш чухал юм. Энэ талаар дөрөвдүгээр бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно.


**Зураг 2. 2 Асуудлын модны загварын үндсэн ойлголт**



**Асуудал:** Нэгэн хөгжиж буй улсын тодорхой бүс нутагт анхан шатны боловсролын чанар яагаад муу байгаа жишээг авч үзье. Зураг 2.3-т үзүүлсэнчлэн энэхүү асуудлыг “Асуудлын мод”-ны тусламжтайгаар шинжилж болно. Анхан шатны боловсролын чанар муу байх нь боловсролын тогтолцоо доголдолтой байгааг илтгэнэ. Боловсролын чанар муу байгаа шалтгааныг ойлгохын тулд түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох хэрэгтэй. Эдгээр хүчин зүйлс нь сургуулийн нөхцөл муу, багш нарын ур чадвар сул, анхан шатны боловсролд хангалттай анхаарал тавьдаггүй гэх мэт байж болно. Энэ бүхэн нь сургуулийн боловсролд анхаарал тавьдаггүйгээс тус салбарт төсөв бага хуваарилсны үр дүнд үүссэн байж болно. Энэ тохиолдолд боловсролын үр дүн муу байгаагийн суурь шалтгаан нь багш нарын цалин бага, боловсролд хангалттай ач холбогдол өгөөгүй явдал юм. Иймд асуудлын суурь шалтгааныг засалгүйгээр боловсролын салбарын үр дүн сайжрахгүй.



Зураг 2.3 Сургуульд хамрагдалт: Бага сургуулийн жишээ



**Шийдэл:** Энэ бол харьцангуй хялбар жишээ бөгөөд хариулт нь Асуудлын модноос харагдаж байна. Тухайлбал:

1. Эцэг эхчүүд үр хүүхдүүдээ сургуульд явуулах сонирхлыг нэмэгдүүлж болно. Хөдөлгөгч хүч нь нийгмийн ажилтан, багш нар байна.
2. Зарим улсад амжилттай хэрэгжсэн тодорхой болзлыг (тухайлбал, хүүхдүүдээ сургуульд явуулсан, вакцинд хамруулсан гэх мэт) хангасан зорилтот өрхүүдэд (ядуу) бэлэн мөнгө олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж болно. Хөдөлгөгч хүч нь орон нутгийн засаг захиргаа байна.
3. Нийлүүлэлт талаас: Багш нарын сургалтын орчинг сайжруулах, тэдний цалинг нэмэгдүүлэх, сургуулийн барилга, тохижилт, усан хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээг авах. Энэ нь төлөвлөлтийн үйл явцыг дараагийн түвшин буюу төсөв, үндэсний хөгжлийн үзэл баримтлалд боловсролын салбарыг чухалчилан авч үзэх зэрэг асуудалтай уялдуулах



хэрэгтэйг харуулна. Хөдөлгөгч хүч нь боловсролын яам болон сангийн яам байна.

Асуудлын модны нэг давхаргаас дараагийнх руу шилжихэд оролцогч талууд ч бас өөрчлөгдөнө. Жишээ нь багш болон нийгмийн ажилтнаас боловсролын салбарын төлөвлөлтийн мэргэжилтэн, сангийн яамны мэргэжилтэн гэх мэт.

## **Жишээ 2. 1 Асуудлыг илрүүлэх болон шийдвэрлэх арга замыг олох нь**

- Учир шалтгаануудыг нь шинжилж, улмаар асуудлын мөн чанарыг илрүүлэх олон нарийн төвөгтэй арга замууд бий. Эдгээр нь макро асуудлуудын хоорондоо хамааралгүй мэт харагдах микро шалтгаануудыг ухаж ойлгоход хэрэг болдог. Уг аргууд нь ихэвчлэн шугаман бус, кибернетикт суурилсан, салбар дундын хандлагыг баримталсан байдаг бөгөөд шинжлэх ухааны болон нийгмийн аливаа асуудалд хамааралтай зохицуулалтын систем, бүтэц болон саад бэрхшээлийг илрүүлэн судлахад тусалдаг. Дараах жишээгээр хөргөлтийн систем нь эрчим хүчнээс хамааралтай байдаг нэгэн улсын энгийн иргэдийн амьдралд дэлхийн дулаарал хэрхэн нөлөөлж буйг тайлбарлав.
- Ихэнх улсуудад халаалт болон хөргөлтийн зориулалтаар эрчим хүчийг их хэмжээгээр үр ашиггүй зарцуулдаг ба энэхүү байдал нь дэлхий нийтийн нэг томоохон асуудал болоод байна.
- Зураг 2.4-т байшингийн муу дизайн нь дулаан хадгалдаггүй, хөргөлтийн төхөөрөмжид стандарт баримтлахгүй, хэрэглэгчдэд цахилгаан хэмнэх мэдлэг олгохгүй, цахилгааны бодит бус бага төлбөрийн зохицуулалт зэрэг нь хэрхэн эрчим хүчинд хэмнэлтгүй байдлыг өөгшүүлж, улмаар уур амьсгалын өөрчлөлтийг нэмэгдүүлж буйг тусган харуулсан. Мөн эдгээр шалтгаанууд нь уур амьсгалын өөрчлөлтөнд хэрхэн нөлөөлж буйг үе шаттайгаар харуулсан. Ийм асуудлыг шийдвэрлэхэд салбар хоорондын уялдааг хангасан бодлого явуулж, олон оролцогч талуудыг хамруулах хэрэгтэй болдог.










**Зураг 2.5 Цогц асуудлыг шийдэх: Уур амьсгалын өөрчлөлтийг багасгах, удаашруулах<sup>5</sup>**



Дээрх жишээнд:

1. Хөргөлттэй холбоотой цахилгааны эрэлтийг бууруулахын тулд агааржуулагч төхөөрөмжийг илүү эрчим хүчинд хэмнэлттэй байх шаардлагыг тавих. Иймд нийлүүлэлт талд илүү их хяналт тавьж, үйлдвэрлэгчид болон импортлогчдыг үр ашигтай төхөөрөмж үйлдвэрлэх, импортлохыг шаардах, дэмжих хэрэгтэй.
2. Хөргөгч төхөөрөмжийг зөвхөн нэн шаардлагатай үед хэмнэлттэйгээр хэрэглэх. Цахилгааны үнэ тарифийг бодитойгоор тогтоох нь өрхийн болон байгууллагын хэрэглэгчдийг эрчим хүчний хэрэглээндээ зохистой хандаж, гадаа их халуун үед л агааржуулагчаа ажиллуулдаг болгох юм.

<sup>5</sup> Эх сурвалж: "Асуудлын мод, шийдлийн модны шинжилгээ" – [http://evaluationtoolbox.net.au/index.php?option=com\\_content&view=article&id=28&Itemid=134](http://evaluationtoolbox.net.au/index.php?option=com_content&view=article&id=28&Itemid=134)



3. Барилгын архитекторын түвшинд барилгыг гаднаас халууныг амар нэвтрүүлдэггүй, доторх орчныг харьцангуй сэрүүн байлгахаар загварыг гаргах хэрэгтэй. Жишээ нь: хууль, стандартад барилгын норм нормативыг шинэчлэн, дүрэм журмыг чангатгаснаар цаг агаарыг мэдэрч байгалийн агааржуулалтыг хийдэг барилгын загварыг дэмжиж, нэвтрүүлэх боломжтой. Байгалийн агаар солилцоог тэтгэснээрээ байшин барилга байгалийн агааржуулалтаар сэрүүн байж, улмаар эрчим хүчний хэрэглээг бууруулна.
4. Эрчим хүчийг хэмнэх, эрчим хүчний хэмнэлт хэрхэн уур амьсгалд нөлөөлж, эргээд хүн төрөлхтний хойч үеийг оршин тогтноход нөлөө үзүүлэх талаар хэрэглэгчдэд мэдээлж, мэдлэг олгох хэрэгтэй. Иймд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хэрэглэгчдийн холбоо, нийгэмлэгүүдийг бий болгож, ажиллуулах зэрэг үйл ажиллагааг зохион явуулах.

Энэ бүхэн эрчим хүчний эрэлтийг багасгаж, ингэснээр эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор түлш шатаах нь багасч, хүлэмжийн хийн ялгаралт бууран, уур амьсгалын өөрчлөлтийг удаашруулах билээ. Уг жишээг халаалтын асуудалд ч хэрэглэж болох бөгөөд эцсийн үр нөлөө нь ижил юм.

#### 2.4 Макро түвшний төлөвлөлт

Дээр жишээ болгосон асуудлын шийдэл нь тодорхой салбарт хамааралтай, харьцангуй хялбар тодорхойлогдсон. Харин улс үндэсний төлөвлөлтийг хийхэд чиглэсэн нөхцөл байдлын шинжилгээ нь эдийн засаг, нийгмийн макро түвшний олон үзүүлэлтүүдийг нэгтгэн цуглуулахаас эхэлдэг ба Шигтгээ 2.2-т үзүүлэлтүүдийн жагсаалтыг тоймлон бичив.

#### Шигтгээ 2. 2 Макро түвшний төлөвлөлтийн Нөхцөл байдлын шинжилгээний зарим түгээмэл сэдэв

- Хүн ам, газар зүй
- Байгалийн баялаг
- Дэд бүтэц
- Засаглал, төрийн санхүү, алдагдал (төсвийн эсвэл урсгал тэнцлийн), инфляци, гэх мэт
- Өсөлтийн үйл явц, ДНБ-д салбарын эзлэх хувь
- Төвлөрөл, төвлөрлийг сааруулах
- Улс орны өмнө тулгарч буй гол бэрхшээл, тухайлбал, ядуурал түүний урт хугацаанд оршиж буйн шалтгаан (эрэлт болон нийтлүүлэлтийн хүчин зүйлсээр), бүс нутгийн ялгаа
- Хүмүүн капитал- өнөөгийн байдал, чадамж
- Эрүүл мэнд, насжилт, төрөлт, хүүхдийн эндэгдэл
- Шинжлэх ухаан, технологи
- Байгаль орчин
- СВОТ (давуу тал, сул тал, боломж, аюул) шинжилгээ



## ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Улаанбаатар хотын замын хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдалд шинэжилгээ хийх.

**Дасгал 2:** Үндсэн үзүүлэлтүүд: Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ 4,000 ам.доллар, төсвийн орлого ДНБ-ий 40 хувь, төсвийн алдагдал ДНБ-ий 8 хувь орчим. Индонезийн хувьд энэ үзүүлэлтүүд-нэг хүнд ногдох ДНБ 2500 ам.доллар, төсвийн орлого ДНБ-ий 18 хувь, төсвийн алдагдал ДНБ-ий 2.5 хувь тус тус байна.

Индонези улстай харьцуулахад Монгол Улсын ДНБ-д эзлэх төсвийн орлого ихээхэн өндөр ч төсвийн алдагдал өндөр байгаад шинжилгээ.

**Дасгал 3:** Тухайн аймагт хүүхдийн эндэгдэл улсын дунджаас дээгүүр байна. Энэ аймагт уул уурхайн үйл ажиллагаа шинээр явагдаж эхэлсэн учраас нэг хүнд ногдох ДНБ өндөр, эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз бусад аймгийн түвшинд байна. Нялхсын эндэгдэл хурдацтай буурахгүй байгаагийн шалтгааныг шинжлэх.

## 2.5 Мэдээллийг шинжлэх

### Мэдээлэл гэж юу вэ?

Мэдээлэл гэдэг нь хувьсагчдын багц юм. Мэдээлэл нь тоон болон чанарын, эсвэл туршлага болон ажиглалт байж болно. Мэдээлэл нь янз бүрийн хэлбэрээр байж болдог. Жишээ нь: Асуулгын бөглөгдсөн хуудаснууд, судлаачийн бичсэн тэмдэглэл зэргийг **анхан шатны мэдээлэл** гэдэг. Эдгээр мэдээллийг уншиж болохоор ойлгогдохуйц хэлбэрт оруулахаас нааш бодлого судлаач нарт хэрэгтэй мэдээлэл болж харагдахгүй байх талтай. Төлөвлөлтийн мэргэжилтнүүд болон оролцогч талуудад хэрэгцээтэй агуулгыг тусгасан байхаар эдгээр мэдээллийг системтэйгээр боловсруулж, танилцуулах нь аливаа шинжилгээг хийх урьдач нөхцөл юм. Ийм мэдээллийг **боловсруулсан мэдээлэл** (өөрөөр хэлбэл үзүүлэлтүүд, индексүүд, цуваа болон бусад хэлбэрээр илэрхийлсэн) гэж нэрлэдэг. Энэхүү гарын авлагад голлон яригдах тоон мэдээллийг ойлгомжтой болгохын тулд *нэгтгэсэн, индексжүүлсэн, эрэмбэлсэн, хөрвүүлсэн, давтамжийг тархаан харуулсан болон хүснэгтэлсэн* гэх мэт төрөл бүрийн хэлбэрт хувиргасан байдлаар танилцуулав.

**Анхан шатны болон боловсруулсан мэдээллийн жишээ:** Ажилгүйдлийн түвшинг тооцох асуудлын хувьд тухайн хугацаанд ажилгүй байгаа хүний тоог (энэ нь анхан шатны мэдээлэл байх ба хэдэн мянгаар илэрхийлэгдэнэ) гаргаж, эдгээрийг нэмнэ (үүнийг “мета” мэдээлэл гэдэг). Эцэст нь энэхүү нийлбэр тоог нийт ажиллах хүчний тоонд харьцуулж 100-аар үржүүлснээр ажилгүйдлийн түвшин (үзүүлэлт) гарна.

Мэдээлэл нь асуудал хэр хэмжээтэй буйг тооцоолоход хэрэглэгдэх үндсэн үзүүлэлтүүд юм. Шинжилгээ хийх явцад хэмжээ болон харьцаа аль аль нь чухал байдаг. Мэдээллийн төрөл болон эдгээрээс харж болох утга санааг дараах жишээнүүдээр илэрхийлэв.



**Жишээ 1:** Хүн ам зүйд, хэрэв хэн нэгэн судлаач Бангладешт 20,000 хүүхэд эндсэн тухай мэдээлэл олвол “харамсалтай зүйл болжээ” гэж л дүгнэх байх. Гэтэл хэрэв асуулт, хариулт нь дээрх тооноос гадна хэдий насны хүүхдүүд, ямар хугацааг хамарсан мэдээлэл болох, хэдэн хүүхэд төрсний хэд нь амьдарсан, хэд нь эндсэн зэрэг тоо баримтууд өгөгдсөн бол бидний нэрлэж заншсан “Нялхсын эндэгдлийн түвшин” эсвэл “5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин” зэрэг индексийг тооцож болно.

**Жишээ 2:** Зах зээлийн судалгаанд нэг киллограмм цөцгийн тосны үнэ 10 ам.доллар гэсэн мэдээлэл бодлого судлаачдын хувьд ямар нэг утга санааг илтгэхгүй (харин худалдан авагчдад хэрэгтэй мэдээлэл) байж болно. Гэхдээ тухайн бүтээгдэхүүний үнийг өмнөх жилийнхтэй нь харьцуулбал уг бүтээгдэхүүний үнийн өсөлтийг (инфляци) харуулах үзүүлэлт болно.

**Жишээ 3:** Хэрэв гамшгийн үед 1,000 хүн үерийн улмаас нас баржээ гэж мэдээлбэл энэ тоо нь өөрөө аюултай нөхцөл үүссэнийг илтгэнэ.

**Жишээ 4:** Хэрэв 6 сая хүн амтай улсад ажилгүйдэл 60 хүнээс 120 хүн болж нэмэгдвэл хэдийгээр 100% өссөн ч нэг их аюултай байдлыг илэрхийлэхгүй.

Иймд мэдээллийг илэрхийлэхдээ онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

## 2.6 Тогтмол ба урсгал хувьсагчид

Мэдээллийг хэрхэн шинжлэх талаар танилцуулахаас өмнө шинжилгээ хийхэд хэрэглэгддэг ‘тогтмол’ болон ‘урсгал’ гэсэн ойлголтыг тайлбарлъя. Тогтмол хувьсагч нь тодорхой нэг цаг үед хэмжигддэг (жишээ нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар). Урсгал хувьсагч өгөгдсөн тодорхой хугацааны турш хэмжигддэг. Барилга, үйлдвэр, нисэх буудал, зам бол тогтмол, харин орлого, нэмүү өртөг, ДНБ бол урсгал хувьсагч юм. Тогтмол болон урсгал хувьсагчдыг хооронд нь шууд харьцуулж, тэгшитгэж, нэмж эсвэл хасч болохгүй. Харин тогтмол болон урсгал хувьсагчдын харьцааг олох, тэдгээрийг үржүүлэх, хуваах боломжтой. Хэдийгээр нэг ижил нэгжээр хэмжсэн мэт харагдавч, тогтмол болон урсгал хувьсагчид нь хоорондоо адилгүй юм. Жишээ нь: баялаг ам.доллараар хэмжигдэх ч орлого нь жилд олсон ам.доллар, эсвэл сард олсон ам.доллараар хэмжигдэнэ. Өөр нэг жишээ: тухайн улсын тогтмол биет хөрөнгө нь 2012 оны 1 дүгээр сарын 1-нд 20 машин, харин 2013 оны 1 дүгээр сарын 1-нд 23 машин байсан гэвэл 2012 оны турш дахь цэвэр урсгал хөрөнгө оруулалт нь 3 машин болно.



## 2.7 Мэдээллийг хувиргах: Үзүүлэлт болон индексийг боловсруулах

**Хэрэглээ:** Үзүүлэлт болон индекс нь нийлмэл, цогц үзэгдлийн хандлага, төлөв, ижил төстэй байдлыг ойлгоход тусалдаг.

Үзүүлэлт нь төр засаг, бодлого боловсруулагчид болон нийгмийн зүгээс сонирхож буй үзэгдлийг дүрслэн харуулахаар боловсруулсан тоон илэрхийлэл юм. Энэ нь цуглуулсан (эдийн засаг, нийгэм эсвэл улс төрийн үйл явцтай холбоотой) мэдээллийг **нэг тоогоор** нэгтгэн үзүүлдэг статистик хэрэгсэл юм.

Индекс нь нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийг цаг хугацаа, орон зайд зэрэгцүүлэн харуулсан харьцангуй үзүүлэлтийн нэг хэлбэр юм. Судалж буй юмс үзэгдлийн элементүүдийг хамарсан байдлаар нь хувийн болон ерөнхий индекс гэж ангилдаг. Үзэгдлийн зөвхөн нэг элементийн өөрчлөлтийг харуулсан индексийг хувийн индекс, харин нийлмэл үзэгдлүүдийн бүх элементүүдийн дундаж өөрчлөлтийг харуулж байгаа бол ерөнхий индекс гэж нэрлэдэг. Юмс үзэгдлийн өөрчлөлтийг тооцохдоо тодорхой үеийг суурь үетэй харьцуулж индексийг гаргадаг.

Суурь утгыг ихэвчлэн 100 гэж үзэн тодорхой хугацаан дахь өөрчлөлтийг суурь утгад харьцуулна. Жишээ нь: тухайн жилийн хэрэглээний үнийн индекс суурь оноос 105 болсон байна гэдэг нь үнэ 5% өссөнийг харуулна.

Хөгжлийн шинжилгээнд “индексжүүлэх” гэдэг нь инфляцийг тооцсоны дараа хүмүүсийн худалдан авах чадварыг хадгалж үлдэхийн тулд аливаа орлогыг үнийн индексээр залруулах арга юм. Хоёр үндсэн төрлийн индексжүүлэлт бий.

Үзүүлэлтийг анхан шатны болон мета мэдээллийг боловсруулсны үндсэн дээр гаргаж авдаг ба энэ нь аливаа үзэгдлийг ойлгоход тусалдаг.

Үзүүлэлт болон индекс нь хоёулаа үзэгдлийг шууд хэмждэг, мөн үзэгдлийн хандлага эсвэл төлвийг илэрхийлж болно. Жишээ: сайн засаглалыг гэмт хэргийн гаралтын бага түвшин эсвэл хөрөнгө оруулалтын өндөр түвшингээр хэмжиж болно. Ингэж шинжлэхийг үзүүлэлтийг төлөөлүүлэн хэрэглэх гэж нэрлэдэг.

## 2.8 Нөхцөл байдлын шинжилгээнд хэрэглэгддэг дискриптив статистикийн товч танилцуулга

Цуглуулсан мэдээллийг боловсруулан хэрэглэх нь нөхцөл байдлын шинжилгээний чухал алхам билээ. Тухайн нөхцөл байдал болон асуудлын мөн чанараас хамаарч мэдээллийг боловсруулах төрөл бүрийн арга техникийг



ашиглаж байдаг. Заримдаа мэдээллийг хэдхэн төрөлд ангилан график дүрслэлээр үзүүлэлтүүдийг харьцуулах тун энгийн аргыг хэрэглэж болно. Гэтэл зарим тохиолдолд хугацаан цуваа байгуулах, регрессийн шинжилгээний хүчин зүйлсийн хамаарлыг тодорхойлох гэх мэт илүү нарийн төвөгтэй аргуудыг ч хэрэглэдэг. Энэхүү хэсэгт мэдээллийг боловсруулахад хамгийн түгээмэл ашигладаг аргуудыг танилцуулна.

## 2.9 Мэдээллийг бүлэглэх

Цуглуулсан анхан шатны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, зүй тогтлыг нь илрүүлэхийн тулд тэдгээрийг цэгцэлж нэгтгэн, тодорхой дараалалд оруулан ангилан төрөлжүүлснээр тодорхой үнэлэлт дүгнэлт хийж нөхцөл байдлын шинжилгээнд ашиглах түвшинд хүрнэ. Тоо мэдээллийг ямар нэг нийтлэг чанараар нь нэгэн төрлийн бүлгүүдэд хуваах үйл ажиллагааг бүлэглэлт гэдэг. Жишээ нь: Иргэний бүртгэлийн газар иргэдийн үнэмлэхийн мэдээллийг бүлэглэхдээ хүмүүсийг оршин суугаа хот, дүүргээр нь ялган ангилж болно.

Бүлэглэлтийн 4 үндсэн суурь байдаг. Үүнд:

1. *Чанарын суурь*: Хүйс, шашин шүтлэг, бичиг үсэг тайлагдалт, нийгмийн гарал үүсэл зэрэг шинж чанар нь мэдээллийг бүлэглэх суурь болно.
2. *Тоон суурь*: Тоон шинжүүд болох өндөр, жин, нас, орлого зэрэг нь мэдээллийг бүлэглэх тоон суурь болдог.
3. *Газарзүйн суурь*: Аймаг, сум, дүүрэг гэх мэт газарзүйн бүс, байршил нь бүлэглэлтийг хийх суурь болдог.
4. *Хугацаан суурь*: Үзэгдлийн тохиолдсон хугацаа (жил, сар, долоо хоног, өдөр г.м) нь мэдээллийг бүлэглэх суурь болдог.

### 2.9.1 Нэг хэв маягийн бүлэглэлт

Энэ нь судалж буй тоон мэдээллээ чанарын ганц шинж тэмдгээр нь нэг төрлийн төстэй бүлгүүд болгон хуваах арга юм. Жишээ нь: хөгжлийн түвшинг нэг хүнд ногдох ДНБ-ээр хэмждэг тул тухайн улсын дүүргүүдийн хүн амыг бүлэглэхдээ уг үзүүлэлтийг суурь болгон авна.

**Жишээ:** Хэрэв тухайн улс 330 дүүрэгтэй бол эдгээрийг нэг хүнд ногдох орлогоор нь бүлэглэснийг Хүснэгт 2.1-д харуулав.

**Хүснэгт 2. 1 Дүүргүүдийг нэг хэв маягаар бүлэглэх (нэг хүнд ногдох орлого)**

	\$1,000-аас доош	\$1,001-2,000	\$2,001-3,000	\$3,001-ээс дээш
Дүүргүүд	50	110	150	20



### 2.9.2 Хоёр хэв маягийн бүлэглэлт

Судалж буй тоон мэдээллээ чанарын хоёр шинж тэмдгээр нь бүлгүүд болгон хуваах арга юм. Жишээ: Хөгжлийн түвшинг хэмжихдээ тухайн дүүргийн нэг хүнд ногдох ДНБ болон насанд хүрэгчдийн боловсролын түвшинг суурь болгон бүлэглэж болно.

**Жишээ:** Хэрэв тухайн улс 330 дүүрэгтэй бол эдгээрийг нэг хүнд ногдох орлогоор нь бүлэглэснийг Хүснэгт 2.2-д харуулсан.

**Хүснэгт 2.2 Мэдээллийг хоёр хэв маягаар бүлэглэх**

Боловсрол/ Орлого	\$1,000-аас доош	\$1,001-2,000	\$2,001-3,000	\$3,001-ээс дээш
Доогуур	30	35	30	2
Дунд	15	40	58	4
Өндөр	5	30	62	14

### 2.9.3 Дундаж, медиан, моод

Дундаж, медиан, моодыг статистикийн шинжлэх ухаанд төвийн үзүүлэлтүүд гэж нэрлэдэг. Төвийн үзүүлэлтүүдийг зэргийн дундаж болон бүтцийн дундаж үзүүлэлт гэж хоёр ангилна. Зэргийн дундаж үзүүлэлтэд гармоник дундаж, геометр дундаж, арифметик дундаж, квадрат дундаж, куб дундаж ордог бол бүтцийн дундаж үзүүлэлтэд моод, медиан, квартил, децил, перцентил орно.

#### Арифметик дундаж

Нэгэн төрлийн үзэгдлийн нийтлэг шинж чанарыг төлөөлж чадах үзүүлэлтийг дундаж хэмжигдэхүүн гэнэ.

**Хэрэглээ:** Төлөөлсөн сонголттой холбоотой тоон мэдээллээс ганц тоон утга гаргах хэрэгтэй үед хамгийн их хэрэглэгддэг хэмжигдэхүүн нь дундаж юм. Тухайлбал, 21 аймгийн хүн амын дундаж наслалт г.м.

Энгийн арифметик дунджийн томъёо:

$$\bar{X} = \frac{\sum X}{n}$$

#### Жишээ:

2014 оны бүс нутгуудын тариалсан талбай, хураасан ургацын хэмжээ өгөгдсөн үед нэг га-гийн дундаж ургацын хэмжээг хэрхэн тооцохыг харъя.



**Хүснэгт 2. 3 Хураасан ургац, тариалсан талбай, бүс нутгаар**

Бүс нутаг	Тариалсан талбай, га	Хураасан ургац, тн,
Баруун бүс	17 509,4	52 120,0
Хангайн бүс	66 286,4	132 813,1
Төвийн бүс	294 270,4	569 608,6
Зүүн бүс	61 218,5	62 169,1

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ, [www.1212.mn](http://www.1212.mn)

Энгийн арифметик дундажийн томъёо ёсоор:

$$\bar{X} = \frac{\sum X}{n} = \frac{52120 + 132813.1 + 569608.6 + 62169.1}{17509.4 + 66286.4 + 294270.4 + 61218.5} = \frac{816710.8 \text{ га}}{439284.7 \text{ тн}} = 1.86 \text{ га/тн}$$

2014 онд улсын хэмжээнд нэг га-гийн дундаж ургац 1,86 тн байна.

**Медиан**

Утгуудыг нь өсөх эрэмбээр байршуулсан тоон түүврийг таллан хувааж буй хувилбарын утгыг медиан гэдэг. Өөрөөр хэлбэл, медиан нь тархалтын цувааг хоёр тэнцүү хэсэгт хуваадаг.

**Моод**

Тухайн түүврийн багцад хамгийн их давтагдаж буй хувилбарыг моод гэнэ.

**Жишээ:** Хөдөөгийн нэг хүнд ноогдох зарлагын цуваа өгөгдсөн ба моод, медианыг тооцъё.

**Хүснэгт 2. 4 Өрхийн нэг хүнд ноогдох зарлага**

Х-өрхийн нэг хүнд ноогдох зарлагын бүлэг	56000 хүртэл	56001-112000	112001-168000	168001-224000	224001-280000	280001-336000	336001-392000	392001-448000	448001-504000	504001-с дээш
f- өрхийн хувийн жин, %	10.4	32.7	25	12.8	7.2	4.4	2.5	1.4	1	2.6

Хүснэгтээс харахад хамгийн их давтамж (32.7%) бүхий интервал (56,001-112,000) нь моод орших интервал болно.

$$M_0 = 56001 + 56000 * \frac{32.7 - 10.4}{(32.7 - 10.4) + (32.7 - 25)} = 97627.6$$

Өрхийн нэг хүнд ноогдох зардал 97,627.6 төгрөг байдаг өрхийн жин хамгийн их байна.



Медиан оршиж буй интервал буюу  $100/2=50$  оршиж байгаа интервал нь (112,001-168,000) байна.

$$Me = 112001 + 56000 * \frac{\frac{100}{2} - 43.1}{25} = 127457$$

Өрхүүдийн тал нь 127,457 төгрөгнөөс их нэг хүнд ноогдох зардалтай, тал нь үүнээс бага зардалтай байна.

Утгуудын дунджийн харьцуулалт {1, 2, 2, 3, 4, 7, 9}			
Төрөл	Тодорхойлолт	Жишээ	Утга
Арифметик дундаж (μ)	$\bar{x} = \frac{1}{n} \sum_{i=1}^n x_i$	(1+2+2+3+4+7+9) / 7	4
Медиан	Түүврийн багцын их болон бага талуудыг зааглаж буй голын утга	1, 2, 2, 3, 4, 7, 9	3
Моод	Түүврийн багцад хамгийн их давтагдаж буй утга	1, 2, 2, 3, 4, 7, 9	2

### 2.9.4 Стандарт хазайлт болон Вариацийн коэффициент

Судлагдаж байгаа шинж тэмдгийн зөвхөн төвийн үзүүлэлтийг тооцох нь хангалттай биш тул хэлбэлзлийн үзүүлэлтүүдийг мөн тооцох шаардлагатай болно. Статистикт хэлбэлзлийн далайц, шугаман дундаж хэлбэлзэл, дисперс, стандарт хазайлт нь шугаман хэлбэлзлийн үзүүлэлт, осцилляцийн коэффициент, вариацийн шугаман коэффициент, вариацийн коэффициент зэрэг нь хэлбэлзлийн харьцангуй үзүүлэлтүүд юм.

### 2.9.5 Дисперс<sup>6</sup>

Дисперс нь эх олонлогийн утгуудын дундаж утгаас хазайх хазайлтуудын квадратуудын нийлбэрүүдийн хувьд тооцогдсон дундаж хэмжигдэхүүн юм.

Энгийн дисперсийн томъёо:

$$\delta^2 = \frac{\sum(x-\bar{x})^2}{n} \quad (i = \overline{1, n})$$

Жигнэгдсэн дисперсийн томъёо:

$$\delta^2 = \frac{\sum(X_i - \bar{X})^2 f_i}{\sum f_i} \quad (i = \overline{1, n})$$

Стандарт хазайлт буюу квадрат дундаж хэлбэлзэл гэдэг нь дисперсээс квадрат язгуур авсан хэмжигдэхүүн юм.

<sup>6</sup> Статистикийн онол, сурах бичиг Г. Элдэв-очир бусад, 2011 он



Энгийн стандарт хазайлтын томъёо:

$$\delta = \sqrt{\frac{\sum(X - \bar{X})^2}{n}}$$

Жигнэгдсэн стандарт хазайлтын томъёо:

$$\delta = \sqrt{\frac{\sum(X_i - \bar{X})^2 f_i}{\sum f_i}}$$

**Хэрэглээ:**  $\delta$  нь дунджаас хэлбэлзэх хэлбэлзлийг харуулдаг. Дээр дурдсан дундаж хэмжигдэхүүний жишээний хувьд  $\delta$  нь аймгуудын хүн амын насны хэлбэлзлийг илтгэнэ.

Вариацийн коэффициент (COV) гэдэг нь стандарт хазайлтын утгыг дундаж хэмжигдэхүүнд харьцуулсан харьцангуй хэмжигдэхүүн юм.

$$\text{Томъёо: } COV = \left(\frac{\delta}{\bar{X}}\right) * 100$$

Энэ коэффициент өндөр гарах нь их хэлбэлзэлтэй, тоо мэдээллийн үнэн зөвийг магадлах шаардлагатайг илтгэнэ. Хэрэв бага гарвал хэлбэлзлийн өөрчлөлт багатай, мэдээллийг магадлах шаардлагагүй гэсэн агуулга илэрхийлнэ.

**Хэрэглээ:** Зөвхөн стандарт хазайлтаас тархалтын хэр хэмжээг харах боломжгүй бөгөөд энэ үед вариацийг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, вариацийн коэффициент 20%-иас их тархалт нь хэвийн тархалтанд ойр түүврийн вариацийн коэффициент 20%-иас их гарвал ерөнхий хандлага багатай буюу тооцогдсон дундаж хэмжигдэхүүн нь уг түүврийн утгуудыг төлөөлөх чадваргүй гэсэн утгатай.

### 2.9.6 Тархалтын налалтын коэффициент (skewness) болон куртосис (kurtosis) коэффициент

**Налалтын коэффициент:** Энэ нь түүврийн тархалтын тэгш хэмгүй байдлыг хэмждэг. Уг коэффициентын утга нь эерэг болон сөрөг байж болно.

Томъёо:  $Y_1, Y_2, \dots, Y_n$ , гэсэн түүврийн олонлогийн хувьд хазайлтын коэффициент олох томъёо нь



$$\text{Хазайлтын коэффициент} = \frac{E((X-\bar{X})^3)}{\delta^3}$$

Энд,  $\bar{X}$  нь дундаж,  $\delta$  нь стандарт хазайлт,  $E$  нь дундаж авах функц.

**Хэрэглээ:** Ажиглалтуудын тархалт нь хэр тэгш хэмгүй байгааг харуулдаг. Хэрэв моод нь дунджаасаа аль нэг тал руу их холдсон байвал налалтын коэффициент нь өндөр гарна. Моодыг тайлбарласан дээрх жишээнд харилцагчид ганцхан ресторанаар олон үйлчлүүлж байвал бусад ресторануудын хувьд тэгш хэмгүй байдал үүсч байна гэсэн үг юм. Хэрэв Дундаж > Моод бол хазайлтын коэффициент нь эерэг, хэрэв Дундаж < Моод бол хазайлтын коэффициент нь сөрөг гарна. Хэрэв Дундаж = Моод байвал тэгш хэмтэй гэсэн утгатай. Нормаль тархалтын дундаж, медиан, моод тэнцүү байдаг.

**Куртосис коэффициент:** Энэ нь түүврийн тархалт нь нормаль тархалттай харьцуулахад тархалтын хэлбэр нь өндөр эсвэл нам байгааг илтгэдэг.

$$\text{Куртосис} = \frac{E((X-\bar{X})^4)}{\delta^4}$$

Энд,  $\bar{X}$  нь дундаж,  $\delta$  нь стандарт хазайлт,  $E$  нь дундаж авах функц.

Куртосис нь 3-аас их бол хэвийн тархалттай харьцуулахад өндөр, 3-аас бага бол хэвийн тархалтаас нам хэлбэрийн тархалттай гэж үздэг.

**Хэрэглээ:** Энэхүү коэффициентуудыг түүвэр олонлогийн тархалтын хэлбэрийг тодорхойлоход хэрэглэдэг бөгөөд хоёр коэффициентийг ашиглан хэвийн тархалттай эсэхийг Jarque-Berra тестээр тодорхойлдог.

### 2.9.7 Баганан болон шугаман диаграмм

Баганан болон шугаман диаграмм нь статистикийн графикийн төрлүүд юм. Статистикийн график нь нийгэм, эдийн засгийн, үзэгдэл юмсыг цэг, шугаман дүрс, геометрийн дүрс, газарзүйн зурагтай схемийн тусламжтайгаар дүрслэн үзүүлж тэдгээрийн утга агуулгыг тайлбарлан харуулдаг дүрслэл юм.<sup>7</sup>

**Хүснэгт 2. 5 Ажилчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, 2014 он**

	Цалин хөлстэй ажиллагч	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Нөхөрлөл, хоршооны гишүүн	Мал аж ахуй эрхлэгч	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин, хөлсгүй оролцогч	Бусад
Ажилчдын тоо	551 006	17 579	228 241	946	285 843	26 484	599

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, УСХ, [www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>7</sup> Статистикийн онол, сурах бичиг Г. Элдэв-очир бусад, 2011 он



Зураг 2. 6 Баганан диаграмм



Зураг 2. 7 Шугаман диаграмм



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ, [www.1212.mn](http://www.1212.mn)

**Хэрэглээ:** Баганан болон шугаман диаграмм нь нэг хувьсагчийн хувьд хэрэглэгддэг. Хөгжлийн шинжилгээнд эдгээр диаграмм нь судлагдаж буй тоон үзүүлэлтүүдийг дүрсээр илэрхийлэн өөрчлөлтийг харах боломж олгодог.

#### Тоон мэдээллийн хоёр хэмжээст цэгэн диаграмм


Хоёр хувьсагчтай тоон мэдээллийг нэгэн зэрэг боловсруулахдаа шинж тэмдгээр нь дэс дараалсан бүлэгт хувааж тархалтын цуваа байгуулдаг. Дараах хоёр тоон цувааны мэдээлэл өгөгджээ:



Улирал	Хэрэглээ	Орлого
1999 оны I улирал	88,981	97,643
1999 оны II улирал	89,854	100,296
1999 оны III улирал	91,089	101,682
1999 оны IV улирал	92,718	101,558
2000 оны I улирал	93,419	103,277
2000 оны II улирал	94,857	106,532
2000 оны III улирал	98,520	111,964
2000 оны IV улирал	99,204	110,994
2001 оны I улирал	101,210	111,530
2001 оны II улирал	102,761	117,026
2001 оны III улирал	103,457	114,604
2001 оны IV улирал	105,240	117,432
2002 оны I улирал	107,284	119,054
2002 оны II улирал	109,194	120,086
2002 оны III улирал	111,023	119,504
2002 оны IV улирал	112,504	120,933
2003 оны I улирал	114,183	121,554
2003 оны II улирал	115,665	123,736
2003 оны III улирал	117,609	125,356
2003 оны IV улирал	120,178	127,784

Орлого болон хэрэглээ хооронд хамаарал бий эсэхийг шинжлэхдээ эдгээр цувааг 1 графикт байрлуулах замаар цэгэн диаграмм гаргаж болно.

**Зураг 2. 8 Хоёр хэмжээст цэгэн диаграмм**



Дээрх графикт орлого, хэрэглээг нэг диаграммд дүрслэн харуулсан. Орлого болон хэрэглээ хооронд хүчтэй шугаман хамаарал ажиглагдаж байгааг уг диаграммаас хялбархан харж болно.

Статистикт үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг тооцоход хэрэглэдэг энгийн арга нь корреляцийн коэффициент юм. Корреляцийн коэффициент нь үзүүлэлт хоорондын шугаман хамаарлын хүчийг илтгэдэг. Үүнийг дараах томъёогоор олдог:



$$r = \frac{n(\sum xy) - (\sum x)(\sum y)}{\sqrt{[n\sum x^2 - (\sum x)^2][n\sum y^2 - (\sum y)^2]}}$$

Энд,  $r$  нь корреляцийн коэффициент,  $x$  болон  $y$  нь хоёр тоон цувааг,  $n$  нь ажиглалтын тоог илэрхийлнэ. Корреляцийн коэффициент нь 0 болон 1-ийн хооронд байна: 0 утга нь хоёр хувьсагчийн хооронд шугаман хамаарал байхгүйг, харин 1 гэсэн утга нь хоёр хувьсагч хоорондоо төгс шугаман хамааралтайг илтгэнэ. Бидний жишээн дээрх 2 тоон цувааны корреляцийн коэффициент нь 0.89 гарсан нь хоорондоо өндөр шугаман хамааралтайг илэрхийлж байна.

**Хэрэглээ:** Хоёр хэмжээст тархалтын цэгэн диаграмм болон корреляцийн коэффициентын шинжилгээ нь тоон мэдээллийн хоорондын хамаарлыг харуулдаг. Тухайлбал, зам дээрх машины тоо болон тодорхой зайнд хүрэх хугацаа хоёр нь хоорондоо хамааралтай. Өөрөөр хэлбэл, машины тоо нэмэгдэхийн хэрээр хүрэх хугацаа уртасна.

### 2.9.8 Хугацаан цуваа

Хугацааны (өдөр, долоо хоног, сар, жил) тодорхой агшин эсвэл завсарт шинжилж буй үзэгдлийн хэмжээг илтгэж буй үзүүлэлтүүдийн дарааллыг хугацаан цуваа гэж нэрлэдэг. Хугацаан цуваа нь дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй: тренд буюу хандлага, цикл буюу давтагдах нөлөө, улирлын нөлөө болон тогтворгүй нөлөө.

Хугацаан цувааны жишээнүүд:

- Хугацааны турш үнэ өсөх (хандлага),
- Зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэгдэх мөчлөгөөс хамаарч үнэ давтагдах байдлаар өөрчлөгдөж болно,
- Зарим бүтээгдэхүүн, ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд улирлын чанартайгаар зах зээлд нийлүүлэгддэг тул тэдгээрийн үнэ нь улирлын нөлөөгөөр өөрчлөгддөг,
- Үнэ нь тодорхой шалтгаангүйгээр санамсаргүй өөрчлөгдөж болно.

Хугацаан цуваан ажиглалтанд дээрх бүрэлдэхүүнээс нэг нь эсвэл бүгд нөлөөлсөн байж болдог. Хугацаан цувааг шинжлэхийн тулд эхлээд цувааны гол хандлага болон бүрэлдэхүүн хэсгийг бүрхэгдүүлдэг тогтворгүй элементүүдийг арилгаж, цувааг тэгшитгэх хэрэгтэй.



Хугацаан цувааг тэгшитгэх энгийн арга нь энгийн шаталсан дундаж арга юм. Тэгшитгэсэн статистик  $s_t$  ( $t$  нь хугацааг илтгэнэ) нь хамгийн сүүлчийн  $k$  ажиглалтын ( $x$ ) дундаж юм.

$$s_t = \frac{1}{k} \sum_{n=0}^{k-1} x_{t-n} = \frac{x_t + x_{t-1} + x_{t-2} + \dots + x_{t-k+1}}{k} = s_{t-1} + \frac{x_t - x_{t-k}}{k},$$

**Жишээ:** Улсын хэмжээний 15-аас дээш насны ажиллагчдын тоогоор жишээ авъя. Улирлаар авсан ажиллагчдын тоонд улирлын нөлөө байх магадлал өндөр, улирлын хэлбэлзэл их тул тоо мэдээг тэгшитгэх 3 болон 4 жилийн шаталсан дундажийн тооцоог дараах хүснэгтэнд харуулав. Энд задгай тоон мэдээлэл болон хугацаан цувааг тэгшитгэсэн утгыг харуулав.

**Хүснэгт 2. 6 15-аас дээш насны ажиллагчдын тоо, улирлаар**


Улирал	Ажилчдын тоо	3 жилээр авсан шаталсан дундаж	4 жилээр авсан шаталсан дундаж
2011 ¾	1 056 848		
2011 4/4	1 026 582	1 039 129	
2012 ¼	1 033 958	1 039 634	1043937,75
2012 2/4	1 058 363	1 069 186	1058534,75
2012 ¾	1 115 236	1 063 936	1056441,25
2012 4/4	1 018 208	1 055 299	1056065,25
2013 ¼	1 032 454	1 061 985	1075298
2013 2/4	1 135 294	1 084 734	1068102,75
2013 ¾	1 086 455	1 086 660	1073108,75
2013 4/4	1 038 232	1 058 760	1077893,5
2014 ¼	1 051 593	1 064 204	1069766,5
2014 2/4	1 102 786	1 101 068	1085359
2014 ¾	1 148 825	1 097 441	1085978,75
2014 4/4	1 040 711	1 102 131	1102294,5
2015 ¼	1 116 856	1 100 969	1112933,25
2015 2/4	1 145 341		

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ, [www.1212.mn](http://www.1212.mn)





**Зураг 2. 9 Задгай болон тэгшитгэсэн хугацаан цувааны цэгэн диаграмм**



Графикаас тэгшитгэсэн тоо мэдээнд улирлын хэлбэлзэл арилсан харагдаж байгаа бөгөөд ажилчдын тооны ирээдүйн хандлага харагдах боломж олдож байна.

Энэхүү бүлгийн хавсралт хэсэгт хөгжлийн шинжилгээнд өргөн хэрэглэгддэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн жагсаалтыг, тодорхойлолттой нь оруулсан болно.

### 2.9.9 Регрессийн шинжилгээ

Хувьсагчдын хоорондын хамаарлын зүй тогтлыг судлахад регрессийн шинжилгээ хэмээх статистикийн аргыг хэрэглэдэг. Энэ аргыг хамаарах хувьсагч болон нэг ба нэгээс олон үл хамаарах хувьсагчдын хамаарлыг голлон шинжлэх тохиолдолд хэрэглэвэл тохиромжтой. Регрессийн шинжилгээний тусламжтайгаар бусад нөлөөлөгч хувьсагч тогтмол үед хамааран хувьсагчийг тухайн нэг нөлөөлөгч хувьсагчийн өөрчлөлт нь хэдээр өөрчилж буйг харж болно.

Регрессийн шинжилгээнд дараах хувьсагчид ашиглагддаг:

- Үл мэдэгдэх параметрийг  $\beta$  үсгээр тэмдэглэх ба энэ нь скаляр эсвэл вектор хэмжигдэхүүнийг илэрхийлнэ
- Нөлөөлөгч хувьсагч  $X_i$
- Хамаарах хувьсагч  $Y$

Хэрэглэгдэж буй салбараасаа хамаарч хамаарах болон нөлөөлөгч хувьсагчдыг янз бүрээр илэрхийлдэг боловч ерөнхийдөө регрессийн загвар нь  $X$  болон  $\beta$ -ээс хамаарсан  $Y$  функцтэй холбоотой.



$$Y = f(X_i, \beta)$$

Статистик хамааралтай хувьсагчдын функциональ хамаарлыг илрүүлэхдээ эхлээд тэдгээрийн хооронд ямар хэлбэртэй хамаарал байгааг тодорхойлно. Функциональ хамаарлын хэлбэр буюу функцийн хэлбэрийг тодорхойлохдоо цэгүүдийн байрлалын болон үзэгдлийн ерөнхий шинж чанарт үндэслэнэ. Хувьсагчуудын хамаарал шугаман хуулиар илэрхийлэгдэхээс гадна шугаман бус хуулиар илэрхийлэгдэх тохиолдол бас байна. Энэ тохиолдолд муруй шугамын регрессийн шинжилгээг хийнэ.

Шугаман регрессэд хамаарах хувьсагч  $Y$  нь параметруудаас (гэхдээ нөлөөлөгч хувьсагчдаас шугаман хамааралтай байх шаардлагагүй) шугаман хамааралтайг илтгэсэн тэгшитгэлийг ашигладаг. Жишээ нь:  $N$  тоон утгатай ( $i = 1$ -ээс  $N$  хүртэл) загварын хувьд энгийн шугаман регрессийн шинжилгээнд нэг үл хамаарах хувьсагч болох  $X_i$  болон  $\beta_0$  ба  $\beta_1$  гэсэн хоёр параметр байна:

$$Y_i = \beta_0 + \beta_1 X_i + e$$

Энд,  $e$  нь санамсаргүй алдаа,  $i = 1, 2, 3, \dots$  нь мэдээллийн утгууд

Олон хүчин зүйлсийн регрессийн шинжилгээнд хэд хэдэн нөлөөлөгч хувьсагч эсвэл нөлөөлөгч хувьсагчдын функцууд байдаг. Гурван хувьсагчтай функцийн тэгшитгэл дараах байдалтай байна:

$$Y_i = \beta_0 + \beta_1 X_{1i} + \beta_2 X_{2i} + \beta_3 X_{3i} + e$$

### Жишээ:

**Таамаглал:** Тариаланчид зах зээлийн үнэд хариу үйлдэл үзүүлдэг бөгөөд үнээс хамаарч ургацаа нэмэгдүүлдэг.

$$\text{Тооцоолсон регрессийн тэгшитгэл нь: } Y_t = 0.4 + 0.23X_{t-1}$$

Энд,  $Y_t$  нь бүтээгдэхүүн буюу ургац (1,000 тонноор),  $X_{t-1}$  нь үнэ (жилийн өмнөх үнэ).

Уг тэгшитгэл нь үр тарианы үнэ 1-ээр нэмэгдэхэд өгөөж буюу ургацын хувь 0.23-аар нэмэгдэнэ гэдгийг харуулна. Өөрөөр хэлбэл, үнэ 10%-аар өсөхөд жилийн дараах ургац 2.3%-аар нэмэгдэнэ. Үнэ нь өмнөх жилээр байгаагийн шалтгаан нь үнэ нэмэгдсэнийг тариаланчид мэдээд тариалалтаа нэмэгдүүлэх ба үүний дүнд ирэх жилийнх нь урсгал нэмэгдэх тул үнийг 1 жилийн хугацааны хоцрогдолтойгоор авна.



Ингэж регрессийн тэгшитгэлийн коэффициентүүдийг үнэлсэний дараа коэффициентүүдийн найдвартай эсэхийг, мөн тэгшитгэлийн найдвартай эсэхийг шалгадаг. Энэ зорилгоор олон хүчин зүйлийн детерминацын коэффициент R<sup>2</sup>-ийг тооцдог.

R<sup>2</sup>=0 бол хамаарах хувьсагч болон үл хамаарах хувьсагчдын хоорондын хамаарал сул бөгөөд тэгшитгэл нь найдваргүй (онолын хувьд хангалтгүй)

R<sup>2</sup>=1 бол хамаарах хувьсагч болон үл хамаарах хувьсагчдын хоорондын хамаарал хангалттай хүчтэй бөгөөд регрессийн тэгшитгэлийг судалгаанд хэрэглэх онолын үндэслэлтэй гэдгийг илтгэнэ.

R<sup>2</sup>-ийн хүчийг үнэлэхэд 'F-статистик'-ийг ашигладаг (F-статистик>3 бол том олонлогт статистикийн хувьд ач холбогдолтой гэсэн утгатай). Тайлбарлах хувьсагч бүрийн найдвартай байдлыг үнэлэхдээ 't-статистик'-ийг тооцдог ба энэ нь 2.5-аас их гарвал том олонлогт статистикийн хувьд ач холбогдолтой гэсэн үг юм.

Камбожи улсын 11,882 тосгоны тоог нэгтгэсэн мэдээллийн баазыг ашиглан хүүхдүүдийн сургуульд хамрагдалтийг эрэлт, нийлүүлэлттэй нь уялдуулан тайлбарлахын тулд регрессийн шинжилгээг хэрхэн ашигласныг Хүснэгт 2.7-д харуулав.

**Хүснэгт 2. 7 Хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын хувийг тодорхойлогчид (Камбожи улсын тосгодын нэгдсэн мэдээлэлд үндэслэсэн)**

	Коэффициентийн утга	t-статистик	Дунджийн хэлбэлзэл
(Тогтмол)	63.8943	68.7636	
Сургууль хүртэлх км-ийн бага утга	-0.0028	-1.2274	-0.0002
Сургууль хүртэлх км-ийн өндөр утга	-0.0034	-1.6081	-0.0005
Борооны улирлын тутрагын өгөөж	1.4567	5.0639	0.0391
Тосгоноос мужийн төв хот хүртэлх зай	-0.0489	-7.1378	-0.0272
# Өрхөд ногдох мотоцикл (%)	0.0159	1.9869	0.0106
# Өрхөд ногдох унадаг дугуй (%)	0.0723	16.2546	0.0630
# Нийт өрхөд оромжинд амьдардаг өрхийн эзлэх хувь (%)	-0.1806	-16.2717	-0.0422
# 1 га-аас дээш хэмжээтэй газар тариалдаг өрхүүдийн эзлэх хувь (%)	-0.0043	-2.6795	-0.0008
# Өрхөд ногдох бие засах газар (%)	0.1168	16.1083	0.0551
# Усны шугамтай холбогдсон өрхүүдийн эзлэх хувь (%)	0.0540	11.9045	0.0331
Хуурай улирлын тутрагын өгөөж	0.3676	2.5133	0.0047
R <sup>2</sup> = 0.150; F = 192.063; n = 11,882			

Тайлбар 1: Хэлбэлзэл нь үл хамаарах хувьсагч 1%-иар өөрчлөгдөхөд хамаарах хувьсагч хэдэн хувиар өөрчлөгдөхийг илэрхийлнэ. Тайлбар 2: Өмнө дурдсан β-ийн тоон утгууд нь эдгээр коэффициентүүд юм.




**Хэрэглээ:** Эдийн засгийн шинжилгээнд хувьсагчдын хоорондох хамаарал, хамаарлын хүчийг үнэлэх зорилгоор регрессийн шинжилгээг өргөн хэрэглэдэг<sup>8</sup>.

## 2.10 Монгол Улсын статистик мэдээллийн тогтолцоо

Энэ хэсэгт Монгол Улсын Статистикийн мэдээллийн тогтолцоог тодорхой авах бөгөөд энэ тогтолцоо нь ямар мэдээлэл гаргадаг, хэрхэн ойлгох, эдгээрийг нөхцөл байдлын шинжилгээнд хэрхэн хэрэглэх боломжтойг танилцууллаа. Зураг 2.9-д Статистикийн тогтолцоог схемлэн харуулав.

Зураг 2. 10 Монгол Улсын статистикийн тогтолцоо



### Тооллого судалгаа

Үндэсний Статистикийн Хорооноос дараах тооллого, судалгааг тогтмол явуулдаг:

1. Хүн ам, орон сууцны тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам;
2. Салбар хоорондын тэнцэл, 5 жил тутам;
3. Малын тооллого, үүнд гэрийн тэжээвэр амьтан, малын хашаа, худаг, тэжээлийг оруулна, жил бүр;
4. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (амьжиргааны түвшин, ажил эрхлэлт, г.м) 5 жил тутам; орлого-зарлагын судалгаа улирал тутам;
5. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 5 жил тутам;
6. Ажиллах хүчний судалгаа 3 сар тутам;
7. Цалингийн судалгаа 3 сар тутам;
8. Аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жил тутам;

<sup>8</sup> Дэлгэрэнгүй ойлголт авахыг хүсвэл дараах номуудыг уншина уу: An Introduction to the Theory of Statistics, G.U. Yule and M.G. Kendall, Charles Griffen Publishers, London, 1960; Linear Statistical Inference (Second Edition), C.R. Rao, John Wiley, New York 2008 (интернет хувилбар бий)



9. Цаг ашиглалтын судалгаа 5 жил тутам;
10. Байгалийн нөөц, цаг уурын өөрчлөлтийн төсөөллийн мэдээллийн сан;
11. Яамдын мэдээллийн бааз руу холбосон статистикийн газраас тооцдог жендэрийн үзүүлэлтүүд.

### 2.10.1 Хүн ам, орон сууцны тооллого

“Хүн ам, орон сууцны тооллого” нь нийт улс орны хүн ам, өрхийн тоон мэдээллийг агуулдаг. Хэдийгээр хүн амын тооллогын материалд нарийвчилсан олон мэдээлэл байдаггүй боловч хамрах хүрээ нь газар зүйн байршлын хамгийн доод нэгжийн түвшинд хүртэл задрах боломжийг олгодог. Хүн амын тооллогын мэдээнд:

- Оршин суудаг газар,
- Нас,
- Хүйс,
- Гэр бүлийн байдал,
- Боловсролын түвшин,
- Хөгжлийн бэрхшээлтэй эсэх,
- Хөдөлмөр эрхлэлтийн байдал (ажил эрхэлж буй, ажил эрхлээгүй, оюутан, тэтгэвэрт, оюутан эсвэл ажиллахад хэт залуу),
- Хөдөлмөр эрхэлдэг салбар (суурь салбар, хоёрдагч салбар, гуравдагч салбар),
- Шилжилт хөдөлгөөний байдал зэрэг мэдээлэл багтдаг.

**Хэрэглээ болон хязгаарлалт:** Хүн амын тооллого нь хүн амын мэдээг судалж буй асуудлаас хамаарч олон тооны ангиллаар гаргахад тусална. Гэвч богино хугацаанд нэг удаагийн арга хэмжээгээр цуглуулсан байдаг учраас тоон мэдээлэлд алдаа байх магадлал өндөртэй. Тооллого 10 жил тутамд нэг удаа хийгддэг учраас хоёр тооллогын хооронд хийгдэх нөхцөл байдлын шинжилгээнд хуучин мэдээллийг ашиглахад хүрдэг.

### 2.10.2 Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Энэ нь 5 жил тутам явуулдаг түүвэр судалгаа юм. Түүвэр нь үндэсний болон гол бүс нутгийг төлөөлөх хэмжээнд байна. Олон улс орнууд жил бүр ижил асуулгаар бага хэмжээний түүврийн хувьд нэмэлт судалгааг хийдэг. Ийм жижиг түүвэр нь улсын хэмжээний хүн амыг төлөөлж болох ч мэдээллийн чанар нь алдагдах тул засаг захиргааны нэгжийг төлөөлөхүйц байж чадахгүй. Бусад улсын жишгийг даган Монгол Улс том хэмжээний түүвэр судалгааг 2 жил тутам явуулдаг. Өнөөг хүртэл аймгийн түвшинд эдгээр мэдээллийг ашиглан нийгмийн үзүүлэлтүүдийг гаргадаггүй байсан ч 2015 оноос эхлэн үндэсний хэмжээний ижил асуулгаар түүвэр судалгаа хийхээр төлөвлөгдсөн. Түүврийн хэмжээг “тэгш хэмт” буюу тухайн бүс нутгийн хүн амын тооноос шууд хувилсан,



эсвэл “тэгш бус хэмт” буюу хүн амын онцлог ялгаа ихтэй бус нутгийн хувьд түүврийн хэмжээг ихэсгэх байдлаар авч болно. Тэгш хэмт бус түүврийн хувьд түүвэрт хамрагдсан хүн амын бүлгийг нийт хүн амд эзлэх хувийг гаргаж, улсыг төлөөлүүлэх тооцооллыг хийдэг.

*Тайлбар: Жигнэсэн хувийг түүврийн хүрээнд буюу нийт хүн амын түвшинд гаргана. Жигнэсэн хувийг түүвэрт тухайн өрх сонгогдох магадлаас урвуу хамааралтайгаар авдаг. Түүврийн тооцоог нийт хүн амыг төлөөлөхүйц тооцоолол болгон ерөнхийлөхөд жигнэсэн хэмжүүр тусална.*

**Хэрэглээ болон хязгаарлалт:** Нийгэм, эдийн засгийн судалгаа нь хүмүүсийн амьжиргаа (орлого, зарлага, өр)-ны түвшин, ажил эрхлэлтийн байдал, эзэмшдэг хөрөнгө, боловсрол, эрүүл мэнд, орон сууц, шилжилт хөдөлгөөн болон бусад нийгэм эдийн засгийн нарийвчилсан мэдээллийг багтаасан нарийн мэдээлэл бүхий судалгаа юм. Ядуурал, тэгш бус байдал, хэрэглээний ус болон ариун цэврийн байгууламжийн хүртээмж, боловсрол эзэмшсэн байдал, хүүхдийн хөдөлмөр, эрүүл мэндийн зардал гэх мэт асуудлыг тодорхойлоход энэхүү судалгаа нь гол эх сурвалж болдог. Судалгааны гол дутагдалтай тал нь түүврийн хэмжээ байдаг бөгөөд орон нутгийн түвшний задаргаа тооцоог нарийвчлан гаргах боломжгүй байдаг.

### 2.10.3 Засаг захиргааны мэдээлэл

Яамд, орон нутгийн байгууллагууд, агентлаг, газрууд болон бусад хуулийн этгээдүүд өөрсдийн үйл ажиллагааны бүртгэлээс мэдээлэл гаргадаг. Эдгээр мэдээллийн дийлэнх нь зардлын талаарх мэдээлэл байдаг боловч гарц, үр дүнгийн талаарх мэдээллийг ч мэдэх боломжтой. Тухайлбал, Боловсролын яам янз бүрийн түвшний сургуульд хамрагдалтын мэдээг гаргах бол Зам тээврийн яам замын урт, засварласан болон шинээр барьсан зам, Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, Төв банк нь үнэ, ДНБ, инфляци, хүү, болон бусад мөнгөний үзүүлэлт, Худалдааны яам экспорт, импортын гэх мэт мэдээг гаргадаг.

Нөхцөл байдал болон асуудлын шинжилгээг хийхдээ мэдээллийн үнэн бодитой байдлыг хангах үүднээс статистикийн мэдээллийг засаг захиргааны мэдээлэлтэй харьцуулан ашиглах шаардлагатай.

Монгол Улсын “Статистикийн тухай хууль”-ийн 6-р зүйлд зааснаар тодорхой төрлийн статистик мэдээлэл нь тооллогын арга эсвэл засаг захиргааны эх сурвалжаас гаргасан эсэхээс үл хамааран “албан ёсны статистик мэдээлэл”-д хамаарагддаг. Эдгээр мэдээлэлд макро эдийн засгийн, хүн ам зүйн, аж үйлдвэрийн салбарын, шинжлэх ухаан технологийн, эрх зүйн болон байгаль орчны мэдээлэл багтдаг.





**Анхаарах зүйлс:** Үндэсний статистикийн хороо, бүс нутгуудийн хөгжилд чиглэсэн олон улсын байгууллагууд (Азийн Хөгжлийн Банк, НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хороо), олон улсын хандивлагч байгууллагууд (Дэлхийн Банк, НҮБ-ын Статистикийн газар) болон бусад олон улсын байгууллагууд нь өөрсдийн цахим хуудсандаа нийгэм, эдийн засаг болон хөгжлийн статистик мэдээллүүдийг гаргадаг. Гэхдээ эдгээр байгууллагуудын гаргасан мэдээлэл заримдаа зөрөх тохиолдол бий. Үүний шалтгааныг дурдвал: эдгээр байгууллагын ашигладаг статистикийн аргууд (Бүлэг 5-д дэлгэрэнгүй авч үзнэ) өөр байх; мөн улс орны бүх мэдээллийг авах боломжгүй учраас дутуу байгаа мэдээллийг олох үүднээс засварлах, бусад руу нь шилжүүлэх зэргээр статистик үзүүлэлтүүдийг тооцох; тухайн орны хамгийн сүүлийн үеийн статистик мэдээлэл гараагүй бол хуучин тоон мэдээллийг ашиглах зэрэг шалтгаанаас болоод мэдээллүүд нь зөрөх үе гардаг. Иймд тухайн улсад судалгаа хийж буй шинжээч нар аль болох үндэсний статистикийн байгууллагаас гаргасан албан ёсны мэдээллийг ашиглах нь зүйтэй.

#### 2.10.4 Байгалийн нөөц, цаг уурын өөрчлөлтийн мэдээллийн сан

Байгалийн нөөцийн мэдээллийн сангаас дараах мэдээллийг харж болно:

##### Сэргээгдэх нөөц

- Амьтны төрөл зүйлийн тоо,
- Ургамлын төрөл зүйлийн тоо: Тухайлбал: бэлтгэсэн мод, нийт газар нутагт ойн эзлэх хувь,
- Гадаргын ус,
- Нар, ус, газрын гүний дулаан болон салхинаас гарсан сэргээгдэх эрчим хүч.

##### Үл сэргээгдэх нөөц

- Шатахуун: жишээ нь, нүүрс, байгалийн хий, газрын тос,
- Ашигт малтмал: жишээ нь, алт, зэс, төмрийн хүдэр, цайр.

##### Уур амьсгалын өөрчлөлтийн төсөөллийн мэдээллийн сан

- Температур ( $^{\circ}\text{C}$ ): цагаар, өдрөөр, долоо хоногоор, сараар, жилээр,
- Хур тунадас-бороо, цасны хэмжээ: өдрөөр, долоо хоногоор, сараар, жилээр,
- Салхины хурд (Метр/секунд): өдрөөр, долоо хоногоор, сараар, жилээр,
- Жилийн цөлжилтийн индекс,
- Жилийн газрын доройтлын индекс,
- Жилийн бэлчээрийн доройтлын индекс,
- Бэлчээрийн нөхцөл байдлын индекс,



- Зудын индекс,
- Гангийн индекс,
- Газар ашиглалтын зураглал,
- Агаарын бохирдол: Нүүрстөрөгчийн давхар исэл (CO<sub>2</sub>), азотын давхар исэл (NO<sub>2</sub>).

## 2.11 Мэдээлэл, нотолгоо цуглуулах

**Үндэсний статистикийн газраас гаргадаг жендэрийн үзүүлэлт болон мэдээлэл**  
 Дээрх тооллого, мэдээллийн сангуудаас гадна Үндэсний статистикийн газар нь 2013 онд жендэртэй холбоотой судлагдах 216 үндсэн үзүүлэлтүүдийг баталж, эдгээрийг тооцон салбар яамдын мэдээллийн сан руу холбож байхаар болсон. Нотолгоонд суурилсан жендэрийн мэдрэмжийн асуудлыг шийдэх, бодлого хөтөлбөр гаргахад жендэртэй холбоотой, хүйсээр ангилагдсан үзүүлэлтүүд чухал ач холбогдолтой. Иймд эдгээр жендэрийн үзүүлэлтүүд нь жендэртэй холбоотой бодлого, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжилтэнд хяналт тавихад ашиглагдах гол хэрэгсэл болох юм. Жендэртэй холбоотой 216 үзүүлэлтийг 14 салбараар болон ядуурал, хүн ам, боловсрол, эрүүл мэнд, бэлгийн хүчирхийлэл, ажил эрхлэлт болон ажиллах хүч, шийдвэр гаргалтын түвшин, хүний эрх, хэвлэл мэдээлэл, байгаль орчны институци, охид хөвгүүд, жендэрийн төсөв, жендэрийн индекс зэрэг тодорхой сэдвийн хүрээнд боловсруулан гаргасан.

### Хүснэгт 2. 8 Судалгааны материал цуглуулах аргууд

1. Баримтын судалгаа буюу мэдээлэл ашиглах	<ul style="list-style-type: none"> <li>• Статистикийн байгууллагаас гаргасан мэдээ, баримт цуглуулах</li> <li>• Өмнө хийгдсэн судалгааны материал цуглуулах</li> <li>• Архивын эх материал</li> </ul>
2. Өөрсдөө тодорхой аргачлалаар мэдээлэл цуглуулах	<ul style="list-style-type: none"> <li>• Ажиглалт хийх,</li> <li>• Сурвалжлага хийх,</li> <li>• Санал асуулт явуулах,</li> <li>• Үзэж танилцах, ажлын зураг авалт хийх,</li> <li>• Танилцах аялал, уулзалт зохиох.</li> </ul>
3. Нөхцөл байдлыг турших	<ul style="list-style-type: none"> <li>• Нэг буюу хэсэг хүмүүсийг дагаж ажиллах,</li> <li>• Туршилт хийх,</li> <li>• Өөрийн дадлага туршлагаа ашиглах,</li> <li>• Зураг авалт.</li> </ul>
4. Бусдын саналыг тусгах	<ul style="list-style-type: none"> <li>• Цуглаж хэлэлцэх,</li> <li>• Бүлгээр ажиллах,</li> <li>• Оюуны довтолгоон хийх.</li> </ul>





Баримтын судалгаанд холбогдох төр, төрийн бус байгууллага болон судалгаа шинэжилгээний байгууллагуудын номын сангийн катологийг шүүж үзэх болон энэ чиглэлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хандаж болно.

Тодорхой судалгааны аргачлалаар мэдээлэл цуглуулахад нарийн бэлтгэл ажил шаарддаг бөгөөд энэ нь судалгааны үр өгөөжийг сайжруулах үндсэн аргын нэг юм.

Үндэсний болон орон нутгийн түвшинд тухайн асуудалтай холбоотой тоон мэдээлийг цуглуулах, ингэхдээ өнөөгийн мөрдөгдөж буй Статистикийн тухай хуулиар зохицуулагдаж буй мэдээллийг ашиглах шаардлагатай.

## 2.12 Нөхцөл байдлын шинжилгээнд хэрэглэгдэх бусад сэдвүүд

Энэ хэсэгт шинжилгээнд ихээхэн хэрэглэгддэг ч тусад нь бүлэг болгон нарийвчилж тайлбарлах шаардлагагүй зарим аргыг танилцуулна. Эдгээрээс нөхцөл байдлын шинжилгээнд ашиглагддаг 2 арга болох түүвэр судалгаа болон тэгш бус байдлыг хэмжих аргуудыг тайлбарлана. Тухайн судалж буй асуудлаар албан ёсны статистик мэдээллээр гардаггүй тохиолдолд түүвэр судалгааны аргыг ашиглах хэрэгтэй болдог. Бодлого боловсруулагч нар нэмэлт мэдээлэл цуглуулах, түүвэр судалгааг хийх шаардлагатай нөхцөлд судалгаа хийх арга зүйгээ мэргэжлийн байгууллагатай зайлшгүй тохиролцох хэрэгтэй.

### 2.12.1 Бага түүвэр судалгаа

**Зорилго:** Тодорхой зорилгоор тухайн сонгосон газар нутагт түүвэр судалгааг явуулдаг. Энэ аргыг нь орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, нөхцөл байдлын шинжилгээнд хэрэглэхэд тохиромжтой. Хэдийгээр бусад аргатай адил боловч хамрах хүрээг нь тодорхой зорилготойгоор сонгон авч, бага хэмжээний түүврийг явуулдаг тул үр дүн нь бүх нийтийг төлөөлөх чадваргүй юм. Том хэмжээний тооллого, судалгаа нь 'тодорхой зүйлс яагаад тохиолдсон, эсвэл тохиолдоогүй' талаарх асуултад хариулт өгч чаддаггүй. Харин бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд эдийн засаг, нийгэм болон зан төлөвийн үүднээс "яагаад" гэдгийг мэдэх шаардлагатай болдог ба энэ үед илүү нарийн мэдээлэл өгөх чадвартай бага түүвэр судалгааг хэрэглэдэг. Жишээлбэл, зарим технологийг нутагшуулах, эс нутагшуулах шалтгааныг олох, цэвэр ус болон эрүүл ахуйн орчин үеийн аргыг хүлээж авахгүй байгаагийн шалтгаан, эсвэл тэргүүн туршлагууд хэрхэн хэрэгжсэн зэргийг мэдэх зорилгоор энэхүү түүвэр судалгааг ашиглаж болно.



**Аргачлал:** Уг судалгааг янз бүрийн аргаар хийж болох ба яг хэрхэн хийх тусгайлсан арга байхгүй. Ихэнх тоон судалгаанд уг түүврийг явуулахдаа томоохон хэмжээний судалгаатай ижил асуулгыг ашиглана. Харин зорилгоос үүдэн гарсан асуудалд шууд чиглэсэн асуулгыг хэрэглэдэг. Түүвэр судалгаа нь заримдаа цэвэр тоон судалгаа, заримдаа цэвэр чанарын судалгаа, эсвэл тоон болон чанарын судалгааг хослуулсан хэлбэрээр байж болдог. Нэлээд хэрэглэгддэг судалгааны аргуудаас дурдвал:

1. Кейс судалгаа,
2. Тосгоны зураглал,
3. Оролцооны шинжилгээ,
4. Фокус бүлгийн ярилцлага,
5. Антропологийн ажиглалт,
6. Жендэрийн шинжилгээ зэрэг юм.

**Төрөл:** Зарим нь мэдлэгийн суурь болон суурь судалгааг бүрдүүлэх зорилгоор нэг удаагийн шинжтэй хийгддэг судалгаа (жишээ нь зах зээлийн хандлага, Мэдлэг, Хандлага, Дадлын Судалгаа (МХДС), зарим нь “өмнөх” болон “дараах” судалгаа (хөтөлбөрийн үнэлгээнд), зарим нь үр шим хүртэгчид болон хяналтын бүлэг (хөтөлбөрийн үнэлгээ), эсвэл зарим судалгаа нь ажиглах судалгаа (хөтөлбөрийн нөлөөллийг үнэлэхийн тулд нэг бүлгийг судлах) байдаг.

**Судалгаа явуулах үе шат:** Судалгаа эсвэл үнэлгээний зорилгыг тодорхойлох, асуудлыг судлахад хэрэгтэй асуултуудыг боловсруулах, судалгааны хүрээг тогтоох, зорилтот бүлгийг (шаардлагатай бол нас, хүйсээр ангилсан бүлгүүд) тодорхойлох, хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулахад хэрэгтэй бүх хувьсагчийг жагсаах, судалгааны сул талыг тодорхойлох, судалгааг явуулах, тайлан бичих гэсэн үе шатуудтай.

## Шигтгээ 2. 3 Мэдлэг, хандлага, дадлын судалгаа (МХДС)

- МХДС нь хүмүүс тухайн зүйлийн талаар мэддэг зүйлээ, ямар сэтгэгдэлтэй, яаж биеэ авч явдгаа шинжээчид хэлж өгдөг. Нийгмийн судалгаанд нийгмийн үнэлэмж, үйл ажиллагааны талаарх өргөн хүрээг хамардаг бол МХДС судалгаа нь тухайн сэдэв эсвэл бүлэг сэдвийн талаарх мэдлэг, хандлага, дадал (биеэ авч явах) дээр төвлөрдөг.
- Олон нийтийн эзэмшиж буй мэдлэг нь тухайн сэдвийн талаарх тэдний ойлголт байдаг. Жишээлбэл, хүүхдээ өвлийн хүйтнээс хэрхэн хамгаалах, ган болоход яаж туулах, эсвэл бохироо хэрхэн зайлуулах гэх мэт. Хандлага нь тухайн сэдвээр ямар сэтгэгдэлтэй байгаа болон өмнөх санал бодол юм. Дадал нь тухайн сэдвийн талаарх мэдлэг, хандлагаа өөрсдийн үйлдлээр харуулах арга замыг хэлнэ.
- Энэ аргыг хэрэглэснээр эмзэг асуудлаар харьцангуй нууцлалтайгаар томоохон бүлэг хүмүүсийн дунд ярилцлага явуулах боломжийг олгодог. Бүлгээ төстэй шинжээр нь 3-4 хүнтэй дэд бүлэгт, тухайлбал, охид, хөвгүүд, насанд хүрсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд гэж хувааж болно. Эдгээр дэд бүлгийн хүмүүсийг тус тусад нь суулгаж аль нэг талыг барьсан байдлыг багасгаж болохоос гадна зарим олон нийтийн хувьд ингэх нь нийгмийн талаасаа хүсүүштэй байж болох талтай. Бичиг үсэг бага тайлагдсан бүлгийн хувьд өгсөн асуултанд өнгийн карт дээр энгийн тэмдэглэгээ хийх замаар хариултаа өгдөг. Өгсөн хариултанд шинжилгээ хийдэг. Ихэнхдээ тохиролцоонд хүрч, шинжээч илүү зөв дүгнэлт хийх боломжтой болдог.




### 2.12.2 Тэгш бус байдлыг хэмжих

Тэгш бус байдал олон талтай байж болно. Тухайлбал, орлого, баялаг, газар, хөрөнгө, боловсролын хүртээмж, эрүүл мэндийн хүртээмжийн тэгш бус байдал гэх мэт. Хөгжиж буй улс орнуудын макро эдийн засгийн шинжилгээнд хэрэглээний тэгш бус байдлаар тэгш бус байдлыг хэмжих нь түгээмэл юм. Учир нь орлоготой харьцуулахад хэрэглээний талаарх мэдээллийг олох нь илүү хялбар байдаг.

Тэгш бус байдлын энгийн хэмжигдэхүүн бол хүн амын доод 20 хувийг бүрдүүлж буй бүлэгт нийт хэрэглээний хэдэн хувь оногдож буйг үнэлэх явдал юм. Үүний дараа юмс, үзэгдлийн тархалтын шинж чанарыг харуулдаг Лоренцын муруйг зурах хэрэгтэй. Лоренцын муруйг байгуулахдаа координатын тэнхлэг дээр тархалтын цувааны давтамжийг 0-100 хүртэл хувийн өсөн нэмэгдэх (кумулятив) хэлбэртэй авдаг. Хэвтээ тэнхлэгт хүн амын бүлгүүдийн тархалтын өсөн нэмэгдэх давтамжийг хувиар, босоо тэнхлэгт хэрэглээний тархалтын өсөн нэмэгдэх харьцангуй давтамжийг байрлуулдаг. Энэхүү хэвтээ ба босоо тэнхлэг дэх өсөн нэмэгдэх давтамж нь ижил хувиар байгуулагдах учраас квадрат дүрс үүснэ. Иймд ижил тархалттай бол квадратын диагоналийн дагуу тархалт нь тодорхойлогдоно. Хэрэв ижил биш тархалттай бол диагоналийн доод хэсэгт муруй шугамаар зурагдана. Лоренцын муруйн хотгор ба гүдгэрийн диагоналиас алслагдсан хэмжээ нь нягтралын хүчийг илтгэдэг. Лоренцын муруйг тайлбарлахад Жини коэффициентийг ( $G$ ) ашигладаг. Энэхүү коэффициент нь доорх зургийн ягаан хэсгээр илэрхийлсэн төгс тэгш байдал болон ногоон хэсгээр илэрхийлсэн төгс тэгш бус байдлын нийлбэр талбайд харьцуулсан харьцаа юм. Өөрөөр хэлбэл, Жини коэффициент нь дараах зураг дээрх  $A/(A+B)$  талбайн харьцуулалт билээ.  $G$  их байх нь тэгш бус байдал их байгааг илтгэнэ.

Зураг 2. 11 Лоренцын муруй



Тайлбар:

1. Төгс тэгш байдал:  
Ногоон шугам буюу диагоналийн дагуу байрласан бол тэгш бус байдлыг илтгэнэ ( $G=0$ )

2. Төгс тэгш бус байдал:  
Лоренцын муруй нь  $B$  хэсгийн босоо эсвэл хэвтээ тэнхлэгтэй давхцсан байдлыг хэлнэ. Энэ үед  $G=1$  байна.



Муруй нь тэгш хэмтэй бус учраас муруй шугамын доторх талбайг нарийвчлан тооцох боломжгүй байдаг. Иймд тоон аргыг ашиглан хамгийн ойролцоо утгыг тооцдог бөгөөд үүнийг хоёр арга замаар хийж болно. Эдгээрийн нэг нь бүлэглэсэн мэдээлэл нөгөө нь бүлэглээгүй мэдээллийг ашиглах болно:

Бүлэглэсэн мэдээлэлтэй үед тооцох томъёо нь:

$$G = \left| 1 - \sum_{k=0}^{k=n-1} (X_{k+1} - X_k)(Y_{k+1} + Y_k) \right|$$

Энд,  $X$  нь хүн амын өсөн нэмэгдэх тархалт,  $Y$  нь хэрэглээний өсөн нэмэгдэх тархалтыг илэрхийлнэ.

Бүлэглээгүй мэдээллийн хувьд тооцох томъёо нь:

$$G = 1 + \frac{1}{q} - \frac{2}{q^2 y^*} \times \sum_{r(i)=1}^q y_i r(i)$$

Энд,  $q$  ажиглалтын утга,  $y$  орлого,  $y^*$  дундаж орлого,  $r(i)$  бол орлогын зэрэглэл ба 1-ээс  $q$  хүртэлх дугаарласан тоо болно.

## Шигтгээ 2. 4 Нөхцөл байдлын шинжилгээг тайлагнах

- 1. Нэгдүгээр алхам бол асуудлыг сайтар тодорхойлох явдал болно.
- 2. “Асуудлын модоор зураглах” арга барилыг ашиглан асуудлыг шинж тэмдгээс эхлэн учир шалтгаан хүртэл мөрдөн задлах.
- 3. Урьдчилан таамаглах эсвэл загварлах нь асуудлыг үе шаттайгаар задлан тодорхойлохыг шаарддаг.
- 4. Үе шат болгонд тоон мэдээлэл ашиглах нь чухал юм. Шинж тэмдгийн хүрээ, хүч, шалтгааны далайц, эрч хүч гэх мэт. Үүний тулд төрөл бүрийн мэдээлэл цуглуулахад хэлэлцүүлэг, үүний дотор шаардлагатай бол шинэ мэдээлэл цуглуулах болон эсвэл чанарын судалгааг хийх шаардлагатай болно. Бусад мэдээлэл болон өөр газар болсон ижилхэн нөхцөл байдалтай харьцуулах нь 2 үе шатных шиг асуудлыг задлахад тусална.
- 5. Эцэст нь шинжилгээний дараа асуудлын шинж тэмдгийг бус суурь шалтгааныг авч үзэхэд шийдэл оршдог учраас яагаад асуудал гарч байна гэдгийг хэлж өгөх нь чухал болно.
- Тайлбар 1: Асуудалд тэнцвэртэйгээр хандах байр суурь гардаг учраас асуудлын янз бүрийн талаас нь хүлээн зөвшөөрөх нь чухал юм.
- Тайлбар 2: Бидний хяналтанд байдаг болон хяналтаас гадна (цаг агаар, олон улсын байдал, хандлага) хүчин зүйлийг тодорхойлох нь чухал юм.
- Тайлбар 3: Нөхцөл байдлын шинжилгээ байгаль орчны бүрэлдэхүүнтэй байх ёстой. Үүнд аль нэг талыг хэт барихгүй гэвч хүндэтгэлтэйгээр хандах нь зүйтэй.

### 2.12.3 Хүн амын болон боловсролтой холбоотой мэдээлэл

Ихэнх нийгэм эдийн засгийн судалгаанд хүн ам зүйн асуудлыг орхигдуулах байдал ажиглагддаг. Гэтэл бүх бодлого төлөвлөлт нь хүний төлөө хийгддэг гэдгийг санах хэрэгтэй. Хүн амын үзүүлэлтүүд нь олон талаар нэн чухал ач



холбогдолтой. Жишээ нь: хэрэв нийт төрөлтийн хувь буурч байвал энэ нь сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээнд нөлөөлөх тул шинээр эмнэлэг, сургууль барих, багш нарыг сургах, эмнэлэгт нярайн тасгийг нэмэх зэрэг асуудлыг төлөвлөхдөө харгалзаж үзэх шаардлагатай. Хүн амын гарах шилжилт хөдөлгөөн ихтэй орон нутгийн хувьд дээрхтэй ижил нөхцөл байдал үүснэ. Иймд хүн амын шинж чанар, динамикийг аливаа төлөвлөлтөнд анхаарч үзэх хэрэгтэй.

Хүн амтай холбоотой зарим чухал үзүүлэлтийг доор танилцуулав. Эдгээрт:

$$\text{Ерөнхий төрөлтийн хувь} = \frac{\text{Тухайн хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоо}}{\text{Тухайн хугацааны хүн амын дундаж тоо}} \times 1000$$

$$TFR = \left( \sum \{ASBR\} \times \{H\} \right)$$

Энд,

TFR (total fertility rate) - нэг эхээс амьдралынх нь турш төрөх хүүхдийн тоо

$ASBR = B_x/P_x$

ASBR (Age-specific birth rate)- тодорхой насны бүлгийн 1000 хүнд ногдох төрөлтийн тоо

$B_x$  = тухайн X насны бүлгийн нэг эхээс төрсөн хүүхдийн тоо

$P_x$  = тухайн X насны бүлгийн эмэгтэйчүүдийн тоо

H- насны бүлэг бүрийн жилийн тоо ( ихэнхдээ 5 жил)

$$IMR = \frac{\text{1 нас хүрэлгүй нас барсан хүүхдийн тоо}}{\text{Тухайн хугацаанд нийт амьд төрсөн хүүхдийн тоо}} \times 1000$$

Энд, IMR (Infant mortality rate)- Нялхсын эндэгдэл

#### ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Монгол Улсын анхдагч, хоёрдогч болон гуравдагч гэсэн 3 салбарын хөдөлмөрийн бүтээмжийг тооцно уу.

**Дасгал 2:** Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ ойролцоогоор 4,000 ам доллар боловч хүн амын 22% ядуу байна. Үүний шалтгааныг тайлбарлана уу.

**Дасгал 3:** Нэрлэсэн ДНБ-ий жилийн өсөлт 14% , инфляци 8% бол бодит ДНБ-ий өсөлтийг олно уу?

**Дасгал 4:** Дараах үзүүлэлтүүдийн аль нь тогтмол, аль нь урсгал үзүүлэлт вэ? Үүнд: уурхайн тооцсон алт, бод малын тоо, зарсан ноосноос орсон орлого, уул уурхайн концессын жилийн нөөцийн төлбөр, уул уурхайн салбарын удирдах ажилтны төлсөн татвар.



## 2-р бүлгийн Хавсралт 1: Хөгжлийн шинжилгээнд ашиглагддаг зарим нэг статистикийн үзүүлэлтүүд

Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ) болон Үндэсний Нийт Бүтээгдэхүүн (ҮНБ): Тодорхой хугацаанд тухайн улсад шинээр бүтээгдсэн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэр юм. Нэг хүнд ногдох ДНБ-ээр тухайн улсын амьжиргааны түвшинг хэмждэг. Дотоодын нийт бүтээгдэхүүнд тухайн улсын хил дотор байгаа бүх үйлдвэрлэлийг оруулж тооцно. Харин ҮНБ гэдэг нь тухайн улсын оршин суугчдын хөдөлмөр болон хөрөнгөөр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнэлгээний нийлбэрийг хэлнэ. ДНБ нь үйлдвэрлэлийн газар зүйн байрлалд тулгуурлан тооцогддог бол ҮНБ нь үйлдвэрлэлийг тухайн үйлдвэрлэгчийн эзэмшлээс нь хамааруулж гаргадгаараа ялгаатай.

### Төлбөрийн болон худалдааны тэнцэл

Худалдааны тэнцэл = тухайн жилийн нийт экспортын хэмжээ – нийт импортын хэмжээ  
Худалдааны тэнцлийн индекс =  $\{(худалдааны тэнцэл)/ДНБ\} * 100$

Төлбөрийн тэнцэл = Худалдааны тэнцэл+ хөрөнгийн дотогшлох урсгал+ орж ирсэн зээл тусламж + шилжүүлэг (гадаадад буй Монголчуудын шилжүүлсэн мөнгөн гуйвуулга, Монголд буй гадаадын иргэдийн шилжүүлсэн мөнгөн гуйвуулга) – зээлийн эргэн төлөлт– ашгаа эх компани руугаа шилжүүлэх (Монгол дахь гадны компаний салбар, охин компани)

Төлбөрийн тэнцлийн индекс =  $\{(төлбөрийн тэнцэл)/ДНБ\} * 100$

### Төсвийн алдагдал

Төсвийн алдагдал нь засгийн газрын нийт орлого болон зарлагын зөрүү бөгөөд зээл, тусламжийг тооцоонд оруулахгүй.

### Инфляци

Тухайн хугацааны туршид эдийн засаг дахь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин нэмэгдэхийг инфляци гэнэ. Үнийн инфляцийг хэмждэг үндсэн үзүүлэлт нь “инфляцийн түвшин” буюу тухайн хугацааны туршид үнийн ерөнхий түвшинд гарсан жилийн өөрчлөлтийн хувь хэмжээ юм.

Инфляцийг тооцоход:

Инфляцийн түвшин =  $\{(P2-P1)/P1\} * 100$

Энд, 1 дэх жилийн үнийн индекс P1, 2 дахь жилийн үнийн индекс P2 гэж тэмдэглэв.

### Үнийн индекс

Дээрх томъёоноос харахад инфляцийг тооцоход гол нь P1, P2 олох явдал юм. Үнийн индексийг хэрэглээний сагсанд байгаа бүлэг бараа, үйлчилгээний тухайн жилийн үнийн дүн буюу үнийн дундаж түвшний уг бүлэг бараа, үйлчилгээний суурь жилийн үнийн дүн буюу үнийн дундаж түвшинд харьцуулан 100%-аар үржүүлж тодорхойлдог.



### Нэмүү өртөг

Аж ахуйн нэгж, эдийн засаг нь хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ нийлүүлэхээс өмнө түүнийг сайжруулсны үр дүнд гарч буй өөрчлөлтийг нэмүү өртөг гэдэг. Тавилгын үйлдвэрийн хувьд нэмүү өртөг нь нийт олсон орлогоос материалын зардлын үнийг (мод, будаг, хадаас г.м) хасч тооцогдоно. Орчин үеийн аж үйлдвэрийн салбар, тухайлбал электроникийн салбарын хувьд нэмүү өртгийг тооцох нь илүү төвөгтэй болж байна. Эйпл компаний Ай-фон гар утаснуудын жишээн дээр харъя:

Хятадад бүтсэн нэмүү өртөг: 5% (угсрах үйл ажиллагаа)  
АНУ-д бүтсэн нэмүү өртөг: 35% (дизайн, програм хангамж)  
Японд бий болсон нэмүү өртөг: 25% (өндөр технологийн хэсэг)  
Солонгост бүтсэн нэмүү өртөг: 15% (дэлгэц, хатуу диск)  
Их Британид бүтсэн нэмүү өртөг: 12% (ARM процессор)  
Бусад оронд бүтсэн нэмүү өртөг: 8% (гадаад үзэмж болон бусад)

### Бүтээмж

Бүтээмжийг дараах аргаар тооцдог:

- Хөдөлмөрийн бүтээмж = (Нэмүү өртөг)/(ажилчдын тоо) эсвэл
- Хөдөлмөрийн бүтээмж = (Нэмүү өртөг)/(ажилласан хүн цаг/өдөр)
- Орцын бүтээмж = НӨ /Орц

### Ашиг

Бизнесийн үйл ажиллагаанаас олсон орлогын зардлаас (үйл ажиллагааг явуулахын тулд гарч буй зардал, татвар) давсан хэмжээгээр санхүүгийн ашиг тодорхойлогдоно. Олсон ашиг нь бизнесийн эздэд үлддэг ба түүнийгээ бизнестээ дахин оруулах эсэхээ эзэд шийддэг.

Ашиг = Нэмүү өртөг – Элэгдэл – Цалин

Ашгийг татварын өмнөх ашиг (нийт ашиг) болон татварын дараах ашиг (цэвэр ашиг) гэж ангилдаг.

# БҮЛЭГ - 3

---

**БОДЛОГО  
ТӨЛӨВЛӨЛТ**



---





## БҮЛЭГ ГУРАВ. БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ


**Тойм:** Энэ бүлэг нь үндэсний, бүс нутгийн болон салбарын бодлогыг төлөвлөх зарчим болон шат бүрт хэрэгжилтийг хангах үйл явц, түүнийг хариуцах байгууллагын чиг үүргийг тусгасан. Эрсдлийн шинжилгээ, төслийн болон байгаль орчны үнэлгээ зэрэг тусгай сэдвүүдийг хөндсөн. Тус бүлэгт багтсан зарим нэг ойлголтуудыг хавсралтаар дэлгэрэнгүй тайлбарлав.

### 3.1 Төлөвлөлтийн зарчим ба үйл явц

#### Тодорхойлолт

Төлөвлөлт нь үндэсний, бүс нутгийн, орон нутгийн болон салбарын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зураглах үйл явц юм. Өөрөөр хэлбэл, Засгийн газар бодлогын зорилгоо тодорхойлж, түүнд хүрэх (бодлогод суурилан) стратегиа боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээгээ тогтоох, шаардлагатай нөөцийг төсөвлөх, хуваарилах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явцыг тус тус нарийвчлан төлөвлөх шаардлагатай. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь тухайн бодлого төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна уу, хүссэн үр дүндээ хүрч байна уу, залруулга, засвар, тодотгол хэрэгтэй байгаа эсэхийг тодорхойлох үүрэг гүйцэтгэдэг. Сайн төлөвлөлтийн тогтолцоо нь тодотгол, засвар, сайжруулалтыг тасралтгүй хийх боломжийг бүрдүүлсэн уян хатан байхыг шаарддаг (Зураг 3.1-т харуулав). Үүнийг **Үр дүнд суурилсан удирдлагын хүрээ**<sup>9</sup> гэдэг ба бодлогын зорилгоо тодорхойлж, түүний хэрэгжилт, хяналт- шинжилгээний үйл ажиллагааг богино болон дунд хугацаанд нэгтгэсэн тогтолцоо юм.

Зураг 3. 1 Үр дүнд суурилсан удирдлагын хүрээ



Үр дүнд суурилсан төлөвлөлт нь асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай орц, хэрэгжилтийг хангах арга зам, гарч болох хүндрэлүүдийг (хэрэгжилтийн

<sup>9</sup> Results-based Management Framework



хугацааны хоцрогдолыг оруулан) тодорхойлсон байдаг. Энэ нь үндэсний, бүс нутгийн болон салбарын бодлого төлөвлөлтөд аль алинд нь хамаатай юм. Макро болон микро түвшнээс үл хамааран бодлогын асуудалд шийдэл олоход тус бүрт нь Үр дүнгийн хүрээний зураглалыг боловсруулдаг.

Үр дүнгийн хүрээний зураглал нь шийдвэр гаргахаас үнэлгээ хийх хүртэлх төлөвлөлт нь шулуун шугамаар хийгдэх бус харин хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээний үр дүнд засаж сайжруулж байх уян хатан үйл явц болохыг харуулав. Энэ нь төлөвлөлтийн аргачлалыг сайжруулсан хэлбэр юм<sup>10</sup>.

Нөхцөл байдлын шинжилгээ хийсний дараа төлөвлөлтийн үйл явц нь дөрвөн үндсэн үе шатаас бүрддэг:

1. Бодлогод суурилан төлөвлөлт хийх,
2. Төсөвлөх,
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх,
4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Гарын авлагын энэ бүлэгт төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар харин Бүлэг 5-д нь хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тусгасан. Төсөв, санхүүжилтийн асуудал нь өргөн цар хүрээтэй, тусад нь авч үзэх шаардлагатай тул энэхүү гарын авлагад санхүүгийн нөөцийг тодорхойлох аргачлалыг товч дурдсан.

### Шигтгээ 3. 1 Үр дүнгийн хүрээ (ҮДХ) буюу Логик хүрээ (ЛХ)<sup>11</sup>

Үр дүнгийн буюу Логик хүрээ нь удирдлагын арга хэрэгсэл юм. Үр дүнгийн хүрээний гол зорилго нь асуудалд илүү төвлөрч, үр дүнд хүрэхийн тулд стратегиа тодорхойлж, нөөцийг зохистой хуваарилахад чиглэгддэг. Үр дүнгийн хүрээ нь шалтгаан-үр нөлөөний уялдаанд үндэслэн завсрын үр дүнд хүрснээр хөтөлбөрийн эцсийн зорилгод хүрэх хэд, хэдэн зорилтыг дэвшүүлсэн байдаг.

Мөн стратегийг баталгаатай хэрэгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг заавал тооцсон байна. Үр дүнгийн/логик хүрээ нь төслийг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц хүчин зүйлсийг таамагласан байх шаардлагатай. Төслийн хэрэгжилтийн биелэлтийг бататгах үүднээс төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц болон үйл ажиллагааны төрлийг ангилал тус бүрээр гарган тооцоолно.

Доорх зурагт ҮДХ болон ЛХ тус бүрийг хэрхэн ашигладгийг харуулав. ҮДХ нь ихэнхидээ үр дүнд хүрэхийн тулд хэд хэдэн стратегийн зорилтыг дэвшүүлдэг бол ЛХ нь зорилтод хүрэх арга замуудыг нэг шугаманд дараалсан байдлаар тодорхойлдог. Зургийг хэрхэн гаргаснаас шалтгаалан ҮХ-г нь ЛХ-нд багтааж болох ба мөн урвуугаар нь зураглаж болно.


Үндсэн ойлголт: ЛХ-г 1969 онд тусламжийн төслүүдийг боловсруулахад ашиглахаар гаргасан. Үүнээс хойш энэ хүрээг өргөжүүлэн сайжруулсаар ирсэн. Үүний дараа гарсан үйл ажиллагаануудыг нэг шугаманд дараалуулан жагсаасан байдаг ЛХ-ний урвуу нь болох ҮДХ нь хүрэх үр дүнд төвлөрсөн байдаг. Эдгээр нэр томъёонууд нь эцсийн дүндээ нэг ижил бөгөөд ялгаа нь ЛХ-г нь хандивлагч

<sup>10</sup> Үр дүнд суурилсан удирдлагын гарын авлага, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Нью-Йорк 2011, [http://www.undg.org\\_docs\\_12316\\_UNDG-RBM Handbook-2012.pdf](http://www.undg.org_docs_12316_UNDG-RBM Handbook-2012.pdf)

<sup>11</sup> Эх сурвалж: 'The Rosetta-Stone of Logical Frameworks', CARE International, <http://www.mande.co.uk/docs/Rosettastone.doc>



байгууллагуудын бүлэг (Европын Холбоо), ҮХ-г нь АНУ-ын Хөгжлийн Агентлаг, Дэлхий банк болон бусад хандивлагчид байгууллагууд ашигладагт байгаа юм.





### 3.2 Бодлого төлөвлөлтийн үр дүнгийн хүрээ

Үндэсний, бүс нутгийн, салбарын болон бусад хөгжлийн төлөвлөгөөг (түүний бүрэлдэхүүн хэсэг нь) боловсруулахад Үр дүнгийн хүрээг гаргах шаардлагатай байдаг. Үр дүнгийн хүрээг гаргах ердийн зураглалыг Зураг 3.2-т харуулав. Зурагт хөгжлийн зорилгоос эхлээд хэрэгжүүлэх стратеги болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явц, тэдгээрийн уялдааг харуулав. Тус ерөнхий схемийг бүх төрлийн болон хугацааны бодлогын баримт бичигт ашиглаж болно: урт, дунд хугацааны, үндэсний буюу орон нутгийн, салбарын буюу салбар хоорондын гэх мэт. Аль ч бодлогод судалгааны арга зүй, аргачлал ашиглан нотолгоонд суурилан нийгмийн асуудлын бодит байдлыг хөндөн төлөвлөж, шат бүрт хяналт-шинжилгээ хийснээр төлөвлөлт, түүний хэрэгжилтийг тасралтгүй сайжруулж байдаг.



Зураг 3. 2 Төлөвлөгөөний үр дүнгийн хүрээ<sup>12</sup>



### 3.3 Төлөвлөлтийн төрөл

Төлөвлөгөө нь үндэсний, бүс нутгийн, салбарын гэсэн төрөлтэй байж болох ба тухайлсан болон бүх салбарыг хамарсан урт, дунд, богино хугацаанд байж болно. Аливаа төлөвлөлтийн үйл явц нь урт хугацааны бодлогын баримт бичгээ боловсруулахаас эхэлдэг ба энэхүү бодлогын баримт бичгийг Vision document буюу **Үзэл баримтлал** гэдэг. Үзэл баримтлал нь хүмүүсийн амьжиргааны түвшин, нийгэм, эдийн засаг, улс төрийн байдлыг сайжруулах болон байгаль орчны доройтлыг бууруулах зэрэг ерөнхий зорилгуудыг


12 Эх сурвалж: 'A Framework for the Strategic Planning and Evaluation of Public Diplomacy', Joint Analysis and Lessons Learned Centre, Avenida Tenente Martins, Monsanto, 1500-598 Lisbon, 2013



дэвшүүлсэн байдаг. Үзэл баримтлалыг арай богино хугацааны бодлогод тусгаж, бодлогоо бодитой төлөвлөгөө болгож хэрэгжүүлдэг.

Салбарын бодлого нь улс орны хөгжлийн үзэл баримтлал нь хэрхэн уялдаж байгааг Зураг 3.3-т харуулав. Зурагт харуулснаар үндэсний болон салбарын дунд, богино хугацааны төлөвлөгөө нь урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байх ба зорилтуудаа тодорхойлсны үндсэн дээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргадаг. Энэхүү уялдааны талаар энэ бүлгийн төгсгөлд зорилтыг тодорхойлох гэсэн хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

**Зураг 3.3 Төлөвлөлтийн уялдаа**



### 3.3.1 Урт хугацааны бодлого

Урт хугацааны бодлогын баримт бичиг нь урт хугацаа (15-20 жил)-ны явцад хүрэх зорилго, зорилтыг нөхцөл байдлын дүн шинжилгээ, улс орны хөгжлийн ололт амжилт, сорилт, боломжид үндэслэн тодорхойлдог (Шигтгээ 3.1) ба энэ нь дунд болон богино хугацааны төлөвлөлтийн үндэслэл болдог. Урт хугацааны бодлогын зорилгод үндэслэдэг. Урт хугацааны үзэл баримтлалын баримт бичиг нь хүмүүсийн амьжиргааны түвшин, орлогын тэгш бус байдал, жендер, боловсрол, хүний нөөц, эрүүл мэнд (нялхасын эндэгдэл, насжилт, болон бусад), ажлын чанар, аж үйлдвэр, макро эдийн засгийн үндсэн тэнцвэрт харьцаа, байгаль орчин, эдийн засгийн болон нийгмийн салбарын нээлттэй байдлын талаарх хэтийн зорилтыг тодорхойлсон байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, “Нөхцөл байдлын шинжилгээ”-нд дурдсан гол үзүүлэлтийг сайжруулах явдал болно (Шигтгээ 3.2).



### Шигтгээ 3. 2 Турк улсын 2023 оны Алсын Хараа: Мэргэшлийн тэргүүлэх чиглэл<sup>13</sup>

Турк улсын 2023 оны Алсын хараа нь Бүгд Найрамдах улс байгуулагдсаны 100 жилийн ойгоос өмнө Туркийн Засгийн газраас тавьж буй зорилгын жагсаалт юм. Турк улсын Засгийн газар Алсын хараа баримт бичгийг 2001 онд баталсан. Алсын хараа нь улсын санхүүгийн бодлого, орлого, зарлага, хөрөнгө оруулалтын бодлого, мөнгөний бодлого, ажил эрхлэлтийн бодлого, судалгаа шинжилгээ, шинэ бодлого, микро эдийн засаг, хувиараа бизнес эрхлэх болон аж үйлдвэрийн бодлогууд, экспортын бодлого, аялал жуулчлалын бодлого, хөдөө аж ахуйн бодлого, уул уурхай, эрчим хүчний бодлого, тээвэр, дэд бүтцийн бодлогыг тоймлож өгнө. 2023 он гэхэд Алсын харааны дараах зорилгод хүрэхээр дэвшүүлжээ. Үүнд:

- ДНБ-ээ 2 их наяд ам долларт хүргэх,
- Нэг хүнд ногдох ДНБ 25,000 ам. Долларт хүргэх,
- Экспортыг 500 тэрбум ам.долларт хүргэх,
- Ажилгүйдлийн түвшинг 5 болон түүнээс доош хувьд барих,
- Инфляци, зээлийн хүүгийн тогтвортой бөгөөд бага түвшинд барих,
- Дэлхийн 10 том эдийн засагтай улс орны нэг болох.

Хөгжлийн төлөвлөлтийн үйл явцын тасралтгүй байдлыг хангахын тулд улс төрийн нам, хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн холбоод болон бусад бүлэглэлийн дунд энэхүү баримт бичгийн гол үзүүлэлтийн талаар хэлэлцүүлж, зөвшилцөлд хүрсэн байх нь зүйтэй.

#### 3.3.2 Дунд хугацааны бодлого

Дунд хугацааны бодлого нь урт хугацааны бодлогын баримт бичгийг бодитой хэрэгжүүлэх эхний алхам юм. Зарим улс орнууд “4-5 жилийн Төлөвлөгөө” гэж нэрлэдэг дунд хугацааны бодлого хэрэгжүүлдэг. Монгол Улсын хувьд хөгжлийн дунд хугацааны бодлогын голлох баримт бичиг нь “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” түүнийг дагалдаж гарсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” юм. Гэвч энэхүү баримт бичиг нь хүлээж байснаас бага нарийвчилсан тухайлбал хэрэгжилтийн механизм, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд хийгдэх санхүүжилт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар маш бага тайлбарласан байна. Зарчмын хувьд дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулах үйл явц наад зах нь 3 үе шатыг шаарддаг.

Үүнд:

1. Урт хугацааны үзэл баримтлалтай уялдсан байх,
2. Нийт оролцогч талууд (парламент, иргэний нийгэм, хувийн салбар болон бусад)-ын саналыг тусгасан, зөвшилцөл дээр үндэслэсэн байх,
3. Улс орны нөөц (ил болон далд), шингээх чадвартай уялдсан, бодитой байх,
4. Орон нутгийн хүн амын хүсэл эрмэлзлэл, нийтлэг эрх ашгийг хангахад чиглэгдсэн байх.

<sup>13</sup> Эх сурвалж : Туркийн Засгийн газрын Хөрөнгө оруулалтыг дэмжих, хөхиүлэх Агентлаг



Дунд хугацааны бодлого нь тодорхой байхаас гадна тухайн бүс, орон нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нийцтэй, ерөнхий томъёологдсон байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоотой ихэнх улс орнууд үндэсний болон салбар хоорондын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг төлөвлөх чиг үүргийг бодлогын яам эсвэл агентлаг (Камбожи улсын Төлөвлөлтийн яам, Лаос эсвэл Вьетнамын төлөвлөлт, хөрөнгө оруулалтын яам) хариуцдаг. Эдгээр байгууллага нь урт болон дунд хугацааны зорилтот түвшинд хүрэхийн тулд дунд хугацааны салбарын төлөвлөгөө, шаардагдах хөрөнгийн тооцоолол, салбарт хаана, хэзээ, хэр хэмжээний хөрөнгө оруулалт оруулахыг салбар, байршлаар боловсруулдаг.

Дунд хугацааны бодлого боловсруулахын өмнө урт хугацааны үзэл баримтлалтай уялдсан философи, уялдааг тайлбарласан **Дунд хугацааны бодлогыг боловсруулах удирдамж** бэлтгэх шаардлагатай.

### Шигтгээ 3. 3 Дунд хугацааны бодлого

Улс	Төлөвлөгөө	Тойм
Энэтхэг	12 дахь удаагийн 5 жилийн төлөвлөгөө (2013-2017)	<ol style="list-style-type: none"> <li>2012-2017 онд 8 хувийн дундаж өсөлтөнд хүрэх,</li> <li>Фермерийн салбарын өсөлтийг 4 хувиас нэмэгдүүлж, аж үйлдвэрийн салбарын өсөлтийг 10 хувьд хүргэх,</li> <li>8 хувийн өсөлтөд хүрэхийн зэрэгцээ 50 сая шинэ ажлын байр бий болгох,</li> <li>2017 оны сүүл гэхэд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг ДНБ-ий 9 хувьд хүргэн нэмэгдүүлэх,</li> <li>5 жилийн хугацаанд ядуурлын түвшинг 10 хувиар бууруулах,</li> <li>2020 онд гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 2005 оны түвшнээс 20-25 хувь бууруулах зорилтын дагуу ДНБ-ий хүлэмжийн хийн ялгарлын нягтшилийг бууруулахыг эрмэлзэх.</li> </ol>
Малайз	Малайзын 10 дахь удаагийн Төлөвлөгөө (2011-2015)	<ol style="list-style-type: none"> <li>ДНБ-ий жилийн өсөлтийг 6 хувь,</li> <li>2015 гэхэд нэг хүн ногдох Үндэсний нийт бүтээгдэхүүнийг 12,139 ам.долларт хүргэх,</li> <li>2015 он хүртэл үйлчилгээний салбарын жилийн өсөлтийг 7.2 хувьд хүргэснээр ДНБ-д тус салбарын эзлэх хувь 2010 оны 58 хувиас 2015 онд 61 хувьд хүрэх,</li> <li>Дэд бүтэц, боловсрол, аялал жуучлал, эрүүл мэндийн тэргүүлэх салбарын хөгжлийн зөрүүг арилгахын тулд 20 тэрбум Малайз долларын сан байгуулах,</li> <li>2009 онд экспортын хэмжээ 1.16 их наяд малайз долларт хүрч худалдааны эргэлт ДНБ-ээс хоёр дахин их байсныг 2015 онд гэхэд 2.19 их наяд малайз долларт хүргэх,</li> <li>2015 он гэхэд усан цахилгаан, нүүрс, шингэн хий зэрэг эрчим хүчний хоёрдогч эх үүсвэрийг ашиглах замаар эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх.</li> </ol>

Хөгжиж буй, буурай хөгжилтэй улс орны дунд хугацааны бодлогод зориулсан бодлогыг боловсруулах удирдамжийн жишээг энэ бүлгийн хавсралт 1-т үзүүлэв. Дунд хугацааны бодлогыг боловсруулах удирдамжийг эцэслэн боловсруулахаас өмнө Засгийн газар болон бусад эрх ашиг нь хөндөгдөх



бүлгийн оролцогчид (хувийн салбар, иргэний нийгэм, сөрөг хүчин, орон нутгийн сонирхлын бүлэглэл болон тэргүүлэх төрийн бус байгууллагууд) түүнийг хэлэлцэх шаардлагатай юм.

Дунд хугацааны бодлогыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын удирдлага дор салбар, хэрэгжүүлэгч яамд хамтран боловсруулна. Салбарын яамд өөрийн хариуцах хэсгийн бодлогын төслийг боловсруулж холбогдох яам (нэгээс илүү яамд байж болно. Үүнд сангийн яам, гадаад харилцааны яам, боловсрол, хөдөө аж ахуйн, үйлдвэрийн яамд)-д хүргүүлнэ. Дунд хугацааны бодлого нь дараахь суурь баримт бичгүүдэд тулгуурладаг. Үүнд:

1. Урт хугацааны “Үзэл баримтлал”,
2. Салбарын урт хугацааны бодлого,
3. Орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг тусгасан байх,
4. Өмнөх төлөвлөгөөний хугацааны дунд үеийн хэрэгжилтийн биелэлт,
5. Одоогийн дунд хугацааны бодлогыг боловсруулах удирдамж.

Үүнээс гадна хамгийн сүүлийн үеийн мэдээлэл дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулахад нэн чухал болдог (Бүлэг 2 Нөхцөл байдлын шинжилгээг үзнэ үү).

Бодлого төлөвлөлтийн уялдааг хангах, зохицуулах төрийн захиргааны төв байгууллага нь дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулах, нэгтгэх, хоорондын уялдааг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ зохицуулалтын Загвар гарын авлагыг энэ бүлгийн хавсралт 2-т харуулав.

*Тайлбар: Салбарын төлөвлөгөөнд бодитой хэрэгцээ шаардлагыг тусгахын тулд салбарын яамд нь орон нутаг (аймаг, сум болон бусад)-ийн удирдлагатай хурал зохион байгуулах болон бусад хэлбэрээр харилцахын хамт хамгийн сүүлийн үеийн судалгааг авч үзэх үүрэгтэй.*

Дунд хугацааны бодлого нь зорилтот түвшин, хүлээх үүрэг, хуваарилалт, жилд гарах ахиц, дэвшлийг агуулсан баримт бичиг юм. Энэхүү баримт бичиг нь хуулийн үйлчлэх хүрээнд хариуцлагыг сайжруулах болон төвлөрлийг сааруулахад чиглэгдсэн байдаг.

**Анхааруулга 1:** Орон нутгийн түвшинд эрх мэдлийг шилжүүлэх боломжийг (хэрэгжүүлэх, хүний нөөц болон санхүүгийн) олгох уу?

**Анхааруулга 2:** Санхүүгийн төвлөрлийг сааруулах, эрх мэдлийг шилжүүлэхэд орон нутагт материаллаг бааз байгаа юу?

**Анхааруулга 3:** Төвлөрлийг сааруулах үйл явцын үр дүнд тавьсан зорилгоо үр дүнтэй хэрэгжүүлэх тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо (ялангуяа мэдээллийн тогтолцоо) найдвартай юу?







### 3.3.3 Жилийн төлөвлөгөө

Жилийн төлөвлөгөө нь дунд хугацааны бодлогыг жил жилээр хуваарилсан төлөвлөгөө боловч энэ нь дунд хугацааны төлөвлөгөөг механик байдлаар нэг нэг жилд хуваана гэсэн үг биш юм. Дунд хугацааны бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилт нь жил бүрийн санхүүгийн болон бусад нөөцтэй уялдсан зорилтуудад хуваагддаг.

Үндэсний дунд хугацааны бодлогод үндэслэн яамдууд өөрийн салбарын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулна. Яамдын төлөвлөгөө нь улсын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдаатай, тооцоо, судалгаа, мэдээлэлд суурилсан байх шаардлагатай. Жишээ нь: Суурин газар, аж үйлдвэрийн төвүүдийн хэмжээ, байршлыг мэргэжлийн сургалтын институт, орон сууц болон ажилчдын хүүхдийн боловсролын байгууллага зэрэг бусад байгууллагатай холбоотойгоор сонгодог. Салбарын анхдагч мэдээлэл болон салбарын эцэслэсэн төлөвлөгөөний ялгааг дараах шинж чанараар гаргаж болно.

Үүнд:

1. Төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэхийг нарийвчлан тусгасан,
2. Төвлөрлийг сааруулах хүрээнд ажил үүргийн хуваарилалтын бүтцийг оруулсан,
3. Төрөл бүрийн хөтөлбөр, төслийн санхүүжилтийг тодорхойлсон,
4. Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн жагсаалт – нэг удаагийн эсвэл 4 жилээр хойш гүйлгэх хэлбэрээр) боловсруулсан,
5. Яамд, агентлагийн хоорондын хамтын ажиллагааны хүрээ, салбар хоорондын асуудалд хамтын ажиллагааг хэрхэн зохицуулах талаар тодорхойлсон,
6. Газруудын мэдээлэл, материалыг ашиглан үндэсний хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоотой уялдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний дэд төлөвлөгөөг гаргасан,
7. Газруудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь ерөнхийдөө орц, гарцыг харуулна.

*Тайлбар 1: Зарим орнуудын засгийн газар салбар хоорондын асуудал болох хүүхэд, жендэр гэсэн тусгайлсан сэдвээр төлөвлөгөө хийдэг завсрын үе шаттай байдаг. Гол зөвлөмжийг салбар/хэрэгжүүлэгч яамд өөрсдийн жилийн төлөвлөгөөнд тусгадаг. Уг арга барилыг баримталдаг шалтгааны нэг нь салбар хоорондын асуудал өөрөө чухал ч гадаад санхүүжилтийн эх үүсвэртэй бас уягдсан байдаг.*

*Тайлбар 2: Салбарын төлөвлөгөөг дэд салбар эсвэл үйл ажиллагааны ажлын төлөвлөгөө болгон задалдаг. Жишээ нь анхан шатны, дунд болон дээд/мэргэжлийн боловсролын бие даасан дэд төлөвлөгөө байж болно. Эдгээр нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн жагсаалт, хөтөлбөр төсөл бүрийн үнэлгээ, тойм (ТХҮА) зэргийг оруулсан илүү нарийвчилсан байдаг. Эцэст нь төлөвлөгөө нь ТХҮА графиктай уялдсан үнэлгээний бүрэлдэхүүн болсон найдвартай хяналт-шинжилгээ багтаасан байна.*




### Шигтгээ 3. 4 Төслийн үнэлгээ, хяналтын арга хэрэгсэл

Төслийн үнэлгээ, хяналтын арга хэрэгсэл (ТХҮА) нь бие даасан төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашигладаг аргачлал юм. ТХҮА нь хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх замын зураглал бөгөөд бүх үндсэн үйл ажиллагаануудыг харилцан хамааралтай хамт тодорхойлдог. ТХҮА-ын диаграм нь ихэвчлэн хойноосоо урагшаа хийгддэг, учир нь ихэнхи төслийн хувьд дуусах хугацаа нь тодорхой байдаг ба гэрээлэгч нь төслийг эхлэх тал дээр уян хатан байдаг. ТХҮА-ыг ашиглан төлөвлөхийн үндэс нь бусад үйл ажиллагаануудаас шалтгаалдаг чухал үйл ажиллагаануудыг тодорхойлоход оршдог.

ТХҮА-ын дүн шинжилгээний гол шинж чанар нь төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусахад шаардлагатай гол үйл ажиллагаанууд болон тэдгээрийн дарааллыг харуулсан хамаарлын зураглалыг боловсруулах явдал юм. Үйл ажиллагаанууд нь төслийг хэрэгжүүлэхэд цаг хугацаа, нөөц шаардсан тус тусдаа үе шатуудад хуваагдсан байдаг. Хамаарлын зураглал нь сум болон огтлолцлын цэгүүдээс бүрдсэн байдаг ба үйл ажиллагаа бүрийг явуулах дараалал болон шаардлагатай хугацааг харуулсан байна. Төслийн менежерийн төслийн үйл ажиллагаа болгоны хугацаа харилцан адилгүй бөгөөд тодорхой хэмжээнд баталгаатай байдаг. Хугацаа нь илүү тодорхой байвал баталгаатай тооцоолол гэж үздэг. Харин хугацаа нь өөрчлөгдөхөөр байвал тэдгээрийг магадлалтай тооцоолол гэж үздэг. Магадлалтай аргачлалыг ашиглахдаа төслийн менежерүүд үйл ажиллагаа бүрт гурван төрлийн таамаглал дэвшүүлдэг: өөдрөг буюу хамгийн сайн, гутранги буюу хамгийн муу болон хамгийн их магадлалтай. Статистикийн аргачлал ашиглан таамаглал бүрийн өөрчлөлтийн хэмжээг тооцоолж үйл ажиллагаа бүрт гарч болох хугацааны тодорхойгүй байдлыг тооцоолж болно. Таамаглал бүрийн стандарт хазайлтыг тооцоолсноор төслийг бүрэн хэрэгжүүлж дуусахад шаардагдах магадлалтай хугацааг олно.

Зураг 3. 4 Компьютерийн танхим тохижуулахад ашиглаж болох ТХҮА-ийн зураг





### 3.3.4 Салбарын бодлого

Салбарын бодлогыг салбарын яамд үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу төлөвлөдөг. Энгийн жишээ дурдвал, зам, ус, ариун цэврийн байгууламж, ДОХ-ыг бууруулах, бүх нийтийн боловсрол гэх мэт асуудлаар салбарын бодлого байна. Эдгээр бодлогууд нь ихэнхидээ урт хугацааны (8-10 жил) байх ба эдгээр бодлогыг хэрэгжүүлэн үр дүнг нь үзэхэд урт хугацаа шаардагддаг.

Салбарын урт хугацааны бодлого нь үйл ажиллагааны зорилготой, жил бүрийн зорилттой дунд хугацааны бодлого болон жилийн төлөвлөгөөнд задардаг. Салбарын дунд хугацааны бодлого нь Үндэсний дунд хугацааны бодлоготой уялдсанаар салбар дундын уялдааг хангадаг. Салбарын жилийн төлөвлөгөө нь үндэсний болон бус нутгийн жилийн төлөвлөгөө болон санхүүжилтийн эх үүсвэртэй уялдсан байна.

### 3.3.5 Бүс нутгийн болон орон нутгийн бодлого

Улс орнууд засаг захиргааны нэгжид хуваагддаг. Иймд бүс нутгийн болон орон нутгийн бодлогод анхаарал хандуулах шаардлагатай болдог.

1. Батлан хамгаалах, гадаад харилцаа, уул уурхайн салбар болон хөгжлийн ихэнхи салбаруудын үйл ажиллагааг Засгийн газар хариуцдаг ба орон нутгийн захиргаа үндэсний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцдаг.
2. Хот төлөвлөлт, мал аж ахуй, нийгмийн дэд бүтэц гэх мэт асуудлыг нутгийн захиргаа хариуцдаг.
3. Орон нутгийн зам, явган хүний зам, хүүхдийн тоглоомын талбай, мал аж ахуйн зарим асуудлыг хотын Засаг даргын Тамгын газар хариуцдаг.

Хүн ам нягтрал ихтэй зарим улсад татварын орлогын нилээд хэсгийг орон нутгаас хуримтлуулдаг. Түүнчлэн, Засгийн газрын төвлөрүүлсэн татварын орлогыг орон нутагт хуваарилах тогтолцоотой байдаг. Монгол Улсын хувьд татварын болон татварын бус орлогын дийлэнхийг Засгийн газар төвлөрүүлдэг ба Төсвийн тухай хуульд зааснаар Засгийн газраас орон нутаг руу санхүүжилт олгодог. Энэ нь нийт нэмэгдсэн өртөгийн албан татварын 27 хувь, уул уурхайн салбарын орлогын 5 хувиас бүрдсэн Орон нутгийн хөгжлийн сан юм. Аймгууд болон Улаанбаатар хотын дүүргүүд болон сумдын удирдлагууд 2012 оны Нэгдсэн төсвийн тухайн хуульд заасан тэргүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилготой тус сангаас гарч буй санхүүжилтийг зарцуулдаг.

Монгол Улс орон нутагт тулгамдаж буй асуудлаа шийдэх, бодлого боловсруулах, төсөв хуваарилахдаа сум, хорооны иргэдийн оролцоог хангах зорилгоор “Шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг”-ийг



батлан хэрэгжүүлж байна. Мөн энэхүү бодлогын хүрээнд "Төсвийн тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

Бүс нутгийн бодлогын зарчим нь бусад энд дурдсантай адил боловч эрх зүйн хэм хэмжээ нь хязгаарлагдмал бөгөөд хөрш зэргэлдээ аймгууд нөөцөө хуваарилах асуудал нь маш чухал нөлөөтэй байдгаараа ялгаатай. Жишээ нь: усны нөөцийг хуваарилах асуудал. Бүс нутгийн бодлогын зорилго нь ДНБ-ий өсөлт, инфляци зэрэг асуудалтай шууд уялдахгүй ч хүн амын амьдрах, ажиллах орчныг сайжруулахад чиглэсэн байна.

Орон нутгийн сангийн нөөцийг хуваарилахтай холбоотой зарим тэргүүлэх салбаруудыг дор жагсаав:

1. Хот төлөвлөлт, байгуулалт – зам, дэд бүтэц болон бусад,
2. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил,
3. Ядуурлыг бууруулах,
4. Хөдөө аж ахуйн хөгжил,
5. Байгалийн нөөцийн ашиглалтыг сайжруулах.

*Тайлбар: Үндэсний бодлого нь бүс нутгийн хөгжлийн асуудлыг тусгах хэмжээнд уян хатан байх шаардлагатай байдаг. Мөн бүс нутгийн хөгжлийн бодлого нь үндэсний бодлоготой нягт уялдсанаар Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс гадна Засгийн газраас хуваарилсан төсвийн санхүүжилтээс хэтрэхээргүй байна.*

### Шигтгээ 3. 5 Үндэсний болон орон нутгийн хариуцлага–Олон улсын туршлага

Зарим улсад Үндсэн хуулиараа төсвийн хуваарилалт, хариуцлагын асуудлыг үндэсний болон бүс нутгийн удирдлага болон салбар бүрээр зохицуулсан байдаг. Хэрэв ямар нэгэн маргаантай асуудал гарвал үндсэн хуулиар байгуулагдсан ажлын алба авч хэлэлцдэг. Түүнчлэн үндэсний болон бүс нутгийн удирдлагын төсвийн санхүүжилтийг хуваарилах томъёо ашигладаг. Эрх зүйн хэм, хэмжээ болон санхүүжилтийн хуваарилалтыг таван жил тутамд хянадаг.

1. Засгийн газрын хариуцах салбарын асуудлын жагсаалтыг Парламент нь орон нутгийн удирдлагатай хамтран гаргаж, тохиролцдог.
2. Орон нутгийн хариуцах салбарын асуудлын жагсаалтыг Парламент нь орон нутгийн удирдлагатай хамтран гаргаж, тохиролцдог.
3. Давхардсан салбар, үйл ажиллагааны жагсаалтыг (Засгийн газрын болон бүс, орон нутгийн) гаргаж, тохиролцдог. Эдгээр асуудлыг Парламент нь орон нутгийн удирдлагатай хамтран таван жил тутамд хянадаг. Институцийн зохион байгуулалтын зарчмыг Үндсэн хуулиар баталгаажуулдаг.

#### ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Тухайн улсын урт хугацааны Үзэл баримтлал нь улсын нийт иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх болно. Гэвч Дунд хугацааны сүүлийн үеийн төлөвлөгөөнөөс харахад шилжилт хөдөлгөөн ихтэй цөөн тооны суурин газруудад уг салбарын хөрөнгө оруулалт хэт төвлөрсөн байна. Алсын хараа болон Дунд хугацааны төлөвлөгөө хоорондоо зөрчилдсөн байна уу?

**Дасгал 2:** Шинэ засгийн газар тээврийн салбарын тэргүүлэх чиглэлд өөрчлөлт оруулсан. Өмнө нь замд ихээхэн хөрөнгө оруулж байсан бол одоо Зүүн-Баруун чиглэлийн төмөр замд төвлөрч байна. Алсын хараа болон Дунд хугацааны Төлөвлөгөө хоорондоо зөрчилдсөн байна уу?



**Дасгал 3:** Монгол Улсад төвлөрлийг сааруулж, орон нутгийн түвшинд төлөвлөлт хийх нь ямар сөрөг талуудтай вэ?

### 3.4 Зорилго тодорхойлох

Бодлогын зорилго, зорилтыг хэрхэн тоон утгаар илэрхийлэх вэ?


*Зарчмын хувьд бүх зорилтууд нь эрэлтэд суурилсан байдаг. Макро эдийн засгийн түвшинд эдгээр эрэлт нь улс төрийн үйл явцаар тодорхойлогддог бол салбарын болон микро түвшний эрэлт нь шаардлагатай хэрэгцээ болон бодит нийлүүлэлт дээр үндэслэдэг. Эцсийн дүнд хөгжлийн зорилт нь Хүний хөгжлийг хангахад чиглэгдсэн байх шаардлагатай. ДНБ-ий өсөлт, салбарын өсөлт, бүс нутгийн ялгаатай байдал болон тэгш бус байдлыг бууруулах зэрэг зорилтууд нь бүгд эрэлтэд үндэслэсэн, үр дагавраас гарсан зорилтууд юм. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн зорилтууд ч өнөөгийн болон ирээдүйн хүн төрөлхтөн тогтвортой оршин тогтнох, хүний хөгжлийг сайжруулахад үндэслэсэн байдаг.*

*Асуулт: Бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь хувийн хэвшлийнх байхад Засгийн газар яагаад улсын болон салбарын хэмжээнд зорилт тавьдаг вэ?*

*Хариулт: Эдгээр зорилт нь дэд бүтэц, хүний хөгжил, хотын хөгжил гэх зэрэг тухайн салбарын асуудлаар макро эдийн засаг болон хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд чухал байдаг.*

Бодлого, төлөвлөгөөний зорилтууд нь зорилгоос урган гарах ба зорилго нь тодорхой хугацаанд хэмжигдэхүйц, хянаж болохоор байна. Энэхүү логикийг урвуугаар нь харвал, сонгосон шалгуур үзүүлэлтүүд нь зорилтод чиглэсэн, зорилт нь зорилгодоо хүрэхэд чиглэсэн байна.

#### Зураг 3. 5 Зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт тодорхойлох





Дээрх зурагтай уялдуулан Ядуурлыг бууруулах гэсэн зорилго дэвшүүлэн, нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэсэн хоёр зорилт тавья. Нэгдүгээр зорилтын хувьд эхний гурван шалгуур үзүүлэлт нь ядуу хүмүүст шинээр олгосон тэтгэврийн хэмжээ, ядуу оюутнуудад олгосон тэтгэлэг болон зорилтот бүлэгт олгосон бэлэн мөнгөний шилжүүлэг бол хоёрдугаар зорилтын хувьд шалгуур үзүүлэлт нь шинээр бий болсон цалинтай ажлын байрны тоо байх юм.

Зорилт болон шалгуур үзүүлэлт нь бие биенийхээ толин тусгал юм. Шалгуур үзүүлэлт нь зорилтод хүрсэн амжилтыг үнэлэхийн зэрэгцээ үр ашгийг хэмжих боломжийг бүрдүүлдэг. Ингэсэнээр хэрэгжиж буй бодлогыг (үйл ажиллагаа, орц) засч сайжруулах талаар санал дэвшүүлдэг. Тэргүүн туршлагаас харахад бодлого төлөвлөлт хариуцсан болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчид хамтдаа зорилт, шалгуур үзүүлэлтээ тодорхойлдог байна. Шалгуур үзүүлэлтүүд нь тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай байх шаардлагатай. Энэ талаар тавдугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Зорилгыг урт хугацаанд дэвшүүлдэг. Жишээ нь: Хөгжлийн үзэл баримтлалд хөгжлийн зорилгуудыг дэвшүүлнэ. Тэдгээрт зорилгууд дээр үндэслэн дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөний зорилтуудыг тодорхойлно. 20 жилийн урт хугацааны зорилго нь механикаар таван ширхэг дөрвөн жилийн төлөвлөгөөний таван зорилтуудад ба 20 ширхэг нэг жилийн зорилтуудад хуваагдаж болохгүй. Урт хугацааны зорилгод үндэслэн дунд хугацааны болон жилийн зорилтуудыг дэвшүүлэх онцгой аргачлал байхгүй ч, доорхи асуудлуудыг анхаарах нь зүйтэй:

1.Зорилго, стратегиуд нь ихэнхи тохиолдолд шууд шугаман хамааралтай байдаггүй. Тус хамаарлыг урт хугацааны статистикийн болон эконометрикийн аргачлалд суурилан тооцсон мэдээлэлд үндэслэн гаргадаг.

2.Хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд гарах цаг хугацааны хоцрогдлыг тооцох нь чухал. Бүх нийтийн бага боловсролын асуудлыг авч үзье. Зарим улсад хүн ам нь маш тархуу суурьшсан, дэд бүтэц хөгжөөгүй, сургалтын тоног төхөөрөмж хангалттай байдаггүй. Энэ тохиолдолд сургууль шинээр барих, багш нараа ажилд авах болон сургуулийг тоног төхөөрөмжөөр хангахад 2-3 жил шаардагдах ба мөн энэ хугацаанд хүүхдүүдийг шууд сургуульд хамруулах боломжгүй юм. Харин сургууль үйл ажиллагаагаа бүрэн явуулахад бэлэн болсон үед л сургалтанд хамрагдах боломжтой бөгөөд 2-3 жилийн дараа энэхүү түвшин нэмэгдэх магадлалтай.

3.Салбар хоорондын хамаарал, уялдаа нэн чухал. Тухайлбал, төвлөрлийг сааруулах гэсэн урт хугацааны зорилго тавилаа гэж үзье. Энэ





зорилго нь тээвэр, харилцаа холбоо, болон бусад дэд бүтцийг орон нутагт хэр сайн хөгжүүлэхээс хамаарна. Эдгээр дэд бүтцийг бүтээн байгуулахад дор хаяж 4-5 жил шаардлагатайгаас гадна хүмүүсийг татахын тулд эдийн засгийн наад захын үйл ажиллагааг явуулахад тохиромжтой орчинг бүрдүүлэх шаардлагатай. Тиймээс эхэндээ хүн амын тархалт ялимгүй байх ч бага багаар нэмэгдэх магадлалтай. Харин арваад жилийн дараа л хүн амын тархалтын огцом өсөлт гарч болох юм.

Урт хугацааны зорилгыг арай богино хугацааны зорилт болгоход тухайн зорилгын онцлогийг агуулсан байх ба тэдгээр зорилтуудыг дэвшүүлэхэд өргөн хүрээний судалгааг шаарддаг.

### **3.5 Дунд хугацааны бодлого болон нэг жилийн төлөвлөгөөний зорилт**

ДНБ-ий өсөлтийн зорилтот түвшин 7-8 хувь байхад эдийн засаг тогтвортой өснө гэж үздэг ч энэ түвшинг гэнэтийн тэнцвэргүй, тогтворгүй байдалд хүргэх хэт өндөр биш мөн амьжиргааны түвшинг сайжруулахааргүй хэт бага байхаар тодорхойлдоггүй. Салбар бүрийн өсөлтийн түвшинг тодорхойлохдоо сайтар хэлэлцүүлэх шаардлагатай юм.

Өсөлтийн үндсэн зарчим бол урт хугацааны тогтвортой байдал болохоос өсөлтийн тоон утга биш юм. Богино хугацааны хэт хурдацтай өсөлт (өндөр хэлбэлзэл) тэнцвэргүй байдалд хүргэж болох ба энэ нь хор уршигтай байдаг. Жишээлбэл, дэлхийн зах зээлийн түүхий эдийн үнэ огцом буурах эсвэл хялбар аргаар олборлох нөөц дуусах эдгээр нь нэгэн зэрэг тохиолддог учраас түүхий эдийн үйлдвэрлэлд суурилсан 12-14 хувийн өсөлт 3-4 жил өнгөрмөгц тогтворгүй болдог. Гэсэн ч 3-4 жилийн их өндөр өсөлт нь бусад салбарт түлхэц (мөн хүмүүсийн хүлээлтийг) өгдөг бөгөөд түүхий эдийн хэрэгцээ буурах эсвэл үнэ буурахад өндөр өсөлт хангагдахгүй болдог. Энэ үед Голланд өвчний аюул (баялгийн хараал) бий болдог ба эдийн засгийн бусад үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх аюултай. Удаан өсөлт (жилийн <3-4%-ийг хүсэшгүй доогуур гэж нийтээр хүлээн зөвшөөрснийг энд хэлэх нь илүүц билээ.

#### **3.5.1 Хөдөө аж ахуй**

Энэ салбар биологийн хязгаарлалтыг тооцон хамгийн сайн жилдээ 3-4 хувь өсдөг. Хөдөө аж ахуйн эмзэг орчинтой Монгол шиг улсуудын хувьд өсөлт бага байх бөгөөд саяхан ган, зуд зэрэг цаг агаарын нөхцөл муудахад сөрөг буюу уналттай болдог.

#### **3.5.2 Аж үйлдвэр**

Хятад улсын аж үйлдвэрийн салбар хамгийн сайн үедээ 10-14 хувийн өсөлттэй байсан бөгөөд энэ нь онцгой тохиолдол юм. Аж үйлдвэрийн салбарын өсөлт өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалт, илүүдэл хүчин чадал, дэлхийн зах зээлийн эрэлтээс хамаардаг. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн салбарын өндөр



өсөлтийг (онцгой тохиолдол болох Хятад улсаас гадна) цөөн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг улс орнууд (Камбожи, Вьетнам, Лаос) үзүүлсэн. Ерөнхийдөө өсөлт тогтвортой байх хэрэгтэй бөгөөд 8-10 хувийн өсөлтийг хүлээн зөвшөөрөхүйц (Зүүн өмнөд, Хойд азийн орнуудад ажиглагдсан) гэж үзэж байна. Уул уурхайн салбарт үүнээс өөр дүр зураг ажиглагддаг. Хэрэглээ эрчимтэйгээр нэмэгдэж байснаа огцом бууралт гардаг ба үүнийг байгаль орчны доройтол дагалддаг. Цаашлаад нөхөн сэргээгдэхгүй баялгийн хувьд урт хугацааны эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр болоход хязгаарлагдмал байдаг.

*Тайлбар 1: Арлын жижиг улс Науру нь 1960, 1970 оны үед фосфорын нөөцдөө түшиглэн нэг хүнд ногдох ДНБ-ний хувьд баян улсуудын нэг байлаа. Нөөц дууссаны дараа Науру нь байгаль орчны томоохон асуудалтай, бага дунд орлоготой орон луу шилжсэн.*

*Тайлбар 2: Хүний чадавхийг ашиглан нөөц, экологи, байгаль орчноо хамгаалах замаар буй болсон үнэ цэнэд суурилсан өсөлт урт хугацаанд тогтвортой байдаг. Үүнээс гадна тогтвортой эдийн засагтай байх үйл явц нь орлогын зөв, зохистой хуваарилалт, нийгмийн тогтвортой байдлыг хангадаг.*

*Тайлбар 3: Уул уурхай, нефть, нүүрс болон бусад эх үүсвэрээс гэнэт олсон орлогоо засгийн газар найдвартай бөгөөд итгэл даахуйц (сайн хөгжсөн зах зээл) чиглэлээр хөрөнгө оруулалт хийж орлогыг сайн удирддаг. Оруулсан хөрөнгө оруулалтыг аажмаар дэд бүтэц, хүний хөгжил болон улс орны бусад тэргүүлэх чиглэлд зарцуулдаг. Тэргүүн туршлагатай орны нэг бол Норвеги улс юм. Газрын тосны орлогоо ирээдүй хойч үеийнхэндээ тогтвортой, хангалттай орлогын эх үүсвэр болгохоор хөрөнгө оруулалтыг хийж чадсан. Хятад улс АНУ-ын засгийн газрын үнэт цааст хөрөнгө оруулалт хийж байна. Хүний болон материаллаг хүчин чадлыг буй болгоход хөрөнгөө ухаалгаар зарцуулж буй улсын жишээ бол Малайз юм. Монгол Улсын хувьд "Тогтворжуулалтын сан" байгуулсан бөгөөд түүнийг зохистойгоор удирдах шаардлагатай байна.*

### 3.5.3 Үйлчилгээний салбар

Ихэнх хөгжиж буй орнуудын үйлчилгээний салбарын өсөлтийн эх сурвалж нь санхүүгийн гүнзгийрэлт, тээвэр, аялал жуучлал, жижиглэн худалдаа, холбооны салбарын хөгжил юм. Эдгээр нь худалдаа, тээвэр, барилгын салбарт түлхэц болж чадна. Зүүн өмнөд болон Зүүн Азийн орнуудын (Бангладеш, Энэтхэгийн зарим хэсэг) сүүлийн үеийн туршлагаас харахад үйлчилгээний салбарын жилийн өсөлт 7-8 хувийн түвшинд байх нь тогтвортой болон хүлээн зөвшөөрөгдөх түвшин гэж үзэж байна. Монгол улс төвлөрсөн бус төлөвлөлт, санхүүгийн эрх мэдлийг саармагжуулахыг зорьж байгаа нь эдийн засгийн өсөлтийн хөшүүрэг болж болох юм. Дэд салбарын нарийвчилсан зорилтот түвшинг тогтоох дасгал нь өсөлтийн хөдөлгүүр болсон салбарын хэрэгцээ, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу дэд салбар болон орон нутаг бүр шинжилгээ хийхийг шаарддаг. Зарим нэмэлт мэдээллийг энэ бүлгийн хавсралт 1-ээс үзнэ үү.

*Тайлбар: Салбарын хөгжлийн бодлогын зорилт нь аливаа улс хэрхэн хөгжих эрмэлзэлтэй байгаагаас ихээхэн шалтгаална. Хэрэв тухайн улс эрчим хүч ихээр ашиглах аж үйлдвэрийг хөгжүүлэх зорилттой бол нүүрс, газрын тос болон эрчим хүчний салбарыг хөгжүүлэх нь тэргүүлэх зорилт юм. Харин тус улс өргөн уудам газар нутгийг хөгжүүлэх эрмэлзэлтэй бол зам, төмөр зам, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх нь тэргүүлэх зорилт болох юм.*





### 3.6 Бүс нутгийн хөгжлийн зорилтыг тодорхойлох нь

Бүс нутаг, орон нутгийн хөгжлийн зорилтыг тодорхойлохдоо үндэсний хөгжлийн зорилттой уялдуулдаг. Орон нутаг нь нэг талаас үндэсний бодлогуудыг хэрэгжүүлэхэд чиглэдэг бол нөгөө талаас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн орон нутгийн дэд бүтэц, хүн амын амьжиргаа, сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг бие даан боловсруулж, хэрэгжүүлдэг. Бүс нутгийн хөгжлийн зорилтыг тодорхойлохдоо дараах хүчин зүйлийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

1. Хөгжлийн зорилт нь эрэлтэд суурилсан, тодорхой асуудалд чиглэсэн байх,
2. Хөгжлийн зорилт нь ерөнхийдөө орон нутгийн хэмжээнд гарцад, улсын хэмжээнд үр дагаварт төвлөрсөн байх.

**Асуулт:** Орон нутгийн тулгамдаж буй асуудал болох “Гудамжны гэрэлтүүлэг”-ийн талаар нөхцөл байдлын шинжилгээ хэрхэн хийж, зорилтоо тодорхойлох вэ?

**Хариулт:** Замын урт болон хэмжээг гаргана. Дараа нь гудамжны гэрэлтүүлгийг шөнө ашиглах боломж болон иргэдэд тулгарч буй асуудал (аюулгүй байдал, осол, аялах боломжоор хязгаарлагдах гэх зэрэг), болон гудамжны гэрэлтүүлэггүй байснаас гарч буй үр дагаврыг олж харна. Энэ талаар оршин суугчид, байнгын жуулчид, эмэгтэйчүүд, хүүхдүүд, худалдаачид, жолооч гэх зэрэг хүмүүсээс судалгаа авна. Энэ мэдээлэл нь гудамжны гэрэлтүүлэг хэр их ач холбогдолтой байгаа талаар мэдээлэл өгнө.

**Тайлбар:** Аймаг, сумын түвшинд хөгжлийн бодлого төлөвлөх талаар гарын авлагыг Мерси Корп, Сангийн яам, Дэлхий банк боловсруулсан байдаг. Тиймээс энэ түвшинд төлөвлөлт хийх талаар энэхүү гарын авлагад нарийвчлан тусгалгүй зөвхөн товч мэдээлэл оруулсан болно.

### 3.7 Хүний хөгжил болон байгаль орчны зорилтыг тодорхойлох

#### 3.7.1 Хүний хөгжил<sup>14</sup>

Хүний хөгжил нь эдийн засгийн суурь хөдөлгөгч болсон иргэдэд хөрөнгө оруулж байгаа явдал юм. Бодлого боловсруулагчид тогтвортой бөгөөд байгаль орчинд ээлтэй хүний хөгжилд хөрөнгө оруулах, эдийн засгийн салбаруудтай уялдуулах асуудлыг авч үзэх хэрэгтэй. Бараг бүх оронд үйлдвэрлэлийн салбар нь хувийн хэвшлийн мэдэлд байдаг болохоор Засгийн газрын үүрэг нь эрх зүйн зохицуулалт, гэрээний зохицуулалт, нөөц ашигласны татвар, бусад татвар болон хөрөнгийн гадагш, дотогш урсгалын асуудалд л оршдог. Гэвч нийгэм,

<sup>14</sup> Сакико Фукуда-Парр, А.К Шива Кумар, Хүний хөгжлийн гарын авлага- Ойлголт, Хэмжүүр, Бодлого. Оксфорд хэвлэлийн газар, Нью-Йорк; Мөн Нээгдсэн Үндэсний Байгууллагын шийдвэр болон олон улсын болон хоёр талын агентлагын зорилт, Томас Кухн, Шинжлэх ухааны хувьсгалын бүтэц, Чикагогийн Их Сургуулийн Хэвлэл, Чикаго, 1970.



хүний хөгжил, байгаль орчны чиглэлээр оролцоход Засгийн газрын үүрэг тодорхой, ач холбогдолтой байдаг. Үүнээс гадна хувийн хэвшлийн үйл ажиллагаа тогтвортой бөгөөд байгаль орчинд аюулгүй байх нөхцөлийг хангахад Засгийн газрын гол үүрэг оршино.

### 3.7.2 Ядуурал

Хүний хөгжлийг хангахад ядуурлыг бууруулах зорилтыг дэвшүүлэх нь чухал. Юуны өмнө өсөлт- ядуурлын хамаарлыг тогтоох шаардлагатай, тухайлбал, дор хаяж 7-8 жилийн хугацааны цувааг ашиглан ДНБ-ий өсөлт нь ядуурлыг бууруулахад хэрхэн нөлөөлснийг шинжлэх хэрэгтэй юм. Энэхүү хамаарал дээр үндэслэн зорилтыг дэвшүүлэх хэрэгтэй. Гэхдээ эдгээр зорилт нь ядаж Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хангахад чиглэгдсэн, ойрын хугацаанд ядуурлыг бууруулж чадахуйц байх хэрэгтэй.

*Тайлбар 1: Хэрэв ДНБ-ий жилийн өсөлт 2-3 хувийн доод түвшинд байвал энэ өсөлтийн үр шим нь өсөн нэмэгдэж буй хүн амын хэрэгцээг л хангахад хүрдэг учраас ядуурлын түвшинд бараг нөлөө үзүүлэхгүй юм. ДНБ-ий өсөлт 6-7 хувиас өндөр өсөлттэй байх үед ядуурлын түвшинд нөлөөлж эхэлдэг байна.*

*Тайлбар 2: Өсөлтийн бүтэц чухал юм. Хэрэв эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр зөвхөн 1-2 салбар байх, цөөн тооны хүмүүсийг ажиллуулан үйлдвэрлэсэн түүхий эдийг экспортолж байвал үр ашгийн хуваарилалт хамгийн бага байна. Ийм үед тухайн түүхий эдийн үйлдвэрлэлээс төлж буй ашигт малтмалын нөөцийн өндөр татвар болон бусад татвар нь Засгийн газар нийгмийн хөгжил болон эдийн засгийг төвлөрүүлэхэд хангалттай орлого бүрдүүлэхэд тусалж болно. (Аж үйлдвэр хэсгийн доорхи Тайлбар 2-ыг үз)*

### Шигтгээ 3. 6 Ядуурал ба байгаль орчин

**Ядуурал-Байгаль орчны холбоос:** Ядуу хүмүүс байгалийн нөөцөөс ихээхэн хамаардаг, тиймээс байгалийн нөөцийг зохисгүй ашиглан, байгаль орчныг доройтуулдаг. Жишээ нь: хууль бус гар аргаар алт олборлох, бэлчээрийн даац хэтрүүлэх гэх мэт. Нөгөө талаас хотын ядуу иргэд ил задгай хаягдсан шил, лааз зэргийг түүж байгаль орчинд ээлтэй ажил хийдэг боловч хатуу хог хаягдлыг дахин боловсруулах хүчин чадал бага байдаг. Иймд тэдний амьжиргааг төдийлөн сайжруулахгүй байна.

#### Монгол дахь ядуурлын нөхцөл байдлын шинжилгээ

*Хэн нь ядуу вэ?:* Тэнэмэл хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ганц бие өндөр настан, хөдөлмөр эрхлэдэггүй хүмүүс, ажилгүйчүүд, хөдөөгийн ядуучууд (ихэвчлэн зуднаас үүдэлтэй) гэх мэт. 2012 оны байдлаар Монгол улсын ядуурлын түвшин 27.4% байсан бөгөөд хөдөөгийн ядуурлын түвшин 35.5% байсан бол хотын ядуурлын түвшин 23.2% байжээ.

*Ядуурлын шалтгаан:* Хувийн ухамсар, зан чанарын доройтол, соёл, уламжлал, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, газар зүйн байршил, ялгаварлагдсан хөгжил, хуримтлагдсан гадаад нөлөөллүүд гэх мэт. Ажлын байрны хомсдол, орлогын хэмжээ бага байгаа нь ядуурал бий болоход мөн нөлөөлж байна. Үүнээс гадна өнөөгийн ядуу байдал нь дараагийн үр удамд уламжлагдах явдал нь ирээдүйн ядуурлыг бий болгодог.

*Ядуурлын үр дагавар:* Сургууль завсардалт, гудамжны хүүхдүүд, гэмт хэрэг ихсэнэ, мөн хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ, хүнсний хангамж, аюулгүй байдал, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ, ган, зуд, хүчтэй шуурга, үер, байгаль орчны бохирдол зэрэг байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлд өртөх эмзэг байдал нэмэгдэнэ (орчны бохирдол нь жишээ нь: гэрээ дулаацуулах, хоол хийх зорилгоор хог эсвэл хаягдал дугуй шатааж агаар бохирдуулах, хууль бус аргаар алт, нүүрс



олборлох зорилгоор хяналтгүй химийн бодис ашиглан ус бохирдуулах, байгаль орчны нөхөн сэргээлт хийлгүй орхих, гол мөрний гольдролыг өөрчлөх зэргээс үүдэлтэй).

*Гол үзүүлэлтүүд:* Ядуу иргэдийн боловсролын түвшин, ядуу иргэдийн ажиллаж буй газар, ажил хийж буй хэлбэр, цөлжилтийн индекс, бэлчээрийн нөхцөл байдлын индекс, бэлчээрийн доройтлын индекс, хамгаалалтанд авсан усны эх үүсвэрийн тоо гэх мэт юм.

### 3.7.3 Боловсрол, хүний нөөц, эрүүл мэнд

Хүний нөөцийг хөгжүүлэх зорилт нь Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан байх ба Монгол Улс шиг дундажаас дээгүүр орлоготой эдийн засгийн хувьд эдгээр зорилтын хүрэх түвшин илүү өндөр байна. Дундаж орлоготой болон хөгжиж байгаа орнуудын хувьд боловсролын салбарт зарцуулж байгаа төсөв нь ДНБ-ий 5-6 хувиас багагүй байхаар зорилт тавьсан байдаг.

Боловсролын тогтолцооны бүхий л түвшинд техник, шинжлэх ухааны боловсрол хүчтэй байх ёстой. Боловсролын тогтолцооны бас нэг шинэ тал бол хүүхдийн эрүүл мэнд, танин мэдэхүйн чадварыг дээшлүүлэхийн тулд “сургуулийн өмнөх боловсрол”-ыг өргөжүүлэх явдал болно (Шигтгээ 3.7).

Боловсролын салбарт төрөөс явуулж буй бодлогыг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн олгож буй боловсролын чанарыг хянах эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад төр, хувийн хэвшлийн түншлэл шаардлагатай.

Боловсролын салбарын нэгэн адил хувийн хэвшлийн олгож байгаа эрүүл мэндийн үйлчилгээнээс гадна эрүүл мэндийн салбарт зарцуулах төсөв нь ДНБ-ий 3 хувиас доошгүй байдаг.

### Шигтгээ 3. 7 Сургуулийн өмнөх боловсролын ач холбогдол<sup>15</sup>

Сургуулийн өмнөх насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг хамгаалах нь тэдний танин мэдэхүй, сэтгэл зүйн болон хэлний хөгжлийг дэмжсэн тогтвортой халамжийн бодлоготой холбогдоно. Эдгээр нь ядуурал, тэгш бус байдал ялангуяа хамгийн эмзэг бүлгийн хүүхдийн дундах мөчлөгийг таслахад дэмжлэг болно. Нотолгооноос үзэхэд хүний нөөцөнд оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж хүүхдийн бага насанд хамгийн өндөр байдаг байна. Энэ насанд гарсан аливаа золгүй явдлыг анхааралгүй, засалгүй алдвал насан туршийн гажиг болж үлддэг. Амьдралын хэт их стресс (аюултай орчинд хүүхэд ажиллах), өвчин тусах (аюулгүй аж төрөх нөхцөл- цэвэр ус, ариун цэврийн нөхцөл), хүнсний шим тэжээлийн байнгын дутагдал (чанарлаг бус хоол хүнс, өлсгөлөн) нь хүүхдийг өсөлтийг эрсдэлд орох эмзэг болгох, танин мэдэхүйн чадварыг муутгах, биеийн өсөлтийг зогсоох, амьдралын туршид орлого олох боломжийг бууруулахад хүргэдэг. Байнгын халамжинд байх зэргээр хариуцлагатай харилцаа, амьдралын баялаг орчинд хүүхэд өсөн бойжсоноор насанд хүрсэн бүтээлч хүн болохын төлөө тэд тэмцэж өснө. Товчхондоо сургуулийн өмнөх асаргаа бол хамгийн чухал юм.

<sup>15</sup> Эх сурвалж: Грантам-МсГрегор .С болон бусад. Хөгжиж буй орнуудын 5 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн боломж. 2007, Ачарья С. Камбожийн хүүхдийн зураглал гаргах нь. Камбожийн Засгийн газар, Хүүхдийн төлөө дэлхий дахины холбоо, 2014 он.



### 3.7.4 Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй

Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хангахад ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зорилтыг дэвшүүлэх шаардлагатай. Дундажаас дээгүүр орлоготой Монгол Улсын хөгжлийн зорилт нь улс орон даяар ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах юм.

Баталгаат ундны ус болон ариун цэврийн байгууламжийг сайжруулах зорилтыг хамтад нь дэвшүүлэх шаардлагатай. Учир нь баталгаат ундны ус байгаа хэдий ч ариун цэврийн байгууламж нь чанаргүй бол баталгаат ундны устай байсны давуу талыг ашиглах боломжгүй юм<sup>16</sup>.

### 3.7.5 Жендэр

Эдийн засаг, нийгмийн хөгжилд эмэгтэйчүүдийн үүрэг, тэдний эрх мэдлийг нэмэгдүүлэх явдал амин чухал ач холбогдолтой. Энэ асуудлыг салбар хоорондын бүхий л үйл ажиллагаанд тусгаж, хөрөнгийн тусгайлсан хуваарилалт хийх шаардлагатай юм. Зорилтууд нь дор хаяж ТХЗ-уудыг хангахад чиглэгдсэн байх хэрэгтэй.

*Тайлбар: Соёл, хэл, спорт гэх зэрэг салбарууд нь орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлөхгүй, шууд хэмжих боломжгүй ч маш чухал. Тэдгээр нь ард түмэн үндэсний бэлэг тэмдэг болон үнэт зүйлээ авч үлдэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг учир зорилгоо тодорхойлоход эдгээрийг хэрэгсэхгүй үлдээх нь учир дутагдалтай.*

### 3.7.6 Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засаг

Хөгжлийн бодлого болон стратеги төлөвлөлтийн нөхцөл байдлын шинжилгээнээс эхлээд үр дүнг тодорхойлох хүртэлх бүх үе шатанд **Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн** асуудлыг тусгах ёстой. Эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглалын асуудлыг багтаасан Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн асуудлыг бүх төрлийн бодлого, төлөвлөлтөд авч үзэх шаардлагатай.

**Эдийн засгийн талаас:** Бодлогын зорилго, зорилтууд нь нөөцийг үр ашигтай ашиглах, нүүрстөрөгч бага ялгаруулах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, зохистой хөдөлмөрийн шалгуурыг хангасан ажлын байрыг бий болгох, байгаль орчинд ээлтэй технологи ашиглах замаар эдийн засгаа хөгжүүлж, ядуурлыг бууруулж, нийгмийн зорилтоо биелүүлэхэд чиглэсэн байна.

<sup>16</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу: НҮБХС, Усны салбарын зээл тусламж, Бангкок 2013 он- Зүүн Ази, Номхон Далайн бүсийн олон нийт тэргүүлсэн ариун цэврийн нөхцөл сайжруулах: Сургамж, Чиглэл. Ажич Эде, Дэлхийн банкны олон нийт тэргүүлсэн ариун цэврийн нөхцөл сайжруулах хөтөлбөр ( Дэлхийн Усны форум, Мексик улс, 2006 оны 3 дугаар сарын 19). [http://www.worldwaterforum4.org.mx/sessions/FT3\\_22/Community%20Led%20Total%20Sanitation.pdf](http://www.worldwaterforum4.org.mx/sessions/FT3_22/Community%20Led%20Total%20Sanitation.pdf)



**Нийгмийн талаас:** Бодлогын зорилго, зорилтууд нь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэх, тэгш байдлыг (ялангуяа жендэрийн тэгш байдлыг) хангахын зэрэгцээ байгаль орчинд ээлтэй байхад чиглэсэн байна.

**Байгаль орчны талаас:** Бодлогын зорилго, зорилтууд нь байгалийн баялгийг өндөр бүтээмж, үр ашигтай ашиглах, байгаль орчны аливаа бохирдол, доройтол, байгалийн гамшгийн үр дагаврыг бууруулах, экосистемийн унаган байдлыг хадгалах, тогтвортой байлгах, мөн эдгээрийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулахад чиглэсэн байна.

**Засаглалын талаас:** Бодлогын зорилго, зорилтууд нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, бодлогын шийдвэр гаргахад иргэдийн, ялангуяа нийгмээс ялгаварлагдсан бүлгийн оролцоог дээшлүүлэх, мөн улсын болон хувийн салбарт ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн байна.

### 3.8 Бүс нутгийн хөгжлийн бодлогын анхаарах асуудал

Бүх асуудал нөөцийн хуваарилалттай холбоотой байдаггүй. Ус зарим нутагт хомс байхад зарим нутагт элбэг байдаг. Газар нутаг бүр өөрийн гэсэн тухайн орон нутгийн түвшинд л шийдвэрлэж болох онцлогтой асуудлуудтай тулгардаг. Зарчмын хувьд эдгээр асуудлыг шийдвэрлэх арга зам нь бүс нутгийн хөгжлийн бодлогын нэг хэсэг болох ёстой ч хэрэв асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгө нь орон нутгийн төсвөөс их эсвэл зөвхөн нэг орон нутгийн төлөвлөлтийн нэгжийн эрх мэдлээс давсан бол үндэсний хөгжлийн бодлогын нэг хэсэг болох тохиолдол бас байдаг.

#### ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Хувийн хэвшлийн дээд боловсролын институт олон улсын харилцаа эсвэл нягтлан бодох эсвэл санхүү гэсэн цөөн тооны хичээл санал болгодог. Гэтэл улс орны хэрэгцээ шаардлага бол шинжлэх ухаан, технологийн боловсрол олгохыг шаардаж байна. Хэрэгцээ шаардлагатай хичээлийг заахад хувийн хэвшлийн нөөцийг хэрхэн хандуулах талаар хэлэлцэнэ үү.

**Дасгал 2:** Засгийн газрын бодлого нь ус, ариун цэврийн салбарыг тэргүүлэх чиглэл болгож байгаа ч хүмүүс орчин үеийн ус, ариун цэврийн аргыг нэвтрүүлэхгүй байна. Энэ хандлагын боломжит шалтгаан юу вэ?

**Дасгал 3:** Иргэдийн орлого өсөөгүй байхад орчин үеийн хэрэглээний технологийг ашиглахгүй байх шалтгаан юу вэ?



## 3.9 Үр дүнгийн хүрээний хэрэгжилтийн үйл явц<sup>17</sup>

### 3.9.1 Үр дүнгийн хүрээний төлөвлөлт ба төсөв

Үр дүнд суурилсан төлөвлөлтийн нийтлэг сэдэв бол нийгэмд хүргэхээр зорьсон үйлчилгээг үр дүнтэй, үр ашигтай хүргэх явдал юм. Ингэхийн тулд хөтөлбөр, дэд хөтөлбөр бүрийн нөлөөг тооцож, биелэлтэнд суурилан хөрөнгийг хуваарилахыг шаардана. Төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ үнэлгээний хоорондын харилцааны тайлбарыг Хүснэгт 3.1-т харуулав. Хөтөлбөр, төсөв, хяналт-шинжилгээ үнэлгээг холбохын тулд мэдээллийн тогтмол урсгалтай, хэрэгжилтийн үе шат бүрт тавьсан зорилтот түвшиндээ хүрэхэд анхаарлаа чиглүүлсэн байдлаар хэрэгжилт асуудалгүй явагдахыг шаардана.

Хүснэгт 3.1 зурагласан хүрээ нь засгийн газар, яам, эсвэл хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөлт, төсөвлөлтийн мөчлөг, дунд-хугацааны стратегийн төлөвлөлтийн суурийг бүрдүүлж өгнө. Өгөгдсөн форматаараа энэхүү тогтолцоо нь харьцангуй хийсвэр бөгөөд тухайлсан яамд, хөтөлбөр, дэд хөтөлбөр болон төслийн хувьд тохируулан хэрэглэх хэрэгтэй.

### 3.9.2 Үндэсний зорилт ба яамд

Засгийн газар хэд хэдэн яамдтай бөгөөд тэдгээрийн олонхи нь хэрэгжүүлэгч яамд байдаг. Жишээг Хүснэгт 3.2-т үзүүлэв. Үүнд: 3 яамд, Яам II нь 3 хөтөлбөртэй. Хөтөлбөр тус бүр 2 дэд хөтөлбөрүүдтэй, дэд хөтөлбөр бүр 2 үйл ажиллагаатай. Зохистой төлөвлөлтийн тогтолцоонд үйл ажиллагаа нь хөтөлбөрт, хөтөлбөр нь яамдад, яам нь төв байгууллага, төлөвлөгөөний зорилтонд тус тус холбогдсон байдаг. Урт хугацааны салбарын төлөвлөгөө боловсруулсан эсвэл хэрэгжиж буй хөтөлбөртэй сонгосон жишээний хувьд эдгээр үйл ажиллагаа нь (урт хугацааны төлөвлөгөөнд дурдагдсан хөтөлбөрүүдийн) дунд хугацааны бодлогын зорилготой уялдсан байдаг.

<sup>17</sup>Энэхүү хүрээг “Олон нийтэд суурилсан улсын салбарын удирдлагын хүрээ”, “Хөгжлийн үр дүнг удирдах олон нийтийн практик”, 2011 (Азийн Хөгжлийн Банк), “Олон нийтэд суурилсан улсын салбарын удирдлагын хүрээ- Орны жишээ”, “Хөгжлийн үр дүнг удирдах олон нийтийн практик”, , 2011 (Азийн Хөгжлийн Банк) үз.



**Хүснэгт 3. 1 Төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хүснэгт**<sup>18</sup>

ТӨЛӨВЛӨЛТ	ТӨСӨВЛӨЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭЛТ	ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ	ҮНЭЛГЭЭ
Хүрэх дүнгүүдийн уялдааг тодорхойлох	Үр дүнд суурилсан төсөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх	Төлөвлөлтийн үр дүнтэй институцийн тэргүүлэх асуудлыг зэрэгцүүлэх	Төлөвлөлтөөс гарсан шалгуур үзүүлэлтүүд	Үнэлгээний аргачлалыг боловсруулах
Үр дүнгийн түвшин бүрт зорилтот түвшинг тодорхойлж шалгуур үзүүлэлтийг тодорхойлох	Төлөвлөлтийн үр дүнд суурилан төсөвлөх	Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд бодлого, хүн хүч, үйл ажиллагааг чиглүүлэх	Байгууллагуудын хүлээх хариуцлагыг тодорхойлох	Байгууллагуудын хүлээх хариуцлагыг тодорхойлох
SMART (тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болох, ач холбогдолтой, цаг хугацаатай) зарчмыг баримтална.	Төсөв нь төлөвлөлттэй уялдан дунд хугацаанд төлөвлөгдсөн байх	Үйлчилгээ үзүүлэх стандартуудыг боловсруулах	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлалыг тодорхой болгох	Мэдээллийг түгээх аргачлалыг тодорхойлох
	Төсвийн гүйцэтгэлийг хянах, тайлагнах аргачлалыг боловсруулах		Дүн шинжилгээ хийх, тайлагнах аргачлалыг боловсруулах	Талуудын оролцоог хангах
Төлөвлөлтийн хүрээ нь үнэлгээний мэдээлэл болон тэргүүлэх асуудлуудыг төсөвлөлтөд авч үздэг.	Төсөв нь зорилтот түвшинг төлөвлөхтэй зэрэг хийгдэх ба эцсийн бүтээгдэхүүн/гарцыг тодорхойлдог.	Үр дүнг хянахад бүтээгдэхүүн/гарц нь хэмжигдэхүйц явцын шалгуур үзүүлэлтийг төсөвтэй уялдуулсан байна.	Хяналт-шинжилгээний үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн/ гарц болон үнэлгээний мэдээллийг сайжруулдаг.	Үнэлгээ нь хүрсэн үр дүнг үнэлж, цаашид дараагийн төлөвлөлтийн үйл ажиллагааг мэдээллээр хангадаг.

Яамд, хөтөлбөр, дэд хөтөлбөр, үйл ажиллагааны бүтэц нь үндэсний үр дүнгийн хүрээ эсвэл логик хүрээтэй холбогдсон байдаг. Энэ хоёр нь нэг учраас нэрийг нь харилцан хэрэглэж болно. Хэрэгжилтийн стратегийг тодорхойлох болон түүнийг хүлээгдэж буй үр дүнтэй холбохын тулд түвшин бүрт үр дүнгийн хүрээг байгуулж болно. Үүнийг урвуу дарааллаар харвал:



-Үйл ажиллагааны түвшинд үр дүнгийн хүрээ нь тухайн үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөг тодорхойлж болно.

-Дэд хөтөлбөрийн түвшинд үр дүнгийн хүрээг дэд хөтөлбөр бүрийн зорилтыг үйл ажиллагааны үр дүн хангах хамаарлыг тогтооход ашиглаж болно.

-Дээд түвшинд үр дүнгийн хүрээ нь дэд хөтөлбөр, хөтөлбөр, яамны зорилт улмаар Дунд хугацааны бодлогын үр дүн хоорондын логик холбоог боловсруулахад тусалж болно.

### 3.9.3 Хөтөлбөр

Хүснэгт 3.2-т үзүүлсэнчлэн хэрэгжүүлэгч яам болон агентлаг нь бүлэг хөтөлбөр, түүний дор дэд хөтөлбөр болон үйл ажиллагаануудтай байна. Хөтөлбөр бүр хэд хэдэн дэд хөтөлбөр, нэлээд тооны үйл ажиллагаанаас бүрдэж болно. Яамны дэд хөтөлбөр эсвэл үйл ажиллагааны тоо нь яам, түүний үйл ажиллагаанаас хамаарна. Боловсролын яамны хөтөлбөрүүд нь бага боловсрол, дунд боловсрол, дээд боловсрол болон насанд хүрэгчдийн боловсролын чиглэлээр байж болох бол Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны хөтөлбөрүүд нь үр тариа, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэртэй холбоотой байж болно. Дунд хугацааны төлөвлөгөөнд туссан бодлогын тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд хөтөлбөр бүр нь чиглэгдсэн байх, холбогдох яамны салбарын стратеги болж хөрвөсөн байна.

*Тайлбар: Зардлын хамгийн томоохон задаргааг үйл ажиллагаа эсвэл төслийн түвшинд хийнэ.*

### Хүснэгт 3. 2 Хөтөлбөр, дэд хөтөлбөр, үйл ажиллагааны уялдаа

Яам 1			Яам 2			Яам 3		
Хөтөлбөр 1	Хөтөлбөр 2	Хөтөлбөр 3	Хөтөлбөр 1	Хөтөлбөр 2	Хөтөлбөр 3	Хөтөлбөр 1	Хөтөлбөр 2	Хөтөлбөр 3
-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1
-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2
-ДХ3	-ДХ3	-ДХ3	-ДХ3	-ДХ3	-ДХ3	-ДХ3	-ДХ3	-ДХ3
-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1
Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1
-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1	-ДХ1
Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2
-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2
Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1	Үйл/ажил 1
-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2	-ДХ2
Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2	Үйл/ажил 2

ДХ = Дэд хөтөлбөр; Үйл/ажил=Үйл ажиллагаа;

Дэд хөтөлбөрүүдийн зардал дээр тогтмол зардлыг нэмж хөтөлбөрийн нийт өртөг зардлыг тооцно.





### 3.9.4 Дэд хөтөлбөр

Хүснэгт 3.2-т харуулсанчлан хөтөлбөрийн зорилтод хүрэхэд хувь нэмэр оруулах дэд хөтөлбөрүүдээс хөтөлбөр бүр бүрдэж болно. Шатлалын хувьд яамны үйл ажиллагааны доод түвшин учраас дэд хөтөлбөрт жил бүр тойм хийж, шаардлагатай бол өөрчлөлт оруулдаг. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг (хөтөлбөрийн хүрээнд) тодорхойлно. Хэдийгээр дэд хөтөлбөрүүдийг 2-3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөдөг ба дэд хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн нь гүйцэтгэл, байгаа нөөцөөс хамааран өөрчлөгдөж болно. Хэрэгжүүлж буй яамнаас хамааран шинэ дэд хөтөлбөрүүдийг нэмж боловсруулж болдог. Хяналт бүрэн тавих, төсвийг удирдахад хялбар байх үүднээс дэд хөтөлбөрүүдийг яамны нэг газарт дангаараа хамаарахаар боловсруулах нь илүү үр дүнтэй. Хэрэв боломжгүй бол салбар хоорондын уялдааг хангах тодорхой зохицуулалт мөн шаардлагатай.

Дэд хөтөлбөрийн өртөг зардлыг үйл ажиллагааны нийт зардал гэж тодорхойлно. Харин дээд түвшний тогтмол зардлыг оруулдаггүй.

### 3.9.5 Үйл ажиллагааны болон ажлын төлөвлөгөө

Дэд хөтөлбөрүүд нь яамны эрх зүйн хүрээнд үйл ажиллагаануудыг нэгтгэсэн байдаг. Эдгээр нь дангаараа үйл ажиллагаанууд байхаас гадна дороо мөн дэд хөтөлбөрийн зорилтод чиглэгдсэн төслүүдээс бүрдэж болно. Энэхүү задаргаа үйл ажиллагааны төрөл болон яамны бүтэц, зохион байгуулалт гэсэн хоёр хүчин зүйлээс хамаардаг. Хөтөлбөрийн шатлал дотроо үйл ажиллагаа болон төсөл нь хамгийн доод шатанд байх ба энэ түвшинд ажлын байрнаас гадуур хийгдэх ажлыг гүйцэтгэдэг. Мөн энэ түвшинд ихэвчлэн гүйцэтгэх ажилтнууд ажиллах ба зарим тохиолдолд үйл ажиллагаа нь төрийн өдөр тутам үзүүлэх үйлчилгээ байж болно.

Үйл ажиллагаанууд нь үр дүнгийн хүрээнд хэрэгжих ба санхүү, техникийн нөөцийн хэлбэрт үйл ажиллагааны орц байдаг ба тодорхой үр дүнд хүрнэ. Үйл ажиллагааны үр дүн/гарц нь бодитой, баригдахуйц (хялбар хэмжихүйц), орцыг хэрэглэснээр гарах урьдчилан тодорхойлсон үр дүн юм. Үр дүн нь бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл дэд бүтцийн хэлбэртэй байж болно. Жишээ нь: “Улаанбаатар-Дарханы хооронд 15 км зам зассан”, “бага сургуулийн 100 багш нарын мэргэжил дээшилсэн”, “эрүүл мэндийн 20 төвийг сайжруулсан” гэх мэт. Энэ түвшний гарц бүрийг тодорхой, маргаангүй байх үүднээс ерөнхийдөө нэгээс илүүгүй үзүүлэлтээр хэмжих ёстой. Гэвч гарцыг нэг үзүүлэлтээр илэрхийлж, харуулж чадахгүй онцгой тохиолдолд нэг нэмэлт үзүүлэлтийг гаргаж болно.

Дээд түвшний тогтмол зардлаас бусад зардлыг үйл ажиллагааны түвшинд тодорхойлно.



Тайлагналтын нэгдсэн зургийг хүснэгт 3.3-т харуулав. Энэхүү хүснэгт нь түвшин бүрт тайлагнах давтамжийг харуулсан ба шатлал нь доошлох тусмаа тайлагнах хугацаа нь богиносч байна.

*Тайлбар 1: Зарчмын хувьд орон нутагт эрх мэдэл өгсөн төвлөрсөн бус төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн тогтолцоо байх нь сайн арга барил боловч түүнд хязгаарлалт байдаг. Жишээлбэл: Монгол Улс 3 сая хүн амтай, 1.5 сая хавтгай дөрвөлжин км газар нутагт тархан амьдардаг. Улаанбаатар хотод хүн амын 45 хувь суурьшиж байгаа нь зарим төвлөрсөн бус (аймаг, сум) газарт зарим үйл ажиллагааг явуулахад хамрагдах хангалттай тооны хүн ам байхгүй байдаг. Зарим салбарын хувьд цөөн тооны хүн амд зориулан төлөвлөлт хийх нь үр ашиггүй байдаг. Үүнээс гадна бусад хөгжиж буй болон буурай хөгжилтэй улс орнуудын жишээнээс харахад хүүхдийн боловсролын чанар, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, орон сууц, үзвэр үйлчилгээ болон бусад шалтгаанаар боловсрол, мэргэжилтэй хүмүүс алслагдсан газар очиж ажиллах сонирхолгүй байдаг. Сайн мэргэжилтэн байхгүй бол техник, санхүү, ажил үүргийг задалж чадахгүй юм. Иймээс төвлөрлийг саармагжуулахад шинжлэх ухааны нухацтай шинжилгээ хийх, зөвшилцөлд хүрсэн байхыг шаардана.*

### Хүснэгт 3.3 Засаг захиргааны түвшин ба тайлагналт

Түвшин	Засаг захиргааны түвшин	Хөтөлбөрийн түвшин	Хяналт-шинжилгээ, үнэлгээ		Байгууллага	Мэдээллийн эх сурвалж
			ҮДХ	Давтамж		
Зорилт	Яамны түвшний төлөвлөлт	Бүлэг хөтөлбөрүүд	Үр дагавар	3-5 жил	Яам	Яамны мэдээлэл цуглуулах хүснэгт
Үр дүн\гарц	Газар	Хөтөлбөр	Газрын гарц	Жил	Газар, газар хоорондын	Газрын урьдчилсан хүснэгт, хөндлөнгийн үнэлгээ
Бүрэлдэхүүн үр дүн\гарц	Хэлтэс	Дэд хөтөлбөр	Бүрэлдэхүүн гарц	6 сар бүр эсвэл 3 сар бүр	Газар, хэлтсийн хооронд	Газрын мэдээллийн хүснэгт
Үйл ажиллагаа эсвэл орц	Хэрэгжүүлэгч нэгж	Үйл ажиллагаа	Зардал, орон нутгийн гүйцэтгэл	сар бүр	Хэрэгжүүлэгч агентлаг	Төслийн урьдчилсан хүснэгт

### 3.10 Салбар хоорондын асуудал

Яамд хоорондын хөтөлбөрийг хэрхэн уялдуулж болох болон үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамтран хөтөлбөр боловсруулах шаардлагатай гэдгийг Жишээ 3.8-д үзүүлэв. Хамтран хөтөлбөр боловсруулах гэдэг нь яам, газар, бусад байгууллагууд хамтран ажиллах албан ёсны механизмтай байж, хэрэгжүүлэгч олон байгууллагуудыг холбох төлөвлөгөөг боловсруулна гэсэн үг юм.

Зарим хөгжиж буй орнуудад яамд бие биенийхээ шийдвэрт нөлөөлөх хэмжээнд уян хатан хамтран ажилладаггүй бөгөөд энэ хүндрэлийг богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй юм. Гэхдээ салбар хоорондын уялдааг ханган асуудлыг шийдвэрлэх арга замууд байдаг.



Зарим орнуудад яамд уялдаагүйгээр үйл ажиллагаа явуулдаг ч бодлогын хэрэгжилтийн шатанд тухайлбал, дүүргийн түвшинд Хүний хөгжилд чиглэсэн хөтөлбөрүүдийг гүйцэтгэх удирдлага (хотын дарга, засаг дарга гэх мэт) уялдуулдаг. Үүнд хоёрдмол үүрэг хүлээдэг: нэг нь яамд болон дээд удирдлагын ажлын төлөвлөгөөг биелүүлэх, хоёр дахь нь төсвийг захиран зарцуулах, салбарын яамдын бодлогын уялдааг ханган хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэсэн үүрэг хүлээдэг. Улс орны нөхцөл байдал болон төрийн байгуулалтын бүтэц, зохион байгуулалтаас хамааран гүйцэтгэх удирдлага нь дээд шатны байгууллагадаа тайлагнадаг. Энэхүү давхцал нь хамтарсан хөтөлбөр боловсруулахад хязгаарлагдмал талуудыг бий болгодог.

Зарим жижиг улсууд тосгоны зөвлөлүүдийн оролцооны аргаар салбар хоорондын бодлогын хэрэгжилтийн уялдааг хангах асуудлыг шийдвэрлэхээр оролдсон. Гэвч тосгоны зөвлөлүүд зөвхөн жижиг хэмжээний асуудлуудыг авч үздэг. Зарим тохиолдолд суурь судалгаанд үндэслэн Эрүүл мэндийн яам нь ядуу иргэдэд үнэгүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн карт” олгодог. Мөн зарим улсуудад Боловсролын яам нь улсын сургуулийн бүх хүүхдүүдэд өдрийн хоол, ядуу оюутнуудад тэтгэлэг олгодог.

Доорх дэд хэсэг яамдын хөтөлбөрүүдийг хооронд нь хэрхэн холбож, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамтарсан хөтөлбөр боловсруулах талаар кейс жишээг тайлбарлав. Хамтарсан хөтөлбөрийг боловсруулахдаа хэрэгжүүлэгч газруудыг уялдуулсан яамд, газар, хэлтсүүд хамтран төлөвлөгөө боловсруулдаг.

### **Шигтгээ 3.8 Салбар хоорондын уялдааг хангахад хамтарсан хөтөлбөр боловсруулах нь: Камбожи улсын кейс жишээ**

Камбожи улсын Засгийн газар болон НҮБХХ 2013 онд хамтран МХЗ-уудын хэрэгжилтийг хангах ажлыг хэрхэн эрчимжүүлэх талаар судалгаа хийсэн. Энэхүү судалгааны нэг хэсэг нь хэрэгжилтийг хангахад салбарын яамд болон хамтарсан хөтөлбөрүүдийн хамаарал хэр чухал болохыг судлах байсан. Тус судалгааны гол үр дүнг дор танилцуулав.

#### **БОЛОВСРОЛ**

*Асуудал/Арга зам:* Хүүхдүүд сургуульд сурч чадахгүй байгаад нөлөөлж буй хүчин зүйлс юу вэ? *Судалгааны үр дүн:* Сургуулийн анги, танхимыг бүрэн дүүрэн ашиглаж чаддаггүй, багш нарын хичээл заах чадавхи сул мөн багш нарын ажил таслалт өндөр, хүүхдүүдээ гэрт нь аль эсвэл хаа нэгтээ хөдөлмөр эрхлүүлэхээр сургуулиас гаргадаг, ээж нар боловсролгүй, боловсрол багатай учраас хүүхэддээ сургуульд ороход нь урам өгч, дэмжлэг үзүүлдэггүй, ядуурал нь хүүхдийн боловсролд сөргөөр нөлөөлдөг.

#### **УС ХАНГАМЖ БА АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ<sup>19</sup>**

*Асуудал/Арга зүй:* Хүмүүсийг гэртээ ариун цэврийн байгууламж барихад нь нөлөөлөх, байшин нь жижиг эсвэл ариун цэврийн байгууламжийн усны хоолой оруулах боломжгүй хэмжээнд баригдсан

<sup>19</sup> , 'How Valuable are Environmental Health Interventions? Evaluation of Water and Sanitation Programmes in India', S K Pattanayak, C Poulos, Jui-Chen Yang & S Patil, Bulletin of the World Health Organisation 2010; 88:535-542; 'Scaling Up Rural Sanitation: Findings from the Impact Evaluation – Baseline Survey in Madhya Pradesh, India', A L. Salvatore and Sumeet R. Patil, Water and Sanitation Program, World Bank, Washington, March 2011; 'Evaluation of the Rajiv Gandhi National Drinking Water Mission', PEO, Planning Commission of India, New Delhi, 2010



бол байшингийн загварыг өөрчлөх, байшинг өргөтгөх зайгүй бол нийтийн усан сан болон бие засах газар байгуулах.

*Судалгааны үр дүн болон шалтгаан:* Ариун цэврийн байгууламжийн зураг амжилт багатай байсан бол усан сангийн зураг бүгд биш ч арай амжилттай байсан. Шалтгаан: Тосгон, байрны загвар нь тохиромжгүй, үйл ажиллагааны зардал олгогдоогүй, орлогын түвшин нэмэгдээгүй тохиолдолд хүмүүс дадсан хэвшлээ өөрчлөх хүсэлгүй байна, цаг агаарын бүх нөхцөлд ус байдаггүй, хүмүүс баталгаат ундны ус болон ариун цэврийн байгууламжийн талаар мэдээлэл багатай байдаг, нийтийн байгууламжийн менежмент муу, бохир ус болон хог хагдлыг зайлуулах асуудлыг төлөвлөдөггүй.


**ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ**

*Асуудал/Арга зүй:* Усжуулалт, хөдөөгийн дэд бүтэц, бүх нийтийн эрүүл мэнд, боловсрол, ус хангамж, ариун цэврийн байгууламжид хөрөнгө оруулалт хийж, ажлын хөлсөнд хоолонд хамрагдах болон бэлэн мөнгөний шилжүүлэг хөтөлбөрүүдийг эхлүүлснээр ядуурлыг бууруулах боломжтой юу?

*Судалгааны үр дүн ба шалтгаан:* Дээр дурдсан бүх зүйл тус болох ч хангалтгүй юм. Нэгдүгээрт, эдийн засаг тэгш, хүртээмжтэй өсөхгүй л бол эдгээр арга замуудыг талыг нь хэрэгжүүлж болохоос гадна цаашид үргэлжлэх боломжгүй юм. Дараа нь хүмүүс орлого өсөхөд хүний нөөцийн чадавхи сайжрах, ажил эрхлэх биет хөрөнгө нэмэгдэх шаардлагатай. Гуравдугаарт, боловсрол үнэгүй мөн ач холбогдолтой байхаас гадна хүмүүс эрүүл байхад чухал баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан байх хэрэгтэй.

Дээрх гурван асуудал нь хоорондоо уялдаатайгаас гадна тус тусад нь шийдвэрлэх боломжгүй гэдэг нь тодорхой байна. Боловсролын яам, Орон нутгийн хөгжлийн яам (ус хангамж болон ариун цэврийн асуудал хариуцсан) болон Хөдөө аж ахуйн яамны гүйцэтгэх түвшний албан хаагчид хамтдаа нэгдсэн шийдэлд хүрэхийг оролдсон. Үр дүн нь хамт боловсруулсан хамтарсан хөтөлбөрийн зураг бөгөөд Зураг 3.6-д харуулав.

**Зураг 3. 6 Салбар хоорондын асуудал**





### 3.11 Төлөвлөгөөг төсөвлөх

#### 3.11.1 Капитал болон гарцын өсөлтийн харьцаа

Аливаа төлөвлөгөө санхүүжилт шаарддаг бөгөөд энэ нь салбар хооронд болон дэд салбар хооронд ялгаатай юм. Шаардагдах нөөцийг тооцохын тулд нэг нэгж бүтээгдэхүүн нэмж үйлдвэрлэхэд шаардагдах хөрөнгө эсвэл капитал (капитал/гарцын харьцаа)-ийг тодорхойлдог.

Капитал/гарцын харьцаа (ICOR) нь гарцыг нэмэгдүүлэхийн тулд капиталын нэмэгдэж буй харьцаа юм. Энгийнээр хэлбэл тухайн улс нь нэг нэгж үйлдвэрлэл (ДНБ) нэмж хийхийн тулд шаардагдах нэмүү хөрөнгө оруулалтын хэмжээг төлөвлөгч нарт хэлж өгдөг харьцаа бол капитал/гарцын харьцаа болно. Капитал/гарцын харьцаа өндөр байх тусам капиталын бүтээмж буурна эсвэл урвугаар байдаг. Зарим үед капитал/гарцын харьцааг капитал ашиглалтын үр ашигтай/ашиггүй байдлын хэмжээр гэж үзэж бас болно. Үйлдвэрлэлийн бүтэц, технологиос хамаарч олонхи улс орнуудад капитал/гарцын харьцаа 3-5 орчим байдаг байна.

$$ICOR = (\Delta K \div \Delta Y) = (\Delta \div Y) / (\Delta Y \div Y) = (I \div Y) / (\Delta Y \div Y)$$

K: капитал; Y: гарц/ бүтээгдэхүүн (ДНБ); I: цэвэр хөрөнгө оруулалт; болон  $\nabla$  өмнөх хугацаанаас гарсан өөрчлөлт.

Тооцоо:

$$ICOR = (\text{Жилийн хөрөнгө оруулалт}) \div (\text{ДНБ-ий жилийн өсөлт})$$

Тооцоохын тулд томъёог дараах хэлбэрт оруулж болно:

$$ICOR = (K \text{ өөрчлөлт}) / (ДНБ өөрчлөлт)$$

$$= [(K \text{ өөрчлөлт}) / (ДНБ)] / [(ДНБ өөрчлөлт) / (ДНБ)]$$

$$= [I / ДНБ] / [(ДНБ өөрчлөлт) / (ДНБ)]$$

**Хийсвэр жишээ:** ССС орны капитал/гарцын харьцаа 5 байна. Энэ нь 1 ам.долларын нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд 5 ам доллартай тэнцэх хөрөнгө оруулалт хийдэг гэсэн үг юм. Өнгөрсөн жил энэ улсын капитал/гарцын харьцаа 6 байсан бол тус улс капитал ашиглалтаа илүү үр ашигтай болгосон эсвэл гарцын бүтэц өөрчлөгдсөн байна. Ерөнхийдөө капиталын хомсдолтой орны хувьд энэ харьцаа өндөр байх нь зохистой бус бөгөөд тухайн улсын үйлдвэрлэлийн үр ашиггүй байдлыг илэрхийлнэ. Тухайн улсын үйлдвэрлэлийн түвшинг тодорхойлоход энэ хэмжүүрийг голчлон ашигладаг.



Капитал/гарцын харьцааг шүүмжлэгчид харьцааг ашиглах ашиглалт хязгаарагдмал гэж үзэж байна. Улсуудын үйлдвэрлэлийн үйл явц боловсронгуй болох тусам хэр үр ашигтай байх нь хязгаарлагддаг. Жишээ нь: онолоор бол хөгжсөн улстай харьцуулахад хөгжиж буй улс нь өгөгдсөн нөөцөөр илүү их ДНБ үйлдвэрлэж чадна. Яагаад гэвэл хөгжсөн улс өндөр технологи, дэд бүтцийг ашиглан үйлдвэрлэлээ явуулдаг билээ. Цаашид сайжруулахын тулд илүү өндөр өртөгтэй судалгаа шинжилгээ хийх хэрэгтэй. Хөгжлийн түвшин болон бүтээгдэхүүний бүтцээс хамаарна. Иймд капитал/гарцын харьцаа нь шаардлагатай капиталыг тооцох, үндэсний хэмжээний нөөцийн ашиглалтын үр ашигтай байдлыг хэмжих богино хугацааны хэмжүүр болно.

Нийгмийн болон дэд бүтцийн салбарын хувьд капитал/гарцын харьцааг мэдэх нь чухал ач холбогдолтой. Улсын төлөвлөлт нь голчлон нийгмийн салбар, зарим дэд бүтцийн салбарын хүрээнд хийгдэж аж үйлдвэрлэлийн салбарыг хувийн хэвшилд үлдээдэг. Иймд нийгэм, дэд бүтцийн салбарын харьцааг мэдэх нь улсын төлөвлөлт ялангуяа капиталын хэрэгцээг тооцоход чухал болно.

### 3.11.2 Санхүүгийн эх үүсвэр

Засгийн газар бодлогоо хэрэгжүүлэхдээ хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжтой. Жишээ нь:

1. Татварын орлого – шууд (хүн амын болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар), шууд бус татвар, тодорхой зорилгод зарцуулахаар төвлөрүүлсэн татвар, бусад татвар (замын татвар, нислэгийн татвар, үзвэр, үйлчилгээний татвар)
2. Татварын бус орлого – нийтийн аж ахуйн болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн ашиг
3. Байгалийн нөөц ашигласны төлбөр
4. Төр хувийн хэвшлийн түншлэл (хамтарсан санхүүжилт)
5. Зээл (гадаад, дотоод)
6. Олон улсын тусламж

*Тайлбар: Ихэнхи хандивын санхүүжилт нь хөрөнгийн зардалд зориулагдсан байдаг. Ховорхон тохиолдолд л үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд ашиглагддаг. Тиймээс дээр дурдсан дөрвөн санхүүгийн эх үүсвэрийн аль нэгээр нь хөрөнгөө нэмэгдүүлсэн тохиолдолд холбогдон гарах үйл ажиллагааны зардал нь дотоод эх үүсвэрээс санхүүжнэ гэсэн үг юм.*

Зээл авч санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж буй улс орнуудын хувьд тогтвортой эх үүсвэрүүдийн багц үүсгэх шаардлагатай.

Дундаж болон дундажаас доогуур орлоготой орнуудын баримталдаг дараах зарчим байдаг. Тухайлбал:





1. Төсвийн орлого/ДНБ-ий харьцаанд нэмэгдэх өсөлтийн хувийг тогтоох, тухайлбал жил бүрийн өсөлт 1 хувь,
2. Тодорхой зорилгод зарцуулах татварыг төвлөрүүлэх (боловсрол, ядуурлыг бууруулах),
3. Гадаад эх үүсвэрт буцалтгүй тусламжийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх талаар хэлэлцээр хийх,
4. Эргэн төлөх хугацаа, ялангуяа гадны зээлдүүлэгчтэй хэлэлцээр хийхдээ зээлийг аль болох хөнгөлөлттэй болгох (эргэн төлөх хугацаа нь урт, бага хүүтэй),
5. Боломжтой бол байгаль орчныг бохирдуулсны төлбөрийг авах хэрэгтэй (нүүрстөрөгч ялгаруулалтын төлбөр),
6. Зардлыг хатуу хянаж үр ашгийг үр дүнтэй нэмэгдүүлэх.

### ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Монгол улсын капитал/гарцын харьцаа хэд вэ?

**Дасгал 2:** Хүүхдийг нэг жил сургах боловсролын нэгж зардлыг тооц.

**Дасгал 3:** Засгийн газар хөрөнгө оруулалт хийх салбараа тодорхойлохдоо салбар бүрийн ICOR-ыг тооцож, харьцуулах нь хэр боломжтой вэ?

## 3.12 Төлөвлөлтийн тусгай сэдэв

Гарын авлагын энэ хэсэгт төлөвлөлтийн зарим тусгай сэдвүүдийн талаар товч дурдлаа. Эрсдлийн шинжилгээ болон Хөтөлбөрийн үнэлгээ гэсэн хоёр сэдвийг танилцуулж байна.

### 3.12.1 Эрсдэлийн шинжилгээ

Бүх хөтөлбөр, төслүүд нь хэрэгжилтийнхээ явцад зогсох, саатах, зардал нь хэтрэх зэрэг эрсдлүүдтэй тулгардаг. Эрсдэлийн шинжилгээ нь тухайн хөтөлбөр, төсөл, хөтөлбөр хугацаандаа бүрэн хэрэгжихгүй байх эсвэл зардал хэтрэх магадлалыг тодорхойлдог аргачлал юм. Загварт төсөөлсөн гол хувьсагчуудын тодорхойгүй байдлыг тооцоолж төслийн хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг тооцдог аргачлал юм. Энэ аргачлалд загварыг хэд хэдэн симуляци хийдэг (боломжит эрсдлээс хамаарна). Дараалсан сценаруудыг төслийн тодорхойгүй түлхүүр хувьсагчуудад орцын утгуудыг өгснөөр гаргадаг.

Үр дүнг нэгтгэн статистикийн аргачлал ашиглан шинжилж хэд хэдэн төрлийн эрсдлийн хөтөлбөр болон төсөлд үзүүлж болох үр дагаврыг тооцдог. Эрсдлийн шинжилгээг хэд хэдэн үе шатуудад хуваан хийнэ. Нэгдүгээрт, эрсдлийн шинжилгээ хийх үе шатуудыг Зураг 3.7-д үзүүлсэнчлэн гаргана.




**Зураг 3. 7 Эрсдэлийн шинжилгээний аргачлал<sup>20</sup>**



Дараагийн шат нь ирээдүйн хандлагыг тодорхойлох загварыг тодорхойлно. Маш энгийн загварыг Зураг 3.7-д харуулав.

**Зураг 3. 8 Ирээдүйн хандлагыг тодорхойлох загвар**



Гурав дахь шат нь эрсдэлийн хувьсагчуудыг тодорхойлох юм. Хүснэгт 3.4 үйлдвэрийн санхүүгийн үзүүлэлтийг харуулсан хялбаршуулсан орлогын тайланг харуулав. Энд эрсдэлийн хувьсагчууд нь борлуулалтын хэмжээ, үнэ (эдгээр нь унах магадлалтай), түүхий эдийн үнэ (энэ нь өсөх магадлалтай) юм.

Хүснэгт 3. 4 Үйлдвэрийн орлогын тайлангийн жишээ (эрсдэлийн хувьсагчуудыг заасан)


	Мөнгөний нэгж (\$)	Эрсдлийн хувьсагч
Зарах үнэ	12	*
Борлуулсан тоо ширхэг	100	*
<i>Нийт мөнгөн гүйлгээний орлого</i>	1,200	
Түүхий эд	300	*
Цалин	400	
Зардал	200	
Нийт мөнгөн гүйлгээний зарлага	900	
<i>Цэвэр мөнгөн гүйлгээний орлого</i>	300	
<i>Таамаглал</i>		
Түүхий эдийн үнэ/нэгж	3.00	
Цалин/нэгж	4.00	

<sup>20</sup> Risk Analysis for Investment Appraisal' Savvakis C. Savvides, MPRA Paper 10035, Harvard University, Cambridge, 1994, <http://mpr.a.ub.uni-muenchen.de/10035/>





**Зураг 3. 9 Үйлдвэрийн санхүүгийн тайлангийн жишээ, бүтээгдэхүүний үнэд эрсдэлийн хэлбэлзлийг харуулсан байдал**



Дөрөв дэх үе шат нь эмпирикийн аргаар үнэ зах зээлд хэр хугацаанд хэр олон удаа унасныг тооцно (нэг эрсдлийн хувьсагч). Давтамжийн мэдээллээс харахад таван зах зээл/хугацаанд, үнэ нэг л удаа хамгийн их өссөн, таван удаа хэвийн үнэтэй байсан бол үлдсэн дөрвөн үзэгдэлд хэвийн үнээсээ бага байсан байна. Үзэгдэл бүрийн магадлалын мөн Зураг 3.8-д харуулсан байна.

Сонгон авсан хувьсагчийг эцэст нь эрсдэл/магадлалд тохируулан төсөлд үзүүлэх үр дагаврыг тооцно. Үүнээс өөр хувилбаруудыг сонгон авч сценарь боловсруулж болно.

**Асуулт:** Эрсдэлийн хувьсагч нь бүтээгдэхүүний үнэ гэж үзээд төлөвлөгөөний хугацааг 10 сар гэе. Дээр дурдсанчлан, үнэ нь 12 ам.доллар дээр тогтсон ч хэлбэлзэх магадлалтай (эрсдэл). Эхний сард үнэ нь өндөр буюу 15 ам доллар, дараа нь таван сарын турш 12 ам.доллар байж, эцэст нь 10 дахь сард 10 ам.доллар болсон гэж үзээд борлуулалтын орлогыг тооцно уу.

**Хариулт:** Сарын дундаж орлогыг дараах байдлаар тооцоолно:  
 $(15 \times 1 \times 100 + 12 \times 5 \times 100 + 11 \times 3 \times 100 + 10 \times 1 \times 100) / 10 = \$1,170$  бөгөөд энэ нь анх төлөвлөж байсан сарын дундаж орлого болох сарын 1,200 ам доллараас бага байна.



### Шигтгээ 3. 9 Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн бодлогод тусган төлөвлөх нь

Экологи нь эмзэг газар нутагт бусад газар нутагтай харьцуулахаа байгалийн гамшиг илүү их тохиолддог. Монгол Улсад үерээс гадна зуд хамгийн түгээмэл тохиолддог гамшиг юм. Маш их цастай, шуургатай, хүйтэн өвлийн улирал нь малын тоо толгойг олноор нь хорогдуулж улмаар малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн, их хэмжээний цас, шуурганы улмаас зам, төмөр замаар зорчих боломжгүй болж зарим тохиолдолд малчид гэрээсээ хаалгаа онгойлгож гарах боломжгүй хэмжээний их цас унадаг. Орон нутгийн алслагдсан газруудад энэ нь элбэг байдаг ба хүний амь нас эрсдэх үе ч байдаг. Хүний амжиргаа, малд учирдаг гарзаас гадна хүнсний сүлжээний түгээлт мөн мал аж ахуйн гаралтай боловсруулах үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд саад учирдаг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусгах нь Монгол Улсын хувьд чухал асуудал юм. Ингэхдээ тухайн орон нутаг тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөөг гаргахдаа энэхүү гарын авлагад заасан төлөвлөлт, хэрэгжилтийн зарчмыг хадгална. Төлөвлөлтийн явцад тодорхой бүлгийн гамшгийн эмзэг байдал (нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт), газар зүйн байрлал тэдгээрийн гамшигт өртөх байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшгийг бууруулах нэгдсэн бодлогоор гамшгаас урьдчилан сэргийлэх арга замуудыг тодорхойлох болон санхүүжүүлэх эх үүсвэр, арга замуудыг зайлшгүй тооцоолох шаардлагатай. Эдгээрээс доорх асуудлуудыг эн тэргүүнд авч үзнэ:

1. Гамшигт өртсөн газруудыг болон тэдгээрт тусламж хүргэх замуудыг хэрхэн тодорхойлох газрын зураг боловсруулах,
2. Хүнс, цэвэр ус, түлшийг (нүүрс, бусад хатуу түлш) хэрхэн түгээх,
3. Өвчтэй болон тусламж шаардлагатай хүмүүст хэрхэн хүрч очих,
4. Мал нь олон тоогоороо гамшигт нэрвэгдсэн газруудад малын тэжээл хэрхэн хүргэх,
5. Гамшгийн дараах нөхөн сэргээлт, бүтээн байгуулалтыг хэрхэн хийх.

Гамшгийн удирдлагын гамшгийн эрсдэлийг бууруулах болон гамшиг тохиолдонгуут хариу үзүүлэх төлөвлөгөөг (орон нутаг тус бүрээр тусгайлсан) маш сайн боловсруулах хэрэгтэй юм. Мөн энд салбар дундын асуудлыг авч үзэх шаардлагатай. Ингэхдээ аль байгууллага гамшгийн үед ямар асуудлыг хариуцан ажиллах чиг үүргийн хуваарилалт маш тодорхой болгох нь чухал. Гамшгийн асуудал хариуцсан Засгийн газрын байгууллага нь эрх мэдэл, хангалттай хүн хүч байхаас гадна байнга хангалттай төсөв, санхүүтэй байх хэрэгтэй.

#### 3.12.2 Хөтөлбөрийн үнэлгээ

Хөтөлбөрийн үнэлгээ нь ерөнхийдөө дараах хоёр үндсэн асуултад хариулт өгөх зорилготой.

- Нөөцийг (хязгаарлагдмал) хамгийн сайн ашиглаж чадсан уу?
- Нөөцийг ашигласнаар хүссэн үр дүндээ хүрч чадсан уу?

Хөтөлбөрийн үнэлгээний аргачлал нь эдийн засгийн үр ашиг болон алдагдсан боломжийн зардал дээр үндэслэдэг. Засгийн газрын хэрэгжүүлж байгаа төслүүдийг доорх хүснэгтэд үзүүлсэн байдлаар ангилж болно:



**Хүснэгт 3. 5 Төслийг үнэлэх аргачлал**

<b>Төслийг үнэлэх аргачлалын тайлбар<sup>21</sup></b>				
Зардал болон үр дагаврыг хоёуланг нь тооцсон уу?				
Хоёр өөр хувилбаруудыг харьцуулсан уу?	1. Үгүй			2. Тийм
	1. Үгүй	<b>(А).</b> Зөвхөн өгсөн зардлаас гарах үр дагаврыг тооцно	<b>(В).</b> Зөвхөн тодорхой үр дагаврыг гарган авахын тулд зардлыг тооцно	<b>(Д).</b> - Зардал, үр өгөөжийн шинжилгээ (ЗҮӨШ)
	2. Тийм	<b>(Б).</b> Үр дагаврын шинжилгээ	<b>(Г).</b> Төслүүдийн зардлын шинжилгээ	- Зардал ашиглалтын шинжилгээ (ЗАШ)

Хүснэгтийн нүд бүрийн утгыг тайлбарлавал:

1. Нүд (А) нь ямар ч сонголтгүй гэдгийг харуулж байна: тодорхой хөтөлбөр, төслийн үр дагаварт хүрэхэд зардлыг хамгийн бага түвшинд барьж чадаж байгаа эсэхийг шалгадаг,
2. Нүд (В) нь сонголт байгаа гэдгийг харуулж байна: өгөгдсөн төсвийг зарцуулснаар төслийн үр дүнд нь хамгийн их бүтээгдэхүүн гаргаж чадах хэмжээнд байгаа эсэхийг тооцоолдог,
3. Нүд (Б) нь сонголтууд байгаа гэдгийг харуулж байна: өгөгдсөн төсвийг өөр өөр хөтөлбөр, төсөлд зарцуулснаар аль нь хамгийн их үр дүнтэй хэрэгжихийг тооцоолдог,
4. Нүд (Г) нь сонголтууд байгаа гэдгийг харуулж байна: хөтөлбөр, төслийн зорьсон үр дүнд хүрэхэд төсвийг хэрхэн хуваарилж ашигласнаар хамгийн бага зардал гарахыг тооцдог,
5. Нүд (Д) нь төсөв болон хөтөлбөр, төслөөс гарах үр дүнгийн аль алинд нь сонголтууд байгаа бөгөөд төлөвлөгч ямар үр дүнд хүрэхийг зорьж байгаагаасаа шалтгаалан дээр дурдсан дөрвөн сонголтуудаас сонгож болно.

Зардал, үр өгөөжийн шинжилгээ болон зардал ашиглалтын шинжилгээний хооронд сонголт хийхдээ үр дүнд мөнгөний нэгжээр үнэлж болох эсэхийг тооцоолох хэрэгтэй.

<sup>21</sup> Adapted from 'Health Economics for Developing Countries: A Survival Kit', Anne Mills and Lucy Gilson, HEFP-WP 01/88, London School of Hygiene and Tropical Medicine, London 1988



Тайлбар 1: Бүх үр дагавар болон зардал нь (Төслийн үр дагавар) орлогыг хуваарилах болон байгаль орчны нөлөөллийг авч үзсэн байх хэрэгтэй.

Тайлбар 2: Үр дагавар (Төслийн үр дагавар) тодорхой хугацаанд илэрч, зардал нь мөн тодорхой хугацаанд гарч байдаг. Тиймээс ирээдүйд олох орлого болон төлөх төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг олох хэрэгтэй. Энэ нь өнөөгийн зах зээлийн хүүгийн түвшин эсвэл нөөцийн алдагдсан боломжийн өртөгөөр тодорхойлогдоно. Ихэнхи олон нийтийн ашгийн бус төслийн хувьд зах зээлийн хүүг ашиглан тооцоолол хийхэд хангалттай юм. Учир нь ашиг олох гол зорилго биш юм. Энэ тооцооллыг хийхэд ашигладаг стандарт томъёо нь:

**Өнөөгийн цэвэр үнэ цэнэ = Net Present Value = NPV =  $[\sum b_i / (1+r)] / n$**

NPV нь өнөөгийн үнэ цэнэ бөгөөд  $b_i$  нь үр өгөөжийн урсгал,  $r$  нь хорогдуулах хүүгийн түвшин,  $n$  нь үр өгөөж бий болох жилийн тоо.

Тайлбар 3: Өнөөдөр байгаль орчны асуудал маш чухлаар тавигдаж байна. Эдийн засагчид байгалийн нөөцийн ашиглалтын үнэлгээг биет байдлаар тодорхойлж эхэлсэн. Байгаль орчин буюу байгалийн нөөцийн үнэ цэнийн талаар энэ бүлгийн Хавсралт 3-д орууллаа.





### **3-р бүлгийн Хавсралт 1: 2016-2021 оны Үндэсний хөгжлийн бодлогыг боловсруулах удирдамжийн загвар**

#### **1. ӨМНӨХ ҮГ**

**1.01** Монгол Улсын Засгийн газар ард иргэдийнхээ амьдралын чанарыг улам бүр дээшлүүлэх үүрэг хүлээдэг. Мөн эдийн засаг, улс төр, соёл, бусад салбарт нийт иргэдэд тэгш эрх, боломжийг бүрдүүлсэн ардчилсан хуулийг баримталсан нийгэм байгуулах үүргийг ч мөн адил хүлээдэг. Засгийн газар эдийн засгийг дэмжин тэтгэсэн нөхцөлийг бий болгосон бодлого бүхий нээлттэй зах зээлийг бий болгохыг зорьж байна.

**1.02** 1990-ээд оны эхнээс зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлэх үндсэн чиглэлийг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх замналаар явж ирлээ. Эдийн засаг амиа аргацаах баримжаа бүхий системээс ангижирч, илүү тэнцвэртэй, зах зээлийн эрэлт хэрэгцээг мэдэрсэн системд аажмаар шилжин, буурай хөгжилтэй, далайд гарцгүй орны статусаас гарах замдаа явж байна. Эдийн засгийн энэ систем гадаад орчинд үүссэн хүндрэл, дэлхий дахины санхүүгийн хямрал, инфляцийн нөлөөгөөр бий болсон ухралтыг тэсэн давах чадвартай гэдгээ харуулав.

**1.03** 2017-2021оны зорилтуудыг Засгийн газрын төрөл бүрийн хөтөлбөр, чиглэлүүдэд тухайлбал, 2030 оны алсын хараа баримт бичигт тусгасан урт хугацааны алсын харааны хөгжлийн өргөн хүрээний зорилготой нийцүүлэх шаардлагатай байна.

**1.04** 2017-2021 онд үндэс болох бодлогын үндсэн чиглэл, хөгжлийн гадаад орчны байдал нь:

1. Өмнөх төлөвлөгөөний дунд хугацааны үнэлгээгээр гарсан үр дүн, ажиглалтууд,
2. Яамдуудаас урт хугацааны алсын хараагаа тодорхойлж гаргасан салбарын баримт бичгүүд,
3. Дотоод, гадаад орчны өөрчлөлт,
4. Далайд гарцгүй орны статусаа дээшлүүлэхийн төлөө Засгийн газраас авч байгаа арга хэмжээ,
5. Бүсийн (олон улсын) эдийн засгийн интеграцлалын үйл явц,
6. Тогтвортой хөгжлийн бүх зорилгод аль болох хүрэх, тэдгээрийг давуулан биелүүлэх зорилго, чармайлт,
7. Тус улсыг тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн замд оруулах.



## 2. ХӨГЖЛИЙН ОРЧИН

Ойрын жилүүд дэх эдийн засгийн гүйцэтгэл

### А. Ололтууд

**2.01** Үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ) жилд хэдэн хувьд хүрсэн урт хугацааны эдийн засгийн өсөлтийг манай улс хангав. 2012-2014 онуудад тохиолдсон хямралын дараа ҮНБ эргээд 2010 оны түвшинд хүрч өсөв. Хөдөө аж ахуйн салбарын жилийн өсөлт сүүлийн 10 жилийн хугацаанд N1%, аж үйлдвэрийнх 2009 оноос бусад жилүүдэд N2%, үйлчилгээнийх N3% байв. 2012-2014 гарсан ухралтын дараа ҮНБ –ийн урт хугацааны өсөлт эргээд N%-д хүрэв.

**2.02** Хөрөнгө оруулалтын ҮНБ-ний J%-тай тэнцэх хэмжээнд тогтвортой байсан нь ҮНБ-ий бүтцэд дараах өөрчлөлт гарахад нөлөөлөв: хөдөө аж ахуйн бус салбараас оруулах хувь хэмжээ 10 жилийн өмнөхтэй харьцуулахад K1% K0% болжээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХӨ) эрс өсчээ: 200X онд Z сая орчим ам.доллар"-т хүрсэн нь хамгийн оргил өсөлт байсны дээр дэлхий нийтийн хямралын нөлөөгөөр уналт гарсаны дараа эргэн 2010 оны түвшинд хүрэв.

**2.03** Хууль, шүүхийн шинэчлэлээр дамжуулан Сайн засаглалыг хэрэгжүүлэх хүчин чармайлт, төрийн захиргаа, төвлөрлийг сааруулах шинэчлэлүүдийн үр дүн гарч эхэлсэнээр хараахан гарч эхлээгүй ч хөрөнгө оруулагчид, нийт иргэд Засгийн газарт илүү итгэл үзүүлж эхлээд байна.

**2.04 ТХЗ-ууд:** Ядуурлын түвшин буурав: 1990-ээд оны эхээр P0% байсан бол 2013 онд P1% орчим болжээ. Жини коэффициентийг ашиглан гаргасанаар Хэрэглээний тэгш бус байдал сүүлийн жилүүдэд 0.n1% -аас 0.n2% болон буурсан байна. Хүүхдийн дундах тэжээлийн дутагдал зэрэг бусад үзүүлэлтүүдэд нааштай ахиц гарч (гараагүй) байна. Дараагийн үзүүлэлт болсон Нярайн эндэгдэлийн түвшин (НЭТ), 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (5ХННХЭТ) болон Эхийн эндэгдлийн түвшиний (ЭЭТ) талаархи зорилтуудад хүрээд (хүрээгүй) байна.

**2.05** Эцэст нь хэлэхэд, төлөвлөлтийн систем сайжирч, хяналт-шинжилгээ, үнэлгээнд урьдынхаас илүү их, чанартай мэдээллийг цуглуулдаг болоод байна. Жилд YYYU асуумж судлагаа авч, ZZZZ тооны захиргааны удирдлагын мэдээллийн систем ихээхэн сайжраад байна. Бусад судалгаанд Хүн амын эрүүл мэндийн судалгаа, Олон кластерийн үзүүлэлтийн судалгаа, Хүн амын судалгаа (10 жил тутамд, хугацааны дунд үед шинэчлэл хийгдэнэ) багтаж байна. Эдийн засгийн тооллого, Хөдөө аж ахуйн тооллого, хөдөлмөрийн судалгааг хийгээд байна.



Б. Сул талууд

**Б.1 Эдийн засгийн салбар**

**2.06** Хөрөнгө оруулалтын чиглэлээр тавьсан зорилтод хүрэхэд Эдийн засаг ГШХӨ, Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)–аас хамааралтай байна. Түүнчлэн, одоогийн байдлаар ХАЁТ/бусад хөрөнгийн эх үүсвэрээс нөхөж буй худалдаа, төсвийн алдагдал их байна. Эдийн засгийн бүрдлийн төрөл бага байна, нэмүү өртөг бий болгох гүнзгий бус, хүмүүс ихэвчлэн ур чадвар бага шаарддаг, бүтээмж муутай тариалан /мал аж ахуй/ албан бус салбарт ажиллаж, эдийн засаг гадаад орчны давалгаа, хямралд асар өртөмтгий байна. Эцсийн дүнд, аж үйлдвэрийн салбар уул уурхай, жижиг үйлдвэрлэлээр хязгаарлагдаж, дэлхийн нэмүү өртгийн нийт сүлжээнд нэмэр багатай үйлдвэрлэл явуулж байна.

Б.2 Нийгмийн салбар

**2.07** БЗХӨ/ДОХ-ын тохиолдол (буурсан/нэмэгдсэн) бол, эмэгтэйчүүд, хүүхдийн цус багадалт, хүүхдийн дундах хоол тэжээлийн дутагдал, сүрьеэ өвчин шийдэл хүлээсэн асуудал хэвээр байна. Боловсролын салбарт, дунд болон тусгай боловсролын аль аль нь асуудал болж байна.

Б.3 Засаглал

**2.08** Засаглалын үр нөлөөг улам бүр гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Яамд үндэсний болон орон нутгийн түвшний хооронд босоо болон хэвтээ чиглэлээр зохицуулалт бага хийгддэг, төрөл бүрийн хөтөлбөрийн уялдаа зохицуулалт муу байгаа нь хэрэгжүүлэлтийн үр нөлөөг бууруулж байна. Дүгнэж хэлэхэд, Засгийн газрын агентлагуудын түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийн тодорхойлолт, мэдээлэл гаргах үйл ажиллагааны стандарт өөр өөр байна

Б.4 Ой, мал аж ахуй/загасны аж ахуй

**2.09** Ойн хувьд дараах чиглэлээр мэдлэг, чадавхи голлон дутагдаж байна: (1) хилийг зааглан тогтоосон ойгоор бүрхэгдсэн бүс нутаг, ойн ангилал, ойн нөөцийн тооллого, болон (2) хууль сахих, засаглалыг сайжруулах. Мал аж ахуйн салбарт мал сүргийг цаг агаарын хүндрэл, халдварт өвчнөөс хамгаалах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, малчдын хамтын суурьшлийн бүсийг хөгжүүлэх, удирдах, ойн хамгаалалтын бүсийг хамгаалах, авран хамгаалах усан санг бий болгох, усан байгууламжийг хөгжүүлэх шаардлагатай байна.



## **2.2 Чадамж, чадвар дутаж буй асуудлууд**

### **А. Бүс нутгийн/олон улсын эдийн засагтай интеграцчилалд орох**

**2.10** 20XX оноос эхлэн Хойд Азийнхан хөрөнгө, хөдөлмөр, хил хязгаарыг даван чөлөөтэй хөдөлгөөнийг бий болгохыг зорьж байна. Гэхдээ нэгэн цул болоогүй, интеграцчилалд орох зам нь ярвиг ихтэй. Жишээ нь: манай улс импортын татвар хураамжийг бууруулах шаардлага гардаг бөгөөд энэ нь эргээд Засгийн газрын орлогод сөргөөр нөлөөлдөг. Дотоодын орлого зардлаасаа NNN% дутаж байгаа тул энэ зөрүүг хаах хэрэгтэй болно. Биет бус хөрөнгийн буюу хүчин зүйлийн зах зээл нээгдсэнээр иргэдэд хилийн чанадад ажиллах боломж нээгддэг ч, манай улс руу орж ирэх чөлөөт хөрөнгийн урсгал нэмэгдсэнээр үнэ цэнэтэй газар, усны судал болон бусад байгалийн нөөцийн эрэлт нэмэгдэнэ. Энэ нь маргаан дагуулдаг асуудал юм.

### **Б. Дэлхийн санхүүгийн хямрал, Европын өрийн хямралын нөлөөлөл**

**2.11** Дэлхийн санхүүгийн хямрал, Европын өрийн хямрал үр дагавар даамжирснаар нээлттэй жижиг улсуудад үр дагавар, үр нөлөөгөө үзүүлнэ.

### **В. 2015 онд баталсан ТХЗ-г биелүүлэх тухайд**

**2.13** Цөөн хэдэн үзүүлэлтээр (дурдах) төлөвлөсөн зорилтод хүрээгүй байна. Гэхдээ хүний хөгжлийн зорилтууд ТХЗ-р хязгаарлагдахгүй, 2015 оноос хойш 2030 он хүртэл хүмүүс юунд зорих талаар нухацтай бодож эргэцүүлэх шаардлагатай байна.

## **2.3 Боломжууд**

**2.14 Хүн ам зүйн ашиг өгөөж:** ССС улсын хүн ам залуу, нийт төрөлтийн түвшин (НТТ) буурч байна. Өндөр настангууд, өсвөр насныханы тоо харьцангуй цөөн тул эдийн засагт ажиллах хүний тоо, хөдөлмөрлөж буй хүний орлогоос хамааралтай амьдрах хүний тоотой харьцуулахад хавьгүй олон. Тэр тусмаа тэдгээр ажиллагсад ур чадвартай бол энэ нь нь баталгаатай боломж юм.

**2.15 Нүүрсхүчлийн ялгарлын нөлөөг бууруулах:** Ой бүхий бүс нутаг .... эзэлдэг тус ССС улс ойн нягтралыг улам бүр нэмэгдүүлэхэд анхаарч, нүүрсхүчлийн ялгарлын нөлөөг бууруулах боломжтой. Үүнийг тодорхой хугацаанд хийх шаардлагатай.

**2.16 Уул уурхай:** Төрөл бүрийн метал, ашигт малтмалын нөөцийг олон олноор нь нээж байна. Манай улс гадаад солилцоо, валют олох ажлын байрыг нэмэгдүүлэхэд ашигт малтмалын нөөц баялагийн давуу талыг ашиглах боломжтой. "Голланд өвчинд" нэрвэгдэхгүй байхын тулд анхааралтай байх нь зүйтэй.

**2.17 Газар, капитал:** Шинэ үеийнхэн хөдөө аж ахуй, мал аж ахуйгаас өөр салбарт ажиллахыг хүсч байна. Тиймээс газрыг илүү өндөр үнэ цэнэтэй







хөрөнгө болгон эргэлтэд оруулах өргөн боломж байна.

## 2.4 Хураангуй

**2.19** Дээр дэвшүүлсэн үндэслэл санаануудыг дараах байдлаар дүгнэж болно:

1. Макро эдийн засгийн түвшинд гол тохируулгыг хийх шаардлага гарч байна,
2. Мэргэжлийн ажилчдыг чанарын болон тооны хувьд сайжруулах, бүс хоорондын болон жендэрийн тэнцвэрт бус байдлыг бууруулах шаардлага байна,
3. Цаг үетэйгээ нийцүүлэхийн тулд татвар, шалгалт, хяналт, үзлэгийг хийх, олон өөрчлөлт хийх хэрэгтэй байна,
4. Бүс нутгийн интеграцид нэгдэх, дундаж орлоготой орны жагсаалтаас гарахад тулгарч буй сорилтыг даван туулах шаардлагата байна.

## **3. ГОЛ ЗОРИЛТУУД**

**3.01** Энэхүү төлөвлөгөө нь дараах тэргүүлэх чиглэлд анхаарал хандуулах болно. Үүнд:

1. **Хүртээмжтэй хөгжлийн орчинг бий болгох:** Энх амгалан байдал, улс төрийн тогтвортой байдлыг улам бэхжүүлэх, сайн засаглалын талаар мэдрэгдэхүйц алхамыг хийх, төвлөрлийг сааруулах, эдийн засгийн засаглал, удирдлагыг сайжруулах, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, хүртээмжтэй хөгжлийн угтвар нөхцөлийг бий болгох зорилтыг Засгийн газраас тавьж байна.
2. **Макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах талаар:**
  - Худалдаа, төсөв, инфляци гэсэн гол эдийн засгийн гурван тэнцвэрийг хадгалах,
  - Төсвийн алдагдлыг бууруулахын тулд 201X он гэхэд төсвийн орлогыг ДНБ-ний R% доошгүй хүртэл хувиар өсгөх,
  - Худалдааны тэнцвэрийг хадгалахын тулд экспортыг нэмэгдүүлэх,
  - Инфляцийг 5 хувиас дээшгүй түвшинд барих,
  - Эдийн засгийн удирдлагыг сайжруулахын тулд үр дүнтэй төсөв, мөнгөний бодлого боловсруулан хэрэгжүүлэх,
  - Улсын санхүүгийн удирдлагын шинэчлэлийн хүрээнд тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх.



### 3. **Үйлдвэрлэлийн салбар**

**А. Хүртээмжтэй өсөлтийг дэмжих:** Уг зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах тэргүүлэх зургаан чиглэлийг дэвшүүлж байна.

- Хөдөө аж ахуй, мал аж ахуйг орчин үеийн болгон хөгжүүлэх, төрөлжүүлэх, гарц/үр шимийг дээшлүүлэх, мал аж ахуйн (ялангуяа жижиг үйлдвэрлэл) арилжааны хөгжлийг бэхжүүлэх; фермерийн хоршоодыг (худаг, усан хангамжаа хамтран эзэмших, маркетинг хамтрах гэх мэт) байгуулах,
- Солонгосон аж үйлдвэржүүлэлт, аж үйлдвэрийг орчин үеийн болгон хөгжүүлэхийг дэмжих; ноолуур, ноос болон арьс ширэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх,
- Жижиг хот, түүний ойр зэргэлдэх нутагт санхүүгийн үйлчилгээг хүргэхийн тулд банк, санхүүгийн салбарыг бэхжүүлэх,
- Өрсөлдөх чадвартай, ил тод хөдөлмөрийн зах зээл хөгжих боломжийг хангах, “нэмүү өртөг” бүтээх ажлын байр бий болгох үйл ажиллагааг дэмжих,
- Дэд бүтэц (тээвэр, цахилгаан, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо болон бусад салбар)-ийг сайжруулахад хөрөнгө оруулах,
- Аялал жуулчлалын салбарыг дэмжих.

**Б. Нээлттэй, тэнцвэртэй эдийн засаг хөгжих орчинг буй болгох:** Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд дараах гол дөрвөн чиглэлийг баримтлах болно. Үүнд:

- Экспорт, ялангуяа мал аж ахуйн болон хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулсан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх,
- Монгол улсыг нэн ядуу орны статусаас “шинэ тулгар хөгжиж буй эдийн засаг” болгон хөгжүүлэх,
- Бүс нутаг, олон улсын эдийн засгийн интеграцчилалд бэлтгэх,
- Худалдааг чөлөөлөх, бүс нутаг болон олон улсын түвшинд худалдааны бодлогыг боловсруулах, хөрөнгө оруулалтын гэрээ, хэлэлцээрийг дэмжих арга хэмжээ, эрх зүйн шинэчлэл гэсэн гол асуудалд төвлөрөх замаар нээлттэй худалдааны тогтолцоог бэхжүүлэх.

### **4. Мэдлэг, боловсрол болон шинжлэх ухаан, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх**

Монгол Улсыг бүс нутгийн болон олон улсын хөдөлмөрийн хуваарьт элсэн оруулахын тулд олон арга замаар орчин үеийн технологи, туршлагыг эзэмших хүчин чармайлт гаргах хэрэгтэй юм. Гол асуудал нь мэдлэг, дадлыг олж авах, хөгжүүлэх болно.



### **5. Ядуурал, тэгш бус байдал**

- Жил бүр ядуурлыг Р-ээс доошгүй хувь бууруулж, шим тэжээлтэй хоол хүнсний хэрэглээг дэмжих,
- Тэгш бус байдлыг багасгах: хамгийн бага зарлагын түвшний бүлэгт хамрагдаж буй хүн амын хэрэглээг нийт хэрэглээний Q-аас доошгүй хувьд хүргэх,
- Бүс нутаг, хүйс, нас, боловсрол, эрүүл мэнд, боломж, бололцоо болон бусад тэгш бус байдлын асуудлыг шийдвэрлэх,
- Нийгмийн хамгааллын тогтолцоог буй болгох.

### **6. Боловсрол, эрүүл мэнд, усан хангамж, ариун цэврийн үйлчилгээ**

- Боловсролын түвшин хөвгүүд, охид тус бүрт бодитой тоон зорилтыг дэвшүүлэх,
- Суурь боловсролын түвшин, чанарыг сайжруулах,
- Хүний капиталын суурийг бэхжүүлэх: ажилчдын техникийн чадвар, ялангуяа мэдээлэл, харилцаа, холбоо, хөдөө аж ахуй болон үйлдвэрлэлд хэрэглэхэд сайжруулах,
- Хүний капиталыг хөгжүүлэхийн тулд эрүүл мэнд, хүнс тэжээлд хөрөнгө оруулалт хийх (амьдралын мөчлөгийн үе шат),
- Ундны ус, ариун цэврийн үйлчилгээг бүх иргэдэд хүргэх,
- Эрүүл хүн ам, ажиллах хүчинтэй байхын тулд хүн амын идэвхтэй бодлого, түүний дотор шилжилт хөдөлгөөний бодлогыг дэмжих,
- Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх (1-7 зорилт нь зорилтот түвшний үзүүлэлттэй бол 8 болон 9 дэх зорилтууд зорилтот түвшний үзүүлэлтгүй тул тэдгээрийг хэрэгжүүлэх).

### **7. Нийгэм-соёлын хөгжил:**

1. Үндэсний соёлын өвийг хамгаалан дэмжих,
2. Нийгмийн эе эвийг сахихад шашны гүйцэтгэх үүргийг дэмжих.

### **8. Байгаль орчин:**

Байгаль орчны удирдлагын талаар Ногоон хөгжлийн стратегийг баримтлах нь чухал юм. Энэ стратегийн бүрэлдэхүүнд ядуурлыг бууруулахын хамт ойг хамгаалах, газрыг ашиглах, эрчим хүчний хэмнэлтийн тоног төхөөрөмж, амьдралын хэв маяг, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг дэмжих зэрэг бусад олон санал санаачилга орно. Нийт газар нутгийн ММ%-ийг ойгоор хүрээлүүлэх, хүлэмжийн хийн зээлдүүлэгч орон болох зорилт тавьж, байгаль орчноо хамгаалах.



**9. Салбар хоорондын асуудал:** Засгийн газраас салбар хоорондын дараах гурван асуудлыг тодорхойлсон. Үүнд: жендэр, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин ба байгалийн баялгийн удирдлага, болон гамшгийн удирдлага. Эдгээр асуудлыг бүх салбарт тавих оролдлого хийх хэрэгтэй.

**10. Хяналт-шинжилгээ, үнэлгээ:** Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх зарим эхлэл тавигдаад байна. Хүртээмжтэй өсөлт, сайн засаглал (ил тод байдал, хариуцлага, мэдрэмжтэй байх чадварыг илэрхийлэх) гэх мэт үр дүнг үнэлэх илүү олон үзүүлэлтийг тодорхойлох, эдийн засгийн мэдээллийн баазыг бэхжүүлэх талаар хүчин чармайлт гаргаж болно.

## **4. 2017-2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨЛӨВ: ДНБ-ИЙ ӨСӨЛТ**

### **4.1 Зорилтын түвшинг тогтоох**

**4.01** Одоогийн (2012-2016) төлөвлөгөөнд ДНБ-ий жилийн өсөлтийг N% хүргэх зорилт тавьсан бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэхээр байна. Дараагийн төлөвлөгөөнд ДНБ-ий өсөлтийг ижил түвшин буюу жилийн N% байхаар тусгаж өгөх нь зүйтэй юм. Нийт өсөлтийг салбараар задалбал

- (1) Хөдөө аж ахуйн салбарын өсөлт жилийн N4 % ( 2018 оны ДНБ-ий NN1 %-ийг эзлэх),
- (2) Аж үйлдвэрийн салбарын өсөлт жилийн N5 % ( 2018 оны ДНБ-ий NN 2%-ийг эзлэх)
- (3) Үйлчилгээний салбарын өсөлт жилийн N6 % ( 2018 оны ДНБ-ий NN 3%-ийг эзлэх).

**4.02** ‘Өсөлтийн хөдөлгүүр” нэгээс олон байж болно. Цочрол (шок)-оос сэргийлэх, олсон үр шимийг сайн хуваарилахад солонгорсон өсөлт чухал юм.

### **4.2 Салбарын/салбарын хоорондын зорилтот түвшин**

A. Засаглал

#### **A1. Авлигатай тэмцэх**

**4.03** Хоорондоо холбоотой гурван арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд: (1) хуулийн боловсрол, (2) урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, (3) авлигын хэргийг мөрдөх хуулийн хэрэгжилт. Эдгээр арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй юм.



## **A2 Хууль, эрх зүй, шүүхийн шинэчлэл**

**4.04** Бүрэн хэрэгжүүлж амжаагүй хүчин чармайлтууд бол (1) Бүх нийтэд хуулийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, (2) Орчин үеийн хууль эрх зүйн хүрээ, (3) Бие даасан үйл ажиллагаатай эрх зүйн тогтолцоо.

## **A3. Төрийн захиргааны шинэчлэл**

**4.05** Эрх зүй, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх хүний нөөц хязгаарлагдмал байна. Цаашид хүлээгдэж буй ажил бол төрийн үйлчилгээний чанарын стандартыг тогтоон түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, хүний нөөцийг удирдан баяжуулах, ажилчдыг сэлгэн ажиллуулах механизмыг боловсронгуй болгох, үр дүнд суурилсан арга, хэрэгслийг нэвтрүүлэх, цалин, урамшууллын тогтолцоог шинэчлэх явдал юм.

**4.06** Төрийн албан хаагчдын тоог оновчтой болгох: Хэвшиж болох нэг дүрэм бол төрийн албан хаагчдын тоог улсын ажиллах хүчний 2-3%-аас хэтрэхгүй байхаар тогтоох хэрэгтэй боловч, ядуу буурай болон уулархаг орнууд бие даан тогтоож болно. Энэ нь тэдний цалин урамшууллыг нэмэгдүүлэхийг мөн зөвшөөрдөг. Үр дүнгийн удирдлага болон цалин, урамшууллын шинэчлэлийг зэрэг хэрэгжүүлснээр төрийн албаны үйл ажиллагааг сайжруулна.

## **A4. Орон нутгийн ардчилсан хөгжлийн шинэчлэлийг бэхжүүлэх**

**4.07** Төвлөрлийг сааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсны дараа орон нутгийн удирдлагын шийдвэр гаргах, удирдах, нөөц хуваарилах болон үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны чадавхийг сайжруулах хэрэгтэй болно.

## **A5. Санхүүгийн Шинэчлэл**

**4.8** Санхүүгийн удирдлагын шинэчлэлийн хөтөлбөр нь төрийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээ хүргэх үр дүнтэй арга хэрэгсэл болсон төрийн санхүүгийн удирдлагын тогтолцоог буй болгоход чиглэсэн. Төсвийн бодлого, төрийн үйл ажиллагааны үр дүн, төрийн үйлчилгээг хүргэх хариуцлагад төвлөрсөн зорилтуудыг тавьж өгөх шаардлага байна.

## **A6. Цахим засаглал**

**4.9** Засаглалын үр дүнтэй байдал, ил тод байдлыг сайжруулах талаар ихээхэн үр дүнд хүрэхэд цахим-засаглалыг хөгжүүлэх нь зүйтэй юм.



Б. Хөдөө аж ахуй, түүнтэй холбоотой үйл ажиллагаа

**4.10** Үр тариа, мал аж ахуйн салбарт хэвтээ холбоо хэрэгтэй байна. Дараах чиглэлээр ажиллах. Үүнд:

- Шинэ технологи, усжуулалтын системийг ашиглах замаар га-гаас авах ургацыг нэмэгдүүлэх,
- Хуваагдахгүй нөөц болон маркетинг хамтран эзэмших фермерийн хоршоодыг байгуулах,
- Хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний маркетингийн арга хэрэгслийг олшруулах, үнийн мэдээллийн системийг бүрдүүлэх,
- Цаг уурын төлөв, түүнийг мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах,
- Хөдөө аж ахуй, мал аж ахуйн судалгаа шинжилгээ, өргөжүүлэх ажлыг тоо, чанарын хувьд сайжруулах,
- Бүтээгдэхүүний аюулгүй байдал, байгаль орчин болон эрүүл ахуйн үүднээс хөдөө аж ахуйн химийн бодисын аюулгүй байдлыг хангах.

**4.11** Ойн удирдлагыг сайжруулах, шинээр мод тарих, ой, модыг хамгаалах.

**4.12** Хөдөө аж ахуйн фермийн бүрэлдэхүүний талаар:

- Мал аж ахуй эрхлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулан савлах, мах, сүү болон сүүн бүтээгдэхүүний брэнд нэрийг (химийн бодис ашиглаагүй) бий болгох,
- Гол усны загас, ургамлыг судлах.

**4.13** Тогтоох зарим гол харьцаанууд:

- Үйлдвэрлэл, газар, мал аж ахуйг өсгөн нэмэгдүүлэх- гарцын хүчин зүйл,
- Нэгж бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах- үр дүнгийн хүчин зүйл,
- Нэг ажилчны бүтээмж, бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх- орлогын хүчин зүйл,
- Нэг ажилчид ногдох үр тариа, мал аж ахуйн бүтцийг нэмэгдүүлэх- солонгоруулах хүчин зүйл.
- 

**Тайлбар:** Газар зүйн бүх бүс нутагт нэг нэр төрлийн үйл ажиллагааг дэмжих шаардлагагүй. Газар зүйн давуу талыг ашиглах хэрэгтэй. Жишээ нь ямар үр тариа (үр тарианы бус) хамгийн өндөр нэмүү өртөгтэй, фермерийн хувьд хамгийн өндөр орлого өгч байгааг тодорхойлон ажиллах.





**В. Усны нөөцийн удирдлага, хөгжил**

**4.14** Усны нөөцийн үр дүнтэй, тэгш бөгөөд тогтвортой удирдлагын дараах арга хэмжээг авах. Үүнд:

1. Усны нөөцийн удирдлага, хөгжилд олон улсын усны нөөцийн удирдлагын зарчмын хэрэгжилтийг дэмжих,
2. Усжуулалт, бохир ус зайлуулах, хамгаалахад усыг ашиглахын тулд усны гүнийн нөлөө, давамгайлал (hydro-hegemony)-ыг хэрэгжүүлэхийг дэмжих.

**Г. Аж үйлдвэр**

**4.15** Үйлдвэр, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд “Нийлүүлэлтийн талыг бэхжүүлэх” төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй байна. Тэргүүлэх чиглэлийн зарим үйлдвэр бол хүнс, хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах, ноолуур, ноос, арьс шир болон тэдгээртэй адилтгах үйлдвэрүүд болно. Зарим угтвар нөхцөлүүд бол үйлдвэрийн кластерийг байгуулах, хүнс, хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах технологийг судлан нутагшуулах, гэрээ эсвэл адилтгах системийн тусламжтайгаар мал аж ахуйн салбарыг үйлдвэртэй холбох, гэрээний тухай хуулийг бэхжүүлэх зэрэг болно. Эцэст нь уул уурхайн салбарын дагалдах үйл ажиллагааг боловсруулах, үйлдвэр бол зайлшгүй нэг хувилбар юм.

**4.16** Эдгээр үйлдвэр хөгжихөд зарим угтвар нөхцөл зайлшгүй болно. Нэгдүгээрт, хөрөнгө оруулагчийн итгэлийг нэмэгдүүлэх, хоёрдугаарт, стратегийн газар нутагт эдийн засгийн тусгай бүсийг байгуулах, гуравдугаарт, ажилчдад механик, цахилгаан, электроник, хими, металлургийн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн технологи эзэмшүүлэх.

**4.17** Тогтоох зарим гол харьцаанууд. Үүнд:

- Нэг ажилчинд ногдох нэмүү өртгийг нэмэгдүүлэх- бүтээмжийн хүчин зүйл,
- Нэгж бүтээгдэхүүний зардлыг бууруулах- үр ашгийн хүчин зүйл,
- Технологийг нутагшуулах- хяналт, бүтээмжийн хүчин зүйл,
- Ажлын байрны дадал эзэмшсэн ажилчдыг хөгжүүлэх- мэргэшил, дадлын хүчин зүйл,
- Мал аж ахуй, хөдөө орон нутгаас өөр газарт ажиллах хүчний байрыг нэмэгдүүлэх- ажлын байрны хүчин зүйл.

**Д. Уул уурхай**



**4.18** Монгол улс уул уурхайн баялагтай орон юм. Зэс, алт, молибден, нүүрс, нефть, нүүрс, нефтийн түүхий эдээс гаргаж авсан химийн бүтээгдэхүүн байна. Уул уурхай болон үйлдвэр, хөдөө аж ахуйн яамд зорилтот үзүүлэлтийг боловсруулан гаргаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр-хувийн хэвшлийн түншлэл, худалдааны нөхцөл, тээврийн байгууламж гэх мэт хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлагын талаар ажиллах хэрэгтэй байна.

Е. Дэд бүтэц

**4.19** Стратегийн тэргүүлэх чиглэлийн дагуу авто замын сүлжээг байгуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуй, мал аж ахуй болон бусад салбарын бүтээгдэхүүнийг тээвэрлэх шаардлагатай бүс нутгийг тодорхойлсны дараа авто замыг эрэмбэлэх,
2. Арилжааны эсвэл бусад зориулалтаар замын хөдөлгөөн нэмэгдэх газруудын авто замыг эрэмбэлэх,
3. Алслагдсан бүс нутгийг холбох асуудлыг эрэмбэлэх.

**4.20** Төмөр замын гол шугамын дагуу стратегийн хот, тосгоныг байгуулах.

**4.21** Эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд байгаль орчинд ээлтэй, нүүрсэнд түшиглэсэн цахилгаан станцыг байгуулах. Мөн эрчим хүч хэмнэдэг, эрчим хүчинд халгүй аргыг үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглах замаар хүлэмжийн хийн ул мөрийг багасгах.

**4.22** Үйлчилгээний салбарт дэмжлэг үзүүлэх: хувийн хэвшлийн мэдэлд мэдээлэл холбооны салбар байх.

Ё. Санхүүгийн салбарын хөгжил

Санхүүгийн салбарын хөгжил хоёр бүрэлдэхүүнтэй. Үүнд: хадгаламжийг дайчлах, зээлийг санхүүжүүлэхэд чиглэсэн санхүүгийн гүнзгийрэлт (байгууллагын болон зохицуулалтын) болон улсын санхүүгийн удирдлага. Тэдгээр нь хоорондоо харилцан уялдаа, холбоотой болно.

**4.23** Урт хугацаанд санхүүгийн салбарыг тогтвортой хөгжүүлэх зорилготой Санхүүгийн салбарын хөгжлийн стратегийг Засгийн газраас боловсруулах шаардлагатай юм. Тулгарч буй зорилтууд:

1. Банкны салбарыг бэхжүүлэх, өргөжүүлэх, банкны салбарт итгэх иргэдийн итгэлийг хангах,





2. Иргэд, хөдөөгийн иргэдэд банкны үйлчилгээг хүргэхийг дэмжих,
3. Банкны системийг хөгжүүлэх, улмаар түүнийг бүс нутгийн болон олон улсын банкны системд холбох.

**4.24** Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг оновчтой болгох, орлого, зарлагыг үр дүнтэй удирдах (түүний дотор нарийвчилсан нягтлан бодох бүртгэл хийх) зорилготой улсын санхүүгийн удирдлагын шинэчлэлийн хүрээнд улсын санхүүгийн удирдлагыг сайжруулах. Төлөвлөгөөний хугацаанд улсын санхүүгийн удирдлагын шинэчлэлийн ач холбогдол өндөрсөх бөгөөд орлого, зарлагын төлөвлөгөөний зорилтыг биелүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргах.

Ж. Аялал жуучлал

**4.25** Аялал жуулчлалын салбарын одоогийн байгаа үзвэр, үйлчилгээг олшруулан солонгоруулах зорилготой.

З. Шинжлэх ухаан, технологи

**4.26** Өнөөдрийн дэлхий дахинд бүх салбарт “орчин үеийн байгаль орчинд ээлтэй” технологийг хэрэглэх, мэдлэг, дадлагыг нэмэгдүүлэх шаардлага байна. Хөгжлийн үйл явцад үйлдвэрийн технологийн хэрэглээний дөрвөөс доошгүй үе шат байна. Үүнд:

1. Шинэ ойлголт, арга барилын хөгжил- жишээлбэл, электроникийн салбарт шинэ ойлголт, эмийн үйлдвэрлэлд электроникийг хэрэглэх гэх мэт (дээд үе шат),
2. Өнөөгийн арга барилыг нутагшуулах болон эсвэл нэвтрүүлэх- машин угсрах, машин үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, электроник гэх мэт (завсрын/ хөгжсөн үе шат),
3. Машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг бүрэн эсвэл хагас угсрах, туслах үйлдвэрийг хөгжүүлэх (завсрын эхний үе шат),
4. Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэр, хувцасны үйлдвэр, гар урлал, болон адилтгах үйлдвэрүүд (эхний үе шат) .

**4.27** Монгол улс 4 дэх үе шатнаас 3 дугаар үе шат руу тэмүүлэх хэрэгтэй байна. Мэдлэг, дадлыг нэмэгдүүлэхийн тулд шинжлэх ухаан, инженер, эм зүй, математикийн шинжлэх ухааныг ойлгох, ухах, нутагшуулах суурь байгууламжийг байгуулах хэрэгтэй. Сүүлийн арваад жилд энэ үйл явцыг даван туулсан бусад хөгжиж буй улстай хамтран ажиллавал илүү үр дүнтэй байж болох юм. Бүс нутгийн их, дээд сургуультай хамтран хамтарсан сургуулийг байгуулах түншлэлийг хайх хэрэгтэй. Хөгжиж буй улс орнуудын эдийн засаг, технологийн хамтын ажиллагааг ашиглах боломжтой. 10-15 жилийн Шинжлэх





ухаан, технологийн мастер төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй.

**4.28** Шинжлэх ухаан, технологи, инженер, архитектур болон бусад шинжлэх ухаанд оюутныг сургах судалгаанд суурилсан техникийн их сургуулийг байгуулах нь зүйтэй юм. Үүнээс гадна боловсролын тогтолцоо шинжлэх ухаан, математикийн суурийг сайжруулах хэрэгтэй. Нэг хувилбар бол “анхан-дунд боловсролын тэргүүлэх” 20-25 сургуулийг нээж, авьяастай хүүхдүүдийг сонгон элсүүлж, тэдэнд сайн чанарын шинжлэх ухаан, математикийн мэдлэг олгох юм.

И. Хүний Хөгжил

К.1 Ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх

**4.29** Ядуурлын түвшин буурсан боловч асуудал оршсоор л байна. Тавьсан зарчим, бодлоготой уялдуулан ядуурлыг бууруулах зорилтот түвшинг тавих нь дараагийн алхам болно. Ядуурлаас бүх иргэдийг гаргах нь эцсийн алхам болно. Зарим тэргүүлэх чиглэлийг дурдвал:

1. Ядуучуудад зориулсан хөтөлбөрийг тодорхойлон боловсруулах,
2. Үндэсний нийгмийн хамгааллын стратегийг үргэлжлүүлэх,
3. Хүнс, тэжээлийн стратегийн тусламжтайгаар хоол, тэжээлийн хөтөлбөрийг дэмжих,
4. Хөдөлмөрийн багтаамжтай, хүртээмжтэй эдийн засгийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийг дэмжих,
5. Ажилчид болон өөр мэргэжлийн ажилчдыг ажилтай болгох мэргэжлийн сургалтыг явуулах,
6. Хөдөөгийн амьжиргааг дэмжих чиглэлээр хөдөө аж ахуй, мал аж ахуйг гангаас хамгаалах арга хэмжээг авах,
7. Нэн ядуу иргэд болон зах зээлээс алслагдсан бүс нутгуудад зориулсан тусгай хангамж бэлтгэх,
8. Хулгай, дээрмээс сэргийлэх, хууль бус тамхи, эмийн үйлдвэрлэл, худалдаа, наймаа, хэрэглээтэй тэмцэх, хүний наймаа, гэр бүлийн хүчирхийллийг зогсоох замаар нийгмийн аюулгүй байдал, хэв журмыг сайжруулах.

**4.30** Нэг болон хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар ядуу иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөө, алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэд ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэдэд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх, ажлын байраар хангахын төлөө энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх хэрэгтэй.



## К.2 Боловсрол

**4.31** Боловсролын салбарын өмнө тулгарч буй хоёроос доошгүй зорилтыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд: боловсролын чанарыг бүх шатанд сайжруулах, хүмүүст дадал, чадвар олгох. Үүнд:

1. Дунд боловсролыг бэхжүүлэх хэрэгтэй,
2. Шинжилгээний арга (логик, математик, шинжлэх ухаан)-ыг заах арга зүйг сайжруулах шаардлагатай,
3. Дээд боловсролын тогтолцоонд бүрэн шинэчлэл хийх хэрэгтэй. Үүнд: магадлан итгэмжлэл, стандарт, зардал, хичээлүүд.

**4.32** Боловсролын салбарын төсвийн зардлыг нэмэгдүүлж дараагийн 5 жилд ДНБ-ий 6-7 хувьд хүргэх. Холбогдох яам дэлгэрэнгүй хөтөлбөр боловсруулж болно.

## К.3 Эрүүл мэнд

**4.33** Эрүүл мэндийн яам дараах асуудалд анхаарал тавих хэрэгтэй. Үүнд:

1. Эх, нялхас, хүүхдийн эндэгдэл, өвчлөлтийг цаашид бууруулах,
2. Хүний дархлал, хомсдолын хам шинж өвчин, хүний дархлал, хомсдолын хам шинж өвчний вирусаар халдвар, гэдэсний халдварт өвчин, уушигний сүрьеэ болон бусад халдварт өвчний өвчлөлт, эндэгдлийг цаашид бууруулах,
3. Халдварт бус өвчин болон бусад эрүүл мэндийн асуудлын дарамтыг бууруулах,
4. Эрүүл мэндийн тогтолцоог өргөжүүлэн сайжруулах,
5. Үйлчилгээг төвлөрсөн бус замаар хүргэх, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх замаар үйлчилгээг хүмүүст ойр, тэдний хэрэгцээнд нийцүүлэх,
6. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх: урьдчилан сэргийлэх, эмчилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох,
7. Ядуу иргэдэд зориулсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, ядуу иргэдийг төлбөрөөс чөлөөлөх,
8. Эрүүл мэндийн хууль, мэргэжлийн ёс зүйг мөрдүүлэх,
9. Эрүүл мэндийн салбарыг ажиллагсдын мэдлэг, дадлыг дээшлүүлэх,
10. Эрүүл мэндийн мэдээллийн систем, өвчлөлтийг тандах системийг сайжруулах,
11. Эрүүл мэндийн салбарын дэд бүтэц, шинэ технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах,
12. Байгаль орчны эрсдэл, эмийн буруу хэрэглээ, гэмтэл, мэргэжлийн эрүүл



мэнд, гамшиг зэрэг асуудалтай тэмцэхэд эрүүл мэндийн салбарт төрийн оролцоог бэхжүүлэх.

**4.34** Эрүүл мэндийн салбарыг дэмжих гол шаардлагын нэг бол олон түвшний мэдлэгтэй, хангалттай тооны мэргэжилтнийг сургах явдал юм. Хөдөө, орон нутгийн суурин газрын бага оврын эмнэлэгт өндөр мэргэжилтэй мэргэжилтэн очиж ажиллах тул анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнийг бэлтгэх хэрэгтэй.

Л. Хүн ам, түүний шилжилт, хөдөлгөөн

**4.35** Хүн амын хэт хамаарал (хэт олон хүүхэд, хэт цөөн тэжээгч)-ын харьцааг бууруулах, цөөн гишүүдтэй гэр бүл, төрөлт хоорондын зайг нэмэгдүүлэхийг дэмжсэн арга хэмжээг авах хэрэгтэй байна.

**4.36** Хүн амын шилжилт, хөдөлгөөн ихтэй байна. Иргэд хөдөө, орон нутаг хооронд болон хөдөөнөөс хот руу ихэнхдээ шилжиж байгаа учраас хүн амын нягтаршил бүс нутагт харилцан адилгүй байна. Гурван асуудал урган гарч байна. Үүнд:

1. Хүн амын шилжилт хөдөлгөөн их байгаагаас хүн амын тоонд нийцүүлэн нийгмийн үйлчилгээг төлөвлөн хүргэх нь үр дүнтэй бус байна,
2. (Хүмүүс шилжин ирсэн орон нутагт) Газрын асуудал нь иргэдийн дунд зөрчил үүсэх эх үүсвэр болж байна,
3. Хүмүүс шилжин нүүсэн болон ирсэн орон нутагт ус, цахилгаан зэрэг дэд бүтцийн тэнцвэртэй бус байдал үүсч байна.

*Хүн амын шилжилт, хөдөлгөөний мэдээлэл нь үнэн зөв төлөвлөлт, зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд чухал юм.*

М. Жендэр

**4.37** Бүх түвшинд эмэгтэйчүүдэд техникийн боловсрол, дадал, мэргэжлийн сургалт, төрийн үйлчилгээ болон шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж олгогдсон байх ёстой. Жендэрийн асуудал нь бодит салбар хоорондын асуудал болоод байна.

Н. Байгаль орчин

**4.38** Ойгүйжилт, далан ашиглалт, нүүрсний хэт хэрэглээ, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдол зэрэг сүүлийн үеийн хандлага, үйл явц байгаль орчны салбарт сөрөг нөлөө үзүүлж байна. Хоёр талтай байна.



Үүнд:

1. Нэг үр тарианы хиймэл тариалалт нь ус, олон төрлийн ургамал, амьтдын амьдралыг дэмждэг ойг нөхөж чадахгүй юм. Монгол улсын хувьд энэ хоёрыг хоёуланг тариалж, тэдгээрийн тэнцвэрийг барих хэрэгтэй юм.
2. Усны нөөцийн олдоц ховордож байгаатай холбогдуулан усны нөөцийн удирдлагын стратегийг өөрчлөх шаардлагатай байна.

**4.39** Ус, ойн нөөцийг хамгаалахаас гадна “био түлш”-ийн зориулалтаар мод тарих ажлыг Засгийн газраас эхлээд байна. Уг асуудлыг өргөн хүрээтэй авч үзэх хэрэгтэй юм.

О. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

### ***P1. Мэдээллийн сан***

**4.41** Судалгааны болон захиргааны мэдээллийн санг сайжруулан өргөжүүлэх шаардлагатай байна.

**4.41** Байгууллагуудын ашигладаг үзүүлэлт, хувьсагчийн тодорхойлолт, тэдгээрийн талаарх ойлголт зөрүүтэй байгаа бөгөөд тэдгээрийг нэгтгэх хэрэгтэй юм. Олон байгууллагууд мэдээлэл цуглуулахдаа олон төрлийн арга, барилыг ашиглаж байна. Иймд олон төрлийн мэдээллийн санг илүүтэй уялдуулан нэгтгэх шаардлага байна.

**4.42** Эцэст нь ялангуяа захиргааны мэдээллийн чанарыг сайжруулах шаардлагатай юм. Иймд салбарын яамдын газрууд статистикийн мэдээлэл цуглуулах аргаа дахин авч үзэх ёстой. Ингэснээр яамд, агентлагуудын уялдаа, холбоо сайжрах болно.

### ***P2. Бодлогын судалгааны байгууллагатай болох***

**4.43** Төрийн бодлогыг судалгаагаар дэмжих асуудалд анхаарал тавих хэрэгтэй байна. Иймээс эдийн засгийн бодлого эсвэл хөгжлийн асуудлаар судалгаа явуулах байгууллагыг байгуулах хэрэгтэй юм. Засгийн газрын дор бие даасан хөгжлийн судалгааны хүрээлэн /институт/ байгуулснаар энэ хийдлийг нөхөхөд тусална.



## 5. ХӨРӨНГӨ, НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

**5.1** Эдийн засгийн N% өсөлтийг хангахын тулд өнөөдрийн үнээр тооцсон (бодит үнээр) ДНБ ирэх 5 жилд RR дахин өснө гэсэн үг юм. Энэ өсөлтийг хангахад хөрөнгө, нөөц шаардлагатай. Нэгж бүтээгдэхүүний капиталын өнөөгийн харьцаа ICOR1 байна. ДНБ-ий бүтэц өөрчлөгдөхийн хамт энэ харьцаа ICOR2 болон ICOR3 хооронд болж өсөхөөр байна. Элэгдэл хорогдлыг (жилийн дундач 8% гэж тооцвол) тооцсоны дараа хөрөнгө оруулалт (дотоодын хадгаламжийг хөрөнгө оруулалт болгон хувиргаад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмбэл) -ын жилийн өсөлт II1 болохоор байна. Сүүлийн жилүүдэд хүрсэн хөрөнгө оруулалтын хамгийн өндөр өсөлт бол II2% байлаа. Үр ашиггүй байгаа хадгаламжийг үр дүнтэй ашиглаж чадвал асуудлын талыг шийдэж чадна.

**5.2** Дотоодын орлого нэмэгдүүлэх одоогийн байдлаарх урьдчилсан зарим хувилбарууд бол:

1. Шууд татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас нэмэлт татварын орлого олох,
2. Татварын баазыг өргөжүүлэх,
3. Татвар цуглуулалтын удирдлагын засаглалыг сайжруулах,
4. Аялал жуучлал, уул уурхайн болон бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг татварын бус орлогыг нэмэгдүүлэх,
5. Боловсрол, ядуурлыг бууруулах хөтөлбөр арга хэмжээнд зориулан татварыг хуваарилах,
6. Газар, бусад өмчийг дамлан худалдаалахад хөрөнгийн татвар ногдуулах.



### 3-р бүлгийн Хавсралт 2: Дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах загвар

#### Бодлогын хүрээ

Дунд хугацааны төлөвлөгөө боловсруулахад баримтлах бодлогын хүрээ, хөгжлийн агуулга бол:

1. Өмнөх төлөвлөгөөний дунд хугацааны үнэлгээ, дүгнэлт,
2. Салбарын яамдаас урт хугацааны зорилгоо тодорхойлсон салбарын баримт бичиг,
3. Өөрчлөгдөж буй дотоод, гадаад орчин,
4. Нэн ядуу орны статусаас шинээр хөгжиж буй орны статуст улсаа татан оруулахаар Засгийн газраас гаргаж буй хүчин чамайлт,
5. Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн үйл явц,
6. Тогтвортой хөгжлийн зорилгуудыг аль болох давж хэрэгжүүлэх,
7. Улс орныг тогтвортой, хүртээмжтэй хөгжилд хүргэх.

#### Ерөнхий зорилт

Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, эдийн засаг, улс төр, соёл болон бусад салбарт тэгш эрх, боломж бололцоог нийт хүн амд олгосон ардчилсан бөгөөд хуульт нийгмийг байгуулахад оршино. Монгол улс нээлттэй зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх зорилго тавьж байгаа бөгөөд боломж, бололцоог олгох орчинг буй болгох бодлогыг боловсруулна. Төлөвлөгөөнд санал болгосон хоёр чухал бүрэлдэхүүн бол “Хэрэгжилт ба ногоон хөгжил” болно.

#### 2017-2021 оны Төлөвлөгөөний Агуулга

Төлөвлөгөөний баримт бичиг нь арга хэмжээ авахуйц бөгөөд улс орон, нийгмээ улам сайжруулан өөрчлөх стратегийг агуулна. Төрийн төв байгууллага салбарын яамд, орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран уг төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулан бэлтгэнэ. Төлөвлөгөөний баримт бичигт:

1. Тайлагнаж буй салбарын өнөөх хүртэл олсон ололт, амжилт, дутагдлын талаар товч тодорхой өгүүлнэ. Тогтвортой хөгжлийн зорилгуудын биелэлтийн талаар тусгайлан мөн дурдаж өгнө,
2. “Бодлогын хүрээ”-ний баримт бичигт үндэслэн салбарын яамд төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой бодлогыг тодорхойлно. Салбарын төлөвлөгөөний дагуу салбар хоорондын бүх асуудлыг авч үзсэн байх шаардлагатай,
3. Суурь жил нь 2016 он буюу шаардлагатай мэдээ, мэдээлэл олдоцтой хамгийн сүүлийн жил байна,



4. Олон улсын бус эх сурвалжийн статистик, яамдын мэдээллийг ашиглах,
5. Стратегийг хэрэгжүүлэхэд тулгарч болох сорилт, эрсдэл (гадаад, дотоод), тэдгээрийг даван туулах арга хэмжээний хамт тодорхойлох,
6. Тодорхойлсон арга хэмжээ тус бүрийн хэрэгжүүлэгч байгууллага (хувийн хэвшил болон эсвэл түншлэл)-ыг тодорхойлох,
7. Холбогдох яам, агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд хэрэглэх гол үзүүлэлтийн жагсаалтыг гаргах,
8. Төрийн захиргааны төв байгууллагад илгээж, санал авах,
9. Шаардагдах төсвийн тооцоог хийх.

#### Үүрэг, хариуцлага

##### A. Төрийн захиргааны төв байгууллага:

Төлөвлөгөөний баримт бичгийн төслийг боловсруулан бэлтгэх ажлыг төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Төрийн захиргааны төв байгууллага нь:

1. Төлөвлөгөөний баримт бичгийн төсөл боловсруулахад шаардлагатай мэдээ, материалыг бэлтгэх болон төлөвлөгөө боловсруулах үйл явцын тухай журмаар салбарын яамд, агентлагуудыг хангах,
2. Бүх яамд, агентлагаас төлөвлөгөөний баримт бичгийн төсөлд оруулах мэдээ, материалыг авах,
3. Төлөвлөгөөний боловсруулалтын бүхий л үе шатанд бүх оролцогчдын санал, зөвлөмж, мэдээ, материалд үндэслэн төлөвлөгөөний баримт бичгийн төслийг боловсруулах, сайжруулах,
4. Төрийн захиргааны бусад төв байгууллагатай байнга зөвлөлдөн, үйл ажиллагаагаа уялдуулах,
5. Төлөвлөгөөний баримт бичгийн төсөл боловсруулах үйл явцын бүхий л шатанд Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад явцын талаар тогтмол мэдээлэх.

##### B. Яамд, агентлаг:

1. Яамд төлөвлөгөөний баримт бичгийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах шаардлагатай. Ажлын хэсгээс шаардлагатай мэдээ, материалыг төрийн захиргааны төв байгууллагад заасан хугацаанд гаргаж өгнө,
2. Яамд, олон улсын түнш хандивлагчдаас мэдээ, материалыг цаг тухайд нь төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгнө.





### Цаг хугацааны мөчлөг

1. Төрийн захиргааны төв байгууллагаас төлөвлөгөө боловсруулах журмыг бүх төрийн захиргааны байгууллагад зориулан ...оны ...-р сарын ....ны дотор гаргана,
2. Яам хоорондын анхны зөвлөлдөх уулзалтыг ...оны ...-р сарын ....ны дотор зохион байгуулна,
3. “Биелэлт болон шинэ санал” баримт бичгийн төслийг яамд, хэрэгжүүлэгч агентлагууд ...оны ...-р сарын ....ны дотор бэлтгэнэ,
4. Улсын болон орон нутгийн түвшинд засгийн газрын оролцогчдын дунд зөвлөлдөх үйл ажиллагааг яамдаас ...оны ...-р сарын ....ны дотор зохион байгуулна,
5. Энэ үйл явцтай зэрэг олон улсын түнш хандивлагч нартай зөвлөлдөөнийг ...оны ...-р сарын ....ны дотор мөн зохион байгуулна,
6. Харилцан уялдааг шалгасны дараа зорилт, түүнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөх. Энэ ажлыг төрийн захиргааны төв байгууллага ...оны ...-р сарын ....ны дотор зохион байгуулна,
7. Яам хоорондын хоёр дахь уулзалтыг ...оны ...-р сарын ....ны дотор зохион байгуулж, төлөвлөгөөний баримт бичгийн төсөлд гаргасан санал, зөвлөмжийг тусган сайжруулна,
8. Ерөнхий сайдын алба болон яамд хоорондын дээд түвшний уулзалтыг ...оны ...-р сарын ....ны дотор зохион байгуулж, түүнээс гарсан санал, дүгнэлтийг төлөвлөгөөний баримт бичгийн төсөлд тусган боловсруулна,
9. Засгийн газар холбогдох бүх зөвлөлдөөний ...оны ...-р сарын ....ны дотор дуусгана,
10. Төлөвлөгөөний баримт бичгийн төслийг Засгийн газарт өргөн барьж, батлуулна.



### 3-р бүлгийн Хавсралт 3: Экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ

Экосистемийн үйлчилгээ гэдэг нь экосистемээс хүн төрөлхтний хүртэж буй бүх төрлийн үр өгөөжийг хэлнэ. Дөрвөн төрлийн экосистемийн үйлчилгээ байдаг. Үүнд: хангамжийн үйлчилгээ (экосистем нь хүнс, ус, ашигт малтмал зэргийг хангадаг), зохицуулах үйлчилгээ (зуд болон өвчнөөс хамгаалах), соёлын үйлчилгээ (сүсэг бишрэлийн, аялал жуулчлалын, соёлын үр өгөөж), дэмжих үйлчилгээ (дэлхий дээрх амьд организмын амьдрах орчны бүрдүүлсэн бодисын эргэлтийн үр өгөөж) орно.

Байгаль орчны үнэ цэнэ ба түүнийг тооцохын ач холбогдол

Байгаль орчны үнэ цэнийг тооцох гэдэг нь экосистемийн үйлчилгээний биет болон биет бус үр өгөөжийг мөнгөн дүнгээр тооцон илэрхийлэхийг хэлнэ. Энэ нь дараах ач холбогдолтой.

- Бодлого, төсөл, хөтөлбөрүүдийн байгаль орчны доройтол болон байгалийн нөөцийн хомсдлыг бууруулахад үзүүлсэн үр нөлөөллүүдийг шинжлэх, үнэлэх,
- Экосистемийн үйлчилгээг ашигласны төлөөх төлбөрийн систем буюу зах зээлийн системийг бий болгох,
- Байгаль орчныг бохирдуулах буюу доройтуулах үйл ажиллагаанд ногоон татвар (буюу эко татвар) тавих,
- Хүний санаатай болон санамсаргүй үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн, доройтуулсан нөлөөллүүдийг үнэлэх (Шүүхийн өмнө байгаль орчны эсрэг гэмт хэргийг шийдвэрлэх, байгаль орчинд үзүүлсэн хохирлын мөнгөн төлбөрийг нэхэмжлэхэд хэрэглэгдэнэ),
- Үндэсний тооцооны системд байгаль орчны асуудлыг тусгах (Ногоон Дотоодын Нийт Бүтээгдэхүүн гэх мэт).

Экосистемийн үйлчилгээний нийт эдийн засгийн үнэ цэнэ

Эрдэмтэд байгаль орчны үнэ цэнийг ангилах асуудал дээр өнөөг хүртэл нэгдмэл байр сууринд хүрч чадаагүй байна. Ерөнхийдөө байгаль орчны үнэ цэнийг экосистемийн үйлчилгээний ашиглалтын ба ашиглалтын бус үнэ цэнэ гэж хоёр ангилдаг бөгөөд энэ хоёрын нийлбэрийг экосистемийн үйлчилгээний **нийт эдийн засгийн үнэ цэнэ** гэнэ.


- **Экосистемийн үйлчилгээний ашиглалтын үнэ цэнэ** гэдэг нь хүмүүсийн байгаль экосистемийн үйлчилгээг ашиглахтай холбоотой үнэ цэнэ юм. Үүнийг дотор нь 2 ангилдаг. Үүнд:
  - *Шууд ашиглалтын үнэ цэнэ*: Байгалийн нөөцийг шууд ашиглахын үнэ цэнэ. Тухайлбал, газрын тос ашиглах гэх мэт



- *Шууд бус ашиглалтын үнэ цэнэ:* Экосистемийн үйлчилгээний зарим нэг онцгой үүрэгтэй холбоотой үнэ цэнэ. Тухайлбал, нуур, далай, гол мөрөн зэрэг нь хог хаягдлыг шингээх, биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг бүрдүүлэх; мөн ой мод нь хөрсний нөхөн сэргээлтийг дэмжих, хөрс элэгдэхийг зогсоох, нүүрстөрөгчийн шингээх гэх мэт үүргүүд.
- **Экосистемийн үйлчилгээний ашиглалтын бус үнэ цэнэ** гэдэг нь экосистемийн үйлчилгээний өнөөгийн болон ирээдүйн ашиглалттай холбоогүй үнэ цэнэ юм. Өөрөөр хэлбэл, энэ үнэ цэнэ нь тухайн экосистемийн үйлчилгээ оршин байгаа байдлыг мэдэх оюун санааны үр өгөөж, мөн ирээдүйд тухайн экосистемийн үйлчилгээг авахын тулд өнөөдөр оруулж чадах хөрөнгө оруулалтын үр өгөөжөөр илэрхийлэгдэнэ.

# БҮЛЭГ - 4

---



## ТАЛУУДЫН ОРОЛЦОО БА ЗӨВШИЛЦӨЛ

---



## БҮЛЭГ ДӨРӨВ. ТАЛУУДЫН ОРОЛЦОО БА ЗӨВШИЛЦӨЛ

**Тойм:** Оролцоог хангах нь өөр өөр оролцогч талуудаас төрөл бүрийн сувгаар олон төрлийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлж, мэдээллийн баазыг баяжуулж өгнө. Энэхүү бүлэг нь оролцогч талуудын онцлог, ангилал, тэдний ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагын талаар танилцуулж, хэрхэн төлөвлөлтийн үйл явцад оролцуулж болохыг тайлбарлана.

### 4.1 Талуудын оролцоо

Гол оролцогч талуудыг бодлого төлөвлөлтийн үйл явцад оролцуулах нь тэдний ашиг сонирхол, санал бодлыг тусгаж, тухайн бодлогыг амжилттай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм. Хэлэлцүүлэг нь хувь хүмүүс болон бүлгүүдэд шууд нөлөө үзүүлэх эсвэл тэдний ашиг сонирхлыг татах бодлого, хөтөлбөр, төслүүдийн талаар талуудын санал бодлыг сонсохын тулд төв, орон нутгийн төр захиргааны байгууллагуудаас явуулж байгаа үйл ажиллагаа юм. Энэ нь санаа бодлоо хуваалцах ярилцлага, олон нийтийн уулзалт, цомхон хүрээний эсвэл бүлгийн ярилцлага зэрэг хэлбэрээр хийгддэг төлөвлөлтийн үйл явцад оролцогч талуудын оролцоог хангах зорилготой арга хэрэгсэл юм.

Хэлэлцүүлгийг тухайн бодлогын хамрах цар хүрээ, цаг хугацаа болон нөөц боломжоос хамаарч янз бүрийн түвшинд зохион байгуулж болдог. Хэлэлцүүлгийн түвшинг ерөнхийдөө дараах байдлаар ангилж үздэг. Үүнд:

1. Орон нутгийн иргэдтэй төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийн явцад хэлэлцүүлэг хийх.
2. Салбар дундын асуудлаар яамд хоорондын оролцоог хангасан хэлэлцүүлэг,
3. Томоохон бодлого, хөтөлбөр, асуудал ихтэй том төслүүдэд оролцогч талуудын (их сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүд, хөгжлийн олон улсын байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд гэх мэт) хамтын оролцоог хангасан хэлэлцүүлэг. Энэ нь нөхцөл байдлын шинжилгээ, асуудлыг хэлэлцэн шийдлийг олох зэрэг үйл явцад ихээхэн ач холбогдолтой арга болно,
4. Дээд удирдлагад (шийдвэр гаргагчдад) мэдээллийг өргөнөөр түгээх.

Тайлбар: Хэлэлцүүлэгт их сургуулиуд болон судалгааны хүрээлэнгүүдийг оролцуулах нь ихээхэн чухал асуудал юм. Учир нь эдгээр байгууллагын төлөөлөл нь асуудлын талаарх шинэ мэдлэгийг танилцуулах, шийдлийг олох өөр загвар, үзэл баримтлалыг дэвшүүлэн тавих зэрэг ач холбогдолтой.



Хэлэлцүүлгийг эхлээд байгууллагынхаа хэлтэс нэгжүүдийн дунд зохион байгуулж, үүний дараа байгууллагаас гаднах оролцогч талуудтай хийх ёстой гэдгийг бодлого төлөвлөлтийн мэргэжилтнүүд мэдэж байх хэрэгтэй. Хэрэв хэлэлцүүлгийг эхлээд дотооддоо хийхгүй бол байгууллагын доторх бусад хэлтсүүдийн эсэргүүцэлтэй тулгарах, бодлогын шинжилгээнд цуглуулсан мэдээлэлд давхардал гарах зэрэг саад бэрхшээл үүсч болзошгүй юм. Түүнчлэн, байгууллагаас гаднах оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийх нөхцөлд оролцогч талуудын төлөөллийг байгууллагын дотоодод зохиогдох хэлэлцүүлэгт зочин зөвлөх байдлаар урьж оролцуулан ажилтнууддаа асуудал, боломжит шийдлийн талаарх талуудын санал бодлыг танилцуулж болох юм.

Аливаа хэлэлцүүлгийг зохион байгуулахаас өмнө оролцогч талуудыг тодорхойлох хэрэгтэй. Оролцогч талууд гэдэг нь тухайн бодлогын нөлөөлөлд автах, эсвэл бодлогод нөлөө үзүүлж болох хувь хүмүүс ба бүлгүүд юм.

Бодлого төлөвлөлтийн үйл явцын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь оролцогч талуудын оролцоог хангах явдал бөгөөд энэ нь дараах давуу талуудыг бий болгодог. Эдгээрт:

- Шийдвэр гаргагч болон бодлого төлөвлөлтийн мэргэжилтнүүдэд илүү олон санааг дэвшүүлэн гаргаж өгдөг,
- Бодлогын нөлөө тусах бүх салбар, иргэд хамт олон тодорхой асуудлууд, тэдгээрийн шалтгаан, үр дагавруудыг олон талаас нь тодорхойлж, үзэл бодлоо солилцсоноор, илүү бодитой шийдэл гаргах магадлалтай,
- Тухайн бодлогод оролцогч бүх талуудын дэмжлэгийг авна,
- Бодлого төлөвлөлтийн үйл явц хүн бүрт ил тод явагдана,
- Бодлого төлөвлөлтийн мэргэжилтнүүдийн санал бодлыг хэт их тусгах эрсдлийг бууруулна,
- Хэрэв бодлогын талаар эсрэг байр суурь байгаа бол оролцоог хангаснаар дээд шатны удирдлагын байр суурийг бэхжүүлнэ,
- Тухайн байгууллагын нэр хүнд, итгэл даах байдлыг нэмэгдүүлж, бодлого амжилттай хэрэгжих боломжийг нэмэгдүүлнэ.

*Тайлбар: Зөвхөн бодлогын нөлөөлөлд автах оролцогч талууд төдийгүй шинжлэх ухааны судлаачид, удирдахуйн ухааны мэргэжилтнүүдийг хэлэлцүүлэгт оролцуулж, тэдний санал, зөвлөгөөг тусгах нь ач холбогдолтой байдаг.*





## 4.2 Оролцогч талуудын шинжилгээ

### Ангилал

Оролцогч талуудыг Хүснэгт 4.1-т харуулсанчлан ерөнхийдөө 3 бүлэгт хувааж болно.

Хүснэгт 4. 1 Оролцогч талуудын ангилал<sup>22</sup>

#	Оролцогч талууд	Товч тодорхойлолт	Тайлбар жишээ
1	<b>Үндсэн оролцогч тал</b>	Бодлогын үр шимийг хүртэгсэд эсвэл зорилтот хэсэг	<ul style="list-style-type: none"> <li>▶ Газар зүйн тодорхой бүсийн оршин суугчид – нутаг залгаа хөрш, айл саахалтынхан, хөдөө орон нутаг,</li> <li>▶ Тухайлсан хүндрэл, бэрхшээл тулгарч буй болон тодорхой нөхцөл байдлын үр дагаврыг амсаж буй хүмүүс: Жишээ нь орон гэргүй хүмүүс, наад захын үр чадвар суугаагүй хүмүүс, ажилгүйчүүд, өвчлөгсөд, эмэгтэйчүүд, гар аргаар олборлогчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт,</li> <li>▶ Хамрах хүмүүс буюу нөлөөлөлд хамрагдах байгууллагуудын оролцогчид: сургуулийн сурагчид, нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэж байгаа хүмүүс,</li> <li>▶ Зөвлөх үйл ажиллагааны зорилтот хэсэг болох шийдвэр гаргагчид, агентлагууд.</li> </ul>
2	<b>Үндсэн бус (хоёрдогч) оролцогч тал</b>	Бодлогын үр шим хүртэгчид эсвэл зорилтот бүлэгтэй шууд хамааралтай болон тэднийг хариуцдаг хүмүүс	<ul style="list-style-type: none"> <li>▶ Эх эцэг, гэр бүлийн хүн, ах дүүс, хүүхдүүд, ам бүлийн бусад гишүүд, бусад хүмүүс, найз нөхөд,</li> <li>▶ Сургуулиуд, тэнд ажиллагсад – багш нар, туслах ажилтнууд гэх мэт,</li> <li>▶ Эмч болон эмнэлэгийн мэргэжилтнүүд, түүнчлэн анхан шатны тусламж үзүүлэх болон өрхийн эмч нар,</li> <li>▶ Эрүүл мэнд болон хүмүүнлэгийн байгууллагууд, тэдгээрийн нэгж хэсгийн ажилтнууд – өсвөр, залуу үеийнхэний ажилтнууд, нийгмийн халамжийн ажилтнууд.</li> </ul>
		Бодлогын үйл ажиллагаа болон үр дүн нь ажил, амьдралд нь нөлөө үзүүлэх хүмүүс	<ul style="list-style-type: none"> <li>▶ Шуурхай албанд ажиллаж буй боловсон хүчин, багш нар зэрэг хуулиар үүрэг хүлээсэн хүмүүс,</li> <li>▶ Түрээслүүлэгчид: Байр сууцаар хангахад гарч байгаа ялгаварлалыг зогсоохоор явуулж буй компани ажлын хүрээнд түрээслүүлэгчийн хуулиар олгогдсон эрх, үүрэгт өөрчлөлт орж болох юм,</li> <li>▶ Гэрээлэгчид болон гүйцэтгэгчид: Ашиглагдаагүй сул байгаа газрын тухай хууль, бүсчлэлийн эрхзүйн зохицуулалт, хөшүүргүүд нь гэрээлэгчид ба гүйцэтгэгчид хаана, хэзээ, юуг, яаж барих вэ гэдэг сонголтоо хийхэд нөлөөлж болох юм.</li> </ul>
3	<b>Гол оролцогч талууд</b>	Засгийн газрын албан хаагчид, бодлого боловсруулагчид	<ul style="list-style-type: none"> <li>▶ Хууль боловсруулагчид, хууль тогтоогчид, төрийн төв болон орон нутгийн захиргааны төлөөлөл, парламентын гишүүд г.м</li> <li>▶ Засаг дарга нар, хотын дарга, хот, суурингийн иргэдийн төлөөлөгчид</li> </ul>
		Бусдад нөлөөлж чадах хүмүүс	<ul style="list-style-type: none"> <li>▶ Хэвлэл мэдээллийнхэн</li> <li>▶ Бусдад нөлөө үзүүлдэг албан тушаал эрхлэгчид: Шашныхан, эмч нар, гүйцэтгэх захирлууд болон сургуулийн захиралууд</li> </ul>

<sup>22</sup> Эх сурвалж: “Community Toolbox”, University of Kansas, Kansas, 2014, <http://ctb.ku.edu/en/table-of-contents>



	Хийх ажлаас бий болох үр нөлөөг сонирхож буй хүмүүс	<ul style="list-style-type: none"> <li>▶ Бизнесийнхэн, өмгөөлөгчид</li> <li>▶ Төрийн бус байгууллагууд, идэвхитэнгүүд</li> <li>▶ Эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид</li> <li>▶ Хандивлагчид</li> </ul>
--	---	---

### 4.3 Оролцогчдын зураглал болон шинжилгээ


Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн явцын эхэнд оролцогч талуудад танилцуулга хийн мэдээлэл өгч, тэдний ашиг сонирхол, санал бодлыг тусгах хэрэгтэй. Үүний тулд эхлээд оролцогчдыг тодорхойлох ёстойг өмнө дурдсан билээ. Үндсэн болон гол оролцогчдыг тодорхойлоход (Хүснэгт 4.1 дэх) ихээхэн хялбар боловч хоёрдогч буюу үндсэн бус оролцогч талыг тодорхойлоход хүндрэл гарч болох юм.

Оролцогчдыг дараах алхмуудаар тодорхойлно:

- ▶ Оролцогчид хэн байж болох талаар байгууллагынхаа дотор хэлэлцэх,
- ▶ Нөлөөлөх чадамжаар нь оролцогчдыг эрэмбэлэх,
- ▶ Оролцогч талуудыг зураглах хавтгайд оноон байршуулах.

Оролцогч талуудыг тодорхойлсны дараа ашиг сонирхлыг нь системтэй байдлаар тодорхойлох нь чухал байдаг. Үүнийг хийхэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга бол оролцогч талуудын зураглал юм. Энэ нь оролцогч талуудын дунд хэн нь бодлогод хамгийн их эерэг эсвэл сөрөг нөлөөлөл үзүүлэх, өөр өөр сонирхол, нөлөөлөх байдал нь ялгаатай оролцогчидтой бодлого боловсруулагчид хэрхэн ажиллах нь зүйтэйг тодорхойлох арга хэрэгсэл юм.

Зураг 4.1 Оролцогчдын зураглал







Хаалтад байгаа нэрүүд нь оролцогч талуудын шинж чанарыг тодорхойлно<sup>23</sup>:

- ▶ *Дэмжигчид* – тухайн бодлогыг гаргуулах сонирхолтойгоос гадна уг бодлогыг амжилтанд хүргэх (эсвэл саад хийх) эрх мэдэлтэй байдаг. Иймд тэдэнтэй хамтран ажиллах, удирдах нь чухал,
- ▶ *Хамгаалагчид*-уг бодлогод амин чухал сонирхол бий, дэмжлэг хэрэгтэйг ч мэддэг, гэхдээ тухайн бодлогод нөлөөлөх эрх мэдэл бага байдаг. Тэдэнд бодлогын төлөвлөлтийн явцын талаар байнга танилцуулж байх хэрэгтэй,
- ▶ *Нуугдмал агент нь* яг тийм гэх сонирхол эсвэл хийгдэж байгаа ажилд оролцоо байхгүй хэрнээ сонирхол нь төрвөл бодлогод нөлөөлөх эрх мэдэл бүхий хүмүүс. Тэднийг сэтгэл хангалуун байлгах нь чухал,
- ▶ *Онцын ач холбогдолгүй хүмүүс* – бодлогын талаарх сонирхол болон эрх мэдэл байхгүй, тийм бодлого, асуудал байгааг мэддэггүй. Зөвхөн тэдний авир, төлөв байдлыг ажиглаж байхад л болно.

Бодлого төлөвлөлтийн багийн зүгээс оролцогчдын төрөл бүрийн онцлогийг харгалзан үзэж тэднийг хэрхэн удирдаж, хянах, тэдний дэмжлэгийг авахын тулд юу хийх хэрэгтэй зэргээ төлөвлөх нь зүйтэй.

Аливаа хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа хэнтэй, юун тухай, хэзээ, хаана хэлэлцүүлэг хийх, яагаад хэлэлцүүлэг хэрэгтэй болох, яаж зохион байгуулах нь зүйтэйг бодлого төлөвлөлтийн ажилтнууд тодорхойлох хэрэгтэй. Хүснэгт 4.2-т хэлэлцүүлэг зохион байгуулах үйл ажиллагааны шалгах хуудсыг харуулав.

#### Хүснэгт 4. 2 Хэлэлцүүлгийн шалгах хуудас

<b>Хэн</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэнд мэдээлэл хүргэж, зөвлөлдөх шаардлагатай байгааг тодорхойлох: бусад хэлтсүүд, тухайн салбарын сайд, бусад салбарын сайд нар, Засгийн газрын бусад түвшнийхэн, хууль хяналтын бусад байгууллагууд, засгийн газрын хороод, гаднах оролцогчдын бүлгүүд, иргэд.</li> </ul>
<b>Юу</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэлэлцүүлгийн сэдэв юу байх вэ? Асуудлыг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг дэвшүүлэн гаргах, хувилбарыг сонгох, бодлогын үр дүн, үр дагавар, нөлөөлөл зэргийн талаар хэлэлцэх үү?</li> <li>• Хэрэв бодлогыг боловсруулахад шинжлэх ухааны нарийн мэдлэг шаардлагатай бол хэлэлцүүлгийг тэдгээр мэргэжилтнүүдээс бодлого төлөвлөгч нартай мэдлэгээ хуваалцах, зөвлөлдөх байдлаар зохион байгуулах хэрэгтэй. Зарим тохиолдолд тэдгээр мэргэжилтнийг бодлого төлөвлөлтөнд оролцуулж болох юм.</li> </ul>
<b>Хэзээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэлэлцүүлэг явуулах хугацаа, хэлэлцүүлгээс хүлээсэн үр дүн гарсан эсэх, хэзээ дуусгах зэргийг тодорхойлох. Энэ ажлыг бодлого төлөвлөлтийн мэргэжилтнүүд асуудлын мөн чанарыг ойлгохыг хичээж буй нөхцөл байдлын шинжилгээний явцад хийх хэрэгтэй юу? Бодлого төлөвлөлтийн үйл явц бүрт</li> </ul>

<sup>23</sup> Зураг 4.1-ийн эх сурвалж: 'Community Toolbox', University of Kansas, Kansas, 2014, <http://ctb.ku.edu/en/table-of-contents>



	хэлэлцүүлэг хийх үү? Аль хувь хүмүүс, бүлгүүдтэй бодлого төлөвлөлтийн тодорхой үе шатанд, алинтай нь өөр үе шатанд хэлэлцүүлэг зохион байгуулах хэрэгтэй вэ? зэрэг асуултанд хариулах шаардлагатай.
<b>Хаана</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцүүлгийг хаана зохион байгуулах вэ? Зарим нэг хувь хүмүүс, бүлэгтэй тухайлсан нэг газарт, нөгөө хэсэгтэй нь өөр газарт хэлэлцүүлгийг хийх нь тохиромжтой юу?</li> </ul>
<b>Яагаад, юуны учир</b>	<ul style="list-style-type: none"> <li>Тухайн хувь хүн, хэлтэс, бүлэгтэй яагаад хэлэлцүүлэг хийх хэрэгтэй вэ? Хэлэлцүүлгийн дүнд тухайн хүмүүс, бүлгүүдээс ямар төрлийн мэдээллийг олж авах гэж байна вэ? Хэлэлцүүлгийн зорилго нь мэдээлэл цуглуулах уу, өмнө өгсөн мэдээлэл, хэрэгжүүлсэн ажлын талаар тэдний санал сэтгэгдэлийг сонсох явдал уу, эсвэл аль аль нь уу? Хэлэлцүүлгийн хүрээнд мэдээлэл дамжуулахыг зорьж байна уу? Эдгээр асуултанд хариулснаар бодлого төлөвлөлтийн мэргэжилтэн нь хэлэлцүүлгээс ямар үр дүн хүлээж буйгаа, хэлэлцүүлгийг “хэрхэн”, “хаана” явуулахаа тодорхойлоход хялбар болно.</li> </ul>
<b>Яаж</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцүүлгийг ямар хэлбэрээр хийвэл хамгийн үр дүнтэй болох вэ гэдгийг тодорхойлох. Семинар, дугуй ширээний ярилцлага, эсвэл олон нийтийн уулзалт явуулах нь зүйтэй юу? Бодлогын талаарх мэдээллийг түгээх, хүмүүсийн санал бодлыг авахдаа интернэтийг ашиглах нь зүйтэй юу? Хэлэлцүүлэгт зориулсан баримт бичгийг гаргах нь зүйтэй юу? Харилцагчид, оролцогч талуудын дэд бүлгүүдийг хамтад нь хэлэлцүүлэгт байлгах нь зүйтэй юу?</li> </ul>
<b>Хэдий хэм-жээнд</b>	<ul style="list-style-type: none"> <li>Олон янзын оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулахад зардлыг зайлшгүй харгалзаж үзэх хэрэгтэй. Хэлэлцүүлгийг хаана, хэрхэн зохион байгуулснаас шалтгаалж гарах зардал нь янз бүр байдаг. Иймд хэлэлцүүлгийг өгөгдсөн хугацаа, төсөвтөө багтаан сайтар зохион байгуулах хэрэгтэй.</li> </ul>

Дээрх шалгах хуудсыг ашиглан бодлого төлөвлөлтийн мэргэжилтнүүд хэлэлцүүлгийг хэрхэн хийх төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

#### 4.4 Орон нутгийн хэлэлцүүлэг

Орон нутагт санаачилж буй бодлогын нөлөөлөл шууд тусах хувь хүмүүс болон бүлгүүдийн бодол санааг олж мэдэх зорилгоор орон нутгийн түвшний хэлэлцүүлгийг явуулдаг. Орон нутгийн нөхцөл байдал, нийгэм, соёлын хүчин зүйлсийг харгалзан үзсэний үндсэн дээр харилцах арга хэлбэрээ тодорхойлно. Тухайлбал, нээлттэй хэлэлцүүлэг, олон нийтийн уулзалт, бүлгийн ярилцлага эсвэл олон нийтийн санал асуулга зэргийн алийг хэрэглэх нь зохимжтой, зарим жендэрийн холбогдолтой асуудлыг ярилцахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тус тусад нь бүлэг болгон хэлэлцүүлгийг явуулах уу гэдгийг шийдвэрлэнэ.

#### 4.5 Салбар дундын асуудлаарх яамд хоорондын хэлэлцүүлэг

Яамд хооронд хэлэлцүүлэх шаардлагатай бодлогууд нь ихэвчлэн салбар дундын шинж чанартай байдаг. Тухайлбал, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, байгаль орчны доройтлыг хянах, хотжилтыг зохицуулах зэрэг асуудал нь бүх салбарт хамааралтай юм. Иймд бодлого төлөвлөлтийн явцад бодлого



хоорондын давхцалыг аль болох багасгах, залгамж чанар, уялдааг хангах чиглэлээр яамд хоорондын хэлэлцүүлгийг хийх ёстой билээ. Энэ түвшинд бодлого төлөвлөгчид нь бусад яамдын мэргэжилтнүүд, төрийн захиргааны төв байгууллагуудыг хэлэлцүүлэгт оролцуулна. Уг хэлэлцүүлгээр дунд шатны шийдвэр гаргагчид болон зөвлөхүүд уг бодлогын хэрэгжилтийн хувьд гарч болох эрсдлүүд ба боломжууд, салбар дундын асуудлуудын зардал, үр ашгийг шинжилснээр бодлогыг хэрэгжүүлэх явцад гарч болох сөрөг үр нөлөөллийг урьдчилан харж, бууруулах ач холбогдолтой.

#### 4.6 Оролцогч талуудын хоорондын хэлэлцүүлэг

Оролцогч талуудын хоорондын хэлэлцүүлэгт бодлогын үр нөлөөг сонирхож буй хувь хүмүүс, бүлгүүд оролцоно. Их сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүд, олон улсын хөгжлийн байгууллагууд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд оролцсоноор бодлогын үр дүн, нөлөөг үнэлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

#### 4.7 Дээд шатны шийдвэр гаргагчдад мэдээлэл өгөх, танилцуулах

Бодлогыг Засгийн газар болон УИХ-аас батлах эсэх нь дээд түвшний шийдвэр гаргагчид тухайн бодлогын талаарх мэдээллийг хэр сайн авч, ойлгосноос хамаардаг. Энэ түвшинд бодлого төлөвлөгчид нь баталгаажуулсан нөхцөл байдлын шинжилгээ, бодлогын боломжит хувилбаруудыг танилцуулж, илүү сайн гэж үзэж байгаа бодлогын хувилбар нь аль болох, түүнийг батлуулахад түлхэц болохуйц учир шалтгаан, хүрч болохуйц үр дүнг нь логик тайлбартайгаар сайтар бэлтгэж, танилцуулах хэрэгтэй.

#### 4.8 Хэлэлцүүлгийн мэдээллийг ашиглах

Хэлэлцүүлгийн үеэр хөндөж тавьсан асуудлууд, илэрхийлсэн байр суурь, санал бодлыг тухайн бодлогод тусгаагүй бол хэлэлцүүлэг нь ямар ч үр дүнгүй болдог. Иймд бодлогын баримт бичигт ямар хүмүүс, яагаад хэлэлцүүлэгт оролцсон, тэдний илэрхийлсэн гол асуудлууд юу байсныг дурдах хэрэгтэй. Дэлгэрэнгүй, урт тайлан бус, харин анхаарал татсан гол хэсгүүдийг агуулсан, оролцогчдын байр суурийг нэгтгэн харуулсан товч хураангуй байдлаар бичигдсэн байх ёстой. Хэлэлцүүлгээс гарсан санал болон бодлогын чиглэл нь хоорондоо логиктой байх хэрэгтэй.

#### ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Засгийн газар нэлээд алслагдмал дүүрэгт ус дамжуулах шугам хоолойг уртасган тавих шинэ хөтөлбөрийг баталжээ. Оролцогч талууд нь хэн байх вэ?

**Дасгал 2:** Говийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компанид Засгийн газар тухайн бүс нутгийн малчин иргэдэд зориулж, нийгмийн халамж, хөгжлийн нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэлт тавьжээ. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн энэ хөгжлийн хөтөлбөрийн төсөлд оролцогч талуудыг хэрхэн тодорхойлох вэ?

# БҮЛЭГ - 5

---

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ**

The background features a light blue and grey graphic design. It includes several dashed circles of varying sizes, a hand cursor icon pointing to a small circle, a lightbulb icon, a stack of coins icon, and a group of people icon. The overall theme is related to technology, innovation, and business processes.



## БҮЛЭГ ТАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

**Тойм:** Энэ бүлэг нь үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тодорхойлолт, ойлголт, зорилтууд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шатууд, мэдээлэл цуглуулах, ашиглах зэрэг асуудлуудыг тусгасны зэрэгцээ Өөрчлөлтийн онолын талаар товч дурдана.

**Асуулт:** Бодлого боловсруулагч нь өөрсдийн тавьсан зорилгын дагуу нөөцийг хуваарилсан бол яагаад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай вэ?

**Хариулт:** Бодлого боловсруулагч нь өөрөө эдгээр нөөцийг “эзэмшдэггүй”. Төрийн нөөц нь хүмүүсийн өмч хөрөнгө бөгөөд бодлого боловсруулагч нь зөвхөн эдгээр нөөцийг хуваарилах хариуцлагыг хүлээж байгаа хүн юм. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хэрэгтэй байдаг.

**Асуулт:** Өмнөх ядуурлыг бууруулах зорилт нь энэ төлөвлөгөөнд бас тусгагдах уу?

**Хариулт:** Өмнөх үнэлгээний тайланг үзээд хариу өгье.

**Асуулт:** Замын төсөл яагаад саатаж байна?

**Хариулт:** Хяналт-шинжилгээний сарын тайланг үзээд хариу өгье.

### 5.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний ялгаа

#### 5.1.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ гэж юу вэ?

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь бодлого төлөвлөлтийн мөчлөгийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Төлөвлөлтийн мөчлөгийн эхний гурван бүрэлдэхүүн нь төлөвлөлт, төсөвлөлт, болон хэрэгжилт бөгөөд дөрөв, тав дахь бүрэлдэхүүн хэсэг нь хяналт-шинжилгээ, үнэлгээ юм.

**Хяналт-шинжилгээ** гэж хөгжлийн зорилгод хүрэхэд гарч байгаа ахиц дэвшил, хуваарилсан хөрөнгийн ашиглалтын явцыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хянаж, системтэй мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, бодлогын хэрэгжилтийн талаар удирдлага болон гол оролцогч талуудад тасралтгүй мэдээлэх үйл ажиллагааг хэлнэ.

**Үнэлгээ** гэж хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дууссан бодлого, хөтөлбөр, төсөл, түүний дотор тэдгээрийн боловсруулалт, хэрэгжилт, үр дүнг системтэй, бодитой үнэлэх үйл явц юм. Үнэлгээний зорилго нь төсөл, хөтөлбөрт тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, хэрэгжилтийн үр дүн болон үр ашигтай байдал, нөлөө, цаашид бие даан хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлоход оршино. Хяналт-шинжилгээ болон үнэлгээний аль аль нь төсөл, хөтөлбөр төлөвлөсний дагуу хэрэгжиж байгаа эсэх (хэрэгжүүлэх шаардлага, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж), менежер эсвэл бодлого төлөвлөгч оновчтой бодлого боловсруулж байгаа эсэх (үр өгөөжтэй байдал, үр дүнтэй, уялдаа холбоотой байх, нөөцийг үр ашигтай, оновчтой зарцуулах), илүү сайжруулан хийх арга замуудыг гаргасан



боломжит хувилбар, тэргүүн туршлага, авсан сургамж) байна уу гэсэн асуултад хариулт өгнө.

*Тайлбар: Үнэлгээг үр дагаварт, тэр ч байтугай үйл явцад хийж болно. Шаардлагатай тохиолдолд бодлогын баримт бичгийн төсөлд урьдчилсан үнэлгээ хийж болно.*

Товчоор хэлбэл хяналт-шинжилгээ нь хөтөлбөр, төслийн хэрэгжилт нь төлөвлөлтийн дагуу явж байна уу гэдгийг шалгахад тусалдаг бол үнэлгээ нь үйл ажиллагааг хэрэгжүүлснээр үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлох үүрэгтэй “үр дүнг тооцох” шинжилгээ юм<sup>24</sup>.


Аливаа эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа нь Зураг 5.1-д үзүүлснээр нягтлан бодох бүртгэл, аудит, үр дүнг үнэлэх зэргээр багадаа хяналтын таван аргаар үйл ажиллагааныхаа гүйцэтгэлийг хянаж байна. Тус зураг дээр хяналт-шинжилгээ, үнэлгээ нь том төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд төлөвлөлтийн үр дүнгийн хүрээний салшгүй нэг элемент гэдгийг харуулж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээг санхүүгийн аудит, боловсон хүчний үнэлгээ эсвэл судалгааны үр дүнгээр орлуулж болохгүй, харин эдгээр нь нэмэлт аргууд байж болох юм.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь өнгөрсөн, одоо, ирээдүйн хөгжлийн санаачилга, үр дүнгийн хоорондын уялдаа холбоог тодорхойлох замаар хөрөнгө оруулалтын үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хэрэгжүүлэгч яам, агентлагт өмнө нь хэрэгжсэн болон одоо хэрэгжиж байгаа ямар нэг хөтөлбөрийн үйл ажиллагаанаас холбогдох мэдээллийг цуглуулснаар дараагийн бодлого төлөвлөлтөд суурь мэдээлэл болгон ашиглах, нарийвчлах, хэрэгжүүлэх арга замыг нь сайжруулахад тусалж чадна.

<sup>24</sup> <http://www.differencebetween.com/difference-between-monitoring-and-vs-evaluation/#ixzz2zaMbtCXF> –с авав.



**Зураг 5. 1 Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо<sup>25</sup>**



Хяналт-шинжилгээг Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төслүүд, нөөц, бэлэн мөнгөний гүйлгээний ямар ч үед хийх боломжтой. Гэхдээ энэхүү гарын авлагад төсөл, хөтөлбөр, бодлогын хяналт-шинжилгээг танилцуулах тул Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар тусгаагүй болно.

**Шигтгээ 5. 1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хоорондын ялгаа<sup>26</sup>**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хэрэгжүүлэгч яам, агентлагийн дэвшүүлсэн зорилгод гарсан ахиц дэвшлийг тодорхойлох хоёр арга юм. Гэхдээ асуудалд хандах арга замын хувьд хоорондоо ялгаатай байна.


1. Хяналт-шинжилгээ нь тодорхой тогтоосон цаг хугацаанд гарсан өөрчлөлтийг тодорхойлох мэдээллийн байнгын, системчилсэн шинжилгээ юм. Харин үнэлгээ нь зорилтыг хэрэгжүүлэхэд гарсан ахицад үнэлгээ өгөх замаар үйл ажиллагааны үр дүнг шинжилдэг.
2. Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийдэг. Энэ нь тодорхой хугацааны явцад төслийн гаргасан ахиц (биелэлт)-ыг нягтлан шалгадаг. Хяналт-шинжилгээ хийхдээ өмнөх хугацааны биелэлтийн явцыг заавал авч үзэх албагүй. Харин үнэлгээг хэрэгжиж дууссан төслийн гүйцэтгэл, биелэлтийн явцын судалгаа гэж тодорхойлж болно. Үнэндээ үнэлгээ нь хүрсэн амжилтын “үнэ цэнийг” тооцоход оршино.
3. Хөтөлбөр, төслийг хугацаанд нь дуусгахын тулд хяналт-шинжилгээг хийдэг. Үүнд хяналт-шинжилгээний үндсэн зорилго оршино. Энэ нь тодорхойлсон зорилго, зорилтот түвшинд хүрэхийн тулд төслийн гаргасан ахицыг тогтмол шалгадаг. Үнэлгээ нь хөтөлбөр, төслийн үр дүн, үр дагаврыг судалдаг.
4. Хяналт-шинжилгээ нь хэрэгжилтийн явцад тулгарсан хүндрэлийг илрүүлснээр сайжруулан засах арга хэмжээ авахад тусалдаг. Шаардлагатай тохиолдолд төслийн хуваарьт өөрчлөлт оруулах, төслийн төсөвт тусгайлсан хуваарилалт хийх эсвэл ажилтныг шилжүүлэн ажиллуулах асуудлаар санал оруулж болно. Тэгвэл үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг тогтмол сайжруулах үүргийг гүйцэтгэдэг. Энэ нь мөн төсөлд алдаа гарах магадлалыг бууруулахад боломжит санхүүгийн болон бусад нөөцийг үр дүнтэй ашиглах, төслийг хэрэгжүүлэхийн тулд ашигласан шинэ техник, арга, аргачлалын үр дүнтэй байдлыг турших, судалгаа, асуулга, ярилцлага болон бусад аргаар төсөлд оролцогчдын ойлголт, хүртсэн бодит үр шимийг хянан баталгаажуулах үйл явц юм.

<sup>25</sup> Эх сурвалж: НҮБХС, Үнэлгээний газар, Бангкок

<sup>26</sup> Эх сурвалж: <http://mop.gov.kh>, “Үр дүнд хүрэх зам: Хөгжлийн үнэлгээг үр дүнтэй удирдан явуулах нь” Линда Г. Морра Имас, Рей С. Рист, С.Рист, Вашингтон ДС, 2009.



**Зураг 5. 2 Хяналт шинжилгээ-үнэлгээний ялгаа**



**5.1.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчийн чиг үүрэг**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн ажлын чиг үүргийг энэ хэсэгт товчхон танилцуулна.

**Шигтгээ 5. 2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчийн чиг үүрэг**

<b>Хаана</b>	Засгийн газар, яам, агентлаг, нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газар
<b>Юу хийх</b>	Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцыг боловсруулан сайжруулах Бодлогын хэрэгжилтийн ахиц, дэвшилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулах Бодлогын хэрэгжилтийн биелэлтийг улирал болон хагас, бүтэн жилээр тайлагнах Сургалтад чиглэсэн дүн шинжилгээг сайжруулах Мэдээлэл цуглуулах, шинжлэх, тайлан бичих Шийдвэр гаргагч нарт мэдээлэх, оролцогч талуудтай хамтран ажиллах
<b>Хэнтэй</b>	Засгийн газрын харьяа агентлаг, байгууллага Орон нутгийн засаг захиргаа, агентлаг Их дээд сургууль, эрдэм шинжилгээний институт Олон улсын хөгжлийн түнш байгууллагууд Хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагууд Орон нутгийн иргэд
<b>Юунд тулгуурлан</b>	Үр дүнд суурилсан удирдлага, мэдлэг, дадлага Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга, аргачлал (тоон, чанарын болон оролцооны) Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны төлөвлөлт, хэрэгжилт Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл, техникийн чадвар Улс төрийн амлалт Бүтэц, зохион байгуулалт Хөтөлбөр, төсөв, журам, хууль тогтоомж
<b>Юуны төлөө</b>	Урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэх

**5.1.3 Сургалт болон чадавхи**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу Засгийн газрын бүх шатны байгууллагууд нь хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг хүлээнэ. Харин Засгийн газар манлайлан төрийн албан хаагч, шинжээч, иргэний нийгмийн байгууллага болон хувийн хэвшлийн төлөөллийг хамруулсан сонирхлын бүлэг байгуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхийг





тодорхойлж, бэхжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг явуулах нь оновчтой байдаг. Үндэсний болон орон нутгийн хэмжээнд олон улсын шилдэг туршлагад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээний стандарт боловсруулж, алдаа, оноог шинжилж, чадавхи бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэгтэй. Засгийн газар нь яамдын хөтөлбөр хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжаар хангаж, статистик мэдээллийг ашиглах талаар мэргэжилтнүүдэд шаардлагатай сургалтуудыг явуулна.

## 5.2 Үр дүнгийн хүрээ/Логик хүрээ

### 5.2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээнд үр дүнгийн хүрээг боловсруулах нь

Төсөл, хөтөлбөрийн матрицын түгээмэл схемийг Хүснэгт 5.1-д харуулав. Энэ нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэс суурь болдог.

Хүснэгт 5. 1 Үр дүнгийн хүрээ/Логик хүрээний дарааллын түгээмэл схем<sup>27</sup>

Хөтөлбөрийн тайлбар	Шалгуур үзүүлэлт	Нотлох арга хэрэгсэл	Таамаглал ба өмнөх нөхцөл*
<b>Зорилго:</b> Үндэсний болон салбарын түвшинд боловсруулсан хөтөлбөр үр нөлөөгөө өргөн хүрээнд үзүүлнэ.	Зорилгыг хангахад чиглэсэн хөтөлбөрийн оруулж буй хувь нэмрийг хэмжинэ - Үнэлгээ	Мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл цуглуулах арга	Таамаглал хийх
<b>Зорилт:</b> Хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсэг нь хүлээгдэж буй үр дагаварт чиглэсэн байна.	Хөтөлбөрийн зорилго биелсэн болон хүрсэн үр дүн тогтвортой эсэхийг тогтоох хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээ	Мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл цуглуулах арга	Таамаглал хийх
<b>Хэрэгжүүлэгч нэгжийн зорилт:</b> Бүх нэгжийн гарц нь хүлээгдэж буй үр дагаварт чиглэсэн байна	Бүрэлдэхүүний зорилт биелснийг тогтоох бөгөөд зорилгыг тоймлон үзнэ	Мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл цуглуулах арга	Таамаглал хийх
<b>Гарц:</b> Хөтөлбөрийн шууд үр дүнг (бараа, үйлчилгээ) хэмжинэ.	Гарцын тоо, чанар, цаг хугацааг хэмжих хяналт-шинжилгээ, шалгалт	Мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл цуглуулах арга	Таамаглал хийх
<b>Үйл ажиллагаа:</b> хөтөлбөрийн арга хэмжээнүүдийн дүнд гарц бий болно.	Хөтөлбөрийн зорилтот түвшинг хэмжих хяналт-шинжилгээ	Мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл цуглуулах арга	Өмнөх нөхцлийг дурдах

Тайлбар: \*- Төслийн төрлөөс хамаарч таамаглал ялгаатай байна.

<sup>27</sup> Эх сурвалж: Хэмжилт, сургалтын болон үнэлгээний төсөл, <http://www.urbanreproductivehealth.org>; ба <http://www.tools4dev.org/resources/logical-framework-logframe-template/>



Энэ хүснэгтийн эхний баганад төсөл, хөтөлбөрийн нь зорилго, зорилтууд, хэрэгжүүлэгч нэгжийн зорилт, гарц, үйл ажиллагааны хоорондын харилцан хамаарлыг харуулж байна. Хэрэв хөгжлийн хөтөлбөр нь ядуурлыг бууруулах зорилготой гэж үзвэл түүний зорилт нь бүс нутгийн хүн амын орлогыг нэмэгдүүлж, чадавхийг сайжруулах, хэрэгжүүлэгч нэгжийн зорилт нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэх мэт үйл ажиллагаа явуулах болно. Харин гарц нь малын тэжээл, сургалтын үйлчилгээний<sup>28</sup> чанарыг сайжруулах, малчдад мэдээлэл өгөх, сургалт явуулах төв байгуулах, тэжээл хуваарилалтын системд хөрөнгө оруулалт хийх зэрэг үйл ажиллагаануудыг явуулж болох юм.

Хүснэгтийн хоёр дахь багана нь эхний баганын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Зорилгын шалгуур үзүүлэлт нь 2015 он гэхэд ядуурал хоёр дахин буурсан байна, зорилтын шалгуур үзүүлэлт нь тодорхой у тооны аймгийн малчдын чадавхи, орлого х хувиар сайжирсан байна, гарцын зорилтын шалгуур үзүүлэлт нь хх тооны сайжруулсан малын үүлдэрийг нэвтрүүлсэн гэх зэргээр холбогдох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг харуулж байна. Багана 1 болон 2 нь хоорондоо яг адил утгатай байх ёстой бөгөөд багана 2 нь SMART<sup>29</sup> шинжийг хангасан тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэнээрээ ялгаатай байна.

Хэрэв цуглуулсан тоон мэдээлэл, тогтоосон шалгуур үзүүлэлтүүд нь хүн эсвэл нөөц, үйлчилгээг хүлээн авсан хүмүүстэй холбоотой бол хүйсээр мэдээллийг ангилан (дээр дурдсан малчдын х хувь нь эрэгтэй, эмэгтэй) гаргана. Эдгээр хүйсээр ангилан нэгтгэсэн статистик мэдээлэл нь задаргаагүй байж болох учраас анхаарал татахуйц, нарийвчилсан байх шаардлагатай. Иймд тус мэдээлэлд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээний санал, зөвлөмжийн дагуу хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн дараагийн үе шатыг сайжруулах, үйл ажиллагааг засч, залруулах дүгнэлт өгч болно.

Хүснэгтийн гурав дахь багана нь хоёр дахь баганад тодорхойлсон тоон мэдээллийг хэрхэн цуглуулах талаар тайлбарлана. Үүнд ямар мэдээллийг, ямар аргачлал болон судалгаагаар, ямар эх үүсвэрээс олж авах талаар оруулж өгнө.

Хүснэгтийн дөрөв дэх баганад тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл байдлыг аль болох дэлгэрэнгүй таамагласан байдлаар үзүүлнэ. Жишээ нь:

<sup>28</sup> Экстейншний үйлчилгээ гэдэг нь хөдөө аж ахуй эрхлэгчдийн чадавхийг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний гарц болон чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн болон хувийн байгууллагын үзүүлж буй үйлчилгээг хэлнэ. Тухайлбал: чадавхийг сайжруулах сургалт явуулах, малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэх зэрэг байж болно.

<sup>29</sup> SMART- тодорхой, хэмжигдэхүйц, биелүүлэхүйц, ач холбогдолтой, хугацаатай



1. Зорилгын хувьд: Тодорхой бүс нутагт мал аж ахуйг хөгжүүлэх нь орлогыг тогтвортой нэмэгдүүлнэ,
2. Зорилтын хувьд: Малын гаралтай бүтээгдэхүүний чанар сайжирснаар зах зээл нь (үнэ, борлуулах тоо хэмжээ, тээврийн хэрэгсэл гэх мэт) тэлнэ,
3. Хэрэгжүүлэгч нэгжийн зорилтын хувьд: Малчид малынхаа үүлдэр, угсааг сайжруулах шинэ арга барилд суралцан, түүнийг ашиглана,
4. Гарцын хувьд: Малчид малын үүлдэр угсааг сайжруулахад үзүүлж буй туслалцааг хүлээн авч, малчдад дэмжлэг үзүүлэх сургалтын төвийг сайн дураараа ашиглана,
5. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тавигдах нөхцөлийн хувьд: Хангалттай чадварлаг хүний нөөцтэй, тоног төхөөрөмжөөр хангагдсан сургалтын төвүүд байгуулагдана.

Түүнчлэн энэ хүснэгт нь мөрийн дагуу хэвтээ уялдаа, холбоотой. Зорилгыг бодитой дэвшүүлэх үүднээс харгалзах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж өгнө. Энэ нь хэрэгжүүлэх болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аль ч шатанд шалгуур үзүүлэлтийг нотлох мэдээллийн эх сурвалж шаардлагатай гэсэн үг юм. Уг холбоос нь мөр бүрт шаардлагатай. Дээр тайлбарласан төслийн загвар матрицыг төрийн болон ашгийн бус байгууллагууд ч хийж, ашиглаж болно. Энэ матрицыг дараах хоёр жишээн дээр авч үзье.

### Хүснэгт 5. 2 Нийгмийн хоёр төслийн матрицын жишээ

1. Зээл олгох замаар эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг хүчирхэгжүүлэх		
Төслийн танилцуулга	Шалгуур үзүүлэлтүүд	Нотлох арга хэрэгсэл
(1)	(2)	(3)
<b>Зорилго:</b> Эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн байр суурийг нэмэгдүүлэх	Нийт ажиллах хүчинд бодит орлого бүхий эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Үнэлгээний судалгаа, ҮСХ-ны мэдээлэл
<b>Зорилт:</b> Эдийн засгийн хараат байдал сайжирсан болон эрэгтэйчүүдтэй харьцуулсан харьцаа	Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондын цалингийн ялгаа	Үнэлгээний судалгаа, Жендэрийн үндэсний хороо, СХ хорооны мэдээлэл
<b>Нэгжийн зорилт:</b> Нийт эмэгтэйчүүдийн тоонд олон эх үүсвэрээс орлого олох нийгмийн болон эдийн засгийн боломжууд нь нэмэгдсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Орлого нь нэмэгдсэн эмэгтэйчүүдийн тоо, Шинээр бизнес эхэлсэн эмэгтэйчүүдийн тоо	Орон нутгийн төрийн байгууллага болон ҮСХ-ны мэдээлэл
<b>Гарц:</b> Эмэгтэйчүүдэд олгогдсон зээлийн хэмжээ, гэрээний дагуу төлөгдсөн зээл	Зээлд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, Зээл хүссэн эмэгтэйчүүдийн тоо	Хөдөлмөрийн яам, Орон нутгийн байгууллага, банкны мэдээлэл
<b>Үйл ажиллагаа:</b> Дүрэм, журам боловсруулах, Сан байгуулах, Оролцогч талуудтай уулзалт хийх	Эмэгтэйчүүдэд санал болгосон зээлийн журам, Санхүү, хүний нөөц, Уулзалтын тоо гэх мэт	Байгууллагын үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн тайлан



2. Мод тарихыг дэмжих		
Төслийн танилцуулга	Шалгуур үзүүлэлтүүд	Нотлох арга хэрэгсэл
(1)	(2)	(3)
<b>Зорилго:</b> Байгаль орчинг хамгаалах	Ногоон бүсийн хэмжээ, Ой модны нягтрал/км <sup>2</sup> , Хамгаалагдсан газрын тоо	Үнэлгээний судалгаа, ҮСХ-ны мэдээлэл
<b>Зорилт:</b> Ой модны өсөлт ба ой хамгаалах	Тарьсан мод болон суулгацын тоо	Үнэлгээний судалгаа, БОНХАЖЯ, ҮСХ-ны мэдээлэл
<b>Нэгжийн зорилт:</b> Модны суулгацын тариаллын талаар хэрэглэгчдийн мэдлэг, боловсрол дээшилсэн байх	Тарьсан модны тоо, Хуулиар хамгаалагдсан байгалийн нөхөн сэргээлтийн газар нутаг	БОНХАЖЯ-ны мэдээлэл
<b>Гарц:</b> Шинжлэх ухааны үндэслэлтэй тарьсан мод	Тараасан үрийн тоо, сургалтад хамрагдсан хүний тоо, мод суулгах, хамгаалах талаар олон нийтэд хийсэн сурталчилгаа	БОНХАЖЯ-ны мэдээлэл
<b>Үйл ажиллагаа:</b> Мод тариалах төсөв, мөнгө, урамшуулал, ногоон эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх	Санхүүгийн зориулалтын эх үүсвэр, бэлтгэгдсэн хүний нөөц, зохион байгуулсан сургалтын тоо	Байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, санхүүгийн тайлан

### 5.2.2 Үр дүнгийн хүрээг тодорхойлох нь

Үр дүнгийн хүрээнд (ҮДХ) хэрэглэдэг нэр томъёонууд болох үр дагавар, гарц нь тогтсон нэршилтэй болоогүй тул төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшин, агуулгаасаа хамааран үр дагавар нь гарц байж болдог. Төсөл, хөтөлбөрийн ҮДХ-г боловсруулахдаа үр дүн, үр дагавар нь юу болохыг тодорхойлох нь чухал юм. Иймд хөтөлбөрийн үр дагавар нь яамны үйл ажиллагааны гарц байж болно. Жишээ нь: БСШУЯ “Бага сургуулийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ” гэж зорилтоо тодорхойлжээ. Тэгвэл энэ нь “Хүүхэд, залуу хүн бүрийг 12 жилийн боловсролтой болгох замаар бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрэн арилгаж, хүний нөөцийг сайжруулах” гэсэн үндэсний хэмжээний зорилгын нэг болох юм. Үүнтэй адилаар усжуулалтын төсөл хэрэгжүүлсэн байгууллагын хувьд үр дагавар байх бөгөөд усны хүртээмж нь хөдөө аж ахуйн салбарын хувьд орц нь байх болно. Төсөл, хөтөлбөрийн ҮДХ гаргах болгонд шинэ агуулга шаардлагатай. Авч үзэж буй хөтөлбөр, төслөөс хамаарч нэгтгэх эсвэл задлах үе шат, түвшинг тогтооно.

### ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Хэрэв төлөвлөлтийг сайжруулахаар хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ хийдэг бол яагаад төслийн хэрэгжилтийн явцад болон дуусах үе шатанд үнэлгээ хийх ёстой вэ?

**Дасгал 2:** Үр дүнд суурилсан хүрээг бодитой гаргаж төлөвлөсөн хугацаанаас хоцрох шалтгааныг тайлбарлана уу. Хариултаа тайлбарлахдаа ХХҮА (Хөтөлбөрийн Хяналт, Үнэлгээний арга хэрэгсэл)-ийг ашиглана уу.

**Дасгал 3:** Үр дүнгийн хүрээг боловсруулахдаа орц, үр дагавар хоёрын алийг нь түрүүлж тодорхойлох ёстой вэ? Хариултаа тайлбарлана уу.



### 5.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, үе шат

#### 5.3.1 Шалгуур үзүүлэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтээр төлөвлөсөн үйл ажиллагаанд цаг хугацааны явцад гарч буй аливаа өөрчлөлт, ахиц дэвшлийг хэмждэг. Хүссэн зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны (эсвэл өөр шалтгааны улмаас) үр нөлөөг харуулахын тулд янз бүрийн түвшин (хэвтээ (газар зүйн байршлаар)) болон босоо (үйл ажиллагааны доод түвшнээс яам хүртэлх) тэнхлэгт үзүүлэлтүүдийг ашиглана. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог үр дүнтэй, найдвартай байлгах үүднээс зохистой үзүүлэлтүүдийг тодорхойлох нь чухал юм. Оролцогч талуудын зөвшилцлийн үр дүнд шалгуур үзүүлэлтийг сонгох ёстой. Ингэж тодорхойлоогүй тохиолдолд зарим оролцогчийн хувьд биелэгдээгүй шалгуур үзүүлэлтүүдийг нуух шууд бус шалтаг болдог. Шалгуур үзүүлэлт нь хүссэн үр дүнтэй аль болохоор ижил төстэй байх ёстой. Ер нь бол шалгуур үзүүлэлт нь зорилтот түвшний тусгал байх хэрэгтэй. Амжилт эсвэл ахисан түвшинг үнэлэх үүднээс шалгуур үзүүлэлт нь зорилтот түвшинг тусгахаас гадна бодлого (үйл ажиллагаа, орц)-ын үр дүнтэй байдлыг мэдээлж, сайжруулах арга замыг санал болгох ач холбогдолтой юм. Үүнээс гадна үзүүлэлт нь SMART эсвэл CREAM байх хэрэгтэй (Хүснэгт 5.3). Дээр дурдсанчлан, хүмүүст өгсөн үйлчилгээ, хөрөнгө, нөөцтэй холбоотой үзүүлэлтийг хүйсээр ангилсан байдлаар гаргасан байх ёстой.

**Хүснэгт 5.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн шинжүүд**<sup>30</sup>

<b>S</b>	Тодорхой – хүссэн үр дүнд хүрэхийн төлөө	<b>C</b>	Тодорхой
<b>M</b>	Хэмжихүйц – хэмжиж болохуйц үр дүн, үр дагавар	<b>R</b>	Ач холбогдрлтой
<b>A</b>	Биелүүлэхүйц – бодитой байх	<b>E</b>	Үр ашигтай
<b>R</b>	Ач холбогдолтой - тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн	<b>A</b>	Зохистой
<b>T</b>	Цаг хугацаатай – төслийн хугацаанд хэрэгжүүлж болох	<b>M</b>	Хяналт тавихуйц

Үзүүлэлт нь тоо хэмжээ, үнэ цэнэ, хязгаарлалт, цаг хугацааны хувьд тодорхойлогдсон байх ёстой. Дараах 2 жишээг авч үзье.

**Жишээ 1**

Алхам 1: Үзүүлэлтийг тогтоох → Махны экспортыг нэмэгдүүлэх ёстой.

Алхам 2: Тоо хэмжээ → Махны экспортыг 10 хувь нэмэгдүүлэх ёстой.

Алхам 3: Үнэ цэнэ, хязгаарлалт → Махны экспортыг 2014 оны үнээр 10 хувь нэмэгдүүлэх ёстой.

Алхам 4: Цаг хугацаа → Махны экспортыг дараагийн хоёр жилд 2014 оны үнээр 10 хувь нэмэгдүүлэх ёстой.

**Жишээ 2**

Алхам 1: Үзүүлэлтийг тогтоох → Нялхсын эндэгдлийг бууруулах ёстой.

Алхам 2: Тоо хэмжээ → Нялхсын эндэгдлийг 5 хувь бууруулах ёстой.

Алхам 3: Үнэ цэнэ, хязгаарлалт → Бүх аймгийн нялхсын эндэгдлийг бууруулах ёстой.

Алхам 4: Цаг хугацаа → Бүх аймгийн нялхсын эндэгдлийг дараагийн 5 жилд 5 хувь бууруулах ёстой.

<sup>30</sup> Эх сурвалж: Үр дүнд суурилсан ХШҮ хийх 10 алхам, J.Z. Kodak and RC. Rest, Дэлхийн банк, Вашингтон 2014



Түгээмэл ажиглагддаг дараах жишээнүүд байдаг. Үүнд:

а) Нэг түвшний зорилтын биелэлтийг харуулсан шалгуур үзүүлэлтийг өөр түвшний амжилтыг харуулахад ашиглаж болохгүй. Иймд “Мэдээлэл сайтай малчид” гэсэн үр дагаврын үзүүлэлтийг хэмжихдээ “Орчин үеийн мал эмнэлгийн үйлчилгээг ашиглах давуу талын асуудлаар хамрагдсан 100 малчин” гэсэн гарцын үзүүлэлт болгон ашиглах нь буруу юм. Харин сургалтын дараа “Үйлчилгээ авахаар мал эмнэлгийн төвд ирсэн малчдын тоо” нь үр дүнгийн сайн үзүүлэлт юм.

б) Үр дагавар болон гарцыг илүү нөхцөл байдалтай нь холбож үзэх хэрэгтэй. Жишээ нь: “олон мал эмнэлгийн төв байгуулах” гэсэн гарцаас бий болох үр дагавар нь “төвд ирэх малчдын тооны өсөлт” юм. “Мал эмнэлгийн төвөөр үйлчлүүлэх малчдын тоог өсгөх” гэсэн зорилго нь “малын эрүүл мэнд сайжруулахад нөлөө үзүүлнэ” гэж болно.

### 5.3.2 Зорилтот түвшний үзүүлэлтийг тогтоох

**Анхаарах зүйл:** Зорилтууд, хэмжих нэгж зэрэг нарийвчилсан мэдээллийг бодлого боловсруулагч, хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчид хамтран тодорхойлох ёстой.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь зорилгодоо хүрэхийн тулд тогтмол хугацааны болон жилийн биелэлтийг хэмжихээр шалгуур үзүүлэлт бүрийн хувьд тогтоосон зорилтот түвшин (өсөн нэмэгдэх)-ийг тогтоохыг шаардана. Иймд тогтмол хугацааны болон жилийн бодит гүйцэтгэлийг зорилтот түвшинтэй харьцуулан ахиц, дэвшлийг хэмжинэ. Энэ арга барил нь шалгуур үзүүлэлт бүрийн хувьд жилийн зорилтот түвшинг бодитой тогтоохыг шаардана.

Төсөл, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлж өгснөөр төслийн (эсвэл үйл ажиллагааны) түвшинд, төсөл дуусахад (барилга, зам), сургалт амжилттай дуусах (багш нар, эрүүл мэндийн ажилтнууд) эсвэл тодорхой үйлчилгээг цаг тухайд нь үзүүлэх (вакцинжуулах үйлчилгээ, экспортын ачааг шалгах) зэргээр орц, гарцыг тодорхойлоход том асуудал гардаггүй.

Хөтөлбөр, үйл ажиллагааны амжилтыг хэмжихээр сонгож авах шалгуур үзүүлэлтийн тоо нь “Хэдэн шалгуур үзүүлэлт зорилтод хүрэх амжилтыг хангалттай тусгах вэ?” гэсэн асуултад тулгуурласан байна. Ерөнхийдөө тогтсон дүрмээр бол аль түвшинд хамгийн багаар тооцоход 2-3-аас ихгүй шалгуур үзүүлэлттэй хэрэгтэй. Үйл ажиллагааны түвшинд шалгуур үзүүлэлт нь зайлшгүй бус бол нэг байх ёстой.





## Шигтгээ 5. 3 Макро түвшний зорилтыг тодорхойлох

Макро түвшинд үр дагавар болон үр нөлөөний зорилтот түвшинг тогтооход нөөцийн боломж болон түүний үр дүнтэй ашиглалтаас хамаарахгүй байх нь элбэг байдаг. Улс төрийн шийдвэр л ихэнхдээ нийгмийн хэрэгцээ шаардлагыг шийддэг. Эдгээр зорилтот түвшин шинэчлэгдэж заримдаа нэгээс олон удаа өөрчлөгдөхөд гайхах зүйлгүй юм. Хамгийн тодорхой жишээ бол Тогтвортой хөгжлийн зорилгууд билээ.

Засгийн газар ядуурлын түвшинг жилд 1-ээс доошгүй хувиар бууруулах зорилтыг тавьсан. Энэ нь өөрийн иргэддээ өгсөн улс төрийн амлалт бөгөөд түүнийг хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ энэ нь өмнөх нөхцөлд суурилаггүй бөгөөд “эдийн засгийн өсөлт болон ядуурлын хоорондын” хамаарлыг загварчлан дэвшүүлсэн зорилт юм. Ийм тохиолдолд зорилтын түвшин стратеги, нөөцийг шаардах бөгөөд хэрэв шаардлагатай нөөц дутвал гадаад эх үүсвэрээс дайчлах хэрэгтэй болдог.

Засгийн газрын дээд түвшинд зориулагдсан макро түвшний хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилтот түвшин 15-20 шалгуур үзүүлэлтээс илүүгүй байна. Иймээс салбарын шалгуур үзүүлэлтүүд нь салбарын төлөвлөж байгаа үйл ажиллагаанаас хамаардаг. Хавсралт 5.1-д жишээ жагсаалтыг хавсаргав.

**Асуулт:** Засгийн газраас ядуурлыг бууруулах арга хэмжээний хүрээнд орлого нэмэгдүүлэх (ядуу хүмүүст зориулсан) олон нийтийг хамарсан ажлыг санаачилжээ. Энэ нийтийн ажлын ердийн үр өгөөж нь 6-8 хувь байхад зардал, өгөөжийн стандарт томъёогоор 2-3 хувиас хэтрэхгүй гэж тооцоолсон. Тэгэхээр энэ арга хэмжээ нь зөв шийдвэр байсан уу?

**Хариулт 1:** Энгийн хариулт нь “тийм, зүйтэй”, учир нь үндсэн зорилго нь ажлын байрыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах болохоос биш өгөөжийг нэмэгдүүлэхэд биш юм.

**Хариулт 2:** Хэрвээ энэ төсөлд ажилчдыг гаргасан бол өгөөжийн хувьд ч болон ядуурлыг бууруулах зорилтод ч аль алинд нь хүрэх илүү боломжтой байна.

**Тайлбар:** Суралцагчид болон багш нар хэлэлцүүлгийн дараа ийм үр дүнг тайлбарлах хэлэлцэх шаардлагатай.

### ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** SMART биш 5 үзүүлэлтийн жишээ хэлнэ үү.

**Дасгал 2:** SMART болон CREAM шаардлагыг хангасан үзүүлэлтүүдийн хоорондын төсөөтэй болон ялгаатай шинжүүдийг тайлбарлана уу.

## 5.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх-үе шат<sup>31</sup>

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэн, юу, хэрхэн гэсэн загварыг Хүснэгт 5.4-д үзүүлэв. Энэ хүснэгт хяналт-шинжилгээ, үнэлгээний “хэн”, “юу”, “хэрхэн”, “хэзээ” гэсэн зарим анхан шатны асуудлуудыг багтаасан. Эдгээр асуултуудад хариулж, дараа нь цаашид дүн шинжилгээ хийх алхмуудыг дагах логиктой болгох юм. Усан хангамж, ариун цэврийн төслийн бодит жишээгээр энэ бүлгийн Хавсралт 2-т үзүүлэв.

<sup>31</sup> Үр нөлөөний хяналт-шинжилгээ хийх процесс, R. Hummelbrunner, INTERACT, Виенна 2006, [http://admin.interact-eu.net/downloads/138/Presentation\\_Process\\_of\\_Monitoring\\_of\\_Impacts\\_INTERACT.pdf](http://admin.interact-eu.net/downloads/138/Presentation_Process_of_Monitoring_of_Impacts_INTERACT.pdf) харах



**Хүснэгт 5. 4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний загвар<sup>32</sup>**

Бид яаж түүнийг мэдэх вэ?	Мэдээллийг хаанаас олох вэ? (Мэдээллийн эх сурвалж, арга)	Хэн мэдээллийг олж авах вэ? (Чиг үүрэг)	Мэдээллийг хэзээ олж авах вэ? (Хугацааны хүрээ)	Өртөг, зардлын тооцоо	Хэн оролцох вэ?	Хэнд мэдээлэх вэ?	Үнэлгээг хэзээ хийх вэ?
---------------------------	---	---	---	-----------------------	-----------------	-------------------	-------------------------

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ дараах алхмуудын дагуу гүйцэтгэнэ (Хүснэгт 5.5).

**Хүснэгт 5. 5 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шатууд<sup>33</sup>**

**Үе шат 1: Төлөвлөлт**

<b>Хяналт-шинжилгээ</b> (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	<b>Үнэлгээ</b> (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
<ul style="list-style-type: none"> <li>• Зорилго, зорилтын биелэлтийг үнэлэх, хяналт-шинжилгээ хийх аргыг тодорхойлох</li> <li>• Хугацааны хүрээг тогтоох,</li> <li>• Мэдээллийг олж авах төлөвлөлт, төсөвлөлт,</li> <li>• Мэдээллийн чиглэлийн ажилтны чиг, үүргийг тодорхойлж, чиг үүргээ биелүүлэхийг шийдвэрлэх,</li> <li>• Хяналт-шинжилгээ хийх ахицын үзүүлэлтийг боловсруулах (гарцад илүү анхаарч, ихэнхдээ тоон үзүүлэлт).</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний зорилгыг тодорхойлох (нийгмийн хөгжил, хяналт-шинжилгээ, зохицуулалт, уялдаа холбоо, хариуцлага, ил тод байдлыг хангах, мэдлэг буй болгох түүнийг хуваалцах, удирдлага, зохион байгуулалтын дэмжлэгийг сайжруулах, оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих),</li> <li>• Шардлагатай мэдээлэл, эх сурвалжийн сонголтыг тодорхойлох,</li> <li>• Судалгааны хүрээг тодорхойлох,</li> <li>• Түүврийг тогтоох,</li> <li>• Үнэлгээний багийг сонгох,</li> <li>• Судалгааны логик хүрээг тодорхойлох,</li> <li>• Зорилго, зорилтод тулгуурлан биелэлтийн үзүүлэлтийг боловсруулах,</li> <li>• Мэдээлэл цуглуулах давтамж, хугацааг тодорхойлох,</li> <li>• Үнэлгээний төсвийг тооцох (цалин, томилолт, зөвлөхийн зардал, тээвэр, холбоо, хэвлэлт, олшруулах, бусад зардал).</li> </ul>

<sup>32</sup> Эх сурвалж: Тогтвортой хөгжлийн төв, Викториа 2011, [http://www.evaluationtoolbox.net.au/index.php?option=com\\_content&view=article&id=20&Itemid=159](http://www.evaluationtoolbox.net.au/index.php?option=com_content&view=article&id=20&Itemid=159)

<sup>33</sup> Эх сурвалж: Хяналт-шинжилгээ, үнэлгээний системийн гарын авлага, N.Welsh et al, Joint UNDP, IUCN, MRC, GEF-funded Programme, Вентиян, 2005.





### Үе шат 2: Бэлтгэл

Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
<ul style="list-style-type: none"> <li>Мэдээлэл цуглуулах маягт, шалгалт,</li> <li>Хяналт-шинжилгээ хийх ажилтныг сургах,</li> <li>Хяналт-шинжилгээний тогтолцооны талаар ажилтанд мэдээлэх,</li> <li>Үйл ажиллагааны заавар боловсруулах,</li> <li>Оролцогчдыг оролцуулан техникийн ажлын даалгаврыг бэлтгэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний төрөл (урьдчилсан, хэрэгжилтийн явцын, төгсгөлийн, төслийн, үр дагаврын, нөлөөллийн, сэдэвчилсэн, үйл ажиллагааны дарааллын, мета үнэлгээ) –ийг сонгох</li> <li>Мэдээлэл цуглуулах хэрэгслийг зохиох (судалгааны маягт, ярилцлагын удирдамж, асуулгын хуудас, шалгах хуудас, баримт бичиг, судалгаа, ажиглалт, фокус групп, жишээ судалгаа),</li> <li>Мэдээлэл цуглуулах хэрэгслийг урьдчилан турших, сайжруулах,</li> <li>Түүврийг хэрхэн сонгохоо шийдэх,</li> <li>Бэлтгэл үнэлгээ, үнэлгээний багийн үүргийг тодорхойлох,</li> <li>Үнэлгээний ажилтныг сургах,</li> <li>Холбогдох бэлэн баримт бичгийг цуглуулах, бүртгэх.</li> </ul>

### Үе шат 3: Мэдээлэл цуглуулах

Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
<ul style="list-style-type: none"> <li>Тохиролцсон мэдээллийг тогтмол хугацаанд газар дээр очих болон байнгын хяналт-шинжилгээ цуглуулах,</li> <li>Системийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх,</li> <li>Хяналт-шинжилгээний мэдээллийн бааз байгуулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Газар дээрх үнэлгээ зохион байгуулах,</li> <li>Оролцогч талын оролцоог хангах,</li> <li>Байгаа мэдээлэл(төлөвлөгөө, тайланг, санал)-ийг цуглуулах, судлах,</li> <li>Үнэлгээний объектыг сонгох (өрхийг сонгох),</li> <li>Ярилцлага авах (ажиглалт),</li> <li>Мэдээллийн боловсруулалтыг эхлэх.</li> </ul>

### Үе шат 4: Шинжилгээ, дахин хянах

Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
<ul style="list-style-type: none"> <li>Цуглуулсан мэдээллийг тохиролцсон үзүүлэлттэй харьцуулах, зөрүүг тэмдэглэх,</li> <li>Бусад асуудлыг тодорхойлох,</li> <li>Аливаа асуудлын шалтгааныг хайх, арга хэмжээний хувилбарыг тодорхойлох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээллийг хүснэгт хэлбэрт оруулах,</li> <li>Үр дүнг хөрвүүлэх тайлбарлах, дүгнэлт хийх,</li> <li>Зөвлөмж дээр тохиролцох,</li> <li>Гол мэдээлэгч нартай шинжилгээг дахин хянах.</li> </ul>

### Үе шат 5: Үр дүнг тайлагнах

Хяналт-шинжилгээ (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	Үнэлгээ (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
<ul style="list-style-type: none"> <li>Мэдээлэл, олдворыг баримтжуулах,</li> <li>Удирдлага, хэрэгжүүлэгчид танилцуулах,</li> <li>Нийт оролцогч талуудад улирлын нэгдсэн мэдээ болон хагас жилийн хэрэгжилтийн тайланг мэдээлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээллийг хүснэгт, графикт нэгтгэх,</li> <li>Эцсийн тайлан бичих,</li> <li>Үнэлгээний чанарын баталгаа гаргах.</li> </ul>



## Үе шат 6: Үр дүнг ашиглах

<b>Хяналт-шинжилгээ</b> (Бодит гарцыг төлөвлөсөнтэй харьцуулна)	<b>Үнэлгээ</b> (Үр дагавар, үр нөлөөг хэмжинэ)
<ul style="list-style-type: none"> <li>Удирдлага, хэрэгжилтийн бодлогыг сайжруулахад үр дүнг хэрэглэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тэргүүлэх чиглэлийн үнэлгээний үр дүнгээр тодорхойлох,</li> <li>Тэргүүлэх арга хэмжээ өөрчлөлтийг төлөвлөх,</li> <li>Үнэлгээний үр дүн, авсан сургамж, зөвлөмжийг олон нийтэд нээлттэй болгох веб хуудастай болох, байршуулах,</li> <li>Оролцогч талуудын хурлыг зохион байгуулах, шинжлэх ухааны сэтгүүл, ном, хэвлэл, хурал, зөвлөлгөөний үер тараах.</li> </ul>

### 5.5 Хяналт-шинжилгээний мэдээллийн хүснэгт

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь үндсэн үзүүлэлтийн мэдээллийг цуглуулахыг шаарддаг. Хөтөлбөрүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх тогтолцоо нь “төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэсэн гурван бүлгийг нэгтгэсэн хэд хэдэн мэдээллийн хүснэгт бүхий тайлангуудаас бүрдэнэ.

Мэдээллийн хүснэгт нь мэдээлэл цуглуулах, тайлагнах стандарт арга байх бөгөөд хяналт-шинжилгээ хийж, эцсийн үр нөлөөнд үнэлгээ өгөх үүрэгтэй. Эдгээр маягыг санхүүгийн, аудитын, хүний нөөцийн гэсэн бусад тайлагнах үйл ажиллагаатай холбоотойгоор хамт хэрэглэнэ.

Ийм хүснэгтүүдийг “хяналт-шинжилгээ, үнэлгээ” болон судалгаа хийх зэрэг үйл ажиллагаанд стандартчилан хэрэглэж байна. Мэдээллийн хүснэгтийн загвар жишээг А1 - А10 хүснэгтүүдээр үзүүллээ. Тухайн тохиолдол, агуулгаас хамаарч эдгээр хүснэгтийг өргөжүүлэн, баяжуулан хэрэглэж болно. Төслийн хяналт-шинжилгээ хийх мэдээллийн 10 хүснэгтийг, товч тайлбарын хамт үзүүллээ.<sup>34</sup> Үүнд:

- а) Хүснэгт А1 нь Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 зорилго бүхий жишээг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн хамт харуулав.
- б) Хүснэгт А2 нь яам, агентлагийн төлөвлөгөөний хоёр зорилгын хувьд зорилтот түвшин, ахиц, биелэлтийг шаардлагатай төсөв, түүний зардлын гүйцэтгэлийг 2 зорилгын жишээний хамт үзүүлэв.
- в) Хүснэгт А3 нь салбарын яам, агентлагийн хэрэгжүүлж буй хоёр хөтөлбөрийн жишээгээр зохих мэдээг шаардагдах төсөв, түүний гүйцэтгэлийн хамт харуулав.
- г) Хүснэгт А4 нь хөтөлбөр доторхи хоёр дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны жишээгээр мэдээг шаардагдах төсөв, түүний гүйцэтгэлийн хамт харуулав.

<sup>34</sup> <http://mop.gov.kh> дээр тухайн хүснэгтүүдийн илүү олон ерөнхий хувилбаруудыг харж болно..



- д) Хүснэгт А5 нь хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгтгэсэн мэдээллийг гаргаж ашиглахад зориулагдав. Энэ нь яамны удирдлагын түвшин, хяналт, шалгалтад хэрэглэхэд зориулагдсан.
- е) Хүснэгт А6 ба А7 нь дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээг 6 сараар хийх (тайлбар, төсвийн хамт) жишээгээр харуулав.
- ж) Хүснэгт А8 ба А9 нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг нэг жилээр хийхийг (тайлбар, төсвийн хамт) жишээгээр харуулав.
- з) Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны ахиц, өөрчлөлтийн мэдээлэл олж авахад газар дээр нь очиж танилцах явдал чухал ач холбогдолтой байдаг. Үүнийг үйл ажиллагааны явцад дээд байгууллагаас асуудал хариуцсан ажилтан хийнэ. Салбар болон үйл ажиллагаа, төслийн онцлогоос хамаарч давтамжийг тогтооно. Хүснэгт А10 нь үйл ажиллагаанд хяналт-шинжилгээг хийхдээ газар дээр нь очиж танилцсан талаарх тайлангийн хүснэгт юм.



<b>Хүснэгт А1: Дунд хугацааны төлөвлөгөөний зорилтууд – Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</b>				
<b>ЗОРИЛТОТ ТҮВШИН</b>				
	Он 1	Он 2	Он 3	Он 4
Зорилго 1: Цалинтай ажлын байр бий болгох				
Төлөвлөсөн үйл ажиллагаа	1. Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого: Ноос, ноолуур, арьс шир, мал аж ахуй, аялал жуулчлал, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх 2. Бизнес хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого			
Зорилтот түвшин, Шалгуур үзүүлэлтүүд				
Зорилго 2: Эрүүл мэндийг сайжруулах				
Төлөвлөсөн үйл ажиллагаа	ЭМ даатгалын хамралтыг нэмэгдүүлэх (ялангуяа ядуу хүмүүс), чанартай оношлогоо, шинжилгээ хийх, эмийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлийг бууруулах			
Зорилтот түвшин, Шалгуур үзүүлэлтүүд				
Зорилго 3: Хүний нөөц, чадавхийг бэхжүүлэх				
Төлөвлөсөн үйл ажиллагаа	Дээд боловсролын чанарыг сайжруулах, МСҮТ-ийг бэхжүүлэх, дунд боловсролын шинэ стандарт боловсруулах, соёл, урлаг, спорт дэмжих, Монгол Улсын уламжлалыг өвлүүлэн үлдээх			
Зорилтот түвшин, Шалгуур үзүүлэлтүүд				
Зорилго 4: Үндэсний аюулгүй байдлыг хангах				
Төлөвлөсөн үйл ажиллагаа	Байгаль орчныг цэвэрлэхэд туслах, замын түгжрэлийг бууруулах, хувийн хаусыг дэмжих (нэгдсэн хаягийн системтэй), газрын шинэчлэлийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, Туул голын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлан хамгаалах бодлогыг бэхжүүлэх, энх тайвны төлөөх гадаад бодлогыг дэмжих			
Зорилтот түвшин, Шалгуур үзүүлэлтүүд				
Зорилго 5: Ардчилал, ил тод байдлыг нэмэгдүүлэх				
Төлөвлөсөн үйл ажиллагаа	Төрийн үйлчилгээг сайжруулах, улс төрийн намыг төлөвшихөд туслах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах, бизнесийн орчин, э-засаглал, стандартыг сайжруулах, авлигыг бууруулах			
Зорилтот түвшин, Шалгуур үзүүлэлтүүд				
Тайлбар:				

Хүснэгт А1-ийг бөглөх заавар: 1.ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь энэхүү мэдээллийн хүснэгтийг бөглөх үүрэгтэй.

2.Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь улсын хэмжээний судалгааны мэдээлэл байх тохиолдолд уг судалгааг явуулсан байгууллагууд нь мэдээллийн үнэ цэнийг батлах ёстой.



3.Хэрвээ мэдээллийг харьцуулахад хугацаа нь өөр байвал эх сурвалжуудыг нь тайлбарлаж өгөх хэрэгтэй.

4.Суурь жил нь үргэлж төлөвлөгөө эхэлсэн жил байна. Хэрвээ уг мэдээлэл хангалттай судалгаа хийгдээгүй байвал орлох мэдээлэл болон тодорхой тайлбарын хамт өгнө.

<b>Хүснэгт А2: ЯАМ, АГЕНТЛАГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТОТ ТҮВШИН БА БИЕЛЭЛТ</b>				
<b>ЗОРИЛГО</b>				
	Он 1	Он 2	Он 3	Он 4
<b>Зорилго 1: Даатгалын тогтолцоонд шинэчлэл хийх</b>				
Үзүүлэлт (үүд)				
Гүйцэтгэл				
Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
<b>Зорилго 2: Иргэн бүрт чанартай оношлогооны үйлчилгээг хүргэх</b>				
Үзүүлэлт (үүд)				
Гүйцэтгэл				
Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
<b>Зорилго 3: Ядуу хүмүүсийг эрүүл мэндийн даатгалд хамруулах</b>				
Үзүүлэлт (үүд)				
Гүйцэтгэл				
Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
<b>Зорилго 4: Импортын эм, хүнсний аюулгүй байдлыг хангах</b>				
Үзүүлэлт (үүд)				
Гүйцэтгэл				
Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
<b>Зорилго 5: Монгол хүний эрүүл мэндийн эрсдлийг бууруулах</b>				
Үзүүлэлт (үүд)				
Гүйцэтгэл				
Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
Тайлбар:				

Хүснэгт А2-ыг бөглөх заавар:

1. Энэхүү мэдээний маягт нь үр дагаврын үзүүлэлтийг харуулна. Энэхүү мэдээллийг бүх яамд, агентлагууд гаргаж өгнө.
2. Мэдээлэл цуглуулсан аргаа тодорхой дурдсан байх хэрэгтэй. Хэрвээ мэдээлэл нь яам, агентлагийн бус эх үүсвэртэй бол үндэслэлийг нь дурдсан байх шаардлагатай. Мэдээлэл эмхэтгэлийн давтамжийг мөн дурдсан байна. Энэ бүхнийг хүснэгтэд заасан тайлбар мөрөнд бичих ёстой.
3. Хэмжих нэгж нь тайлбар шаардана. Хэрвээ шалгуур үзүүлэлт нь харьцааны үзүүлэлт бол хуваарь болон хүртвэр хоёуланг нь мэдээллийн эх сурвалжийн хамт тусгасан байна.
4. Тав дугаар мөрөнд жилийн төсвийн хуваарилалтыг оруулж өгнө. Сангийн яам нь зөвхөн нэг жилийн төсвийг баталдаг бөгөөд дараах жилүүдийн төсвийн санхүүжилтийг тодорхой арга, аргачлалын дагуу оруулж өгнө.



<b>Хүснэгт А3: Хөтөлбөр: Эрүүл мэндийн зорилго, зорилтот түвшин ба үйл ажиллагаа (Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн эрсдлийг бууруулах)</b>				
Хөтөлбөрийн нэр: Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах - Тайлбар: Ахмад настан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх - Дэд хөтөлбөрийн тоо (жагсаах): Хоёр - Уялдаа холбоо бүхий зорилго, зорилтуудыг уялдуулна. (Хүснэгт А3-ыг дунд хугацааны төлөвлөгөөний зорилтууд болон яамны төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулна. Хүснэгт А1-ийн зорилго 2, А2 –ийн зорилго 5-тай адил байна.) - Хэрэгжиж буй/ Шинэ (✓ хийх) Тийм				
	Он 1	Он 2	Он 3	Он 4
Хөтөлбөрийн зорилтот түвшин				
Гүйцэтгэл				
Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
Тайлбар:				

**Хүснэгт А3-ыг бөглөх заавар:**

1. Энэ мэдээллийн маягтыг хөтөлбөр тус бүрт нь бөглөнө. Харин өмнөх төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй хөтөлбөр эсвэл шинэ хөтөлбөр эсэхийг шалгах хэрэгтэй.
2. Зорилтыг 1-3 өгүүлбэрт зорилго, түүнд хүрэх арга зам (хөтөлбөрийн дэд хөтөлбөрийг хамтад нь оруулан)-ыг хураангуй бөгөөд тодорхой бичиж өгнө.
3. Хөтөлбөр бүр дөрвөн жилийн зорилтот түвшинтэй байх ёстой бөгөөд энэ нь жил бүрт хуваагдана.
4. Зорилтот түвшинг хэмжих нэгжийг зааж өгнө. Хэрвээ зорилтот түвшин харьцуулсан үзүүлэлт бол харьцуулсан үзүүлэлтүүдийг бичиж өгнө. Мэдээллийн эх сурвалж болон мэдээлэл цуглуулах аргыг заавал оруулж өгөх хэрэгтэй. Тухайлбал, дэд хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэсэн эсвэл анхан шатны судалгаа явуулсан гэдгийг заавал хэлж өгнө. Хэрвээ судалгаа явуулсан бол хамруулсан хүрээ, төлөөлөл, хязгаарлалт, мэдээлэл цуглуулах давтамж зэрэг бүх тайлбар мэдээллийг “Тайлбар” гэсэн мөрөнд бичиж өгнө.
5. Хэрэгжүүлэгч агентлаг нь энэ мэдээллийг жил бүр бөглөж явуулна.



<b>Хүснэгт А4: Дэд хөтөлбөрийн мэдээлэл - Нэг хөтөлбөр, хоёр дэд хөтөлбөр</b>				
<b>Дэд хөтөлбөр 1.1: Ахмад настан</b>				
-Хөтөлбөртэй холбоотой байдлыг дурдах: Хүснэгт ДЗ-ын "Ахмад настан"				
-Зорилт: Ахмад настны эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх				
-Тодорхойлолт: Ахмад настны эрүүл мэндийн төвүүдийг сайжруулах, эрүүл урт наслалтыг дэмжих (үндэсний хөтөлбөр)				
-Үйл ажиллагааны тоо/ төслүүд (жагсаах): хоёр				
-Хэрэгжиж байгаа/ Шинэ (✓ хийх): Шинэ				
<b>Дэд хөтөлбөр 1.2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд</b>				
- Хөтөлбөртэй холбоотой байдлыг дурдах: Хүснэгт АЗ-ын "Хөгжлийн бэрхшээлтэй иргэд"				
- Зорилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ, хамгааллыг өргөжүүлэх				
- Тодорхойлолт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвүүдийг сайжруулах				
- Үйл ажиллагааны тоо/ төслүүд (жагсаах): нэг				
- Хэрэгжиж байгаа/ Шинэ (✓ хийх): Шинэ				
	(6 эсвэл 3-сараар) Он 1	(6 эсвэл 3-сараар) Он 2	(6 эсвэл 3-сараар) Он 3	(6 эсвэл 3-сараар) Он 4
Дэд хөтөлбөр 1.1 Зорилтот түвшин (үзүүлэлт)				
Гүйцэтгэл				
Дэд хөтөлбөр 1.1 Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
Дэд хөтөлбөр 1.2 Зорилтот түвшин (үзүүлэлт)				
Гүйцэтгэл				
Дэд хөтөлбөр 1.2 Төсөв				
Зардлын гүйцэтгэл				
Тайлбар:				

Хүснэгт А4-ийг бөглөх заавар:

1. Үндэсний хөтөлбөрийн бүрэлдэхүүн нь дэд хөтөлбөрүүд бөгөөд хөтөлбөрийн мөчлөгтэй шууд холбоотой (зогсоосон хөтөлбөрийн хувьд богино) байна. Энэ хүснэгт дэд хөтөлбөр бүрт бөглөгдөнө.
2. Зорилт, түүнд хэрхэн хүрэх арга замыг 1-3 өгүүлбэрээр товч тодорхой бичнэ.
3. Зорилтот түвшинг хэмжих нэгжийг зааж өгнө. Зорилтот түвшин харьцуулсан үзүүлэлт бол харьцуулсан үзүүлэлтүүдийг хэлж өгнө. Мэдээллийн эх сурвалж болон мэдээлэл цуглуулах аргыг заавал оруулж өгөх хэрэгтэй. Тухайлбал, дэд хөтөлбөрийн захиргааны мэдээллийг нэгтгэсэн эсвэл анхан шатны судалгаа явуулсан гэдгийг заавал хэлж өгнө. Хэрвээ судалгаа явуулсан бол хамруулсан хүрээ, төлөөлөл, хязгаарлалт, мэдээлэл цуглуулах давтамж зэрэг бүх тайлбар мэдээллийг "Тайлбар" гэсэн мөрөнд бичиж өгнө.
4. Энэ мэдээллийн хүснэгтийг хэрэгжүүлэгч байгууллага хагас жил (дэд хөтөлбөрөөсөө хамааран 3 эсвэл 6 сар) бүр бөглөнө.
5. "Тайлбар" гэсэн мөрөнд дээд шатны байгууллагаас санхүүжилт саатсанаас болж зарцуулалт бага гарсан гэх зэрэг тайлбар байж болно.



<b>Хүснэгт А5: Зорилтот түвшний биелэлт</b>												
<b>Зорилго/ Зорилтот түвшин</b>	<b>Он 1</b>			<b>Он 2</b>			<b>Он 3</b>			<b>Он 4</b>		
	<b>З</b>	<b>Б</b>	<b>Төсвийн зарцуулсан хувь</b>	<b>З</b>	<b>Б</b>	<b>Төсвийн зарцуулсан хувь</b>	<b>З</b>	<b>Б</b>	<b>Төсвийн зарцуулсан хувь</b>	<b>З</b>	<b>Б</b>	<b>Төсвийн зарцуулсан хувь</b>
Хөтөлбөр 1												
-Дэд хөтөлбөр 1.1												
Үйл ажиллагаа 1.1.1												
Үйл ажиллагаа 1.1.2												
-Дэд хөтөлбөр 1.2												
Үйл ажиллагаа 1.2.1												
Үйл ажиллагаа 1.2.2												
Хөтөлбөр 2												
-Дэд хөтөлбөр 2.1												
Үйл ажиллагаа 2.1.1												
Үйл ажиллагаа 2.1.2												
-Дэд хөтөлбөр 2.2												
Үйл ажиллагаа 2.2.1												
Үйл ажиллагаа 2.2.2												

З - зорилтот түвшин, Б - биелэлт

**Хүснэгт А5-ыг бөглөх заавар:**

1. Энэ хүснэгт нь өмнөх хүснэгтүүдийн мэдээллийг нэгтгэсэн хүснэгт юм. Давчуу цаг хугацаанд боловсруулсан жилийн хэрэгжилтийн гүйцэтгэлийг нэгтгэн гаргахдаа алдаа мадаггүй, сайтар хянасан байх шаардлагатай.

2. Янз бүрийн шатны мэдээллийг дээд түвшиндээ нэгтгэн тайлбарлахдаа анхааралтай хандах ёстой. Жишээ нь дэд хөтөлбөрийн болон доод шатанд сургуулийн барилга баригдсаныг яаран зорилт бүрэн биеллээ гэж үзэж болохгүй. Өөрчлөлтийн онолоор авч үзвэл амжилттай үр дагаварт хүрэх олон үйл ажиллагаануудад саад бэрхшээл нэлээд байж болох тул яаран дүгнэлт хийхээс аль болох зайлсхийх хэрэгтэй.





<b>Хүснэгт А6: Дэд хөтөлбөрийн хяналт-шинжилгээ – Тайлбар болон төсөв (Хагас жилээр – Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн эрсдлийг бууруулах)</b>									
Дэд хөтөлбөр болон зорилтуудыг давтах									
Зорилтот түвшинд хүрсэн/хүрээгүй гол асуудлуудыг дурдах									
Үйл явцын/ хууль эрх зүйн:									
Хөрөнгийн зардлын нөөц:									
Засвар, үйлчилгээ:									
Хүний нөөц (сургалтыг оруулан):									
Ханган нийлүүлэлт:									
Дэд хөтөлбөрийн загвар:									
Гадаад хүчин зүйл:									
Бусад (тодорхойлох):									
<b>Хүснэгт А7: Хөтөлбөрийн - Төсвийн мэдээ</b>									
1 дэх жилийн төсөв				2 дахь жилийн төсөв			3 дахь жилийн төсөв		
	ТЗ	Г	Гүйцэтгэлийн төсөвт эзлэх хувь		Г	Гүйцэтгэлийн төсөвт эзлэх хувь		Г	Гүйцэтгэлийн төсөвт эзлэх хувь
Хөтөлбөр. АХМАД НАСТАН БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ									

ТЗ = төсөвлөсөн зардал; Г = Гүйцэтгэл

**Хүснэгт А6-г бөглөх заавар:**

1. Энэ хүснэгтийг хөтөлбөр бүрт бөглөнө.
2. Төслийн хэрэгжилтэд нөлөөлөх долоон хүчин зүйл болох үйл явцын асуудал, холбогдох хоцрогдол, төсөлд шаардлагатай нөөцийн хомсдол, үйл ажиллагааны нөөцийн хомсдол, хүний нөөцийн асуудал, материалын ханган нийлүүлэлт, цаг тухайд нь гарч ирэх асуудлууд, төслийн үр дүнгүй загвар болон бусад асуудлуудыг тодорхойлж өгнө.
3. Хүснэгт А7-д төсөвлөсөн зардал, гүйцэтгэлийг оруулна. Эдгээр мэдээлэл нь дэд хөтөлбөрийн санхүү, аудитын тайланд өгсөн мэдээлэлтэй адил байна.



<b>Хүснэгт А8: Дэд хөтөлбөрийн хяналт-шинжилгээ- тайлбар (Жилээр, дэд хөтөлбөрийн жишээ, АХМАД НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ)</b>
Дэд хөтөлбөр: Ахмад настны эрүүл мэндийн асуудал. Тухайлбал: ахмад настны эмнэлэг барих, ахмад настанд хөнгөлөлттэй үнээр эмчилгээ, хоол тэжээл өгөх.
Зорилтот түвшинд хүрсэн/хүрээгүй гол асуудлуудыг дурдах:
Үйл явцын Хууль эрх зүйн:
Хөрөнгийн зардлын нөөц:
Засвар, үйлчилгээ:
Хүний нөөц (сургалтыг оруулан):
Ханган нийлүүлэлт:
Дэд хөтөлбөрийн загвар:
Гадаад хүчин зүйл:
Бусад (тодорхойлох):

<b>ХҮСНЭГТ А9: Дэд хөтөлбөрийн - төсвийн мэдээлэл</b>						
	1-6 дахь сарын төсөв			7-12 дахь сарын төсөв		
	ТЗ	Г	Гүйцэтгэлийн төсөвт эзлэх хувь	ТЗ	Г	Гүйцэтгэлийн төсөвт эзлэх хувь
Дэд хөтөлбөр: Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах						

ТЗ = төсөвлөсөн зардал; Г = Гүйцэтгэл

Хүснэгт А7, А8, А9-ийг бөглөх заавар:

1. Энэ хүснэгтийг дэд хөтөлбөр бүрээр бөглөнө.
2. Хүснэгт А9-д төлөвлөсөн төсөв, гүйцэтгэлийг оруулж өгнө. Эдгээр тоо нь дэд хөтөлбөрийн санхүүгийн болон аудитын тайланд өгсөн мэдээлэлтэй адил байна.



<b>Хүснэгт А10: дэд хөтөлбөрийн газар дээрх томилолтын нэгтгэл (Эрүүл мэндийн байгууламж, давтамж 3 сар бүр)</b>	
	Дэд хөтөлбөр: Эрүүл мэндийн байгууламж
Тодорхойлсон зөрүү:	
Горимын ба хууль эрх зүйн:	
Хөрөнгийн зардлын нөөц:	
Засвар, үйлчилгээ:	
Хангамж:	
Хүний нөөц :	
Гадаад хүчин зүйлүүд :	
Төслийн загвар:	
Бусад (тодорхойлох):	
Зөвлөмж:	

**Хүснэгт А10-ыг бөглөх заавар:**

1. Газар дээр нь хийсэн томилолтыг бүх дэд хөтөлбөр, үйл ажиллагааны дагуу явуулахгүй.
2. Эрх бүхий байгууллагаас нэгээс илүү газар дээрх томилолтыг явуулж болно. Хэд хэдэн томилолтын хураангуй мэдэгдлийг хамтад нь нэгтгэн боловсруулах хэрэгтэй. Энэ хураангуй тайланг нь дэд хөтөлбөрийн түвшинд цуглуулна.



## Шигтгээ 5.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл цуглуулах, удирдах хяналтын хуудас<sup>35</sup>

### Хүний нөөц, чадавхи

-Яам нь хөтөлбөр, дэд хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүтэц зохион байгуулалт, орон тоогоо тодорхойлсон байна.

-Энэ ажлын байрны тодорхойлолтод хяналт-шинжилгээ, үнэлгээний үүрэг, тавих шаардлагыг нарийвчлан заасан байна.

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний үүрэг хүлээсэн ажилтан нь техникийн дэмжлэг авах, сургалтад хамрагдах боломжоор хангагдсан байх ба яамны бусад нэгжийн ажилтантай харилцан хамтран ажиллана.

-Яам, хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хувьд шийдвэр гаргахад хяналт-шинжилгээ, үнэлгээний шаардлагатай мэдээллээр хангах асуудал хариуцсан даргатай байна.

### Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

-Яам нь хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөтэй байна. Дэд хөтөлбөр бүрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө нь хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөтэй, эдгээр нь яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөтэй уялдсан байна.

-Дэд хөтөлбөр/хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулахад ажилтан бүр оролцоно.

-Яам, хөтөлбөр, дэд хөтөлбөрийн үр дагавар, гарц нарийн боловсруулагдаж, шалгуур үзүүлэлтүүдтэйгээ уялдсан байна.

-Шалгуур үзүүлэлтүүд нь (хүйс, бүс нутаг, бусад) ангилагдан бүрэн тодорхойлогдсон, суурь он болон зорилтот түвшинг тогтоосон байна.

-Бүх шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цуглуулах аргыг зааж, эх үүсвэрийг тодорхойлж өгсөн байна.

-Бүх шалгуур үзүүлэлтийн хувьд мэдээлэл цуглуулах давтамжийг зааж өгсөн байна.

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын жилийн төлөвлөгөөтэй байна. (Үүнд: хяналт-шинжилгээ, үнэлгээний тэргүүлэх ажлыг дурдаж, хүлээх үүрэг хариуцлага, төсөв зардал, гарцыг гаргах хугацааг тодорхойлсон байна)

-Мэдээлэл цуглуулах үүргийг тодорхой зааж өгнө.

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний зардлыг тооцон, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бэлэн байлгана.

### Байнгын хяналт-шинжилгээ

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь холбогдох шалгуур үзүүлэлтийн (жишээ нь, орц, үйл явц болон гарц) мэдээллийг цуглуулна.

-Байгаа мэдээллийн бааз эсвэл бусад эх үүсвэрээс мэдээлэл бэлэн олдох боломжтой.

-Төрийн байгууллага бүр (жишээ нь, сургууль, аймаг, сум) мэдээлэл цуглуулахдаа хяналт-шинжилгээний тогтсон шалгуур үзүүлэлтийн нэг л тодорхойлолтыг ажилтнууд ашиглана.

-Янз бүрийн байгууллагын цуглуулсан мэдээллийг мэдээллийн стандарт маягтад оруулна.

-Мэдээллийн үнэн зөв байдал, цаг хугацааг хянан нягталж, нэгтгэхээс өмнө алдааг засна.

-Мэдээллийн алдааг залруулах үйл явцтай байна.

-Мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.(Жишээ нь хугацааны явцын өөрчлөлтийг харьцуулах, зорилтот үзүүлэлтийг бодит гүйцэтгэлтэй харьцуулах гэх мэт)

### Мөчлөгт судалгаа

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь тусгай шалгуур үзүүлэлтүүдийг гаргахад давтамжтай судалгааг явуулна.

-Үр шим хүртэгчид/ оролцогч талуудын байр суурийг хүлээж авна.

-Түүврийн зохистой хэмжээг тодорхойлсноор үр дүнг нарийвчлан нэгтгэнэ.

-Хандлагын шинжилгээг хийх боломжтой судалгааны хугацааг зохимжтойгоор тодорхойлно.

-Алдаа гарах, аль нэг талыг барьсан байхаас сэргийлж хяналтыг бүрдүүлсэн байна.

### Мэдээллийн бааз

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний систем нь аргын хувьд, мөн хадгалах, мэдээллийг хэвлэх, дахин гаргах зэргээр бүрэн цахимжсан байна.

<sup>35</sup> Эх сурвалж: <http://siteresources.worldbank.org/NUTRITION/Resources/Tool8-annex3.pdf> ба <http://mop.gov.kh> – с авав.



-Мэдээллийн баазыг ажиллуулахад мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, нийлүүлэлт бүгд бэлэн байна.  
-Мэдээлэл зөв орсныг баталгаажуулах чанарын хяналтын механизм бүрдсэн байна.  
-Мэдээллийн баазыг ажиллуулах, шинэчлэх хүний нөөц болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтэц бүрдсэн байна.

**Чанарын хяналт**  
-Дэмжлэг үзүүлэх хяналттай байна.(Жишээ нь: сумын түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо хэрхэн ажиллаж буйг засгийн газрын түвшний хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан газар дээр нь очиж үзнэ).  
-Дэмжлэг болох хяналтын үр дүнг бүртгэж, түүнд саналаа өгсөн байна.  
-Мэдээллийн удирдлагын үйл явцын бүрэн бүтэн байдал, зөв байдлыг нягтлах мэдээллийн аудитын үйл явц тогтсон байна. (Жишээ нь, газар дээр нь шалгах, дотоод уялдааны шалгалт)  
-Мэдээллийн аудитын үр дүнг тайлагнаж, аудитын саналаа холбогдох байгууллагуудад эргэж танилцуулсан байна.

**Үнэлгээ**  
-Тусгай шалгуур үзүүлэлтийн мэдээлийг цуглуулах үнэлгээг төлөвлөсөн байна.  
-Төлөвлөсөн үнэлгээнд шаардагдах санхүүгийн нөөц бэлэн байна.  
-Үнэлгээний үр дүнг тархааж хэлэлцүүлнэ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээг ашиглах нь**  
-Бүх оролцогч бүх талууд (мэдээлэл цуглуулагч нарыг оролцуулан)-ад тайланг тогтмол тараана.  
-Захирал, менежер болон бусад оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангасан мэдээлэл байна.  
-Шийдвэр гаргах үйл явцад хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийг ашиглана.

## ДАСГАЛ АЖИЛ

**Дасгал 1:** Нийгэм, эдийн засгийн судалгаагаар 2012 онд нийт өрхийн 20% нь эрүүл мэндийн үнэгүй буюу хөнгөлөлттэй үйлчилгээ авсан гэсэн дүн гаржээ. Энэ бодлого нь ядуурлын шугамаас доогуур (30% хүртэл) гэж тодорхойлогдсон бүх өрхийг оруулж болно гэж хараахан шийдээгүй байна. Энэ нь ойролцоогоор ядуурлын шугамнаас доогуур нийт өрхийн 10% нь үйлчилгээг авч чадахгүй байна гэсэн үг үү? Ярилцаж, өөрийн хариулыг тайлбарлана уу.

**Дасгал 2:** Амьжиргааны түвшний түүвэр судалгаа зэрэг үндэсний түвшинд нэгтгэсэн судалгаа нь тухайн орон нутгийн үр шим хүртэгчдийн аж байдлын үр нөлөөг үнэлж чадах уу?

## 5.6 Үнэлгээний аргачлал ба мэдээлэл

### 5.6.1 Зарчмууд

Үр дүнд суурилсан үнэлгээ нь дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

**Ач холбогдол:** Зорилго нь нөхцөл байдлын шинжилгээнд тодорхойлогдсон өнөөгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдэхэд чиглэгдэнэ.

**Үр дүн:** Үйл ажиллагаа нь төлөвлөсөн арга хэмжээ болон цаг хугацааны дагуу хэрэгжсэнийг үнэлэх ёстой.

**Үр ашиг:** Үнэлгээний үр дүн, үр дагавар, үр нөлөөг хангахын тулд ашигласан нөөц (ялангуяа санхүүгийн) холбоотой харьцааг тооцоолох бөгөөд анх төлөвлөсөн харьцаа нь адилхан байх ёстой.



**Хэрэглээ:** Үнэлгээний үр дүнг дээрх "Хамаарал"-ын хүрээнд тодорхойлсон асуудлуудыг шийдвэрлэх эсэхийг харуулах хэрэгтэй.

**Тогтвортой байдал:** Үнэлгээний үр дүнг тодорхой цаг хугацаанд нөөцийн хуваарилалт, санхүү, байгаль орчны талаас нь хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах байдлаар тусгасан байх ёстой.

Үнэлгээг өөр өөр түвшинд (болон нэгтгэсэн) төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх (эсвэл дууссаны дараах) үе шатанд явуулдаг. Хөтөлбөр нь эхлэхээсээ өмнө өөрийн дотоод уялдаа холбоог үнэлэх үнэлгээ хийх, шаардлагатай бол үйл ажиллагааны хэрэгжилтийн шатанд засаж сайжруулах зорилгоор дунд хугацааны үнэлгээ хийх, эсвэл хэрэгжилтийн эцсийн хугацааны үнэлгээ хийж болох юм.

#### Хүснэгт 5. 6: Үнэлгээний төрөл

Хэрэгжилтийн өмнөх	Дотоодын	Урьдчилсан
Явцын/ процесс	Нэгдсэн	Дунд хугацааны
Нэгтгэсэн	Гадаад/хөндлөнгийн	Эцсийн

#### 5.6.2 Үнэлгээний арга<sup>36</sup>

Үнэлгээний олон аргууд байдаг бөгөөд үүнээс түгээмэл хэрэглэгддэг гурван аргыг энд орууллаа. Үүнд: Эдийн засгийн хуваарилалтын арга, Стандарт зорилтот түвшний арга, буюу Оролцооны арга.

#### Эдийн засгийн хуваарилалтын арга

Нөөцийн хуваарилалтын арга буюу Зардал-өгөөжийн шинжилгээний арга нь төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үүднээс нөөцийн үр ашигтай ашиглалтыг авч үздэг. Төсөл, хөтөлбөрийн менежерүүд ихэвчлэн энэ аргыг ашигладаг. Бодлого боловсруулагчид, төлөвлөгчид ихээр хэрэглэдэг арга юм. Зардал-өгөөжийн шинжилгээг төсөл, хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд ашигладаг.

$$\text{Томъёо (1). Зардал, үр өгөөжийн шинжилгээ (санхүүгийн төсөл)} \\ = \sum \text{дууссаны дараах нийт үр өгөөж} - \sum \text{нийт зардал}$$

Өртөг: Бэлэн мөнгө, мөнгөн бус, биет болон биет бус санхүүгийн зардал  
Өгөөж: Тухайн төслөөс хамаарч өгөөж янз бүр байна.

Санхүүгийн өгөөжийн тооцооллыг хийхэд нийт өгөөжийн нийлбэрийн өнөөгийн үнэ цэнийг бодохдоо хорогдуулах хувь хэмжээг ашигладаг. Харин ослын бууралт,

<sup>36</sup> 'EVALSED: Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үнэлгээнд зориулсан аргачлал', Европын Холбоо, Брусел, 2013.



байгаль орчныг сайжруулах гэх мэт санхүүгийн бус өгөөжийн хувьд нэг төгрөгийн зардлаас гарах өгөөжийн харьцаагаар тооцно.

**Томъёо (2).** Нийгэм, байгаль орчны цэвэр үг өгөөж

$$= \sum \text{Нийгэм, байгаль орчны тохируулсан өгөөж} - \sum \text{Зардал}$$

Нийгмийн өгөөж нь (Томъёо 1-д) дээр тайлбарласантай адил ч ялгаа нь өгөөжийн хуваарилалтыг тооцдог: ядууст хир хүртээмжтэйг, байгаль орчны өгөөж нь нүүрстөрөгчийн сөрөг нөлөөг бууруулах гэх зэрэг шаардлагыг харгалздаг.

Зардал-үр өгөөжийн шинжилгээг мөнгөөр хэмжигддэг өгөөжөөс илүү мөнгөөр хэмжигдэхгүй өгөөжийг тооцоход ашигладаг. Хөтөлбөрийн үр дүн нь зарцуулсан нэгж мөнгөн дүнгээр хэмжигдэнэ. (Томъёо 3)

$$\text{Томъёо (3). } \frac{\text{Зардал}}{\text{Өгөөж}} = \frac{\text{Зарцуулсан мөнгөн дүн}}{\text{Мөнгөөр хэмжигдэхгүй нийт өгөөж}}$$

Жишээ нь: иймэрхүү харьцуулсан үзүүлэлт нь Х автын ослыг сэргийлэхэд хичнээн хэмжээний хөрөнгө зарцуулж болохыг тодорхойлох боломжтой.  
[С: Өртөг; В: Үр өгөөж]

Шигтгээ 5.5-д усны нөөц бүрдүүлэх төслийн санхүүгийн шалгуурын дагуу цэвэр санхүүгийн үр өгөөж юу болохыг үзүүлсэн байна. Гэсэн хэдий ч нийгмийн үр ашиг талаас нь харж дор дурдсан асуудлыг нэмж тооцох ёстой болно. Үүнд:

1. Ажлын байр бий болсон эсэх (эерэг – тоо өгөх)
2. Орлогын тэгш бус байдал үүссэн эсэх (сөрөг – тоо өгөх)
3. Хөдөө аж ахуйн хомсдол нэмэгдсэн эсэх - сөрөг

Энэ арга нь нэгэнт бүх үзүүлэлтийг тоогоор илэрхийлж чадахгүй байгаа учир олон тохиолдолд орлуулан тооцох замаар тэдгээрийн тус бүрийн мөнгөн утгаар нөлөөг бодож байна. Гэвч зарим тохиолдолд дээр дурдсан тэгшитгэл (3) шиг (ажлын байр нэмэгдсэн/зардал), (шилжилт хөдөлгөөн нэмэгдсэний улмаас цалин тодорхой хувиар өсөхгүй байх) гэх мэт харьцуулсан үзүүлэлтүүд байж болно.

#### **Стандарт, бусад зорилтот түвшний арга**

Стандарт буюу зорилтот түвшинд суурилсан арга нь урьдчилан тодорхойлсон шалгуурыг ашиглан амжилт, гүйцэтгэлийг үнэлэхэд оршино. Стандарт/ зорилтот түвшний арга нь нөөцийн зарцуулалт анхны зориулалтаар зарцуулсан эсэхийг



тодорхойлох хүсэлтэй шийдвэр гаргагчид, санхүүгийн оролцогч талууд болон Их хурлын гишүүдэд зориулагдсан. Үүнийг хүснэгт 5.7-д үзүүлсэн аргаар тооцно.

Хүснэгт 5.7 Стандарт, бусад зорилтот түвшний арга

Стандарт, бусад зорилтот түвшний арга				
Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Ашигт ажиллагаа	Утгын тайлбар	Зардлын үр ашиг
(1)	(2)	(3)	(4)	(5)
<b>Богино хугацаа</b>	Санхүүгийн болон бодит гарц	$\frac{\text{Гүйцэтгэл}}{\text{Төлөвлөсөн гарц}}$	80 ≤ Үр дүн ≤ 100 үр ашигтай, 50 ≤ Үр дүн ≤ 79 хангалттай биш, Үр дүн < 50 үр дүнгүй	$\frac{\text{Гарц}}{\text{Зардал}}$
<b>Дунд хугацаа</b>	Үр дагавар (үр нөлөө)	$\frac{\text{Гүйцэтгэл}}{\text{Төлөвлөсөн үр дагавар}}$		$\frac{\text{Үр дагавар}}{\text{Зардал}}$
<b>Урт хугацаа</b>	Үр нөлөө (үр дагавар)	$\frac{\text{Гүйцэтгэл}}{\text{Төлөвлөсөн үр нөлөө}}$		$\frac{\text{Үр нөлөө}}{\text{Зардал}}$

Шигтгээ 5.5-д тайлбарласан жишээний хүрээнд харвал энэ арга нь (3) баганад заасан харьцаа бүрийг тооцоход шаардлагатай. Жишээ нь нэгээс илүү үзүүлэлт (бодит нэмэгдсэн үйлдвэрлэл)/(урьдчилан таамагласан үйлдвэрлэл), (бодит орлого нэмэгдсэн)/(төлөвлөсөн орлогын нэмэгдэл), (ажлын байр бий болсон)/(төлөвлөсөн ажлын байр), эсвэл (ажил хайгчдын шилжилт хөдөлгөөн, гүйцэтгэл)/(төлөвлөсөн ажил хайгчдын шилжилт хөдөлгөөн) гэх мэт байж болох юм.

### Оролцооны арга

Доод шатнаас дээд шат руу чиглэсэн, олон нийт болон газар нутгийг хөгжүүлэхийг эрэлхийлж буй арга бол оролцооны арга юм.

Оролцооны үнэлгээ нь бүх оролцогч талуудыг хамтран үнэлгээний загварыг гаргаж, үнэлгээг явуулж, үр дүнг тайлбарлах арга юм. Энэ нь доод шатнаас дээд шат руу буюу иргэний нийгэм, орон нутгийн хүмүүсээр хэлэлцүүлж шийдвэр гаргах бөгөөд орон нутаг үнэлгээгээ иргэдийн саналд үндэслэн тавьсан асуудлаа дэмжиж, чадавхийг бэхжүүлнэ.

Шигтгээ 5.5-д харуулсан жишээн дээр дор хаяж хоёр хүн зөвлөлдөх хэрэгтэй. Нэгдүгээрт, (бичил) сав газрыг хөгжүүлснээр том болон жижиг хэмжээний газар эзэмшигчдийн ашиг хуваарилах талаар шийдвэр гаргахдаа оролцоог маш сайн хангах ёстой. Хоёрдугаарт, оролцооны үйл явц нь усжуулалтыг урсгал дагуу болон эсрэг хэрхэн хийх талаар шийдсэн байх ёстой. Түүнчлэн ялангуяа шилжилт хөдөлгөөний ачааллыг бууруулах үүднээс цалин хөлсний талаар хэлэлцүүлэг хийх шаардлагатай.





## Шигтгээ 5. 5: Хагас хуурай бүс нутаг дахь ус нөөцлөх төслийн үнэлгээ

Энэтхэгийн Засгийн газраас хур тунадас бага унадаг, гол мөрөнгүй, хөрс нь хад чулуурхаг болон ус нэвтрүүлдэггүй газар нутагт гүний усыг ашиглах зөвшөөрөл авч, газар тариалангийн үйлдвэрлэлийг хангах, ус хураах байгууламж барьж байна. Хэрэгжүүлсэн төслүүдийн дотор нь:

1. усалгааны зориулалтаар далан (борооны улиралд) барьж ургацыг жилд 2-3 дахин нэмэгдүүлэх төслүүд,
2. Борооны улиралд жижиг горхины ус налуу доош урсаж шүүгч саванд хуримтлагдаж, хуурай улиралд хөрсөнд нэвчиж, усжуулах төслүүд,
3. Хөрс рүү усыг шингээж аван, чийгийг нэмэгдүүлснээр газар тариалангийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор борооны улиралд усны урсгалыг удаашруулах төслүүд,

### Дүн шинжилгээ

(+) Үнэлгээний судалгаагаар газар тариалангийн үйлдвэрлэл нь туршилт хийгдэж байгаа бүх газарт өссөн гэсэн дүн гарчээ. Хүнсний ногоо, жимсний экспортын хэмжээ ч нэлээд нэмэгдсэн байна. Газар тариалангийн үйлдвэрлэл нэмэгдсэн нь цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг өсгөжээ. Зарим тохиолдолд хөдөө аж ахуй-үйлдвэрлэл (элсэн чихэр, тээрэм, хүнсний тос) бий болсон байна. Фермерийн болон фермерийн бус үйл ажиллагаа өргөжиж, хөдөлмөр эрхлэлт, орлого дорвитой өссөн байна. Тарьсан мод, бусад ургамлууд (хэсэг) нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг саармагжуулснаар барилгын мод болон малын тэжээлээр хангаж эхэлсэн байна.

(+/-) Ажилчид ажилдаа ирээгүйгээс тэдний цалин нэмэгдэхгүй байж болох учраас сонгогдсон бүс нутагт эдийн засгийн үйл ажиллагаа өссөн нь ажилчдыг татах шалтгаан болжээ. Тиймээс ядуурлыг бууруулах үйл явц удаашралтай байсаар байна.

(-) Цалингийн хэмжээ бага байгаа нь бүтээмж дээшлүүлэхэд зайлшгүй шаардлагатай механикжсан хөдөө аж ахуйг бий болгоход сөргөөр нөлөөлдөг.

(-) Тухайн бүс нутагт сайн усжуулалтын систем барих боломжгүй, жижиг аж ахуй нь өөрийн газраа зарж, хөлсний ажилчдын эгнээнд нэгдэн орсноор газрын үнийг өсгөсөн байна. Энэ нь цаашид цалингийн зардлыг өсгөжээ. Ингэснээр эдийн засгийн тэгш бус байдал нэмэгдсээр байна.

(-) Өндөрлөг газарт оршин сууж байгаа хүмүүс илүү ус цуглуулсан байхад нам хэсэгт өмнө нь авч байснаас бага ус цуглуулсан байна. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа суларч, алдагдсаны үр дүнд бүс нутгийн ялгаа нэмэгдсэн байна.

### Дүгнэлт

Ямар ч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эрэл хайгуул нь хуваарилалтын асуудлыг тооцох эсвэл бүс нутгийн ялгаатай талууд бүх давуу талуудыг биш ч гэсэн зарим нэгийг авч үзэх хэрэгтэй. Энэ эрэл хайгуул нь цаашид хөдөө аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх замын схемийг мөн зөвшөөрөөгүй байсан байна.

## 5.7 Хөтөлбөр, дэд хөтөлбөрийн үнэлгээний мэдээллийг бий болгох

Хяналт-шинжилгээний нэгэн адил үнэлгээ хийхэд шаардагдах мэдээллийг цуглуулах хэрэгтэй. Зарим мэдээлэл нь тухайн газар дээрх судалгааны дүн, зарим нь газар, төслийн мэдээлэл (захиргааны мэдээлэл) зэргээс гарч ирнэ. Ер нь явцын үнэлгээ хийгдэх бол (жишээ нь, хоёр жилийн дараа) эдгээр мэдээлэл нь жилийн эцсийн байдлаар гарсан байна. Эсвэл хөтөлбөр дууссаны дараа (дөрвөн жил гэвэл) эдгээр мэдээлэл нь ерөнхий үнэлгээнд нэг их чухал шаардлагатай биш байж болно.



Эдгээр мэдээллийн ерөнхий хэлбэрийг нь хүснэгт E1-E3-д харж болно.

<b>ХҮСНЭГТ E1: ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ</b>						
	<b>Явцын үнэлгээ</b>	<b>Үнэлгээ</b>				
		<b>Бүрэн биелсэн</b>	<b>Зарим талаар биелсэн</b>	<b>Хагас биелсэн</b>	<b>Маш бага биелсэн</b>	<b>Биелээ-гүй</b>
1	Зорилтод хүрэхээр дэд хөтөлбөр боловсруулагдсан байна уу?					
2	Дэд хөтөлбөр зардлын хувьд үр ашигтай юу?					
3	Дэд хөтөлбөр зөв нөхцөлүүдийг тавьсан байна уу?					
4	Дэд хөтөлбөр хангалттай хүний нөөцтэй байна уу?					
5	Дэд хөтөлбөр бусад нөөцөөр хангалттай хангагдсан уу?					
<b>Үр дүнгийн үнэлгээ</b>						
1	Тавьсан үр дүндээ (үзүүлэлт тус бүрээр хүрснийг харах) хүрсэн үү?					
2	Хөтөлбөр/дэд хөтөлбөр зорилгыг биелүүлсэн үү?					
3	Хөтөлбөр/дэд хөтөлбөр хүмүүсийн хүсэн хүлээсэн үр өгөөжийг бий болгосон үү?					

**Тайлбар:** Явцын үнэлгээ нь хөтөлбөр, дэд хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгаа болон хэрхэн үйл ажиллагаа явагдаж байгаад анхаарна. Энэ нь хөтөлбөр/дэд хөтөлбөрийг боловсруулах явцад гаргасан шийдвэрийн дагуу тодорхойлогдоно. Үр дагавар/үр нөлөөний үнэлгээ нь хөтөлбөр хэрэгжсэнээр гарсан өөрчлөлтийг төлөвлөгч нарт мэдээлнэ.

Тайлбар: Дэд хөтөлбөр тус бүрт бөглөнө.

<b>ХҮСНЭГТ E2: ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ</b>				
Дэд хөтөлбөр #	Хэрэгжилтийн байдал (1=дууссан, 2=хэрэгжиж буй)	Үнэлгээ	Төсөвлөсөн төсөв	Гүйцэтгэл
Дэд хөтөлбөр1		(Хүснэгт E1-с авах)		
Дэд хөтөлбөр2		(Хүснэгт E1-с авах)		
Дэд хөтөлбөр3		(Хүснэгт E1-с авах)		

Тайлбар: Хөтөлбөрийн бүх дэд хөтөлбөрийн хувьд хийнэ. Шаардлагатай бол дэд хөтөлбөрт жигнэсэн харьцааг ашиглана.



<b>ХҮСНЭГТ ЕЗ: ЯАМНЫ ҮНЭЛГЭЭ</b>				
Хөтөлбөр #	Хэрэгжилтийн байдал (1=дууссан, 2=үргэлжилж буй)	Үнэлгээ	Төсөвлөсөн төсөв	Гүйцэтгэл
Хөтөлбөр 1		(Хүснэгт Е2-с авах)		
Хөтөлбөр 2		(Хүснэгт Е2-с авах)		
Хөтөлбөр 3		(Хүснэгт Е2-с авах)		

Тайлбар: Хөтөлбөрийн бүх дэд хөтөлбөрийн хувьд хийнэ.

#### Хүснэгт Е1-Е3-г бөглөх заавар:

1. Бүх дэд хөтөлбөрийн үнэлгээг Хүснэгт Е1-д, бүх хөтөлбөрийн үнэлгээг Хүснэгт Е2-д, бүх яамдын хувьд хүснэгт Е3-г бөглөнө.
2. Хүснэгт Е1-д "бүрэн хэрэгжсэн"-нээс "хэрэгжээгүй"-г бөглөхийн тулд үнэлгээний мэдээг ашиглах бөгөөд нийт оролцогч талуудын зөвшилцлийн үндсэн дээр хийгдэнэ.

#### 5.7.1 Макро түвшний үнэлгээ

Үндэсний буюу макро эдийн засгийн түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээ нь үндэсний, бүсийн дунд хугацааны төлөвлөгөө болон жилийн төлөвлөгөөний дагуу хийгдэнэ. Дунд хугацааны төлөвлөгөөнүүдэд эцсийн болон явцын үнэлгээ хийнэ. Явцын үнэлгээнд хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүд болон зарим давхардал зайлшгүй гарч ирнэ.

Хэрэгжүүлэгч яам, агентлаг нь өөрийн мэдээллийн баазад үндэслэн дээд шатны байгууллагын гаргасан ахиц, өөрчлөлтийн талаарх мэдээллээр хангах үүрэгтэй. Мөн төв байгууллага нь томоохон судалгаа, шинжилгээнээс мэдээлэл авч үр дүнгээ баталгаажуулах, нэмэлт мэдээлэл олж авах зэргээр үнэлгээний дүн шинжилгээ хийнэ.

Хамгийн дээд шатанд энэ нь "юу юунд хэрхэн нөлөөлж байгаа"-г макро хүчин зүйлс буюу хавсарсан макро хүчин зүйлүүдийн өөрчлөлтөд нөлөөлсөн болох бодит учир шалтгааныг бүрэн тодорхойлж чадахгүй байж болох юм. Түүнчлэн, макро түвшний үнэлгээний тайлан нь улс орны хувьд суурь мэдээллийн багцыг багтаасан байдаг учраас "Нөхцөл байдлын дүн шинжилгээ"-тэй хамт хосолсон байж болно.



### 5.7.2 Үр дүнгээ тайлагнаж, илтгэх

Макро түвшний бүх үр дүнгийн үзүүлэлт нь Засгийн газрын дээд түвшний удирдлагад байгаа хүмүүс сонирхохгүй байж болно. Жишээ нь, Ерөнхий сайдад зөвхөн ДНБ-ий өсөлт, ядуурлын түвшин, урсгал төсвийн алдагдал зэрэг 2-3 шалгуур үзүүлэлтүүд байж болох юм. Макро түвшний хүрээнд дараах дөрвөн ангиллын дагуу шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох боломжтой юм. Үүнд:

1.Зорилгын шалгуур үзүүлэлтүүд - Ядуурлын түвшин, ДНБ-ий өсөлт, хүртээмжтэй өсөлтийн индекс, ойжуулсан талбайн хэмжээ гэх зэрэг цөөн тооны шалгуур үзүүлэлтүүд (18-20-с хэтрэхгүй),

2.Үр дагаварын шалгуур үзүүлэлтүүд – Эдгээр нь удирдлагын түвшинд шаардлагатай салбарын хэмжээний 40-80 орчим буюу түүнээс олон тооны байж болох шалгуур үзүүлэлтүүд,

3. Гарцын үзүүлэлтүүд – Энэ нь хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдээсээ хамаарна. Үүнд тооны хязгаар байхгүй бөгөөд салбарын бүх гарцын шалгуур үзүүлэлтүүдийг хамааруулах шаардлагагүй боловч салбар, хөтөлбөртэйгээ уялдсан байна. Макро түвшинд зөвхөн нэгтгэсэн үр дүнг гаргана.

4. Орцын шалгуур үзүүлэлтүүд нь гарцын шалгуур үзүүлэлтүүдтэйгээ адил байна.

## 5.8 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зохион байгуулалт

### 5.8.1 Макро түвшний мэдээлэл

#### *Шалгуур үзүүлэлтүүдийн ангилал*

Шалгуур үзүүлэлтүүд нь дараах ангилалд хуваагдана. Үүнд:

1. Тухайн жилд дэвшүүлсэн зорилтуудын дагуу **нэгтгэсэн үр дагаврын шалгуур үзүүлэлтүүд**: Ядуурлын бууралт, ДНБ-ий өсөлт, ойжуулсан талбайн хэмжээ,
2. Зорилтын дагуу үр дагаварт чиглэсэн **гарцын нэгтгэсэн шалгуур үзүүлэлтүүд**: Төлбөрийн тэнцэл, экспорт, импорт, ДНБ-ий бүтэц, ажиллах хүчний бүтэц,
3. Зорилтод чиглэсэн салбарын **үр дагаврын шалгуур үзүүлэлтүүд**: нялхсын болон эхийн эндэгдлийн түвшин, сургууль төгсөлтийн түвшин,
4. Салбарын зорилт, үр дагаварт чиглэсэн **гарцын шалгуур үзүүлэлтүүд**: Мал аж ахуй, ургац хураалт, хариуцсан замын урт, эх барьсан хүүхэд, боловсролын хамрагдалтын хувь,
5. **Орлуулан тооцох үзүүлэлтүүд**: Засаглал, Хүртээмжтэй өсөлт.



### **Нэгтгэсэн чанартай мэдээллийг бий болгох**

Макро түвшинд мэдээллийг бий болгоход хүндрэл, бэрхшээлүүд байдаг. Эдгээрийн нэг шалтгаан нь яам бүр өөрийн гэсэн захиргааны статистик мэдээлэл гаргадаг тогтолцоотой байдаг нь мэдээллийг харьцуулахад байдлыг бий болгож болно.

Яам бүр өөрийн мэдээллийн сангаа байгуулах стандарттай байдаг. Иймд уг тогтолцоо нь бүх төсөл, хөтөлбөрүүдээс (салбар дундын) мэдээлэл авч чаддаг хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж байвал илүү үр дүнтэй байх болно.

Эдгээр нэгжүүд нь шинжлэх ухааны үүднээс нийт мэдээллээ цуглуулан нэгтгэж, яамд, байгууллагууддаа цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Хэрвээ орон нутгийн түвшинд тодорхойлолтуудыг ойлгоход эсвэл мэдээллийн хуудсыг бөглөхөд (алдаатай тайланг хүртэл) алдаа, зөрүү байвал аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн түвшинд залруулж болох юм. Энэ хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж нь аймгийн Засаг даргын тамгын газар болон яамдад мэдээллээ тайлагнах юм.<sup>37</sup>

Мэдээлэл тайлагнахдаа дараах нөхцлүүдийг хангасан байна. Үүнд:

1. Яам, агентлаг бүр нь аймгийн түвшинд харьцангуй бие даасан Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжтэй харилцан анхан шатны мэдээлэл солилцохоор тохиролцсон байх ёстой. Өөрөөр хэлбэл, орон нутгийн засаг дарга болон яамдууд гэсэн хоёр удирдлагатай байна.
2. Яамд болон аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн хоорондын хамтран ажиллах механизм нь чухал урьдач нөхцөл юм.
3. Өргөн бүсийн сүлжээ болон VSAT (very small aperture terminal - маш жижиг нээлттэй терминал) зэрэг дэлхийн мэдээллийн урсгалын зарим нөхцөлүүдийг ашиглаж болох юм.
4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийг (компьютер, агаар сэлгэгч, машин) зэргээр бүрэн тоноглогдсон, мэдээлэл, компьютерийн мэдлэг үр чадвар бүхий хүний нөөц, төсөв санхүүтэй байна.

#### **5.8.2 Мэдээлэл бий болгох явц**

1. Захиргааны бүртгэлээр орц, гарцын мэдээллийг цуглуулж, дээд түвшний эрх бүхий байгууллагад мэдээлнэ. Эдгээр нь газрын болон яамдын үр дагавар болох бөгөөд макро түвшинд бүгдийг нь нэгтгэхийг шаардана.
2. Үр нөлөө болон үр дагаврыг тодорхойлоход судалгаа хийх шаардлагатай. Жишээ нь: мал аж ахуйг өргөжүүлэх нь (мал аж ахуйд шинжлэх ухааны туршлагыг нэвтрүүлэх хэлбэрээр) эсвэл эхчүүд болон нярайн эрүүл мэндийн шинжлэх ухааны мэдээллийг түгээх (залуу гэр бүлд шинжлэх

<sup>37</sup> ЭЗХЯ, Дархан хотод болсон сургалтын материалаас авав. 2014 оны 11-р сарын 20



ухааны практик нэвтрүүлэх) зэрэг зорилтот хүн амын хандлага, дадлагыг ажиглан ярилцах, судалгаа явуулах нь зүйтэй. Өргөн хэмжээний судалгааг явуулахад өртөг ихтэй байдаг. Нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаа, Хүн амын эрүүл мэндийн судалгаа, олон төрлийн кластер судалгаа зэрэг ерөнхий болон олон зорилго бүхий судалгаа нь мэдээлэл үүсгэхийн зэрэгцээ бодлогын нөлөө, бодлогын хүрээнээс гадуурх бие даасан нөлөөллүүдийг хамтад нь гаргадаг. Судалгааны мэдээллийг тайлбарлах учир шалтгаан, ялгааг тодорхойлох чадварыг шаарддаг. Энэ бүлэгт Өөрчлөлтийн онол дээр суурилсан загвар, зарим тоон загварчлалыг тайлбарлаж оруулсан.

3. Сонгогдсон жижиг түүвэр судалгаа нь бодлогын шийдлийг олоход тусла. (Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 2. Нөхцөл байдлын дүн шинжилгээнээс харна уу). Асуулгад суурилсан судалгаанууд болох жижиг түүвэр судалгаа нь ихэвчлэн зорилтот цар хүрээтэй байх бөгөөд өргөн хэмжээний судалгаатай харьцуулахад асуудлыг илүү гүнзгий тодорхойлдог. Хэд хэдэн тохиолдолд үр дүнтэй бодлогын арга хэмжээний талаар мэдээлэхдээ эдийн засаг, нийгэм, зан үйлийн талаас нь “хэрхэн”, “яагаад” гэдгийг мэдэх нь маш чухал. Эдгээр судалгаанууд нь дээрх асуудлаар шаардлагатай мэдээлэл өгч чадна. Зарим энгийн жишээг Шигтгээ 5.6-д өгсөн байна.





## Шигтгээ 5. 6 Судалгааны жагсаалт

### ХӨДӨӨ АЖ АХУЙ

1. Газар, хөдөлмөрийн бүтээмж, үр ашиг, ашиг,
2. Бордоо, услалтын систем – экологийн нөлөө,
3. Малын нүүдэл, насжилт, бүтээмжинд нөлөөлөх нөлөө, ашиг,
4. Маркетинг, гэрээт фермер, хадгалалт, хаягдал, үнэ,
5. Зам, мэдээллийн холболт, фермерийн үнэ/ашиг,
6. Ус хангамжийг хамтран эзэмших, ус түгээлтийн “толгой-төгсгөл” болон “сүүл-төгсгөл” систем, хэрэглэгчийн үнэ, ус хэрэглэгчийн нийгэмлэг.

### ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ

1. Эрүүл мэнд, Усан хангамж, ариун цэврийн байгууламж, хүүхдийн эрүүл мэндийн талаарх судалгаа,
2. Мөнгөн шилжүүлгийн хөтөлбөр, түүний нөлөө (хүссэн болон хүсээгүй),
3. Олон нийтийн ажил, хөтөлбөрүүд (нөхцөлт хүнс, мөнгө шилжүүлэх),
4. Эрүүл мэнд, сургуульд хамрагдалт, эмэгтэйчүүдийн байдал болон хоол тэжээлийн хөтөлбөрийн нөлөө.

### ХҮҮХЭД/БОЛОВСРОЛ

1. Хүүхдийн хөдөлмөр - юунаас бий болдог, яаж зогсоох вэ?
2. Хүүхдийн сургуульд хамрагдалт (хамрагдахгүй байх), завсардсан хүүхдүүд,
3. Багшийн чанар, багш нарын ажилд эрэлттэй холбоотой гол асуудал,
4. Сургалтын хэрэгцээ, ажилд тэнцдэг байдал.

4. Яам нь өөрийн харъяа байгууллагуудаас (эмнэлгийн бүртгэл, худалдааны бараа, үйлчилгээний олон улсын хөдөлгөөнд шалган нэвтрүүлэх цэг, сургууль гэх зэрэг) захиргааны статистик мэдээлэл цуглуулдаг. Эдгээр нь үр дагавар болон үр нөлөөний дүн шинжилгээнд чухал хэрэгтэй. Анхаарах зүйл: Зарим тоон мэдээллийг тайлбарлахдаа хянамгай байх хэрэгтэй. Жишээ нь: импортын цагаан будааны хэмжээг ачсан вагон, ачааны тоогоор нь "олох" нь муу сонголт юм. Үүний оронд өдөр тутмын захиргааны мэдээллийг албан ёсны статистик мэдээлэлтэй тулган тааруулж, баталгаажуулах нь зүйтэй.

*Тайлбар: Орон нутгийн захиргааны байгууллага нь Орон нутгийн хөгжлийн сангийн төслүүдийн хувьд өөрийн гэсэн статистик тоо шаардана. Мэдээлэл цуглуулах хэлбэр нь үндэсний хэмжээний төслүүдэд хийгддэг тайлагналттай төстэй байх ёстой. Гэхдээ тэдэнд нөөц хэрэгтэй.*

### 5.8.3 Мета мэдээллээс шалгуур үзүүлэлтүүдийг тооцох асуудлууд

Зарим үзүүлэлтүүдийг хэд хэдэн аргаар тооцож болдог. Жишээ нь: Нөхөн үржихүйн түвшинг Брассын харьцаа, Арриага-Брассын арга, Релегийн аргаар болон шууд тооцоог ашиглан тооцож болно. Мөн нас баралтын түвшинг (бүх насны бүлгээр, нялхсын эндэгдлийн хамт) Паллрни-Хелигман нарын НҮБ-ын ерөнхий загвар, Трасселийн Коале-Демени барууны загвар болон шууд тооцоогоор тооцож болно. Хяналт-шинжилгээ, үнэлгээний байгууллага ямар арга ашиглахаа өөрөө сонгодог боловч мэдээлэл цуглуулах болон түүвэрлэлт хийхдээ олон улсын туршлагыг авч үзэх нь зүйтэй.



## 5.9 Монгол Улсын Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо

Монгол Улс нь Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу захиргааны статистик, судалгааны мэдээлэлд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг бэлтгэж байна.

**Зорилго:** Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлснээр Засгийн газарт итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, төрийн удирдлагын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад оршино.

**Зорилт:** Холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн дунд болон урт хугацааны зорилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөөг тооцох; төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулах; хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтэд үндэслэн Засгийн газар, сайд, төрийн захиргааны бусад байгууллагаас гаргах шийдвэр, бодлогын хувилбар, санал, зөвлөмж боловсруулж, Засгийн газар, сайд, агентлагийн дарга, Засаг дарга болон холбогдох байгууллагын удирдлагад бодлогын дэмжлэг үзүүлэх; төрийн захиргааны бүх шатны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ-ний тогтолцоог бэхжүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээний стратеги, бодлогыг тодорхойлон, хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, арга зүйгээр хангах; Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ-ний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах зэрэг болно.

**Хамрах хүрээ:** Хяналт-шинжилгээ, үнэлгээнд төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага хамрагдаж, яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагаанд, эсвэл бодлогын тодорхой чиглэлээр хийнэ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө:** Тухайн ажлын зорилго, зорилт, хамрагдах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг тусгана. Мөн байгууллагын алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн бодлогын зорилтын дунд болон урт хугацааны үр дүнг тодорхойлсон байна.

**Судалгаа, дүн шинжилгээ:** Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан тоон болон тоогоор илэрхийлж болох зарим үзүүлэлтийг статистикийн болон тухайн үйл ажиллагааны хүрээний асуудлыг хариуцсан бусад байгууллагын судалгааны үзүүлэлт, тухайн жилд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд газар дээр нь хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн зэрэгтэй харьцуулан нягталж үзнэ. Тайланд







хяналт-шинжилгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

**Үр дүнг үнэлэх аргачлал:** Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ нь үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн түвшин нийлбэрийг нийт үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан дундаж хувиар илэрхийлэгдэнэ.

**Үр дүнг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээ:**

- -Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тэргүүний арга, туршлагыг нэвтрүүлэх,
- -Гүйцэтгэл сайжруулах сургалт явуулах,
- -Гүйцэтгэл сайжруулах яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг даалгавар өгөх,
- -Удирдамжийн дагуу орон нутаг, яамд дээр үзлэг хийж, санал бодлоо солилцох - Засгийн газар ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан таван аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус бүр 20.0 хүртэл сая төгрөгийн, шалгарсан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга тус бүрт хүртэл сарын үндсэн цалинтай нь тэнцэх мөнгөн урамшуулал олгоно.<sup>38</sup>

## **5.10 Тусгай сэдэв: Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Өөрчлөлтийн онолыг хэрэглэх нь<sup>39</sup>**

Тусгай сэдэвт дүн шинжилгээ хийх чухал арга, аргачлалыг тайлбарлалаа. Энд хяналт-шинжилгээ, үнэлгээний шинэ арга болох Өөрчлөлтийн онолыг танилцуулж байна.

### **5.10.1 Ойлголт**

Нийгмийн өөрчлөлтийг дэмжихийн тулд Засгийн газрын түвшинд голчлон ашигладаг төлөвлөлт, үнэлгээний тусгайлсан төрлийн аргачлал бол Өөрчлөлтийн онол юм. Өөрчлөлтийн онол нь төсөл, хөтөлбөр эсвэл салбарын урт хугацааны зорилгыг тодорхойлж, энэ зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцлийг хойш тодорхойлдог. Өөрчлөлтийн онол нь аливаа санаачлагын учир шалтгааныг тодорхойлохдоо санаачлага хэрхэн өрнөх, хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг хариуцлага юу болох, мөн богино, дунд, урт

<sup>38</sup> Эх сурвалж: Засгийн газрын 322 дугаар тогтоол, Улаанбаатар, 2013

<sup>39</sup> 'Зорилтот хөтөлбөрийн онол: Өөрчлөлтийн онол ба Логик загварыг үр дүнтэй ашиглах нь', SC Funnell and PJ Rogers, John Wiley, Сан Франциско, 2011 (Цахим хувилбар); 'Хөтөлбөрийн онол үнэлгээ: Дадлага, Амлалт ба Асуудал', P Rogers, A Petrosino, T Huebner and Timothy A. Hasci, 'Үнэлгээний шинэ чиглэл', #87, Fall 2000; 'Өөрчлөлтийн онолын хэрэглээ' олон улсын хөгжил дэх тойм', Isabel Vogel, DfID, Лондон [https://dfid.gov.uk/pdf/outputs/mis/dfid/toc/review\\_vogelv7.pdf](https://dfid.gov.uk/pdf/outputs/mis/dfid/toc/review_vogelv7.pdf)



хугацааны үр дагаварыг дурдах замаар өөрчлөлтийн үйл явцыг судалж, тусган тайлбарлана. Тодорхойлсон өөрчлөлтийг болох дарааллын дагуу үр дагаварын логик холбоог харуулсан “үр дагаварын зам” зураглалаар харуулдаг. Мөн үр дагавар хоорондын холбоог харуулахдаа нэг үр дагавар нь нөгөө үр дагаварын урьдчилсан нөхцөл болохыг тайлбарлана. Зам бүрт хэрхэн болон яагаад өөрчлөлтөд хүргэсэн өөр өөр боломжит замуудыг Өөрчлөлтийн онол харуулдаг.

Энэ нь Логик хүрээ эсвэл Үр дүнгийн хүрээтэй төсөөтэй харагдуулж болно. Мөн ашиглах зорилгын хувьд ч төстэй байж болно. Энэ онол доорх асуудлуудыг бүтээлчээр сэтгэхийг шаарддаг. Үүнд:

- а) Хөтөлбөрт нөлөөлөх нөхцөл байдал,
- б) Оролцогч талуудын идэвхи оролцоо, хувь нэмэр,
- в) Өөрчлөлтийн дараалал нь хэрхэн, яагаад гарсан болон гараагүй тайлбарууд.

Өөрчлөлтийн онолд суурилсан хамгийн хялбар загвар нь Логик хүрээ/Үр дүнгийн хүрээнээс илүү нарийвчилсан бөгөөд төвөгтэй байдаг гэдгийг Зураг 5.2-т үзүүлж байна.

Анх байснаасаа Өөрчлөлтийн онолын шинэчлэл нь нэгдүгээрт, хүсэн хүлээсэн болон бодит үр дагавар хоёрын ялгааг харуулж өгсөн. Хоёрдугаарт, үр дагаварт хүрэхээр авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг шийдэхээсээ өмнө хүссэн үр дүнгээ загварт оруулах хэрэгтэйг бодлого боловсруулагчдаас шаардах болсон. Өөрчлөлтийн загвар дээр ажилласнаараа бодлого боловсруулагчид стратеги, тактикийн талаар илүү мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжтой болно. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийг сайтар бүрдүүлснээр бодлого боловсруулагчид нь Өөрчлөлтийн онолын загвараа шинэ нотолгооны үндсэн дээр сайжруулж чадна.

Өөрчлөлтийн онол нь үнэлгээ хийхэд дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Онол болон нотолгоонд суурилсан үнэлгээний арга бөгөөд шинжилгээг илүү нарийвчлахад тусална.
2. “Юу ажиллаж байна” гэдгийг мэдэхээс илүүтэйгээр амжилтыг ойлгох нь чухал учраас “хяналт-шинжилгээний асуулт” гэж ашиглаж болох хамгийн тохиромжтой үзүүлэлтийг сонгохыг шаарддаг. Хяналт-шинжилгээний асуулт нь “Үр дүнд хүрэхийн төлөө нөөцийг удирдахдаа бид юу мэдэх хэрэгтэй вэ?” гэсэн хэлбэртэй байж болно.
3. Нэг асуудлын хүрээг хуулбарлан нөгөө асуудлыг шийдвэрлэх нь тийм ч тохиромжтой байдаггүй бөгөөд ингэж ашиглахыг Өөрчлөлтийн онол эсэргүүцдэг. Санаачлага эсвэл багц үйл ажиллагаа хэрхэн ажиллах болон ажиллахгүй байх, тусгайлсан төслөөр хэрэгжүүлэхэд хэрхэн тохируулах шаардлагатай вэ гэдгийг тодорхой итгэлтэйгээр урьдчилан таамаглах





боломжтой болохын тулд хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанаас хангалттай мэдлэг, ойлголттой болохыг Өөрчлөлтийн онол шаарддаг.

4. Юу хэрэгжих, хэрхэн явагдах, агуулга нь санаачлагад хэрхэн нөлөөлөх талаар илүү сайн зураглал хийхийн тулд хэд хэдэн судалгаанаас нотолгоо олж нэгтгэхийг Өөрчлөлтийн онол санал болгодог.

### 5.10.2 Өөрчлөлтийн онолын зарим онцлогууд

Төсөл болон үйл ажиллагаа бүрт өөрчлөлт, хувьслын загвар байдаг гэж Өөрчлөлтийн онол тайлбарладаггүй. Дээрх асуултад тохирсон хариулт өгөхийг л шаарддаг. Гэхдээ нэг эсвэл ихэнх хариултаудыг мэдэж байгаа бол тус хариултыг дахин хайх хэрэггүй юм. Доорх жишээнээс үүнийг харж болно. Үүнд:

Зорилт: Тосгонд шинээр сургууль барих замаар сурагчдын сургуульд хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх

**Жишээ 1:** Ядуу өрхийн хүүхдүүд сургууль завсардах хандлагатай байдаг. Иймээс эдгээр хүүхдүүдэд дэмжлэг, хөшүүргийг үзүүлэх шаардлагатай бөгөөд хэрэгжилтийн нэг хэсэг болсон байх хэрэгтэй. Энэ нь боловсролын хөтөлбөрийг орлого нэмэгдүүлэх хөтөлбөртэй уялдуулан хүүхдийн хөдөлмөрийн зах зээлийн босго давахад шаардах шаардлагыг багасгаж өгвөл эцэстээ илүү үр дүнтэй болно.


**Жишээ 2:** Энэ тосгоны ядуу өрхийн хүүхдүүд сургууль завсардах магадлалтай байна. Иймд барилгын ажил эхлэхээс өмнө сургуульд хамрагдалт, завсардалтын талаар “яагаад” болон “хэрхэн” гэсэн нарийвчилсан судалгааг явуулах нь зүйтэй юм.

Хэрвээ тухайн улсад ядуу өрхийн дунд хүүхдүүдийн сургууль завсардалт их байна гэдгийг судалгаагаар нэгэнт тогтоосон бол судалгаа, асуулгын хариуг хүлээн сургуулийн барилгыг хойшлуулах шаардлагагүй юм. Сургуулийн барилга барих хөтөлбөр эхлэхээс өмнө хуучин туршлагаас гарсан ерөнхий мэдээллийг нэгтгэн бүртгэж байхыг Өөрчлөлтийн онол санал болгодог. Асуудал нь сургуулийн барилга барих үе шатандаа хүрсний дараа буцаж шийдвэрээ өөрчлөхгүй байх явдал юм.



Зураг 5. 3: Өөрчлөлтийн онол ба үр дүнгийн хүрээний зураглал<sup>40</sup>

## Өөрчлөлтийн онол ба Үр дүнгийн хүрээ



Дараагийн нэг чухал зүйл бол Өөрчлөлтийн онол нь хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүнгийн хүрээний шат бүрийг баяжуулж, өргөжүүлж илүү бодитой болгодог. Энэ нь одоо байгаа аргууд, хяналт-шинжилгээ, үнэлгээний аргууд болон үр дүнгийн хүрээг орлох арга биш юм.

Гуравдугаарт, Өөрчлөлтийн онол нь хожимдсон үр нөлөө, шууд бус хамаарал, нэг болон хоёр талт хамаарал болон гадны хүчин зүйл зэрэг эдгээр асуудалд ихээхэн анхаарал хандуулдаг учраас үр дүнд чиглэсэн бодитой загварыг гаргахад чухал ач холбогдолтой байдаг.

Эцэст нь Өөрчлөлтийн онол нь тоон мэдээ, бодит байдал болон эмпирик нотолгоонд илүү ач холбогдол өгдөг. Иймээс Үр дүнгийн хүрээгээр тодорхойлсон хамаарлын утга учрыг тайлбарлахад эконометрик загварыг ашигладаг. Үүний тулд сайн чанарын мэдээллийг бий болгохыг илүү чухалчилж үздэг.

Өөрчлөлтийн онол нь логик систем болохыг доорх жишээгээр үзүүлэв. “Өдөрт нэг алим идвэл эмч рүү явах хэрэггүй” гэсэн хэлц үгийн дагуу алим идэх нь хүмүүсийн эрүүл мэндийг сайжруулдаг гэж үзье. Зураг 9-д энэ нь хэрхэн, яагаад буруу (хэрвээ тэд хийвэл) байж болохыг харуулав. Хүмүүсийн эрүүл мэндийг

<sup>40</sup> Эх сурвалж: <http://www.tools4dev.org/resources/theory-of-change-logical-framework-whats-the-difference-in-practice?>



сайжруулахад олон шалтгаан саад, бэрхшээл учруулж болохыг дараах зураг харуулж байна.

**Зураг 5. 4: Жишээ**

**Алим идэх нь хүн амын эрүүл мэндийг сайжруулдаг: Үгүй ч байж болох шалтгаанууд**

Хүргэж ирсэн алим	Идсэн алим	Нэмэгдсэн С витамин хэмжээ	Эрүүл мэнд сайжирсан байдал	Тайлбар
x	x	x	x	Хэрэгжилтийн алдаа
✓	x	x	x	Ажил үүрэг, түүний биелэлт дэх алдаа (Эхний учир шалтгааны холбоотой)
✓	✓	x	x	Онолын алдаа (Эрт үеийн учир шалтгааны холбоотой)
✓	✓	✓	x	Онолын алдаа (дараах үеийн учир шалтгааны холбоотой)
✓	✓	✓	✓	Онолтой нийцсэн байдал
✓	✓	✓/x	✓/x	Онолын хэсэгчилсэн алдаа (зарим нөхцөл нь биелсэн)
✓	✓	x	✓	Онолын алдаа (учир шалтгааны ялгаатай арга зам)

Өөрчлөлтийн онолыг дүгнэвэл:

1. Өөрчлөлтийн нарийн түвэгтэй байдал болон түүний оролцогчид нь өөрчлөлтөнд нөлөөлдөг болохыг Өөрчлөлтийн онол хүлээн зөвшөөрдөг. Өөрчлөлт хэрхэн өрнөдгийг өргөн шинжилгээ хийх хөтөлбөр, төсөл байршуулахыг зөвшөөрдөг. Иймээс хамт олон, орон нутаг, үндэсний болон олон улсын зэрэг янз бүрийн түвшинд үйл ажиллагааг өөрчлөлттэй холбож өгнө.
2. Хөгжлийн талаарх сургалтад үндэслэн Өөрчлөлтийн онол гарч ирсэн. Иймээс “өөрчлөлт”-д хүрэх янз бүрийн замаас гадна хөтөлбөрийн хэрэгжилтэд холбогдолгүй замуудыг ч оруулсан байдаг.
3. Өөрчлөлтийн үйл явцын ойлголтыг Өөрчлөлтийн онол тайлбарлах бөгөөд хэрэглэгч нарыг түүнийг улам гүнзгийрүүлэн судалж, шинжлэхийг авч үзэхийг дэмждэг.
4. Боломжит өөрчлөлт хэрхэн болон яагаад гарч байгаа болон үүнийг яаж ашиглаж болохыг Өөрчлөлтийн онол тайлбарладаг. Жишээ нь “бодлого боловсруулагч нь Х-ийг хийвэл Y нь шалтгаанаар өөрчлөгдөх болно” гэж өгүүлбэрийг гүйцээнэ.
5. Өөрчлөлтийн онол нь загвар/ тайлбарыг диаграм хэлбэрээр тайлбар текстийн хамт харуулдаг. Диаграм нь уян хатан байх бөгөөд тусгай тогтсон хэлбэргүй. Үүнд, тойрог хэлбэрийн үйл явц, эргэх холбооны шугам, бусад руу чиглэсэн хайрцаг (олон төрлийн), төрөл бүрийн хэлбэртэй хайрцаг гэх мэт.
6. Диаграммаар харуулахдаа Өөрчлөлтийн онолын загвар нь яагаад нэг хайрцаг нь (үйл явдал) нөгөө хайрцагт хүргэхийг дүрслэнэ. Жишээ нь, хэрвээ мэдлэг ихтэй байх нь дадал зуршлаа өөрчлөхөд хүргэдэг гэвэл энэ нь таамаглал уу, эсвэл үүнийг нотлох баримт байна уу?



## 5- р Бүлгийн Хавсралт 1: Үр дагавар/ үр нөлөөний үзүүлэлтийн шат дараалал

Тайлбар: Бүс нутгийн түвшинд шалгуур үзүүлэлт нь дээрхтэй адил байх бөгөөд бүс нутгийн түвшинд зарим нь тооцох боломжгүй байж болно.

<b>(Монгол Улсын хувьд таамаглал жишээ)</b>
<b>ЗОРИЛГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b> <b>(Дээд түвшний удирдлагад зориулсан)</b>
<b>(1) Тогтвортой өсөлт:</b> ДНБ-ий бодит өсөлт, нэг хүнд ногдох ДНБ, Хүртээмжтэй өсөлт ч индекс, ДНБ-ий бүтэц, Ойн эзлэх хувь, Цөлжилтийн хувь, Агаарын бохирдлын индекс
<b>(2) Ядуурлыг бууруулах:</b> Ядуурлын түвшин, орлогын тэгш бус байдлын Жини коэффициент, ажилгүйдлийн түвшин
<b>(3) Тогтвортой байдал:</b> Хөрөнгө оруулалт
<b>(4) Хүний Хөгжил (МХЗ-той холбоотой)</b>  <i>Боловсрол, чадвар:</i> 12 дугаар ангийн төгсөлтийн хувь (хүйсээр), Ур чадварын түвшин (индекс),  <i>Жендэр:</i> Төрийн салбарт шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь,  <i>Эрүүл мэнд:</i> Төрөлт, нялхсын эндэгдлийн түвшин, тураалтай хүүхэд, эхийн эндэгдлийн түвшин,  <i>Усан хангамж, ариун цэврийн байгууламж:</i> Цэвэр усан хангамжинд холбогдсон хүн амын хувь, сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын хувь
<b>САЛБАРЫН ҮР ДАГАВАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (Салбарын сайд, удирдлагад зориулсан)</b>
<b>(1) Макро эдийн засгийн удирдлага:</b> Төсвийн орлого, зарлага, инфляци, гадаадын шууд хөрөнгө оруулалт, урсгал дансны тэнцэл, өрийн үйлчилгээ, хоёр талт худалдаа,
<b>(2) Салбарын өсөлт, төрөлжүүлэх:</b> Салбарын өсөлт, аж үйлдвэрийн үйлдвэрийн индекс, ирсэн жуулчдын тоо, ажил эрхлэлт салбараар,
<b>(3) Байгалийн нөөцийн удирдлага:</b> Улсын хэмжээний тусгай хамгаалалттай 99 газар, аймгийн хамгаалалттай газар
<b>(4) Дэд бүтэц:</b> Хатуу хучилттай замын урт, барьсан болон засвар хийсэн төмөр замын урт, телевиз/радио, хэвлэл мэдээлэл, нэг хүнд ногдох эрчим хүчний ашиглалт, орон сууцанд амьдарч буй хүн амын эзлэх хувь
<b>(5) Засаглал:</b> Авлигын индекс, гэмт хэрэг
<b>(6) Хүний Хөгжлийн дэлгэрэнгүй мэдээлэл</b> <i>Ядуурал:</i> Ядуурлын түвшин (хот, хөдөөгөөр)
<i>Боловсрол:</i> Их дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн бүтэц (18-35 нас)



*Жендэр:* Төрийн албанд ажилладаг эмэгтэйчүүдийн эзлэх хувь, цалинтай хөдөлмөр эрхлэгчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, ахлах анги болон дээд сургуульд эрэгтэй хүүхдийн хамрагдалт, МСҮТ-ийн нийт төгсөгчдөд охидын эзлэх хувь, эмэгтэйчүүдийн үзлэгт жилд 2 удаа ордог эмэгтэйчүүдийн эзлэх хувь, гэр бүлийн хүчирхийлэлд автсан гэр бүлийн эзлэх хувь,

*Эрүүл мэнд:* 5 хүртэлх насны хүүхдйн эндэгдэл, 50 болон түүнээс доош насны хүн амын дотор зүрх судасны өвчлөл, ДОХ-ын тархалт, уушигны сурьеегээр өвчлөлт, жин дутуу хүүхдийн эзлэх хувь, гепатит С өвчлөлт,

*Усан хангамж, ариун цэврийн байгууламж:* Цэвэр усны хүртээмж, сайжруулсан ариун цэврийн байгууламж (хот, хөдөөгөөр)



## 5- р Бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц

5 дугаар бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц – Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн төслийн жишээ							
Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих үзүүлэлт, тодорхойлолт ба нэгж	Тайлагнах арга/ хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх			Тайлагнах үйл ажиллагаа	
			Давтамж, ажлын хуваарь	Хариуцах хүн:			
			Цуглуулах	Удирдлага	Дүн шинжилгээ		
<b>ЗОРИЛГО: Суулгалт өвчний нас баралт / өвчлөлийг бууруулах</b>							
<b>Зорилгын үзүүлэлт:</b> Нүүлгэн шилжүүлсэн нутгийн сүүлийн хоёр долоо хоногт 5-аас доош насны хүүхдүүдийн суулгалтын хувь	"Олон нийтийн бүлэг" гэж нийслэл, орон нутгийн засаг захиргааны тооллогоор хүлээн зөвшөөрөгд сөн хэсэг хүмүүсийг хэлнэ.	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Улирлын явцын тайлангийн үр дүн  <b>Суурь-Төгсгөлийн судалгаа:</b> хийнэ.	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Анхны судалгаа; 12 сарын дараа; Төслийн эцэст  <b>Суурь:</b> 2014/12. <b>Төгсгөл</b> төслийн хугацаанаас хамаарна.	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Олон нийтийн ажилтан (ОНА) харьяа түвшний ажилтнууд  <b>Суурь-Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Төслийн зохицуулагч  <b>Суурь судалгаа:</b> Зөвлөхүүд, ХШҮ-ний нэгж, Төслийн удирдлага	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> (ХД) судалгааны мэдээлэл хариуцсан Мэдээлэл ба Боловсролын мэргэжилтэн (МБМ)  Мэдээллийн дүн шинжилгээг төслийн зохицуулагч хийнэ.  <b>Суурь-Төгсгөлийн судалгаа:</b> Төслийн удирдлага, ХШҮ	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Төслийн ХШҮ; Удирдлага, олон нийт, Засгийн газар, үр шим хүртэгчид
<b>Зорилт 1: Ундны усны нөөцийн тогтвортой эх үүсвэр, хүртээмж хэрэглээг нэмэгдүүлэх</b>							
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 1а:</b>  #Нэг өрхийн өдөрт ашигласан ундны усны хэмжээ, л  Таамаглал: Ундны усанд тохирох өөр ямар ч эх үүсвэр байхгүй.	Нэг хүний нэг өдрийн ундны усны хэмжээ нь 40 л  Дахин шалгалтаар хэмжигдэнэ: 1) <b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Асуулгад сонгогдсон өрх 2) <b>Төгсгөлийн судалгаа</b>	1) <b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> УХАЦБЭА-ын (МХД) судалгааг төслийн өмнөх байдлаар гаргасан байна.  2) <b>Төгсгөлийн судалгаа:</b> ХШҮ зөвлөх болон ариун цэвэр, эрүүл ахуйн багийн хамт боловсруул-	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Цэвэр усны шүүлтүүр тохируулах (ЦУШ) асуултуудыг нэмэх: 2015 оны 6 сарын төгсгөл <b>Мэдлэг, хандлага, дадлын судалгааны давтамж:</b> Эхний, 12 сарын дараа, ба төслийн эцэст	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Нийгмийн ажилтан  <b>Суурь-Төгсгөлийн судалгаа хийгдсэн байна:</b> Зөвлөхүүд	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Төслийн зохицуулагч  <b>Суурь судалгаа:</b> Зөвлөхүүд ба ХШҮ-ний нэгж ба Төслийн удирдлага	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> (ХД) судалгааны мэдээлэл хариуцсан Мэдээлэл ба Боловсролын мэргэжилтэн (МБМ)  Мэдээллийн дүн шинжилгээг төслийн зохицуулагч хийнэ.  <b>Суурь-Төгсгөлийн судалгаа:</b> Төслийн	<b>Ашиглагдах мэдээлэл</b> Дээрхтэй адил





5 дугаар бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц – Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн төслийн жишээ							
Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих үзүүлэлт, тодорхойлолт ба нэгж	Тайлагнах арга/ хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх			Тайлагнах үйл ажиллагаа	
			Давтамж, ажлын хуваарь	Хариуцах хүн:			
				Цуглуулах	Удирдлага	Дүн шинжилгээ	
		сан байх хэрэгтэй.	<b>Төгсгөлийн судалгаа</b> Төслөөс хамаарна.			удирдлага, ХШҮ-ний ажилтан	
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 1b:</b>  Зорилтот өрхөөс хангалттай хэмжээний ундны ус хүртсэн өрхийн % (Зорилтот түвшин нэг өдөрт нэг хүний 40 л)	Нэг хүний нэг өдрийн ундны усны хэмжээ нь 40 л  Усны хэмжээ дахин шалгалтаар хэмжигдэнэ.  Усны чанар ДЭМБ-ын стандартаар хэмжиж, гэдэсний и-савханцрын түвшин 0 байна. Тэд үндсэн бүлгийн 100мл тутамд тэсвэртэй байна.	Усны чанар үр дүнг бүртгэх иж бүрдлийг туршсан байна.  Усны тоо хэмжээ: суурь/ төгсгөлийн судалгаа	<b>Хуваарь:</b> 2015 оны дөрөвдүгээр сар гэхэд усны чанарын тайлангийн маягтыг боловсруулсан байна. <b>Давтамж:</b> Хүлээж авснаас усны чанарыг 1 сарын дараа, мөн 7 сарын дараа туршсан байна.  <b>Усны тоо хэмжээ:</b> Суурь-Төгсгөлийн судалгаа	Усны чанар: Нийгмийн ажилтнууд  Суурь судалгаа/ төгсгөлийн судалгаа: Зөвлөхүүд	Усны чанар: Төслийн зохицуулагч  <b>Суурь судалгаа:</b> Зөвлөхүүд ба ХШҮ-ний нэгж ба Төслийн удирдлага	Усны чанар: Төслийн баг УХАЦЭА-ын ажилтнууд ба Төслийн зохицуулагч  <b>Суурь-Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд, Төслийн удирдлага, Ахлах мэргэжилтэн, ХШҮ-ний ажилтан	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Дээрхтэй адил
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 1с:</b> (ЦУШ) аюулгүй ундны усаар хангахад тусалсан зорилтот өрхийн хувь	Өрхийн өөрийн тайлангаар, өөрөөр хэлбэл “(ЦУШ) ундны ус авахад тусалсан.” Санал бүрэн дүүрэн нийлж байна, огт нийлэхгүй байна.	<b>1) Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Байгаа УАЦЭАБ-ийн МХД мэдээллээс авна.  <b>2) Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд болон ХШҮ-ний зөвлөхүүд боловсруулна	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> <b>Цэвэр усны шүүлтүүр тохируулах (ЦУШ) асуултуудыг нэмэх:</b> 2015 оны 6 сарын эцэст.  <b>МХД давтамж:</b> 12 сар бүрт болон төслийн эцэст цуглуулна.	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Олон нийтийн ажилтан (Улаан загалмайн нийгэмлэгийн ажилтнууд)  <b>Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Төслийн удирдагч  <b>Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд, ХШҮ-ний нэгж, Төслийн удирдлага	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:</b> Мэдээлэл ба Боловсролын салбарын ажилтнууд МХД-ын мэдээллийг оруулна. Ус хангамжийн төлөөлөгчид Төслийн зохицуулагч, төслийн удирдагчдын хийсэн дүн шинжилгээ.  <b>Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд, Төслийн удирдлага, ХШҮ-ний ажилтнууд	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Дээрхтэй адил



5 дугаар бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц – Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн төслийн жишээ							
Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих үзүүлэлт, тодорхойлолт ба нэгж	Тайлагнах арга/ хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх				Тайлагнах үйл ажиллагаа
			Давтамж, ажлын хуваарь	Хариуцах хүн:			
				Цуглуулах	Удирдлага	Дүн шинжилгээ	
<b>Гарц 1.1:</b> Ус цэвэршүүлэх арга нь сайжруулах боломжтой болсон байна.							
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.1a:</b> # Цэвэр усны шүүлтүүр авсан зорилтот өрх (ЦУШ) (зорилтот он YYYY)	Төслийн (ЦУШ) хүлээн авагч тодорхойлог д-сон өрхүүд	(ЦУШ) хүлээн авсан тайлангийн хүснэгт	<b>Хуваарь:</b> Эцсийн гүйцэтгэсэн тайланг хүргэх  <b>Давтамж:</b> Хүлээн авсны дараа	МБС-ын ажилтнууд болон Олон нийтийн ажилтны хамт бүртгэсэн.	Төслийн зохицуулагч	Төслийн баг, (ЦУШ)-ийн нийгмийн маркетингийн төлөөлөгчөөр удирдуулсан УАЦЭАБ-ын ажилтнууд, Төслийн зохицуулагч.	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Дээрхтэй адил
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.1b:</b> (ЦУШ) тараасан өрхийн дундаж харьцаа, өрхийн ам бүлийн тоо (зорилтот ХХ юм)	Хүлээн авагч өрхийн нийт # хүмүүс / (ЦУШ) хүлээн авч нийт өрхийн тоо	(ЦУШ) авсан өрхийн бүртгэлийн хүснэгт  (ЦУШ) хүлээн авсан тайлангийн хүснэгт	<b>Хуваарь:</b> Бүртгэл болон хүлээн авсан тайлангийн бөглөгдсөн хүснэгт.  <b>Давтамж:</b> Бүртгэж, хүргэсний дараа	МБС-ын удирдагчид болон Олон нийтийн ажилтнуудын хийсэн өрхийн бүртгэл	Төслийн зохицуулагч	Төслийн баг, (ЦУШ)-ийн нийгмийн маркетингийн төлөөлөгчөөр удирдуулсан, УАЦЭАБ-ын төлөөлөгчдийн хамт, Төслийн зохицуулагч.	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Дээрхтэй адил
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.1c:</b> 12 сарын дараа (ЦУШ)-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа өрхийн хувь	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа ба Төгсгөлийн судалгаа</b>  “Үйл ажиллагааны”: гэдэг нь үргэжилсэн гэсэн утгаар хэрэглэнэ.	<b>1) Ажиглалт болон шалгах уулзалтын тайлангийн хүснэгтэнд бичигдсэн.</b>  <b>2) Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд болон ХШУ-ний зөвлөхүүд хамт боловсруулсан байна.	<b>Тайлангийн шалгах хүснэгт:</b> 2015 оны 3 сарын 21 гэхэд хянагдсан байна. Төслийн зохицуулагч боловсруулсан байна. <b>Давтамж:</b> <b>1) Шалгах томилолт:</b> 1 долоо хоног, ба 1, 7 дах сар. <b>2) Төгсгөлийн судалгаа</b>	<b>1) Шалгах томилолт:</b> М ба Б салбарын удирдагч, Олон нийтийн ажилтантай хамт  <b>2) Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд	<b>Ажиглалтын томилолт:</b> Төслийн зохицуулагч  <b>Төгсгөлийн судалгаа:</b> ХШУ-ний зөвлөх УАЦЭАБ-н баг хамт	<b>Ажиглалтын томилолт:</b> Төслийн баг, (ЦУШ)-ийн нийгмийн маркетингийн төлөөлөгчөөр удирдуулсан, УАЦЭАБ-ын төлөөлөгчид Төслийн зохицуулагч. <b>Төгсгөлийн судалгаа:</b> Зөвлөхүүд, Төслийн удирдлага, Ахлах мэргэжилтэн, ХУШ-ний ажилтан	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Дээрхтэй адил



5 дугаар бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц – Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн төслийн жишээ							
Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих үзүүлэлт, тодорхойлолт ба нэгж	Тайлагнах арга/ хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх				Тайлагнах үйл ажиллагаа
			Давтамж, ажлын хуваарь	Хариуцах хүн:			
			Цуглуулах	Удирдлага	Дүн шинжилгээ		
<b>Гарц 1.2:</b> Өрхийн баталгаат ундны усны хэрэглээ сайжирсан байна. ТУРШЛАГА							
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.2:</b>  Ундны усаа зөв нөөцөлсөн өрхийн % (Зорилтот түвшин %)	Мэдлэг, хандлага, практик судалгаа:  Төгсгөлийн судалгаа	ЗОРИЛГЫН шалгуур үзүүлэлттэй адил	ЗОРИЛГЫН шалгуур үзүүлэлттэй адил	ЗОРИЛГЫН шалгуур үзүүлэлттэй адил	ЗОРИЛГЫН шалгуур үзүүлэлттэй адил	ЗОРИЛГЫН шалгуур үзүүлэлттэй адил	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Зорилгын шалгуур үзүүлэлттэй адил
<b>Гарц 1.3:</b> Өрхийн баталгаат ундны усны хэрэглээ сайжирсан байна. МЭДЛЭГ							
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.3a:</b>  (ЦУШ) –н 3 хэрэглээг зөв хэрэглэсэн өрхийн % (хамарсан, цэвэрлэх, байрлуулах)	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа ба Төгсгөлийн судалгаа</b>  Дараах зүйлийг: -Нөөцлөх -Цэвэрлэх -Хадгалах шалгасан байна.	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> 1.1с-тэй адил
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.3b:</b> # (ЦУШ) –г хэрэглэх сургалтад хамрагдсан	<b>Мэдлэг, хандлага, дадлын судалгаа &amp; Төгсгөлийн судалгаа</b> 1.1с-тэй адил		1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> 1.1с-тэй адил
<b>Гарц 1.4:</b> Орон нутагт баталгаат ундны усны хэрэглээний мэдээлэл сайжирсан байна.							
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.4a:</b>  # Олон нийтийн баталгаат ундны усны хэрэглээг дэмжих хэлэлцүүлэг	Баталгаат ундны усны хэрэглээг дэмжсэн үйл явдлууд: Сургалт, семинар, (ЦУШ) хүлээн авагчдад болон авсны дараах	Мэдээлэл ба Боловсролын салбарын удирдагчдаас тайланг хянасан байна.  Оролцоо, сургалтын бүртгэлийн хүснэгт:	Нэг (ЦУШ) сайтад хүргэх болон түгээх давхцах	Мэдээлэл ба Боловсролын салбарын удирдагчид, Олон нийтийн ажилтнуудтай хамт	Төслийн удирдагч	Төслийн баг, (ЦУШ)-ийн нийгмийн маркетингийн төлөөлөгчөөр удирдуулсан, УАЦЭАБ-ын төлөөлөгчид Төслийн зохицуулагч.	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> 1.1с-тэй адил



<b>5 дугаар бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц – Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн төслийн жишээ</b>							
Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих үзүүлэлт, тодорхойлолт ба нэгж	Тайлагнах арга/ хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх				Тайлагнах үйл ажиллагаа
			Давтамж, ажлын хуваарь	Хариуцах хүн:			
				Цуглуулах	Удирдлага	Дүн шинжилгээ	
(шууд бус шалгуур үзүүлэлт).		(ЦУШ) хүлээн авагчдад болон авсны дараах					
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.4b:</b>  #(ЦУШ)-ийн туршлагын талаарх мэдээллийг хамгийн багадаа хоёр өөр эх сурвалжаас тараасан орон нутгийн байршил.	Мэдээллийн эх сурвалж: (ЦУШ) хүлээн авагчийн авсан сургалт, материал. Мэдээллийн (ЦУШ) тараах үед ОНА-ы тараасан сурталчилга аны хуудас үеэр тараагдана.	Өрх болон олон нийтэд тараасан (ЦУШ)-ийг хүлээн авсан хуудас  ОНА-ны хүснэгт болон батлагдсан жагсаалт	Тараагдсан (ЦУШ)	Мэдээлэл ба Боловсролын салбарын удирдагчид Олон нийтийн ажилтнуудын хамт	Төслийн удирдагч	Төслийн баг, (ЦУШ)-ийн нийгмийн маркетингийн төлөөлөгчөөр удирдуулсан, УАЦЭАБ-ын төлөөлөгчид Төслийн зохицуулагч.	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> 1.1с-тэй адил
<b>Гарц Шалгуур үзүүлэлт 1.4с:</b>  #Баталгаат усыг хэрэглэх семинарт оролцох зорилтот өрх	(ЦУШ) хүлээн авах зорилтот өрх. Хүлээн авагч өрх бүр хүргэх семинарт оролцоно.	(ЦУШ) хүлээн авах хүснэгт  ОНА-ны хүснэгт болон батлагдсан жагсаалт	Тараагдсан (ЦУШ)	Мэдээлэл ба Боловсролын салбарын удирдагчид Олон нийтийн ажилтнуудын хамт	Төслийн удирдагч	Төслийн баг, (ЦУШ)-ийн нийгмийн маркетингийн төлөөлөгчөөр удирдуулсан УАЦЭАБ-ын төлөөлөгчид Төслийн зохицуулагч.	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> 1.1с-тэй адил
<b>ЗОРИЛТ 2: Олон нийтийн, өрхийн түвшинд усны тунадас/амаар дамжуулахтай холбоотой эрүүл ахуйн дадал, ойлголтыг сайжруулах</b>							
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 2a:</b>  Хоол хүнсээ зөв хадгалдаг өрхүүдийн % (ялаанаас бохирдол/ агаарын замаар хамгаалах) (зорилтот SS% байна)		1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> 1.1с-тэй адил



5 дугаар бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц – Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн төслийн жишээ							
Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих үзүүлэлт, тодорхойлолт ба нэгж	Тайлагнах арга/ хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх				Тайлагнах үйл ажиллагаа
			Давтамж, ажлын хуваарь	Хариуцах хүн:			
				Цуглуулах	Удирдлага	Дүн шинжилгээ	
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 2b:</b> Гараа зөв угааж заншсан өрхийн % (Зорилтот түвшин NN%)	Өрх: (ЦУШ) хүлээн авсан	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	1.1с-тэй адил	Ашиглагдах мэдээлэл: 1.1с-тэй адил
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 2с:</b> Хүүхдийн болон нялхсын бохирыг зөв хаядаг болсон хүний %	Суурь улирал 303.	1) Суурь: 12/2015 дууссан 2) Төгсгөлийн судалгаа: Зөвлөхүүд болон ХШҮ-ний зөвлөхүүд хамтран боловсруулсан байна.	Төгсгөлийн судалгаа Төслийн хугацаанаас хамаарна.	Суурь/ Төгсгөлийн судалгаа: Зөвлөхүүд	Суурь/ Төгсгөлийн судалгаа: Зөвлөхүүд, ХШҮ-ий нэгж, Төслийн удирдлага	Суурь/ Төгсгөлийн судалгаа: Зөвлөхүүд, Төслийн удирдлага, ХШҮ-ний ажилтан	Ашиглагдах мэдээлэл: Дээрхтэй адил
<b>ЗОРИЛТ 3:</b> Баталгаат ундны ус хангамжийн төслийг төлөвлөх, удирдах, дэмжих орон нутгийн чадавхийг сайжруулсан байна.							
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 3a:</b> # Хүргэх хуваарийн дагуу (ЦУШ) үйлдвэрлэх байгууламж (Зорилт MM байна).	Урьдчилан заасан хэмжээгээр үйлдвэрлэх тээрэм, холигч, хэвлэн нийтлэх, хөгц, зуухаар тоноглогдсон шавар хүртээмж бүхий байгууламж.	Семинарын тайланг бэлтгэх	Хуваарь: Сараар, Улирлаар	Төслийн удирдагч	Төслийн зохицуулагч	Төслийн баг, УАЦЭАБ-ын төлөөлөгчид ба Төслийн зохицуулагч	Ашиглагдах мэдээлэл: Дээрхтэй адил
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 3b:</b> # Төсөлд идэвхтэй оролцсон төслийн салбар	Төслийн салбар гэдэг нь төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа газрыг хэлнэ.  "Идэвхтэй оролцоо": Олон нийтээс ариун	Хурал, уулзалтын тэмдэглэл, хийгдсэн сургалт, хэлэлцүүлгийн бүртгэл, тайлан	Сарын тайлан ба улирлын үйл ажиллагааны тайлан	Төслийн удирдагч	Төслийн зохицуулагч	Төслийн баг, (ЦУШ)-ийн нийгмийн маркетингийн төлөөлөгчөөр удирдуулсан, УАЦЭАБ-ын төлөөлөгчид, Төслийн зохицуулагч.	Ашиглагдах мэдээлэл: Дээрхтэй адил



<b>5 дугаар бүлгийн Хавсралт 2: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний матриц – Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн төслийн жишээ</b>							
Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих үзүүлэлт, тодорхойлолт ба нэгж	Тайлагнах арга/ хэрэгсэл	Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх				Тайлагнах үйл ажиллагаа
			Давтамж, ажлын хуваарь	Хариуцах хүн:			
				Цуглуулах	Удирдлага	Дүн шинжилгээ	
	цэврийн хурал, уулзалтад оролцсон байдал						
<b>Дэд зорилт Шалгуур үзүүлэлт 3с:</b>  # Төсөлд идэвхтэй оролцсон төрийн байгууллагын ажилтнууд	Төрийн байгууллагын ажилтнууд (Эрүүл ахуйн байцаагч)-ын төсөл хэрэгжиж байгаа уулзалтад оролцсон байдал	Хурал, уулзалтын тэмдэглэл, хийгдсэн сургалт, хэлэлцүүлгийн бүртгэл, тайлан (ЦУШ) хүлээн авах батлагдсан хүснэгт.	Сарын тайлан ба улирлын үйл ажиллагааны тайлан	Төслийн удирдагч	Төслийн зохицуулагч	Төслийн баг, (ЦУШ), УАЦЭАБ-ын төлөөлөгчид, Төслийн зохицуулагч.	<b>Ашиглагдах мэдээлэл:</b> Дээрхтэй адил

Улаан загалмай нийгэмлэгээс авав.



---

# НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ







## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

**Анхан шатны мэдээлэл:** Нэгтгэгдээгүй, өөр хэлбэрт шилжүүлээгүй, судалгааны талбараас цуглуулсан боловсруулагдаагүй анхан шатны мэдээллийг мэдээлэл гэж нэрлэдэг.

**Асуудал/шийдлийн мод:** Тухайн асуудалтай холбоотой шалтгаан, үр дагаврыг тоймлон харуулдаг. Асуудлын мод нь тухайн асуудлын мэдэгдэж буй шалтгааныг (тухайлбал, мэдлэг муу, нөөц хангалтгүй байх г.м) бичих үйл явц юм. Хэрэв асуудлын модонд бичигдсэн сөрөг асуудлуудыг эерэг байдлаар хувиргавал “Шийдлийн мод” болно. Асуудлын мод нь шалтгаан-үр дагаврыг гаргаж тавьдаг бол шийдлийн мод нь агуулга-үр дүнгийн харилцааг чухалчилдаг. Иймд шийдлийн мод нь гол асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай төслүүд, шийдлийг тоймлон харуулдаг.

**Асуулгад суурилсан судалгаа:** Асуулгад суурилсан судалгааны дүнд бий болсон тоон мэдээллийг асуулгын мэдээлэл гэнэ. Жишээ нь: Амжиргааны түвшинг хэмжих судалгаа, Хүн ам, орон сууцны судалгаа гэх мэт.

**Бага түүвэр судалгаа:** Бага түүвэр судалгааг тодорхой зорилгоор, субъектив байдлаар тодорхойлсон жижиг нутаг дэвсгэр, бүсэд хийдэг. Уг судалгааг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөнд ашиглахад илүү тохиромжтой. Энэ түүвэр судалгааны давуу тал нь өргөн хэмжээний судалгааг бодвол асуудлыг илүү нарийн судлах боломжийг олгодог. Харин судалгаанаас гарсан үр дүнг ерөнхийлж бусад газарт хэрэглэх боломж хязгаарлагдмал байдаг.

**Байгаль орчны бохирдол:** Байгаль орчинд (агаар, ус, хөрс гэх мэт) сөргөөр нөлөөлж буй эсвэл бохирдуулж буй бүх төрлийн (нөхөн сэргээгдэх эсвэл нөхөн сэргээгдэхээргүйгээр нөлөөлж буй) нөлөөллийг хэлнэ.

**Байгалийн нөөц:** Байгалиас хүний ашиглаж болох бүх нөөц. Хүмүүс байгалийн нөөцийг бий болгодоггүй бөгөөд тэд байгалийн баялгийг шууд болон шууд бусаар ашигладаг. Байгалийн нөөцийн жишээ: агаар, ус, мод, газрын тос, салхи, усан цахилгаан, төмөр, нүүрс гэх мэт.

**Бодлого:** Улсын Их Хурал, Засгийн газар болон бусад төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь бүрэн эрхийнхээ хугацаанд мөн шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан шийдвэр, үйл ажиллагааны чиглэл юм.



**Боловсруулсан мэдээлэл:** Анхны хэлбэрээс нь тухайн зорилгод нийцүүлэн тохирсон хэлбэрт оруулан хөрвүүлсэн, нэгтгэсэн, цэгцэлсэн, эрэмбэлсэн болон төрөл бүрийн хэлбэрт хувиргаж боловсруулсан мэдээлэл юм.

**Бүс нутаг:** Тухайн улсын тодорхой улс төрийн эсвэл засаг захиргааны бүс нутгийг, тухайлбал аймаг, сумыг илэрхийлнэ.

**Гарц:** Байгууллага болон төслийн үйл ажиллагааны үр дүнд бий болж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, байгууламжийг гарц гэнэ. Гарц нь үзүүлсэн үйлчилгээ, зарагдсан бүтээгдэхүүн, өгөгдсөн байгууламж юм. Гарц нь оруулсан хүчин чармайлтын үр дүнд бий болдог. Гарц нь хүлээгдэж буй үр дагаварт хүргэхэд чиглэгдсэн байдаг.

**Дэвшил:** Өмнө нь эдийн засаг, нийгмийн хувьд болон шийдвэр гаргах үйл ажиллагаанаас тусгаарлагдсан бүлэг болон хүмүүс тэгш байдалд хүрэхэд гарч буй шилжилт, өөрчлөлтийг хэлнэ.

**Жини коэффициент:** Жини индекс эсвэл Жини харьцаа гэдэг энэ хэмжигдэхүүн нь хүн амын тодорхой бүлэг эсвэл хүмүүсийн орлогын хуваарилалтыг илэрхийлэх зорилготой статистикийн үзүүлэлт юм. Энэ нь тэгш бус байдлыг хэмждэг хамгийн түгээмэл хэмжигдэхүүн.

**Захиргааны мэдээлэл:** Захиргааны бүртгэлээс цуглуулсан мэдээллийг хэлнэ. Жишээ нь: сургуулийн бүртгэл, эмнэлгийн бүртгэл, шалгах хэсэгт бүртгэсэн мэдээлэл, нисэх буудлын болон гаалийн мэдээлэл гэх зэрэг.

**Зорилго, зорилт:** Зорилго, зорилт нь ерөнхийдөө хүрэхийг хүсч буй хүсэл, тэмүүлэл, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараа гарах хүлээгдэж буй үр дүнг илэрхийлдгээрээ хоорондоо төстэй.

**Индекс:** Аливаа хувьсагч болон индикаторын жишиг үзүүлэлттэй харьцуулахад гарч буй өөрчлөлтийг илэрхийлсэн тоонуудын нэгдэл. Жишээ нь: үнэ, хэмжээ, амьжиргааны түвшин, экспорт зэрэг мэдээлэлд тодорхой хугацаанд (сар, улирал эсвэл жил) гарсан өөрчлөлт.

**Индикатор:** Засгийн газар, бодлого боловсруулагч болон нийгмийн үзэгдлийн зүй тогтлыг илэрхийлэх тоон болон чанарын утга юм. Өөрөөр хэлбэл цуглуулсан мэдээллийг (эдийн засаг, нийгэм, улс төрийн үйл явцын талаарх) нэг тоон утгаар дүгнэж шинжлэхэд ашигладаг статистикийн хэрэгсэл.



**Капитал/гарцын харьцаа (ICOR):** Тухайн улс орон нэмэлт нэгж бүтээгдэхүүн/гарцыг үйлдвэрлэхэд шаардагдах нэмэлт капиталын хэмжээ. Ихэнхидээ макро эдийн засгийн тооцоололд ашиглагддаг.

**Мета мэдээлэл:** Индекс болон индикаторуудыг тооцоход ашигладаг мэдээллийг хэлнэ. Мета мэдээлэл нь боловсруулсан мэдээлэл боловч индикаторыг шууд илэрхийлэх хэмжээнд боловсруулагдаагүй байдаг. Анхаарах: Мэдээллийг бодлогын шинжилгээнд эцсийн байдлаар ашиглах хүртэл боловсруулахад хэд хэдэн үе шаттай байдаг. Мета мэдээлэл нь мэдээллийг эцсийн шатны боловсруулалтын өмнөх хүртэл боловсруулсан мэдээлэл.

**Ногоон өсөлт:** Хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалах, нийгмийн оролцоог дэмжих, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн өсөлтийг хэлнэ.

**Мэдлэг, хандлага, дадал (МХД):** Энэ нь тодорхой үйл ажиллагаа, жишээ нь, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, жендэрийн асуудлын талаар хүмүүсийн мэдлэг, хандлага, дадлыг судалж, үнэлдэг судалгаа.

**Ногоон хөгжил:** Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хий, хаягдал багатай, үрэлгэн хэрэглээг бууруулж, нийгмийн оролцоог хангасан хөгжлийн загварыг хэлнэ.

**Ногоон эдийн засаг:** Байгаль орчны эрсдэл, доройтол, байгалийн нөөцийн хомсдлыг бууруулахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засаг юм.

**Нөхцөл байдлын шинжилгээ:** Нөхцөл байдлын шинжилгээ нь засаг захиргааны мэргэжилтнүүд, удирдлагын зүгээс тулгарч буй асуудал, нөхцөл байдлыг ойлгох зорилгоор тодорхой аргуудын нэгдлийг ашиглан нийгэм, эдийн засаг эсвэл байгууллагын дотоод, гадаад орчныг шинжлэхийг хэлнэ.

**Нөхцөлт мөнгөн шилжүүлэг:** Нийгмийн эмзэг бүлгийнхэнд хүүхдүүдээ вакцинд хамруулах эсвэл сургуульд сургах гэх зэрэг тодорхой нөхцлийг хангасан тохиолдолд үзүүлдэг бэлэн мөнгөний дэмжлэг.

**Нялхсын эндэгдлийн түвшин, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл:** НЭТ гэдэг нь 1000 амьд төрсөн хүүхэд бүрт нэг нас хүрэхээсээ өмнө эндсэн хүүхдийн тоо, 5ХХЭ нь 1000 амьд төрсөн хүүхэд бүрт 5 нас хүрэхээсээ өмнө эндсэн хүүхдийн тоо. Тухайн газар нутгийн эндэгдлийн түвшин нь тодорхой насанд хүрэхээсээ өмнө эндсэн хүүхдийн тоог тухайн жилийн нийт амьд төрсөн хүүхдийн тоонд



хувааж 100-аар үржүүлсэнтэй тэнцэнэ.

**Нэгтгэл:** Нэгээс олон арга зүй, хандлагыг хэрэглэн үр дүн болон таамаглалыг батлах арга юм.

**Оролцогч талууд:** Оролцогч талууд гэдэг нь тухайн төсөл, хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хувьд хууль ёсны ашиг сонирхолтой хувь хүмүүс болон байгууллагуудыг хэлнэ.

**Өөрчлөлтийн онол:** Өөрчлөлтийн онол гэдэг нь нийгмийн өөрчлөлтийг дэмжих зорилгоор төрийн болон ашгийн бус салбарт хэрэглэж буй төлөвлөлт, үнэлгээг хийх арга зүй юм. Энэ нь төсөл, хөтөлбөр эсвэл салбарын урт хугацааны зорилгыг тодорхойлсны дараа уг зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай урьдач нөхцөлүүдийг тогтоон үр дагавраас шалтгаан, орц руу зураглах арга юм. Ингэснээр учир шалтгааны уялдаа холбоог тодорхойлох замаар өөрчлөлтийн явцыг илрүүлж, тусган тайлбарлах бөгөөд уг үйл явц хэрхэн тохиолдсон, энэ нь хэрэгжүүлэгч агентлагийн хувьд ямар нөлөө үзүүлэх, богино, дунд, урт хугацааны үр дүнд хэрхэн нөлөөлөх зэрэг асуултанд хариулт өгөх боломжийг олгоно.

**Орц:** Хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхийн тулд ашиглах чадварлаг хүний нөөц, түүхий эд, цахилгаан, болон бусад эх үүсвэрүүдийг хэлнэ.

**Салбар дундын болон салбар дамнасан хандлага:** Нэг үйл ажиллагааг ойлгоход нэгээс олон мэргэжлийн салбарыг хамтатган хэрэглэх хандлагыг салбар дундын болон салбар дамнасан хандлага гэнэ (жишээ нь сургууль завсардалтыг шинжлэх). Энэ хандлага нь зөвхөн нэг үзэл баримтлалын хүрээнээс хальж олон талаас нь бодож, шинжлэхийг хэлнэ. Тухайлбал, орчин үеийн менежмент нь эдийн засаг, төрийн удирдлага, бизнес болон нийгмийн шинжлэх ухаан зэрэг хэд хэдэн салбарыг уялдуулсан салбар юм.

**Салбар хоорондын асуудал:** Нэгээс илүү салбар болон хэрэгжүүлэгч байгууллагыг хамарсан асуудал. Жишээ нь: Жендэрийн асуудал бол салбар хоорондын асуудал.

**Таамаглал:** Хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц амжилттай хэрэгжих нөхцөлд нөлөөлөх эрсдлийн хүчин зүйлсийн талаарх урьдчилсан таамаглал. Тэдгээр нь үнэлгээний баталгаат байдал дээр суурилсан 'урьдчилсан нөхцөлт таамаглал'. Таамаглалыг онолд үндэслэсэн үнэлгээнд суурилж, хүлээгдэж буй үр дүнгүүдийн уялдааг үнэлгээгээр хянаснаар тодорхойлдог.



**Тогтвортой хөгжил:** 21-р зууны хөгжлийн үзэл баримтлал нь байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжил байхаар тодорхойлогдсон. Мөн Тогтвортой хөгжил гэж өнөөгийн хэрэгцээгээ хангахдаа ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээг хангах боломжийг хязгаарлахгүйгээр хөгжихийг хэлнэ.

**Төрөлтийн ерөнхий хувь:** Төрөлтийн ерөнхий хувь буюу зарим тохиолдолд хүн амын төрөлтийн хувь гэж нэрлэгддэг энэхүү хэмжигдэхүүн нь нэг эхээс амьдралынх нь турш төрсөн хүүхдийн дундаж тоог илтгэнэ. Ингэхдээ тухайн эх дараах нөхцлийг хангасан бол тооцоололд оруулна. Үүнд:

1. Хэрэв уг эмэгтэй амдралынхаа туршид төрөх насны төрөлтийн хувийг хангаж байвал, мөн
2. Хэрэв уг эмэгтэй төрснөөсөө эхлээд төрөлтийн насаа дуустал амьдарсан бол тооцоололд оруулна.

**Төслийн үнэлгээ, хяналтын аргачлал (ТҮХА):** Төслийн үнэлгээ, хяналтын аргачлал нь бие даасан төслүүдийг төлөвлөх, зохицуулах арга юм. Тодорхой төсөл эсвэл хөтөлбөрийн гол үйл явдал болон уялдаа холбоо бүхий үйл явцыг тодорхойлсон “замын зураглал” юм. Ихэнх төслийн хувьд төсөл дуусах хугацаа нь тодорхой заагдсан байдаг тул диаграмт нь “хойно”-оос (зорилгоос) “урагш” (орц руу) чиглэсэн байдлаар зурагддаг нь эхлэлээс төгсгөл хүртэлх уян хатан байдлыг хангаж өгдөг. ТХҮА-ын үндсэн хэсэг нь хэв загварыг төлөвлөх явдал бөгөөд энэ хүрээнд бусад үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх гол үйл ажиллагааг тодорхойлно. Шинжилгээний үндсэн онцлог нь төслийн гол үйл ажиллагааг түүнд хүрэх дэс дараалалтай нь дүрсэлсэн зураглалыг харуулдаг “торон диаграм” юм. Ингэхдээ үйл ажиллагаануудыг тухайн төсөл дуусах хүртэл зарцуулах цаг хугацаа, нөөцүүдтэй уялдуулан тодорхойлно. Торон диаграм нь сумнууд болон зангилаа зэргээс бүрдэх ба тогтсон хоёр өөр журмын аль нэгийг нь ашиглан дүрсэлнэ. Сумнууд нь сум хэлбэрт илэрхийлэгдсэн үйл ажиллагааг илтгэдэг бол зангилаа нь зангилаа хэлбэрт илэрхийлэгдсэн үйл ажиллагааг харуулдаг. Менежер нь үйл ажиллагаа бүрийн хувьд гүйцэтгэж дуусах хугацааг нь заана.

**Тэгш бус байдал:** Эдийн засгийн тэгш бус байдал нь иргэдийн орлогын эсвэл хөрөнгийн тэгш бус байдлыг хэлнэ. Энэ нь хөрөнгө, баялаг болон орлого нь тодорхой бүлгийн хувь хүмүүсийн дунд, хүн амын тодорхой бүлгийн дунд болон улс орнуудын дунд тэгш бус хуваарилагдах явдал юм. Эдийн засгийн тэгш бус байдал нь боловсрол, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээнд хамрагдах (хөдөлмөрийн зах зээл, нийгмийн орон зай болох тодорхой сонирхлын бүлэг болон хүрээнд хамрах боломж) гэх зэрэг тэгш бус байдлыг илэрхийлдэг. Тиймээс тэгш бус байдал нь орлогын тэгш бус байдлаас гадна бусад хэлбэрүүдтэй байж болно.





**Тэгш хүртээмжтэй өсөлт:** Ядуурал, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, хүмүүсийн оролцоог хангах, орлогын өсөлтийн өгөөжийг жигд хуваарилах зэрэгт чиглэсэн эдийн засгийн өсөлтийг хэлнэ.

**Тэгш хүртээмжтэй ногоон өсөлт:** Нийгмийн эмзэг давхарга ба ядуучуудад ногдох үр өгөөжийг хамгийн их байлгах, тэдэнд ногдох зардлыг хамгийн бага байлгах, мөн байгаль орчинд засч болохооргүй сөрөг нөлөө үзүүлсэн үйл ажиллагаа болон бодлогоос зайлсхийсэн эдийн засгийн өсөлтийг хэлнэ.

**Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй:** Үүнд найдвартай ус, эрүүл ахуй (эрүүл ахуйн шаардлага хангасан бие засах газар) болон бусад эрүүл ахуйн дадлууд болох гар угаах, ус/ хүнс хадгалах агуулах зэргийг ойлгоно.

**Үнэлэлт:** Аливаа хөгжлийн төсөлд хөрөнгө оруулалт хийхээс өмнө түүний хамаарал, үндэслэл, хэрэгжих боломж болон даацын талаар хийсэн нэгдсэн үнэлгээ.

**Үнэлгээ:** Үнэлгээ гэж хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дууссан бодлого, хөтөлбөр, төсөл, түүний дотор тэдгээрийн боловсруулалт, хэрэгжилт, үр дүнг системтэй, бодитой үнэлэх үнэлгээ юм. Үнэлгээний зорилго нь төсөл, хөтөлбөр нь зорилгодоо хүрсэн эсэх, хэрэгжилтийн үр дүн болон үр ашигтай байдал, нөлөө, цаашид бие даан хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлоход оршино.

**Үр нөлөө:** Хөгжлийн бодлого, хөтөлбөрийн үр дүнд бий болж буй эерэг, сөрөг, анхдагч, хоёрдогч, шууд болон шууд бус мөн санаатай болон санаандгүй үр дүнг хэлнэ.

**Үр дүнд суурилсан удирдлага:** Үр дүнд суурилсан удирдлага гэдэг нь эргэх холбоог ашиглан стратегийн зорилгод хүрэх менежментийн нэг стратеги юм. Тухайн тогтолцоо эдийн засагт буй төлөөлөгчид болон агентлагууд нь үр дүнд шууд болон дам байдлаар хувь нэмэр оруулна. Үр дүн нь биет өөрчлөлт, нөлөө эсвэл өндөр түвшний зорилгод оруулсан хувь нэмэр зэрэг хэлбэртэй байж болдог. Бодит үр дүнгийн нотолгоо нь тухайн төсөл, үйл ажиллагааны тайлан, санал хүсэлтэнд тусгагдаж эргээд төслийн дизайн, нөөц зэрэгт тусгагдсан байх хэрэгтэй. Үр дүнд суурилсан удирдлага нь төлөвлөлт, төсөвлөлт болон хяналт шинжилгээ/нэгдсэн систем бөгөөд эдгээр үйл явцыг харилцан хамаарал, үйлчлэлтэй нь төлөвлөх, төсөвлөх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх боломжийг олгодог.





**Үр дүнгийн хүрээ:** Үр дүнгийн хүрээ нь удирдлагын арга хэрэгсэл бөгөөд асуудалд илүү төвлөрч, үр дүнд хүрэхийн тулд стратегиа тодорхойлж, нөөцийг зохистой хуваарилахад чиглэгддэг. Үр дүнгийн хүрээ нь шалтгаан-үр нөлөөний уялдаанд үндэслэн завсрын үр дүнд хүрснээр хөтөлбөрийн эцсийн зорилгод хүрэх хэдэн хэдэн зорилтыг дэвшүүлсэн байдаг. Мөн стратегийг баталгаатай хэрэгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг заавал тооцсон байна. Энэ нь хөтөлбөрийн зорилго, амжилтын үзүүлэлтүүдийг тодорхойлоход туслахын зэрэгцээ тухайн хөтөлбөр суурилах гол төсөөллүүдийг тоймлон харуулдаг. Түүнчлэн, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц болон үйл ажиллагааны төрлийг ангилал тус бүрээр гарган тооцоолно.

*Үр дүнгийн буюу Логик хүрээний ялгаа: Логик хүрээг 1969 онд тусламжийн төслүүдийг боловсруулахад ашиглахаар гаргасан. Үүнээс хойш энэ хүрээг өргөжүүлэн сайжруулсаар ирсэн. Үүний дараа гарсан үйл ажиллагаануудыг нэг шугамд дараалуулан жагсаасан байдаг логик хүрээний эсрэг нь болох үр дүнгийн хүрээ нь хүрэх үр дүнд төвлөрсөн байдаг. Эдгээр нэр томъёонууд нь эцсийн дүндээ нэг ижил бөгөөд ялгаа нь логик хүрээг нь хандивлагч байгууллагуудын бүлэг (Европын Холбоо), үр дүнгийн хүрээг нь АНУ-ын Хөгжлийн Агентлаг, Дэлхийн банк болон бусад хандивлагчид байгууллагууд ашигладагт байгаа юм.*

**Хамтарсан хөтөлбөр:** Нэгээс илүү яам, агентлаг хамтран боловсруулан хэрэгжүүлж буй хөгжлийн болон бусад төрлийн хөтөлбөр.

**Хөгжил:** Эдийн засгийн өсөлт болон хүмүүсийн амьжиргааны түвшин тогтвортой мөн тасралтгүй дээшлэх үйл явц. Энэ нь хүмүүсийн амьдралын чанар тоон болон чанарын үзүүлэлтийн хувьд сайжрах үйл явц юм.

**Хөгжлийн төлөвлөлт:** Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх бодит төлөвлөгөө болгон хувиргах үйл явц.

**Хүний хөгжил:** Хүмүүсийн сонголтыг сайжруулахад чиглэгдсэн байдаг. Аливаа сонголтыг хийхийн тулд хүн боловсрол, мэдлэгтэй, эрүүл чийрэг байхаас гадна өөрийн гэсэн үнэт зүйл бүхий амьдралыг цогцлоох чадвартай байх ёстой. Ингэснээр хүн амьдралын тодорхой зорилготой болж, илүү олон боломжтой болох, мөн илүү их орлого олох, нийгмийн баялгаас тэгш хүртэх нөхцөл бүрдэнэ.

**Хяналт-шинжилгээ:** Хөгжлийн зорилгод хүрэхэд гарч байгаа ахиц дэвшил, хуваарилсан хөрөнгийн ашиглалтын явцыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хянаж, системтэй мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ





хийж бодлогын хэрэгжилтийн талаар удирдлага болон гол оролцогч талуудад тасралтгүй мэдээлэх үйл ажиллагааг хэлнэ.

**Экосистемийн үйлчилгээ:** Хүмүүсийн экосистемээс авч байгаа үр өгөөжийг хэлнэ. Үүнд: 1) Хангамжийн үйлчилгээ. Жишээ нь: хүнс, ус, ашигт малтмал; 2) Зохицуулах үйлчилгээ. Жишээ нь: үер болон өвчнөөс хамгаалах; 3) соёлын үйлчилгээ. Жишээ нь: оюун санаа - сүсэг бишрэлийн, аялал зугаалгын, соёлын үр өгөөж; 4) Дэмжих үйлчилгээ. Жишээ нь: дэлхий дээрх амьд организмын амьдрах нөхцлийг бүрдүүлдэг бодисын эргэлт гэх мэт.

**Эрсдэлийн шинжилгээ:** Эрсдэлийн шинжилгээ нь хувь хүмүүс, байгууллага, нийгэм, орон нутаг, бүс нутаг, улс болон олон улсын түвшинд хийгдэж болох эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн тодорхойлолт (хөгжлийн оролцооноос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд бий болзошгүй сөрөг үр дагавар), эрсдэлийг хэмжих (тодорхой эрсдэлүүдийн тохиолдох магадлал, хүлээгдэж буй нөлөөг тооцоолох), эрсдэлийн удирдлага болон бодлого зэргийг багтаасан ойлголт юм.

**Ядуурал-байгаль орчны уялдаа холбоо:** Ядуурал ба байгаль орчин хоорондоо дараах байдлаар нэг нэгэндээ хамаарах уялдаа холбоог хэлнэ.

Үүнд: Амьжиргаанд нөлөөлөх: экосистемийн үйлчилгээний хүртээмжээс хүний сайн сайхан байдал буюу амьжиргаа хамаарах, байгалийн эрсдэлд өртөх байдалд нөлөөлөх: цаг уурын өөрчлөлт болон байгалийн гамшиг ядуу хүмүүс өртөх эмзэг байдал өндөр байдаг, эрүүл мэндэд нөлөөлөх: байгаль орчны доройтол, бохирдол нь хүний эрүүл мэндэд нөлөөлөх, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх: байгалийн нөөцөөс эдийн засаг хамаарах.

**SMART(тодорхой, хэмжигдэхүйц, биелүүлэхүйц, ач холбогдолтой болон хугацаатай):** Төсөл, хөтөлбөрийг хянах, үнэлэхэд шаардлагатай үзүүлэлтүүдийн шинж тэмдгүүдийг илэрхийлнэ.